



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-174

1.Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудал	5-174
--	-------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит
чуулганы 06 дугаар сарын 12-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 65 гишүүн хүрэлцэн ирж, 51.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 04 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга, Ш.Бямбасүрэн, Ж.Ганбаатар, Ж.Энхбаяр;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ, М.Энхцэцэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Т.Доржханд, М.Мандхай, Д.Энхтүвшин;

Тасалсан: Н.Алтанхуяг;

Хоцорсон: Л.Гантөмөр-01 минут, Б.Пунсалмаа-38 минут, А.Ундраа-5 цаг 10 минут, Д.Цогтбаатар-12 минут, Ж.Энхбаяр-02 минут.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, Төрийн байгуулалтын байнгын хороо болон Улсын Их Хурал дахь Ардчилсан Намын бүлэг хуралдаж байгаа тул хуралдааныг үдээс хойш 14 цаг хүртэл түр завсарлуулав.

Чуулганы нэгдсэн хуралдаан 10 цаг 05 минутаас 14 цаг 17 минут хүртэл завсарлав.

Нэг.Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшигч Г.Занданшатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Б.Даваадалай, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга А.Үйлстөгөлдөр, мөн газрын Хуулийн газрын дарга Ж.Мөнхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Нарангэрэл, мөн хэлтсийн зөвлөх Л.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох тухай Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нар танилцуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал, Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан болон нэр дэвшигчээс Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Д.Энхтуяа, О.Алтангэрэл, Б.Бейсен, Н.Наранбаатар, Б.Пүрэвдорж, Ж.Баясгалан, Ц.Туваан, Б.Бат-Эрдэнэ, О.Цогтгэрэл, Б.Түвшин,

Р.Батболд, Ч.Лодойсамбуу, Г.Ганбаатар, Б.Мөнхсоёл, Л.Энхнасан, С.Зулпхар, Ө.Шижир, Д.Пүрэвдаваа, Да.Цогтбаатар, Ж.Чинбүрэн, С.Эрдэнэболд, О.Батнайрамдал, П.Батчимэг, А.Ариунзаяа, Ж.Алдаржавхлан, П.Ганзориг, П.Мөнхтулга, Х.Жангабыл, Ц.Баатархүү, Ж.Галбадрах, Д.Үүрийнтуяа, С.Эрдэнэбат, О.Номинчимэг, Н.Батсүмбэрэл, Ж.Золжаргал, Ч.Номин, С.Замира, П.Сайнзориг, С.Цэнгүүн, Ц.Мөнхтуяа, Б.Батбаатар, Х.Тэмүүжин, Х.Ганхуяг, Л.Мөнхбаясгалан, Б.Заяабал, Г.Уянгахишиг, М.Бадамсүрэн, М.Ганхүлэг, М.Нарантуяа-Нара, Г.Очирбат, Д.Ганмаа, Ч.Анар, Г.Хосбаяр, Д.Ганбат, Р.Эрдэнэбүрэн, Ц.Мөнхбат, Ж.Батсуурь, Ж.Баярмаа нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшигч Г.Занданшатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 18 цаг 05 минутаас 20 цаг 22 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Б.Бейсен, Н.Наранбаатар, Б.Пүрэвдорж, Б.Түвшин, Г.Лувсанжамц, Д.Рэгдэл, Д.Пүрэвдаваа, С.Эрдэнэболд, Л.Соронзонболд, Ц.Идэрбат, Ц.Баатархүү, Н.Батсүмбэрэл, С.Замира, Б.Батбаатар, Б.Жаргалан, Х.Тэмүүжин, Э.Болормаа, П.Наранбаяр, Х.Баасанжаргал, Л.Мөнхбаясгалан, О.Саранчулуун, О.Цогтгэрэл, М.Нарантуяа-Нара нар үг хэлэв.

Чуулганы нэгдсэн хуралдаан 19 цаг 14 минутаас 19 цаг 54 минутад завсарлав.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Монгол Улсын Ерөнхий сайдаар Гомбожавын Занданшатарыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	108
Татгалзсан	9
Бүгд	117

92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Ч.Ундрам нарыг дэмжсэнээр тооцож, 94.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-т заасны дагуу нэр дэвшигчийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./00:21/

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын 34 дэх Ерөнхий сайдаар томилогдсон Г.Занданшатарт Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, үг хэлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатарыг суудалд нь урьж суулгав.

Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар үг хэлж, Төрийн сүлдэнд мэхийн ёслол.

Уг асуудлыг 00 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 9 цаг 49 минут үргэлжилж, 126 гишүүнээс 116 гишүүн хүрэлцэн ирж, 92.1 хувийн ирцтэйгээр 00 цаг 45 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. 65 гишүүн буюу 51.6 хувиар ирц хүрсэн тул 2025 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 3 асуудал байна.

Нэгдүгээрт, Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудлыг хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, “Эрчим хүч-3” төслийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Одоо Төрийн байгуулалтын байнгын хороо болон АН-ын бүлэг хуралдаж байна. Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудлаар. Тэгэхээр АН-ын бүлэг болон Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдах цагийг тооцоолоод чуулганыг түр үдээс өмнөх чуулганыг түр завсарлуулаад, үдээс хойш 14 цагаас чуулганы хуралдаан албан ёсоор үргэлжилж явна аа. Чуулганыг түр завсарлуулж байна.

Д.Амарбаясгалан: Гишүүдэд өдрийн амгаланг айлтгая.

06 дугаар сарын 12-ны өдрийн үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудалд оръё.

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх танилцуулна. Таныг индэрт урьж байна.

У.Хүрэлсүх: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд олонх суудал авсан Монгол Ардын Намаас Гомбожавын Занданшатарыг

Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшүүлж саналыг 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчид ирүүлсэн юмаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Улсын Их Хуралд олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч 5 хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна гэж заасны дагуу Гомбожавын Занданшатарыг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг Улсын Их Хуралд танилцуулж байна.

Гомбожавын Занданшатар нь 1970 онд Баянхонгор аймгийн Баацагаан суманд төрсөн. Эхнэр 4 хүүхэдтэй. Тэрээр 1987 онд Улаанбаатар хотын 10 жилийн 77 дугаар дунд сургууль, 1987-1992 онд Оросын Холбооны Улсын Байгалийн эдийн засаг, эрх зүйн их сургуульд суралцаж, санхүү, эдийн засагч мэргэжил эзэмшсэн. Эдийн засгийн ухааны магистр зэрэгтэй байна.

Гомбожавын Занданшатар нь ажлын гараагаа Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн багшаар эхлүүлж, 1995-1998 онд Хөдөө аж ахуйн банканд эдийн засагч, хэлтэс, газрын захирал, 1998-2000 онд Монголбанкны сургалтын төвийн менежер, Хөдөө аж ахуйн банк дахь Монголбанкны бүрэн эрхт төлөөлөгч, 2000-2003 онд Хаан банкны дэд захирал, 2003-2004 Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд, 2005-2010 онд Монгол Ардын Намын дэргэдэх Монголын Ардчилсан Социалист Залуучуудын Холбооны Ерөнхийлөгч, 2004-2012 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2009-2012 онд Монгол Улсын Гадаад харилцааны сайд, 2012-2013 онд Монгол Ардын Намын Ерөнхий нарийн бичгийн дарга, 2013-2015 онд Америкийн Нэгдсэн Улсын Стенфордын их сургуулийн Хөгжил, ардчилал, хуулийн засаглалын хүрээлэнд судлаач, 2016-2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2017-2019 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, 2019-2024 онд Монгол Улсын Их Хурлын дарга, 2024 оноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар тус тус ажилласан байна.

Гомбожавын Занданшатар нь 1992 оноос хойш эрдэм шинжилгээ, судалгаа, эдийн засаг, гадаад харилцааны чиглэлээр болон төрийн хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын түвшинд ажилласан төрийн албаны туршлагатай, улс төрийн манлайлал, бодлогын тогтвортой байдлыг ханган ажиллах чадвартай хэмээн үзэж Монгол Улсын Ерөнхий сайдад томилуулахаар ийнхүү хуулийн дагуу санал оруулж байна.

Иймд Гомбожавын Занданшатарыг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох асуудлыг Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох хуульд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Та бүхэнд баярлалаа. Төрийн их ажилд нь амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Гомбожавын Занданшатарыг

Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг Улсын Их Хуралд 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох тухай саналыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 6 дугаар сарын 10, 12-ны өдөр хуралдаанаараа бол хэлэлцлээ.

Гомбожавын Занданшатарын намтар, эрхэлсэн ажлын талаар Монгол Улсын Ерөнхийлөгч сая тодорхой танилцуулсан тул үүнийг орхиё. Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн, хэлэлцэх үед асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Б.Батбаатар, Н.Номтойбаяр, Э.Болормаа, Б.Пүрэвдорж, Ж.Баярмаа, Ж.Золжаргал нар асуулт асууж, хариулт авсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын бодлого төрийн өмчийн компанийн бүтэц бүтээмжийн талаар болон Засгийн газрын бүрэлдэхүүнд жендерийн асуудлыг анхаарч үзэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Сулпхар мэдээлэл, байр сууриа нотолгоо, судалгаа, нотолгоонд тулгуурласан хариуцлагатайгаар илэрхийлэх тухай, Монгол Улс ардчилсан чөлөөт улс хэвээр байгаа тул нийгмийг төөрөгдүүлэх, буруу ойлголт өгөхөөс зайлсхийж, төрийн албаны цомхон гэхээсээ илүү зохистой харьцааг барих талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Засгийн газар тогтвортой ажиллах талаар, мөн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний боловсруулалт, үйлдвэрлэлт болон хувийн хэвшлийг дэмжих, дэмжиж ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг эдийн засгийн өсөлт, баялгийн тэгш хуваарилалтыг иргэн бүрд хүртээх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар иргэдийн сайн сайхны төлөө, хариуцлагатай, шуурхай, зарчимч Засгийн газар ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Номтойбаяр Засгийн газарт хамтарч ажиллах тухай асуудал яригдаагүй, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа төрийн албаны шинэчлэлийг цаг алдалгүй эхлүүлэх, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл Засгийн газрын залгамж чанарыг хадгалж, авлига, хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх олон улсын индексүүдийг ахиулах чиглэлд анхаарч ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ ажлын байр, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх талаар тус тус саналаа илэрхийлсэн болно.

Гомбожавын Занданшатарыг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилуулах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох тухай саналыг хэлэлцэх талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, “Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Гомбожавын Занданшатар хүрэлцэн ирсэн байна.

Мөн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Батсуурийн Даваадалай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх, Алтанхуягийн Үйлстөгөлдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга, Жаргалсайханы Мөнхболд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн газрын дарга.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Асуулт 67 гишүүнээр тасаллаа. Ороогүй хэн байна? Батсуурь гишүүн, Мөнхтуяа гишүүн, Ганбат гишүүн кнопоо дарахаар орохгүй байна уу? Өөр нэр нь ороогүй гишүүн байна уу? Саранчулуун, Хассуурийн Ганхуяг. Ингээд нийт 68 гишүүн үү. Саяын нэр хэлсэн гишүүдийг нэмээд нэр тасаллаа. Даваасамбуугийн Ганмаа гишүүнийг нэмье. Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж горимын санал гаргаж байна.

Р.Сэддорж: Өглөө Ардчилсан намын бүлгийн хурал 9 цагаас эхлээд хуралдаж байсан. Тэгээд Ардчилсан намын гишүүдийг 10 цагийн ирцэд оруулж өгөхийг хүсье. Хоцорсон гээд яачих вий. Тийм саналтай байна.

Д.Амарбаясгалан: Энэ ч горимын санал биш байна л даа. Өглөө 10 цагаас ирц бүртгээд чуулганы хуралдаан ирц хүрээд эхэлчихсэн шүү дээ. Яг тэрүүгээрээ явж байгаа байхгүй юу. Тэгээд завсарлуулаад үдээс хойш эхэлье ээ гээд ингээд шийдчихсэн. Тэгэхдээ одоо ингээд түрүүлээд гарчихсан байгаа нэрс дандаа Ардчилсан намын гишүүд байна шүү дээ. Хоцорсон гээд байна аа за за.

Доржзодовын Энхтуяа гишүүн асуулт асууя.

Д.Энхтуяа: Хамгийн түрүүнд ирснээрээ эхлээд гарчихлаа. Юун түрүүнд нэр дэвшигчийг дэмжиж байгаагаа хэлээд 2 асуулт асууя. Та манай Ардчилсан намын бүлэг болон сая Байнгын хороон дээр ер нь их тодорхой зүйл бол хэлсэнгүй. Та бол сүүлийн 20 жил энэ одоо улс төрийн шийдвэр гаргах түвшинд энэ улс төрийн хүрээнд явж байгаа. Асуудлыг маш сайн углуургаар нь харж байгаа хүн гэж би харж байна. Гэтэл та бол одоо хуучин одоо Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын энэ бодлогыг үргэлжлүүлнэ ээ гээд ингээд тэгж байна.

Тэгэхээр энэ хуучин одоо огцорч байгаа Засгийн газрын үед тиймээ 2022-2023 онд Монгол Улсын ядуурлын түвшин 29 хувь буюу 3.5 сая хүнээс 915 мянган иргэн ядуурлын шугамаас доогуур амьдарч байна гэсэн ийм одоо статистикийн тоо гарсан байгаа. Үүнийг Статистикийн газраас гаргасан. Энэ 920 мянган иргэн бол сарын 420 мянган төгрөгөөс доош орлоготой гэсэн үг.

Тэгэхээр 2024 оны байдлаар энэ одоо байдал, энэ ядуурлын түвшин ямар байна вэ гэсэн статистикийг би бас дахиж судалж харлаа. Тэгэхээр одоогоор бол тодорхой түвшинд, тодорхой тогтвортой байна гэж байна. Тэгэхээр ер бол энэ сүүлийн 3 жил тиймээ энэ ядуурлын түвшин буурсангүй ээ, тогтвортой л байгаад байх юм байна. Тэгэхээр та энэ бодлогыг үргэлжлүүлнэ ээ гээд тэгж байна.

Ер нь бол Ерөнхий сайд гэдэг хүн бол ард түмэндээ эдийн засгийн эрх чөлөөг авчрах ийм л одоо үйл ажиллагаа явуулах ёстой гэж ойлгож байгаа. Ерөнхийлөгч бол оюун санааны одоо нэгдмэл байдал, мөн одоо улс орныхоо тусгаар тогтнолыг хангах ийм институт. Улсын Их Хурал бол шударга ёсыг тогтоох гээд. Таны хувьд хийх ажил бол ард түмнээ битгий талцуулаасай гэж хүсэж байна.

Дээрээс нь энэ Монгол Улсын одоо айл өрхийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх талаар ямар тодорхой зүйл хийх юм бэ? Та ажлаа авч байгаад хийнэ ээ гэж ингэж хариулаад байна. Гэтэл таныг бол би энэ дээр маш том мэдээлэлтэй, маш одоо тодорхой мэдээлэлтэй хүн ээ гэж ингэж харж байгаа учраас үүнийг би одоо танаас асууж байна.

Яах вэ эдийн засгийн эрх чөлөөний хувьд бол манай Монгол Улс дунд зэргийн эдийн засгийн эрх чөлөөтэй байна гэж олон улсын байгууллагууд гаргасан байна. Гэтэл амьдрал дээр одоо бас яг ингээд амьжиргааны түвшин сайжрахгүй байгаад та энэ дээр одоо гол анхаарлаа хандуулж ажиллаасай гэж хүсэж байна. Танд ямар одоо хатуу бодлого байна вэ гэдэг нэгдүгээр асуулт байна.

Хоёрт нь, өнгөрсөн хугацаанд манай энэ одоо төрийн 3 өндөрлөг ч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл ч гэж ярьж байна. Ард түмнийгээ бас их талцуулсан. Энэ талбай дээр гарч байгаа одоо ард иргэдийн жагсаалыг ч талцуулж байна. Одоо энэ хэвлэл мэдээлэл, телевизүүдээр ч гэсэн маш олон нэвтрүүлгүүдийг нэг цагаар цацаж ард түмнийг талцуулах ийм ажлыг хийсэн. Ерөнхий сайдын хувьд таныг битгий одоо ийм ажил хийгээсэй гэж ингэж хүсэж байна. Энэ үнэхээр...

Д.Амарбаясгалан: Гомбожавын Занданшатар нэр дэвшигч хариулт өгье.

Г.Занданшатар: Энхтуяа гишүүний асуултад хариулъя. Тэгээд би тодорхой хэлсэн Байнгын хороон дээр. Эдийн засгийн өсөлтийг хүртээмжтэй байлгах, иргэн бүрд хүргэхийг эн тэргүүний зорилтоо болгож ажиллана. Монгол Улс 2024 оны байдлаар 3 сая 544 мянга 835 хүнтэй болсон. Энэ бол хүн амын өсөлт 1.1 хувиар өссөн. Монгол хүний дундаж наслалт 71.7 болсон. 1990 оноос хойш дундаж наслалт 8.3 жилээр нэмэгдсэн. Ядуурлын индекс бол 2022 оноос хойш статистик гараагүй байгаа. Ядуурлын судалгаа 2022 оны байдлаар 27.1 хувь буюу Монгол Улсын 913 мянган иргэн ядуурлын түвшнээс доош буюу хэрэглээтэй байгаа. Ядуурал буурахгүй байхад эдийн засгийн тогтворгүй байдал, үнийн өсөлт, гадаад, дотоод нөхцөл байдалд сөрөг нөлөө үзүүлж байгаа. 2025 он гарсаар үнийн өсөлт буюу инфляцын түвшин өндөр болж байна. Импортын шинж чанартай инфляцууд нөлөөлж байна.

Ийм учраас энэ өсөлтийг эдийн засгийн өсөлтийг тэгш, шударга, хүртээмжтэй байхад нэн ялангуяа уул уурхайгаас хэт хамааралтай эдийн засгийг төрөлжүүлж, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт хийнэ. Үүний тулд татварын реформыг хэрэгжүүлнэ. Ард иргэддээ учирч байгаа татварын дарамтыг аль болох бага болгож, тансаг хэрэглээний болон хэт өндөр орлоготой иргэдэд оногдуулах татварыг нэмэгдүүлж, энэ татварын тэгш шударга нөхцөлийг хангаж, дундаж давхаргаа дэмжих ийм бодлогыг хэрэгжүүлнэ.

Бүхэлдээ хэлбэл энэ зөвхөн ядуурал биш нийт хүн амынхаа хүний хөгжлийг дэмжсэн, эрүүл мэнд боловсролыг дэмжсэн иргэддээ өгөөжтэй ийм эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх замаар эдийн засгийн одоо суурь өөрчлөлтүүдийг

хэрэгжүүлж, төр, хувийн, төрийн оролцоог хязгаарлах, ажил олгогч хувийн хэвшлийг дэмжих замаар одоо энэ эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлнэ. Халамжаас хөдөлмөрт гэдгийг хөдөлмөр хийж байгаа бүх хүнийг дэмжинэ. ТҮЦ эрхлэгчээс авхуулаад хөдөлмөр хийж байгаа иргэдээ дэмжиж байж ажилгүйдэл ядуурлыг бууруулах үндсэн бодлого хэрэгжих ёстой.

Ийм учраас энэ ажлыг хэрэгжүүлэхэд харин одоо Улсын Их Хуралтайгаа энэ талаар санаа зовж ажиллаж байгаа гишүүдийнхээ санал бодлыг сонсож, тодорхой бодлогыг би оруулж ирнэ ээ гэдгийг хэлсэн.

Д.Амарбаясгалан: Энхтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Энхтуяа: Та 2025 оны төсвийг бол бид нар маш өөдрөгөөр төсөөлсөн байгаа. Одоо бол төсөв бүрдүүлэлт маш хүндрэлтэй нөхцөл байдалд явж байна гэж ойлгож байгаа. Та төсвийн тодотгол хийх үү? Тэвчиж болох зардлуудыг тэвчих, хасах, танах ийм одоо асуудлуудыг хэзээ Улсын Их Хуралд оруулж ирэх вэ?

Хоёрт нь, түрүүний асуусан асуултаа үргэлжлүүлчихье. Ер нь бол одоо яг өнөөдрийн бодит амьдрал дээр манай Монголын ахмадууд одоо төр засгаасаа ч гэдэг юм уу, удирдагч нараасаа нэг ийм сэтгэл хайсан ийм байдалтай байна. Тэгэхээр өнөөдөр энэ олон мега төсөл хийнэ л гээд байна. Энэ төслүүдийг чинь хүний хүч хөдөлмөрөөр хийнэ.

Дээрээс нь одоо энэ туршлагатай, олон жилийн улс орондоо хөдөлмөрлөсөн боловсролтой ийм ахмад үеэ бид нар энэ мега төсөл рүүгээ энэ бүх одоо ахмад үеийнхээ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудал дээр ерөнхийдөө бол маш хойрго байна. Амьдрал дээр ингээд яваад уулзахад манай ахмадууд хөдөлмөрийн наснаасаа 55 насанд одоо тэтгэвэрт гарчихдаг, 65 наснаас тэтгэвэрт гарчихдаг тэтгэвэрт гарснаасаа хойш 20 жил хөдөлмөрийн настай байна. Тэгэхээр энэ...

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Оюунсайханы Алтангэрэл гишүүн асуулт асууя.

О.Алтангэрэл: 3 асуудал байгаа юм. Нэгдүгээрт энэ хүний эрхийн төлөв байдлын асуудал байгаа. Монгол Улсын хүний эрхийн холбоотой нөхцөл байдлууд бол олон улсын зарим нэг индексүүдээр нэлээн санаа зовоож байгаа. Ийм учраас өнгөрсөн хугацаанд Засгийн газрын зүгээс хүний эрхийн багц хуулиуд нийт 12 хуулийн төслийг өргөн барьснаас 11 нь хэлэлцэхийг дэмжигдсэн. Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль, Хэвлэлийн эрх чөлөөний хууль зэрэг хуулийн төслүүдийг өргөн мэдүүлээд одоо ингээд хэлэлцүүлгийн түвшинд зарим нэг хууль маань орж ирээд явж байна. Хүний эрхийн нөхцөл байдлыг дээшлүүлэх тал дээр ямар бодлого баримталж ажиллах вэ нэгдүгээр асуудал.

Хоёрдахь нь авлигын өнөөдрийн нөхцөл байдал бол нэлээн санаа зовоосон ийм байгаа. Хэдийгээр манай улс өнгөрсөн жил 121-114 дүгээр байр буюу 7 байр урагшилсан ч гэсэн оноо хэвээрээ байгаа. Авууштай нэг зүйл нь бас энэ өрсөлдөөнд гэж өрсөлдөх бололцоотой гэдэг энэ ангилал руугаа бид нар бас явж байгаа юм байна лээ дүгнэлт нь. Тэгэхээр энэ чиглэлд бас Засгийн газраас хэд хэдэн хуулийн төслүүдийг өргөн барьсан. Нэн ялангуяа нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар хураах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл, дагалдсан

авлигын багц хуулиудыг өргөн барьчхаад байгаа. Энэ бол ганцхан энэ Засгийн газраас барьж байгаа бодлого биш олон улсын экспертүүдийн зүгээс өгч байгаа зөвлөмжийн дагуу хийгдэж байгаа ажил. Мөн трансперенси Интернейшинешл байгууллагатай хамтарч ажиллаад Удирдах зөвлөлийн дарга бусад хүмүүстэй нь уулзаад, Монгол Улсын Засгийн газраас Авлигын эсрэг конвенцод нэмэлт оруулах төсөл санаачлаад, хэлэлцүүлэхээр ингээд явж байна. Энэ батлагдах юм бол авлигын индекс бид нар урагшлах учиртай. Дээрх хуулиуд батлагдах юм бол бас хүний эрхийн индекс бид нар урагшлах учиртай. Тэгэхээр авлигын чиглэлээр ямар бодлого баримталж ажиллана гэсэн ийм бодол байгаа вэ?

Гуравт нь, стратегийн орд газартай холбоотой асуудал. 18 жилийн дараа Монгол Улсын Их Хурлаас энэ стратегийн зарим орд газруудтай холбоотойгоор асуудлыг судалж, шийдвэрлэх дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулагдсан. Тавантолгойн орд газар нэн ялангуяа Ухаа худгийн орд газартай холбоотойгоор ажлын хэсэг гарч ажилласан. Миний бие ахалсан. Хууль зөрчсөн байна гэсэн дүгнэлтээ гаргасан. Ер нь энэ стратегийн орд газар Монголын ард түмэнд оногдох ёстой баялгийг ярихаар маш их дайралт, гүтгэлэг саад бэрхшээл учирдаг юм байна лээ. Ярьсан хүн болгонд саад учрах юм байна лээ.

Тэгэхээр эдгээр зүйлүүдийг даван туулж Монголын ард түмний Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хангаж, эзэмших ёстой баялгаас нь хувь хүртээхээр ажиллах ийм зориг байгаа юу? Стратегийн орд газартай холбоотой Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэдэд оногдох ёстой баялгийг баялгийн санд төвлөрүүлэх тал дээр ямар бодлого барьж ажиллах вэ гэсэн ийм 3 асуултад хариулт авъя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Оюунсайханы Алтангэрэл сайдын асуултад хариулъя. Нэгдүгээрт хүний эрхийн асуудал. Хүний эрхийн тэмцэлд эцсийн цэг гэж үгүй ээ гэж би боддог. Ардчилсан Үндсэн хуулиараа бид хүний эрхийг баталгаажуулсан, тодорхой заасан, хүний эрхийг хангасан улс. Ийм учраас ардчилсан Үндсэн хуульдаа үнэнч байна.

Ер нь бол төр, ард түмний итгэлцэл хүчтэй тийм ардчилсан нийгмийг төлөвшүүлэхийн үндэс нь хүний эрхийг хамгаалах явдал гэж үзнэ. Шинээр томилогдох Хууль зүйн сайдад ийм тодорхой үүрэг чиглэл өгч ажиллах болно оо. Тэр сайдыг Улсын Их Хуралтайгаа, Байнгын хороотойгоо, Хүний эрхийн дэд хороотойгоо уялдаж ажиллах ийм чиглэл болгоно. Хүн биш хууль засагладаг хүний эрхийг дээдэлдэг байх чиглэлээр мөрдөн шалгах ажиллагаа түүнд хяналт тавих, нууц мөрдөн шалгах ажиллагаанд хүний эрхийг хангах чиглэлээр Улсын Их Хурлын гишүүдээс гарах аливаа санаачилгыг дэмжиж ажиллах болно.

Ер нь хууль бол хөгжлийг дэмжигч хүний эрхийг хангахыг эхний зорилтоо болгож ажиллах ёстой гэж бодож байна. Ер нь хүний эрхийн индексээр таныг сайдаар ажиллаж байх үед бас тодорхой дэвшил гаргахаар ажиллаж байсан боловч 2023 оны байдлаар 193 орноос 93 дугаарт, 185 улсаас 97 дугаарт эрэмбэлэгдсэн байгаа нь дотор нарийвчилж үзэх юм бол хүний эрхийн асуудал дээр нөгөө шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчлахаас авхуулаад иргэдийн мэдэх эрх хүртэл одоо Үндсэн хуульд тусгагдсан хүний үндсэн суурь эрхүүдтэй холбоотой олон асуудлууд байгаа.

Энэ чиглэлээр одоо Алтангэрэл сайдын гаргах санаачилгыг дэмжиж энэ чиглэлээр бас шинэ Хууль зүйн сайдтай бас хамтарч ажиллахыг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл гишүүн тодруулж асууя.

О.Алтангэрэл. Стратегийн орд газар баялагтай холбоотой асуудал дээр тодруулж бас хариулт өгөхийг хүсье. Ер нь Занданшатар даргыг дэмжиж байгаа, бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Ажлын хандлагын хувьд одоогийн байгаа хууль эрх зүйн орчинд ч гэсэн тааруулж ажиллаж болдог зүйл байдаг шүү гэдгийг тодруулж хэлье. Тухайлах юм бол жагсаал цуглаан хийх журмын тухай хууль бол хэвэндээ байгаа. Тэгэхдээ миний бие Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллаж эхэлснээс хойш жагсаал цуглааныг албадан тараахгүй ээ, хүчээр зогсоохгүй ээ, зөвшөөрөл шаардахгүй ээ гэдэг энэ жишгийг тавиад яг энэ хугацаанд цагдаагийн байгууллага бол жагсагчидтайгаа эрх чөлөөгөө эдэлж байгаа хүмүүстэйгээ ойлголцоод өдий хүртэл ажиллаж болсон юм. Ингэхээр ажил хийхэд бас санаа санаачилга хууль эрх зүйн орчиндоо тохируулаад явах ийм санаа санаачилга их чухал байдаг юм байна лээ. Би энэ баялгийн сантай холбоотой асуудал дээр гүйцээж хариулахыг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга нэмж хариулъя.

Г.Занданшатар: 2 асуултад хариулж амжсангүй, гүйцээгээд хариулчихъя гэж бодож байна. Авлигачдын хөрөнгө хураах хуулийн талаар энэ авлигатай тэмцэх асуудлаар би тодорхой хариулъя гэж байна. Улсын Их Хурлын даргаар ажиллаж байхдаа Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулж, төрийн өндөр албан тушаалтанд хахууль авбал бүх насаар нь хорих хүртэл ялыг чангатгасан. Манай ялын хамгийн дээд хэмжээг бий болгосон. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг шинэчлэн баталсан. Энэ дотроо үндэслэлгүй хөрөнгөжих, орлогоосоо давсан зарлагыг хянах зохицуулалтыг хийж оруулсан. Эрүүгийн хуулийн ялтай одоо хахуулиар болон хууль бусаар хөрөнгөжсөн орлогыг хурааж.

Тэгэхээр үндэслэлгүй хөрөнгөжих бол зүгээр хөрөнгөө иргэний журмаар хураалгаад дуусгачихдаг иргэний хэрэг биш гэж боддог. Энэ бол одоогийн хуулиар эрүүгийн гэмт хэрэг. Гол асуудал шинэ шинэ хууль гаргахаасаа илүүтэй дабль стандарт байдлаар хууль сахиулах байгууллагууд ажиллаад, заримд нь хууль үйлчлэхгүй байгаад иргэд дургүй байгаа. Ийм учраас бид бол хууль эрх тэгш засагладаг байх дээр хуулийн байгууллагуудаа, хууль сахиулах байгууллагуудаа шаардаж шахаж ажиллах ёстой гэж үздэг.

Хөрөнгө хураах хуулийн төслийн тухайд энэ бол Засгийн газраас нэгэнт Улсын Их Хуралд өргөн баригдсан учраас одоо Улсын Их Хурлын шийдэх асуудал болсон гэж бодож байна. Стратегийн орд газруудын хувьд энэ санаачилгыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд бид оруулж Үндэсний баялгийн сангийн тухай хуульчлах үндсийг Үндсэн хуулиар тогтоосон санаачилгыг өөрөө гаргаж Норвегийн Үндсэн хуулиас эш авч оруулсан. Одоо ба ирээдүйн иргэн бүрдээ үүнийг үр өгөөжтэй, тэгш шударга, хүртээмжтэй байхад чиглүүлсэн ийм агуулгыг оруулсан. Энэнийхээ дагуу Улсын Их Хурлаас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталсан. Тийм учраас үүнийг хэрэгжүүлэх нь зөвхөн эр зориг төдийгүй бидний хүсэл мөрөөдөл учраас өнөөдөр энэ ажлаа гүйцээж хэрэгжүүлэхийн тулд Үндсэн хуульд оруулсан ард түмний, төр, ард түмний хамтын хүсэл эрмэлзлээр оруулсан энэ асуудлыг үргэлжлүүлж, бодитой

энэ үндэсний баялгийн санг бий болгож хэрэгжүүлэхийн төлөө би бас нэр дэвшиж байгаа нэг шалтгаан маань энэ гэж би хэлж үзэж байгаа юм. Тийм учраас энэ зөвхөн зориг биш хүсэл мөрөөдөл маань юм гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Буланы Бейсен гишүүн асуулт асууя.

Б.Бейсен: Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшиж байгаа Гомбожавын Занданшатарыг дэмжиж байгаа юмаа. Бас хэд хэдэн асуулт асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт эрүүл мэндийн салбартай холбоотой 2026 оны хөгжлийн хөтөлбөр дээр эрүүл мэндийн салбарт хуваарилсан төсвийн нийтдээ гуравхан хувь нь байгаа. Эрүүл мэндийн салбарын төсөв хүрэлцээ муу, нөгөө талаар эмч, эмнэлгийн ажилчдын цалин нэмэгдээгүй, хамгийн бага цалинтай. Үүнтэй холбоотой эмнэлгийн одоо боловсон хүчний дутагдалд орж байна. Эмч, сувилагч, асрагч нарын дутагдалд орж байна. Нөгөө талаар эмийн хангалт муу. Тийм учраас цалинг нь одоо 2 дахин нэмэх үү Та.

Хоёрдугаарт, Монгол эрүүл мэндийн салбар 100 жил болоход Үндэсний эмийн үйлдвэр байхгүй. Үүнийг хөгжүүлэх тал дээр анхаарах уу? Баталгаат эмийн лаборатори байхгүй. Энэ үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал. Байгаа мөртөө тоног төхөөрөмжийн дутагдалтай. Энэ тал дээр та ямар бодлого баримталж ажиллах вэ? Мөн одоо сум, багийн түвшин дэх эмийн сангийн асуудал, хөнгөлөлттэй эмээ иргэд авч чадахгүй байна. Энэ дээр ямар бодлого баримталж ажиллах вэ? Цаашдаа үүнийг байгуулах уу?

Та урьд 4 жил байхдаа бас Улсын Их Хурлаар яригдсан малын түүхий эд боловсруулах үйлдвэрийг барина гээд засгийн тухайд ярьж байсан. Тэгсэн мөртөө одоог хүртэл малын түүхий эд үнэгүйдэж хаягдаж байна арьс шир. Үүнийг хэрэгжүүлэх үү одоо бүс нутгийн хэмжээнд үүнийг барих тал дээр анхаарах уу? Нөгөө талаар энэ зарим гишүүдээс санал гарч байсан. Улаанбаатар хотыг 14 хот болгоод хуваарилах асуудал. Үүнийг би эсэргүүцэж байгаа. Энэний оронд зүгээр 21 аймгийг 21 хот болгоод хөгжүүлэх асуудал байгаа л даа үүнийг дэмжих үү та? 14 хот болгоход 14 одоо Засаг даргын тамгын газар байгуулагдана шүү дээ. Бас төсөв тэлэлт явагдана, төсөвт нөлөөлнө. Энэ тал дээр та ямар бодлого баримталж ажиллах вэ?

Дөрөв дэх асуудал энэ банкны хүү өндөр, сая бензин шатахуун нэмэгдсэнтэй холбоотой баруун аймгуудын байдал нэлээн хүндэрсэн. Бензин шатахуун 200, 100 төгрөгөөр нэмэгдсэн. Энэтэй холбоотой өргөн хэрэглээний барааны үнэ бас нэмэгдсэн байгаа. Бензин шатахууны үнэ буух уу, банкны хүү бууруулах тал дээр одоо арилжааны банкнуудтай та одоо яаж ажиллах вэ? энэ талыг асууя.

Дараагийн нэг чухал асуудал энэ баруун аймаг дотор Баян-Өлгий аймгийг одоо ингээд сонгуулийг тусдаа нэг тойрог болгоод үлдсэн. Хуучин соц нийгмийг энэ баруун 5 аймгийн дундад Ази Эстони орнууд оросууд гарах ганц зам нь байсан. Тэнд одоо үйлдвэр барих тал дээр ямар бодлого баримталж байна? Нөгөө талаар Асгатын мөнгөний орд ер нь ашиглалтад оруулах уу та? Энэ талаар асууя. Дараа нь тодруулъя.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Буланы Бейсен гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт энэ Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн асуудал, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн асуудлыг бол нийт зарцуулах төсвийг дотоодын нийт бүтээгдэхүүний 6 хувьд хүргэж, Засгийн газрын нэгдсэн төсвийн 12-т хүргэх, дотоодын нийт бүтээгдэхүүний дор хаяж нэг хувийг анхан шатны тусламж үйлчилгээнд зарцуулахыг Дэлийн эрүүл мэндийн байгууллагаас зөвлөсөн байдаг аа. Үүний үр дүнд одоо эрүүл мэндийн анхан шатын тусламж үйлчилгээг сайжруулах, ийм чиглэлийг баримтлах ийм эрүүл мэндийн бодлогыг хэлэлцэж байгаа. Ингэж үе шаттай нэмэгдүүлж байж энэ хүн амын эрүүл мэндийн асуудлыг хангах юм билээ.

Тэгэхдээ эрүүл мэндийн салбарын ажлын цалинг бол одоо 2 дахин нэмэгдүүлэх энэ жил тийм бололцоо бол байхгүй ээ гэдгийг шударга хэлэх нь зүйтэй. Үнэнээ хэлж байх ёстой бид нар. Одоо тэгээд худлаа амлаад байж би чадахгүй. Энэ төсвийн орлого чинь хэдэн төгрөгөөр тасарч байна.

Түрүүн Энхтуяа гишүүн асуусан би хариулж амжаагүй. Төсвийн тодотголыг ирэх долоо хоногт өргөн барихаар төлөвлөж байна. Төсвийн зардлыг 2.3 их наядаар бууруулахгүй бол энэ жилийн төсвийн орлого үлэмж хэмжээгээр тасарч байна. Зайлшгүй тодотгол хийхээс өөр аргагүй болчихсон. Сүүлийн 5 жилийн хугацаанд нэрлэсэн дүнгээр эрүүл мэндийн салбарын төсөв 2.4 дахин өссөн юм билээ. Тэгээд худалдан авах чадвар бүхий өсөлт нь инфляцыг тооцоогүй өсөлт нь бол 1.8 дахин өссөн. Тэгэхдээ үүнийг цалингийн дундаж хэмжээг дунджаар нэг 2.2 хувиар 2 дахин нэмэгдүүлсэн. Тэгээд энэнийхээ чиглэлийг л барьж ажиллахыг бид гол болгоно оо.

Ер нь эрүүл мэндийн салбарын талаар бол нэлээн цогц шинэчлэл өөрчлөлтүүд Эрүүл мэндийн даатгалын сангийн ковидын улмаас одоо учирсан алдагдал, нөхөн олголт энэ үүнтэй уялдсан Эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэлүүд, өөрчлөлтүүд үргэлжлэх шаардлагатай байгаа.

Энэ төсвийн тодотгол бол төсвийн хэмнэлтийн тодотгол болно. Үргүй зардлыг бид 2.3 их наядаас танахгүйгээр цаашдаа төсөв маань эдийн засгаа дэмжих биш ханшид нөлөөлөх, инфляцад нөлөөлөх хэмжээнд хүрээд байгааг одоо бид ингэж танахаас өөр аргагүй болсон ийм өөрчлөлт хийнэ. Бүтээмж, үр дүн гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний системийг эрүүл мэндийн салбартаа үргэлжлүүлэн нэвтрүүлж, энэ цалингийн бүтээмжтэй уялдсан тогтолцоог нэмэгдүүлснээр сайн эмч нар илүү өндөр цалин авдаг тэр тогтолцоог бүрдүүлж чадна гэж үзэж байгаа юм. Бүх салбарт, зөвхөн эрүүл мэндийн салбарт төдийгүй одоо нийгмийн бүх салбарт үүнийг бүтээмжтэй, гүйцэтгэлтэй уялдуулсан, үр дүнд суурилсан, ийм бүтээмжийн тэнд шинэ тогтолцоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа юм.

Эмийн үйлдвэр эмийн сангийн асуудлууд мөн ялгаагүй олон асуулт байгаа учраас товч харьцуулахгүй бол зээлийн хүүг бууруулах стратегийг бид хэрэгжүүлээд ер нь жилийн 7, 8, 6 хувь руу дөхүүлж байсан. Харамсалтай нь энэ ковид, дайнаас шалтгаалсан, гадаад нөхцөлөөс уялдсан инфляц өнөөдөр зээлийн хүүг бууруулах бололцоог орлохгүй байна. Өнөөдөр ч гэсэн Монголбанк бодлогын хүүгээ нэмэгдүүлж байгаа юм билээ.

Ийм учраас Монголбанктай хамтарч энэ мөнгөний бодлогын ажил боловч зээлийн хүүг үе шаттай бууруулах энэ бодлогыг төсвийн бодлоготойгоо уялдуулж хэрэгжүүлнэ. Бензин шатахууны асуудал бид нар бас импортын бензиний

хамааралтай улс аа. Шатахууныхаа үйлдвэрийг одоо ямар шатанд яаж явж байгааг одоо гишүүд сайн мэдэж байгаа учраас би нуршаад хэрэггүй биз ээ. Өнөөдөр дэлхий дахины геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалаад бензиний үнэ өсөж байна. Энэ маань инфляцад нөлөөлж байна.

Асгатын мөнгөний ордын асуудлыг би анх бас төрд авчирч энэ ашиглах асуудлыг хэлсэн. Энэ бас жоохон эмзэг нөхцөлд, уулын нөхцөлд яг хил дээр байрладаг ийм орд газар. Энэ талаар бол Эрдэнэс Монгол дээр танилцаад тодорхой чиглэл гарахаар танд танилцуулъя. Хот байгуулалтын хувьд бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн нэг гол шинэчлэл бол ганцхан Улаанбаатар хоттой улс болчихсон байсныг аймгийн төвийг бүгдийг нь хот болгох эрх зүйн үндсийг тавьсан. Мөн нийслэлийн дүүргүүдийг ч гэсэн хот болгож хөгжүүлэх боломжийг нээсэн. Дархан, Эрдэнэтээс авхуулаад шинэ хот суурин үүсэж хөгжих нөхцөлийг бас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар шийдсэн.

Ийм учраас одоо бид нөгөө нүүдэлчдийн хот байгуулах уламжлал туршлага дутмаг, социализмын үеийн хот байгуулалтын загвараар явж ирсэн зарчмаасаа илүү ардчилсан, чөлөөт нийгмийн үеийн, хот байгуулалтын эдийн засгийн корпорац байх хэлбэрээр өөрөө өөрийгөө авч явдаг энэ систем байх хэлбэрээр нь энэ хот байгуулалтуудыг үргэлжлүүлж нэн ялангуяа аймгийн төвүүд бүгдээрээ хот болох ёстой, Дархан, Эрдэнэтүүд улсын чанартай хот болох ёстой ийм зарчмаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулсныг та өөрөө бас оролцсон хүний хувьд сайн мэдэж байгаа. Энэ талаар бол жич ярихгүй бол хот байгуулалтын асуудал бол өөрөө том иргэншлийн, нийгмийн, эдийн засгийн реформын асуудалтай уялдана. Энэ дотроо Хархорин нь хотод шинэ төвлөрлийн бүс, шинэ суурьшлын бүс, шинэ хот байгуулах асуудал бол эн тэргүүний зорилт байх ёстой.

Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний боловсруулалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Цагаан алт” хөтөлбөр хэрэгжиж байгааг та бүхэн сайн мэдэж байгаа. Үүний тулд гадаад борлуулалт зах зээлийг нь нээж өгөх нь төрийн үүрэг байх ёстой. Нэн ялангуяа нэг улсаас хамааралтай уул уурхайн экспортыг төрөлжүүлж, диверсификац хийж, бусад улс руу ургадаг ухдаг шар алтнаас ахиж ургахгүй учраас ургадаг цагаан алт, ноос, ноолуураа боловсруулахад 1 тэрбум долларын нэмүү өртөг бүтээж, 50 мянган ажлын байр бий болгож, улс орны эдийн засгийн өсөлтөд чухал хувь нэмэр оруулах бололцоотой.

Ийм учраас гадаад зах зээл дээр нэн ялангуяа Евроазийн орнууд руу цагаан алтаа экспортлох, ургадаг цагаан алтаа бүтээгдэхүүн болгож экспортлох, нэмүү өртөг шингээх бодлого бол эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн нэг чухал чиглэл байх болно.

Ийм учраас энэ мал аж ахуйн талаар баримтлах бодлого, үйлдвэржилтийн бодлого салшгүй нэг цогц болгож түүхий эд бэлтгэлийн тогтолцоотойгоо хамт хэрэгжих ёстой. Банкнуудаар дамжуулаад “Цагаан алт” хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд хөнгөлөлттэй зээл олгож эхэлсэн байгаа, эхэлж байгаа. 300 гаруй тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдоод байгаа юм байна лээ. Үүний үр дүн, үр ашиг олголтод одоо илүү хяналт тавьж...

Д.Амарбаясгалан: Буланы Бейсен гишүүн тодруулж асууя.

Б.Бейсен: Энэ эмнэлгийн салбарын цалин нэмэгдээгүй, үнэхээр одоо цалин багатай учраас энэ ажилчид боловсон хүчин хүрэлцэхгүй байгаа. Энэ талаар анхаарч байж ажиллавал нэгд.

Хоёрдугаарт, энэ Ерөнхийлөгчийн хүнсний хувьсгалын хүрээнд эх орны хөрсөнд ургасан эрүүл хүнсний бүтээгдэхүүнээр хангах, ногоогоор хангах асуудал байгаа л даа. Хавдрын ихсэлтийн 80 хувь нь одоо хүнсний аюулгүй байдал алдагдсантай холбоотой урд хөршөөс кимикат хийхдээ бусад одоо халдваргүйжүүлэгч бодис хийхдээ хүнсний ногоо орж ирж байгаа. Эх орны хэмжээнд аймаг сумын түвшинд хүнсний ногоо тариалаад энэ Ерөнхийлөгчийн хүнсний урсгалыг одоо хэрэгжүүлэх үүднээс та ямар бодлого баримталж ажиллах вэ. Ер нь цаашдаа төсөв мөнгө хуваарилах уу?

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Хүнсний хангамж аюулгүй байдлын тухай хуулийг одоо боловсруулж байгаа юм билээ Засгийн газрын түвшинд. Үүнтэй холбоотойгоор Батчимэг гишүүн ч гэсэн тодорхой асуултыг бүлгийн хурал дээр хөндөж байсан. Энэ бол стандартын шаардлага хангасан техникийн зохицуулалт шаардлага хангасны хүнсний бүтээгдэхүүнээр хүн амаа хангах явдал бол эн тэргүүний зорилт болоод байна. Түүнийг хяналт шалгалтын асуудал үндсэндээ мэргэжлийн хяналт татан буугдсантай холбоотойгоор нэн ялангуяа хөдөө сумдад орхигдсон байна. Энэ талаар хүнсний хангамж аюулгүй байдлыг хангахад онцгой анхаарч ажиллах шаардлага гарч байгаа юм байна лээ. Энэ ч гэсэн одоо хөдөө аж ахуйн салбарт өөрчлөлт хийхэд том чиглэл болно.

Ер нь энэ хүнсний хувьсгалыг хэрэгжүүлэх чиглэлээр 1.3 их наяд төгрөгийн зээлийг арилжааны банкнуудаас олгосон тодорхой шинэ хүнсний үйлдвэрүүд байгуулагдаж байгаа ийм олон жишиг байгаа. Гагцхүү эднийхээ нэмэгдсэн өртгийн албан татвар, татварын бодлогоор дэмжих, зээлийн бодлогоор дэмжих шаардлагатай байна. Жишээлбэл ургамлын тос гэхэд би үйлдвэр дээр нь очиж үзэж байсан. НӨАТ-ынхаа татварыг дийлэхээ больчихсон.

Тэгэхээр үйлдвэрлэгчид бол НӨАТ-ын татварын дарамтад орж байдаг. Яагаад гэвэл тодорхой төлчихдөг учраас. Импортын бараа бол гааль, НӨАТ-ын татвар дээрээ...

Д.Амарбаясгалан: Буланы Бейсен гишүүн дахин тодруулж асууя.

Б.Бейсен: Энэ баруун бүс хуучин цагаан нуурын дамжлага баазаар соц нийгмийн үед одоо мал хөлөөр нь ч гаргаж байсан, мал махны экспорт явагддаг байсан. Тэнд одоо эрүүлжүүлэх бүс байгуулах үед Эстони орнууд Дундад Азийн Оросынхон одоо мал амьдаар авах асуудал хүсэлт тавьж байгаа. Тийм учраас энэ эрүүлжүүлэх бүс одоо вакцинжуулаад гаргавал гаргах боломжтой юм байна. Энэ талаар та ямар бодлого баримтлах вэ?

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Ер нь аливаа бүтээгдэхүүнийг аль болох нэмүү өртөгт шингээж экспортлох чиглэл баримтлах нь манай үйлдвэржилтийн бодлогын чиглэл байх ёстой. Амьд мал гаргахын тулд мал эмнэлгийн хорио цээрийн дэглэм гэрээг

хөрш улсуудтайгаа байгуулж, 45 хоног тодорхой хугацаанд карантилж вакцинжуулах гэхэд маш олон нөхцөл шаардлагатай. Тийм нөхцөлийг дотооддоо бүрдүүлээд байгуулж байгаа махны үйлдвэрүүд бий болсон. Энэ талаар Махны холбооны дарга манай Пүрэвдорж гишүүн сайн мэдэж байгаа. Та бас тодруулаад асуучхаарай. Ингээд ер нь махны экспортыг дэмжих нь бол Евроазийн зах зээлд эдийн гаргах энэ гэрээтэй шууд холбогдоно.

Ийм учраас энэ гадаад зах зээлээ нээх асуудал нь тэгээд малаа эрүүлжүүлэх асуудал нь тэгээд малынхаа эрүүл мэнд фермжлүүлэлтийн бодлогыг оновчтой хэрэгжүүлж, мал аж ахуйн талаар бодлого дээрээ тулгуурлаж шинэчлэл хэрэгжүүлэх шаардлагатай уялдана.

Д.Амарбаясгалан: Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Нэр дэвшигчийг бол дэмжиж байгаагаа илэрхийлье. Би нэг л зүйлийн тухай ярья. Гишүүд аяндаа бусад зүйлүүдийг асуугаад ярьж байгаа учраас. Та бол өмнө нь орон нутгаас сонгогдож ирсэн орон нутгийн ажил амьдралыг бол сайн мэдэж байгаа. Тэгээд өнөөдөр энэ орон нутаг руугаа жаахан харахгүй бол, хандахгүй бол болохгүй болсон байна шүү. Бүх юм ерөөсөө Улаанбаатар хотод хүн амынх нь тал хувь нь, талаас дээш хувь нь Улаанбаатар хотдоо ирчихсэн. Орон нутгийн зарим сумдууд бол ерөөсөө хүнгүй болсон байна шүү. Бүх л юм төвлөрөөд байдаг. Төсөв мөнгөнөөсөө өгсүүлээд бүгдийг нь одоо Улаанбаатар төсөв рүү улсын төсөв рүү татаж авдаг томилгооны эрх мэдлүүд Засгийн газар яамдууд, агентлагууд руугаа бүгдээрээ шилжчихсэн. Дээр нь орон нутгийн хөгжил гээд яриад байдаг. Дэмий л одоо цаасан дээр бичиж ярьдаг л болчихлоо. Яг бодитой хийсэн юм үнэндээ алга.

Таныг Их Хурлын дарга байхад өнгөрсөн жил хүсэж байсан хөгжлийн үзэл баримтлалыг шинэчилсэн. Үнэндээ хэрэгжсэн юм байхгүй шүү. Хэдэн зөвлөгөөнүүд хийж байгаа. Тэгээд мөрийн хөтөлбөрт тусгагдсан хэдэн ажлуудыг л өмнө, хойно нь оруулаад л, эрэмбэд нь оруулаад байгаа болохоос биш шинэ хийсэн юм байхгүй. Энэ бүсчилсэн хөгжлийнхөө үзэл баримтлалыг бүсчилсэн хөгжлөө цааш нь амилуулах ажлыг нэлээн та анхаарч ажилламаар байна. Энэ дотор мэдээж одоо 14 мега төсөл цаашаа хэрэгжээд ингээд явах байх. Энэ дотроос хамгийн түрүүнд энэ эрчим хүч, усныхаа төсөл рүү их анхаарч ажиллах нь хамгийн зүйтэй байгаа шүү. Энэ үгүй бол цаашаа дагалдах бусад төслүүд нь хэрэгжихэд их хүндрэлтэй болчихно.

Сая бас энэ зөвлөгөөнүүдийг харж байхад орон нутгийн асуудлыг бас нэлээд ярьж байсан. Бүсчилсэн хөгжлийг цааш нь амилуулахад нэлээн хэдэн хууль дээр энэ өөрчлөлт оруулахгүй бол, зайлшгүй өөрчлөлт оруулахгүй бол шаардлагагүй.

Нэгдүгээрт энэ Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохион байгуулалтын тухай хууль 2003 онд батлагдсан. Тэгээд одоо хэр нь хэвээрээ ингээд үеэ өнгөрөөгөөд нэгэнт хэрэгжээгүй 24, 25 жил болчихсон ингээд явж байгаа хууль хэвээрээ явж байгаа. Мөн одоо нэгжийн хууль одоо бусад төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиуд гээд энэ хуулиуд дээр ерөөсөө бас энэ бүстэй холбоотой, Бүсийн хөгжлийн сантай холбоотой, бүсийн удирдлага зохицуулалттай холбоотой юу ч байхгүй байгаа шүү. Энэ дээр одоо маш сайн одоо цаашдаа анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Мөн энэ орон нутгууд чинь төсөв хөрөнгө байхгүй бүгдийг нь хамаад авснаас болоод ялангуяа энэ уул уурхайтай, уул уурхайгаа ашиглуулж байгаа аймаг, сумдууд бол үнэхээр хүнд байна шүү. Ямар ч одоо эргээд үр өгөөж байхгүй. Та Цогтцэций суман дээр ажлаа авсан дараагаар нэг очоод хамгийн түрүүнд очоод нэг иргэдтэй нь уулзаад сумынх нь бодит байдлыг очоод хараарай. Үнэхээр гамшиг байгаа шүү, сургууль байхгүй, цэцэрлэг байхгүй, төрийн үйлчилгээ нь одоо тасарчихсан иргэддээ хүрэхээ байчихсан, хамаг мөнгийг нь одоо улсын төсөв рүү татаад хумиад авчихсан, эргээд хуваарилж байгаа юм байхгүй. Тэгэхээр цаашаагаа одоо энэ жишгээр бол дараагийн энэ төслөө цаашаа яв...

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Нанзадын Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Юуны өмнө энэ бодит байдалтай танилцахын тулд Цогтцэций сумд одоо бас хэрвээ томилогдох юм бол тантай хамт ажиллаж, газар дээр нь үзэж харж нөгөө 100 сонссоноос нэг удаа үз гэдэг ажил амьдралтай нь танилцаж ажиллая гэж хариулмаар байна. Үнэхээр энэ орон нутгийн хөгжил тэгш бус хөгжил, дэд бүтцийн үйлчилгээний хүртээмж муу байгаагаас зарим сум хүнгүйдэж байгаа. Хот суурин руу шилжилт эрс нэмэгдсэн. Улс маань Улаанбаатар улс болох гээд байгаа учраас л энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтүүд рүү энэ зорилго чиглэсэн. Тэгээд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг яг бодитой эрчимжүүлэхийн тулд бүсүүдийн эдийн засгийн төвүүдийг тодорхойлох шаардлагатай байгаа юм. Тэгээд эдийн засгийн төвүүддээ дэд бүтцийг нь, татварын хөнгөлөлт, зээлийн бодлого, хөрөнгө оруулалтыг чиглүүлэх шаардлагатай. Орон нутгийн онцлогт нийцсэн үйлдвэрлэл үйлчилгээг бүс бүсээр нь бий болгоод, хөдөлмөр эрхлэлтийн орчныг нь сайжруулах бодлого хэрэгжүүлэх ийм шаардлагатай гэж үздэг.

Ийм учраас нэн ялангуяа говийн бүсийн хөгжил бол уул уурхай, дэд бүтэцтэйгээ холбогдсон, нэмүү өртөг шингэсэн шинэ үйлдвэрүүдийг бий болгох, тэр дэд бүтцээ тойрсон нэн ялангуяа экологийн байгаль орчны бодлого тэр дотроо говьд нэн түрүүнд тэр говийн усны төслөө хэрэгжүүлэх асуудал бол мега төслүүдийн хамгийн чухал төслүүдийн нэг юм. Манай говиос сонгогдсон гишүүд ч гэсэн манай Ганбаатар гишүүн Гомбын Ганбаатар гишүүн бас хөндөж ярьж байсан. Энхбат гишүүн, Мөнхбат гишүүн хөндөж ярьж байсан энэ асуудлууд. Манай Мөнхбаясгалан гишүүн, манай Нанзадын Наранбаатар гишүүн нар ярьж байгаа. Үүнийг бол говиос сонгогдсон гишүүдтэйгээ говийн хөгжлийн бодлого идэж байж хамтарч тодорхойлж хэлэлцье ээ гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Наранбаатар гишүүн тодруулж асууя.

Н.Наранбаатар: Би нэг танд тоо. Өнгөрсөн 2024 онд Өмнөговь аймгаас 3.4 их наяд төгрөгийн Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Эргээд Төсвийн тухай хуульд оруулсан нэг томъёогоороо орон нутгийн хөгжлийн санд хуваарилахад 42 тэрбум төгрөг л хуваарилагдсан юм байна. Тэгээд Өмнөговь аймгаас одоо авсан АМНАТ-ийн 1.1 хувь нь болж байгаа юм. 42 тэрбум. 42 тэрбум бол өнөөдөр нэг 20 хэд, 30 км зам тавьж хүрэхгүй ийм л мөнгө. Тэгэхээр зэрэг уул уурхайн өгөөж байхгүй, уул уурхайн эргээд нөгөө орон нутгаа дэмжих ийм боломж нөхцөл өнөөдөр алга.

Тийм учраас энэ Баялгийн сангийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль одоо ажлын хэсэг томилогдоод ингээд одоо өргөн барихад бэлэн болсон. Үүнийг одоо цааш нь одоо засгаас өргөн бариад, ингээд орон нутгийг дэмжсэн энэ заалтуудыг дэмжээд ингээд явахгүй бол орон нутгийн хөгжил гэж байхгүй боллоо. Ёстой таны хэлдгээр хот улс боллоо шүү. Тийм учраас бид нар орон нутаг руугаа жаахан анхаарахгүй бол болохоо байгаад байгаа шүү гэдгийг...

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

Б.Пүрэвдорж: Өнгөрсөн нэг дэх өдөр Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган суманд иргэдтэй уулзалт хийсэн. Тэгээд өндөр настан Оюунбилэг, Даваасүрэн, Түмэнбаяр нар тэтгэврийн зээлийг одоо зүгээр байж байхад битгий оролдоод байгаач ээ. Ингээд хугацааг нь богиносгоод. Түүнээс болоод бага зээл аваад асуудалд ороод байна гэж хүсэлт тавьсан. Үүнийх нь дагуу одоо 2 дахь өдөр ирж Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн болон Мөнгөний бодлогын 3 гишүүнийг дуудаж уулзсан. Үүний дагуу одоо энэ хуучин хэвд нь болгох, хэрэглээний зээл болгох, хугацааг нь одоо уужуу тавих ийм одоо шаардлагыг тавьсан байгаа. Хэрвээ одоо энэ асуудлыг шийдвэрлэхгүй бол ахмадууд бол намайг дэмждэг. Тийм учраас ахмадуудтайгаа жагсана шүү гэсэн шаардлага тавьсан. Харин энэ одоо өнөөдөр болон маргааш мөнгөний бодлого хуралдаж байгаа. Энэ асуудал дээрээ шийдвэр гаргахгүй бол дараа дараагийн асуудлаа ярина шүү гэдгийг хэлье.

Бөөрлөж багийн иргэн Гончигсүрэнгийн Батчулуун Эрдэнэбулган сум 2024 онд самбарын хураамжаар 7.6 тэрбум төгрөг олсон. Тэрний 7.2 тэрбумыг нь юу руугаа 3 тэрбумыг нь аймаг руугаа татаж аваад дөнгөж хоёр зуун тавьхан сая төгрөгийг нь үлдээсэн. Тэгээд энэ одоо энэ бол төсвийн тухай хууль болон одоо бусад хуулиудыг зөрчиж байгаа юм. 70 хувийг нь одоо тухайн орон нутагт үлдээх ёстой. Тэгэхээр та энэ Ерөнхий сайд болох юм бол энэ одоо баялгаас олж байгаа энэ хураамжийн орлогыг тухайн орон нутагт нь үлдээх талаар хуулийн дагуу ажиллах уу гэдгийг бас асуумаар байна.

Дарханы зам бол 9 жил барьж байна. Уул нь хурдны зам боловч нэг хэдхэн км яваад хурд сааруулагчтай. Тэгээд энэ бол өнөөдрийн эрх баригчдын одоо ямар ажил хийдгийг л харуулж байгаа юм л даа. Тэгээд хурд сааруулагч нь бол ерөөсөө төрийн бүх үйл ажиллагаанд бүгдэд нь ингээд л бүх зүйлийг сааруулж байгаа юм. Та нарын байгаа байдлыг л харуулж байгаа юм. Гэтэл Эрдэнэбулган суманд ард иргэд өөрсдөө айл болгон цемент хандивлаад 1км замыг ямар ч төсвийн хөрөнгө авахгүйгээр шийдсэн байна. Дахиад энэ жил 1.3 км замыг энэ баярынхаа өмнө бүгдийг нь тавина гээд бас тэгээд баахан одоо хандив энэ тэр аваад ажлын хөлс үнэгүй хийж өгнө гээд тэр сумынхан бүгдээрээ нийлчхэж.

Тэгэхээр энэ одоо дээрээс нь өнгөрсөн жил 300 сая төгрөгөөр тэр нөгөө самрынхаа мөнгөнөөс 300 сая төгрөг аваад тэрүүгээрээ ковш, гредер янз янзын машин тэрэг худалдаж аваад, тэрүүгээрээ 17 км замыг өөрсдөө тавьсан байна. Ямар ч одоо хөрөнгө гаргахгүйгээр. Тэгээд тэр сумын дарга Засаг дарга Эрдэнэнаран, ИТХ-ын дарга Анхбаяр, орлогч дарга Баярбат, багийн дарга нар бүгдээрээ өөрсдөө тэр машинуудынхаа жолооч хийгээд, оператор хийгээд 20 хоногийн туршид өөрсдөө тэнд ажиллаад, тэр замаа тавьж байна шүү дээ.

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүнд нэг минут.

Б.Пүрэвдорж: Сэтгэлтэй хүмүүс ингэж ажилладаг юмаа. Тэгээд энэ урдуур ингээд баахан одоо нэг л их тийм эрдэм ном ярьсан, тэгсэн мөртөө хулгай хийдэг хүмүүс урдуур сууж байна. 2028 онд Ардчилсан нам ялна. Эрдэнэ нар аа, ийм сэтгэлтэй хүнийг Ардчилсан нам төв рүү татаж ажиллуулна.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Занданшатар дарга асуултад хариулъя.

Г.Занданшатар: Нэгдүгээрт, Бөхчулууны Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Манай Пүрэвдорж гишүүн бол ер нь бас ард иргэдийнхээ саналыг зөвхөн сонсоод зогсохгүй, чуулган дээр хэлээд зогсохгүй хэрэгжүүлэхийн төлөө бас ажиллана гэж итгэж байна. Тийм учраас тэтгэврийн зээлийн хугацаа нөхцөл байнга өөрчлөгдөж байгаа нь ахмадуудын санхүүгийн ачааллыг нэмэгдүүлж байгаа. Зээлийн дээд хугацааг хууль журмаар тогтмол зааж өгөх асуудлыг Монголбанк Улсын Их Хурлын харьяа байгууллага тэнд Монголбанканд бас таны асуултын харьяа чиглэгдээд тэнд Банкнуудын зээлийн гэрээний ил тод байдлыг хангах, инфляцтай уялдуулж зээлийн нөхцөлийг үе шаттай шинэчилж байх гэсэн бодлогуудыг шийдвэрлэж ингэж явж байх бололцоотой.

Хураамж ашигт малтмалын нөөц АМНАТ-ыг хэлж байна уу. Самрын хураамжийг бол одоо бас л аймагт төвлөрөөд суманд бага хүрч байгаа нь бас баялгийн шударга хуваарилалтын бас л нэг зөрчил мөн гэж бодож байна. Хураамжийн тодорхой хувийг сумандаа үлдээдэг байх, тэр нь байгаль орчноо хамгаалах, модоо ойжуулах, моджуулахад зарцуулагддаг байх ийм зохицуулалт хийх нь зүйтэй гэж бодож байна. Энэ талаар одоо хууль санаачлах эрх нь танд ч нээлттэй. Бид энэ талаар анхаарч хамтарч ажиллахад бэлэн байна.

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүн тодруулж асууя.

Б.Пүрэвдорж: Төрийн өмчийн компаниуд сүүлийн үед маш их данхайсан, олон болсон. Монгол Ардын Намын одоо сүлжээ тэнд одоо бүгдээрээ зүгээр ажил төрөлгүй сууж байгаад л сонгуулиар очоод бүгдээрээ санал өгдөг, ажилладаг ийм л болсон. Тэгэхээр одоо жишээ нь Тавантолгой төмөр зам дээр Ардчилсан намаас хяналтын менежер Тамир гэдэг залуу очсон. Тэнд очоод үл бүтэх бүх зүйлийг нь уудалж гаргасан, шүгэл үлээсэн. Гэтэл нөгөө залуугийн маань одоо бүтцийн өөрчлөлтөөр халаад хаячхаж. Үгүй ээ одоо энэ Ардчилсан намаас очсон хүмүүс тэнд одоо энэ идэж ууж байгаа тэр бүх зүйлийг л одоо хулгай зэлгийг бүгдийг нь байхгүй болгохын төлөө л явж байгаа. Тэгээд ингээд өөрсдөө ингээд хяналт тавих тэр хүмүүсийг бүгдийг нь халчхаад өөрсдөө сайхан идэж уух ийм замыг засаж байгаа юм байна. Тийм учраас энэ одоо төрийн өмчийн аж ахуйн нэгжийгээ багасгах юм уу, хүмүүсийг нь багасгах юм уу энэ тал дээр тодорхой хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Ер нь инфляц бол ард иргэдийн амьжиргаанд нөлөөлж байгаа хамгийн том хүчин зүйл. Улсын хэмжээнд инфляц их байхад Ховд аймагт улсын дунджаар 8.3 байхад Ховд аймагт 13.8 хувь өндөр байгаад байгаа юм. Тэр нь одоо махны үнэ бас л энэ орон нутгийн ченж тогтолцоотой холбоотой. Энэ дээр бас Ховд аймаг энэ ялгаатай байгаа байдлыг орон нутгийн ийм түвшиндээ анхаарч ажиллахад ч гэсэн манай гишүүд анхаарч тал бүрдээ л анхаарч ажилламаар юм байна лээ.

Ер нь энэ төрийн өмчит 129 компанид 12.9 мянган хүн ажиллаж байна. Энэ хүмүүсийн ТӨК-иудын аж ахуйн үр ашгийг сайжруулах, төрийн өмчийн реформ хийж, ТӨК-иудын тоог 2 дахин бууруулах чиглэлээр хувьчлалыг зохион байгуулах. Гэрээний үндсэн дээр ашиглах, зарим ашиггүйг нь татан буулгах, хувийн хэвшилд ажил үүргийг нь шилжүүлэх ийм цогц ТӨК-ийн реформыг сайжруулах замаар төрийн хэт оролцоог хязгаарлах ажлын бодлогыг хэрэгжүүлнэ ээ гэж бодож байна. Таны саналууд бас зүйтэй олон саналуудыг бид тодорхой.

Д.Амарбаясгалан: Жадамбаагийн Баясгалан гишүүн асуулт асууя.

Ж.Баясгалан: Бүгдээрэнд нь өдрийн мэнд хүргэе. Тэгээд таны удирдах Засгийн газар бол дарга төвтэй биш хууль дээдэлдэг Засгийн газар байгаасай гэж хүсэж байна. Нэгдүгээрт 2 асуулт асууя.

Монгол улсад 112 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй гэдэг бол тэр гэр бүл тэр чигээрээ хөгжлийн бэрхшээлтэй гэр бүл гэсэн үг. Тэгэхээр 112 мянган гэр бүл гэдэг бол Монгол Улсын 900 мянган өрхийн 13 хувь. Нийт өрхийн 13 хувь. Тэгэхээр ардчилсан улсын хамгийн эрхэм зүйл бол хүн. Тэр тусмаа хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг дээдэлж байгаа төр засаг бол хамгийн энэрэнгүй одоо хамгийн сайн засаг байна гэж бид нар ойлгож байна. Тэгэхээр та эдгээр өрхийн төлөө яг юу хийх бодолтой байгаа вэ нэгдүгээрт.

Хоёрдугаарт, одоогийн таны удирдаж байгаа Ерөнхийлөгчийн тамгын газар хэчнээн хүний орон тоотой вэ? Энд хөгжлийн бэрхшээлтэй хэдэн ажилтан ажиллаж байгаа вэ? Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлд 25-аас дээш ажиллагсадтай бол 25 хүн тутмын нэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна гэж заасан байгаа. Тэгэхээр одоо Ерөнхийлөгчийн Тамгын газар үүнийгээ биелүүлж байгаа юу? энэ хоёр асуулт.

Тэгээд дээр нь 3 дахь нь та, танай засаг, одоо таны байгуулсан кабинет энэ хуулийг биелүүлээсэй гэж бас шаардаж байна, хүсэж байна. Одоо яагаад гэвэл өнгөрсөн засгаас бол хамгийн их асуусан юм тэр. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих энэ асуудал дээр маш хойрго хандаж байсан. Тэгэхээр энэ дээр ерөөсөө идэвх гаргаад манлайлаад л ажиллаад өгөөрэй. 113 мянган өрх танаас үүнийг хүсэж байгаа.

Тэгээд төрийн албыг цомхон болгож одоо энэ ашиггүй ажиллаж байгаа маш олон ТӨК-иуд байгаа. Эд нарыг одоо цэгцэлснээрээ төрд бол маш их хэмнэлт гарна. Тэгэхээр тэр хэмнэлтийн мөнгөнөөс ер нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэхлээр л дандаа хөдөлмөр эрхлэлт биш халамж юм шиг ойлгодог. Тэгэхээр тэр иргэд маань халамж биш ерөөсөө хөдөлмөр эрхлэхийг хүсэж байгаа. Тэгэхээр энэ хөдөлмөр эрхлэлт талд нь.

Хоёрдугаарт нь, хүүхдүүдийн хөгжих одоо өөрсдийгөө зөв боловсон ирээдүйд иргэн болгож бэлтгэх тэр төвүүдийг барих тал дээр бас энэ хэмнэлтээсээ оруулж өгөөсэй гэж бодож байна. Тэгээд эцэст нь хэлэхэд бол таныг бол дэмжиж байгаа 100 хувь. Яагаад гэвэл бас төрийн ажил одоо олон жил хийсэн. Хоёрдугаарт, төрийн ажил удаан зогсох ёсгүй. Маш хурдан үргэлжлүүлээд аваад яваасай гэж хүсэж байна. Ингээд энэ 3 асуултад нь хариулаад өгөөрэй.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Жадамбаагийн Баясгалан гишүүний асуултад хариулъя. Жадамбаагийн Баясгалан гишүүн бас Ерөнхийлөгчийн Тамгын газарт бас харьяалагдаж ажиллаж байсан хүний хувьд энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар, тэдний оролцоог дэмжих чиглэлээр бас хамтран ажиллаж та бүхнийхээ санал санаачилгыг дэмжиж ажиллах болно. Манай Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн манлайллыг дэмжихийн тулд төрийн байгууллагуудад, орон нутгийн удирдлагуудад тэдний төлөөллийг нэмэгдүүлэх энэ зарчмыг баримтална.

Манай энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн зарчим ч гэсэн энэ рүү чиглэсэн. Саранчулуун гишүүн байна, Баясгалан гишүүн байна. Та бүхэнтэй хамтраад одоо хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн оролцоог дэмжих, зөвхөн одоо дэмжих төдийгүй манлайлах, сургах, мөн одоо нийгмийн асуудлыг нь шийдэх тэрэнд тохирсон дэд бүтэц, сургууль, соёл, аж ахуйн үйлдвэрийн газрууд бий болгох чиглэлээр ийм цогц бодлогыг хэрэгжүүлж, дэд бүтэц нийгмийн үйлчилгээний стандартыг тогтоох, ажлын байрны квотын бодлогыг хэрэгжүүлэх, боловсрол, эрүүл мэндийн хүртээмжийг нь нэмэгдүүлэх, төрийн бүх бодлогод тэдний хэрэгцээ оролцоог заавал тусгах чиглэлээр ажиллах болно. Нийтдээ 107 мянга 904 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бол албан ёсоор бүртгэлтэй байгаа. Энэ 107 мянган иргэдээ төлөөлж байгаа одоо Баясгалан гишүүн, Саранчулуун гээд одоо олон гишүүдтэйгээ хамтраад энэ талаар бодлогоо шинэчлэх чиглэлээр, стандартыг шинэчлэх чиглэлээр, тэдний оролцоог дэмжих чиглэлээр одоо хамтран ажиллаж та бүхний саналыг сонсож ажиллах болно гэдгийг онцолж тэмдэглэе.

Д.Амарбаясгалан: Баясгалан гишүүн тодруулж асууя.

Ж.Баясгалан: Баярлалаа. Тэгэхээр одоо яг байгаа би нөгөө таны ажиллаж байгаа Ерөнхийлөгчийн тамгын газрын орон тооны хувьд асуусан. Тэрийг хариулаад өгөөрэй. Тэгээд ер нь бол танд дахиад сануулахад энэ 112 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн маань ерөөсөө 13-хан хувь нь орон сууцанд амьдардаг. Үлдсэн 87 хувь нь гэр хороолол болон орон нутаг, сум, аймаг, багт амьдардаг.

Тэгэхээр эд нарын одоо нөгөө орон сууцны асуудал дээр бас та маш онцгой анхаараарай гэдэг дээр санал хэлье. Тэгээд мэдээж дэмжигдээд гараад ирэх байх. Тэр үед нь яг энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал дээр бол хамтраад одоо түрээд дэмжээд явна. Тэгээд саяын асуултад хариулаад өгөхгүй юу та.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Сүүлээс нь эхлээд хариулчихъя Жадамбаагийн Баясгалан гишүүний асуултад. Ер нь том утгаараа бас би нэг миний нэг банканд ажиллаж байсан банкирын хувьд нэг хүсэл мөрөөдөл бол энэ Солонгос, Японы загвараар орон сууцжуулалтын банкныг байгуулах Хаузинг банк гэж байгаа энэ банкныг байгуулах, энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ч одоо нөгөө affordable housing гэдэг нөгөө орон сууцжуулах, гэр хорооллыг орон сууцжуулах энэ бодлогыг хэрэгжүүлж ирсэн, Солонгосын хөгжилд хүргэсэн нэг том нууцуудын нэг гэж үздэг. Ийм орон сууцжуулалтын банк байгуулахыг Төрийн банкныг тийш нь хуваах ч юм уу ийм бодлого хэрэгжүүлэхийг бол боддог.

Тийм учраас орон сууцжуулалтын банк байгуулагдах юм бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ бас хөдөлмөр эрхлэлттэй нь яаж уялдуулж дэмжих вэ, ийм цогц бодлого хэрэгжүүлэх бололцоотой. Ер нь хөгжлийн бэрхшээлтэй 12 мянган хүүхэд байдгийн 50 хувь нь бол сургуульд хамрагддаг юм байна лээ. Тэгэхээр...

Д.Амарбаясгалан: Занданшатар даргын микрофоныг өгье. Гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Тэгээд бусад бодлого Ерөнхийлөгчийн Тамгын газартай яаж хамтрах ажил орон тоо, төсвийн талаар танд жич мэдээллийг жич цаасаар хүргүүлье.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууя.

Ц.Туваан: Бүгдээрэнд нь энэ өдрийн мэнд хүргэе ээ. Өнөөдөр дэлхий нийтийн нөхцөл байдал маш хүнд байна. Дайнтай, худалдааны дайнтай, тарифын дайнтай гээд маш их нөхцөл байдал хүнд байна. Тэгэхээр энэ үед бас манай улсын хувьд бол тогтвортой байдал нягт эвтэй байдал бол маш чухал байгаа. Тэгэхээр үүнийг одоо бас удирдлага болгож ажиллана гэж ингэж үгэнд чинь гарч байна.

Дээрээс нь Монгол төр бол өн удаан, урт удаан хугацааны залгамж чанартай ийм одоо төр. Тэгэхээр Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийн одоо хэрэгжүүлж ирсэн бодлогыг төрийн залгамж ч халаа, залгамж чанарын хүрээнд бас үргэлжлүүлэн авч явна гэдэг үгийг бас сонслоо. Энэ мөрийн хөтөлбөрийн амин сүнс нь бол 14 мега төсөл байсан. 14 мега төслийг төсөл бол салбар салбарын яамдууд дээр байсан. Манай яаман дээр бол Гашуунсухайт, Ганцмод, Орано, газрын тос боловсруулах үйлдвэр, зэс боловсруулах үйлдвэр, гангийн цогцолбор, нүүрс, хими, кокс хими, алт цэвэршүүлэх гээд эдгээр мега төслүүд бол манай салбар дээр байсан. Энэ төслүүдийг бол одоо 4-ийг нь яг эхлэх шатанд нь гэрээ хэлэлцээг нь хийгээд ингээд эцэслэсэн байгаа. Цаашдаа энэ одоо бодлогууд бол бас таныг залгамжлуулаад үргэлжлээд явна аа гэдэгт бол итгэлтэй байгаа.

Мөн одоо улсын эдийн засаг, санхүүгийн асуудал ч гэсэн хүнд байгаа. Тэгэхээр таны амнаас бас төсвийн тодотгол гэдэг үг гарч байна. Тэгэхээр бид бүхэн бол энэ одоо уул уурхайн бүтээгдэхүүнийхээ экспортын орлогоор амьдардаг ийм улс. Тэгэхээр энэ салбарт бас нэлээн одоо ачаа ноогдож байгаа. Тэгэхээр бид бүхэн гадаадад уул уурхайн бүтээгдэхүүний үнэ одоо бас буурсан байна, бага байна. Энэ тарифын дайн, худалдааны дайнтай холбоотой.

Тэгэхээр бид нар айлаас ирэхээр авдраа ух гэж өөрт байгаа энэ алтныхаа асуудлыг бас бодлого болгоод явж байсан. Үүнийг цааш нь үргэлжлүүлэх үү? Алт-3 аян алтны үндсэн ба шороон ордын асуудал. Дээрээс нь энэ газрын ховор элемент гээд дэлхий дээр маш хурцаар яригдаж байгаа энэ бодлогуудыг та үргэлжлүүлж явах уу? Дээрээс нь бид нар энэ одоо ачааны хүндийг үүрч, орлогын эхийг авчирч байсан, бүрдүүлж байсан уул уурхайн салбарынхандаа бол талархах ёстой. Одоо тэр хүмүүсийг энэ салбарынхныг бодлогоор дэмжиж авч явж, улсынхаа эдийн засагт бас тодорхой орлогыг бүрдүүлэх ёстой.

Тэгэхээр уул уурхайн салбарын нийт ажилчид, уурхайчдадаа бас энэ улс орныхоо өмнө байгуулсан энэ том гавьяаных нь төлөө бас талархал илэрхийлэх нь зүйтэй гэж ингэж бодож байна. Даргаа нэг минутаа авчихъя.

Д.Амарбаясгалан: Нэг минут нэмье.

Ц.Туваан: Бид нарын үндсэн зорилго ерөөсөө л тодорхой байсан. Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 10 мянган ам.доллар болгох ийм л зорилготой, ийм л сэтгэл зүйтэй, ийм л сэтгэл гаргаж ажиллаж байсан. Тэгэхээр энэ бодлого маань бас цаашаа үргэлжлээсэй гэж бодож байна. Дээр нь Ардчилсан намын одоо үед, үед гээд хэлчихье дээ АН-ынхны үед бас Ардчилсан намын сор болсон чадвартай боловсон хүчнүүд энэ салбарууд дээр орж ирж ажилласан. Бас яаж ажилладгаа тэр хэд маань харуулсан, харуулаад явж байгаа. Тэгэхээр энд байгаа энэ цөөхөн одоо нийт төрийн албан хаагчидтай дүнтэй харьцуулахад бол цөөхөн тооны алба одоо хүмүүст томилгоо хийгдсэн байгаа. Тэгэхээр энэ хүмүүсийн чадварыг нь бас ашиглаж, үргэлжлүүлэн ажиллах тал дээр бас та ямар бодлого барьж ажиллах вэ гэдэг ийм асуултаар үгээ дуусгая.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүний асуултад хариулъя. Ер нь дэлхийн геополитикийн тогтворгүй байдал нэмэгдэж байгаа энэ үед тэгээд энэ нь худалдааны дайн, тарифын дайн хэлбэрээр үргэлжилж байгаа энэ үед бол Монгол Улсын засаглалын тогтвортой байдал, бодлогын тогтвортой байдал залгамж чанар туйлын чухал аа. Тэгээд нэг Засгийн газар гараад л өмнөх Засгийн газрынхаа хийсэн юмыг үгүйсгээд байж болохгүй ээ. Нэн ялангуяа Засгийн газар бол энэ 14 мега төслийг улс төрийн циклээс ангид энэ чинь урт хугацаанд хэрэгжих төслүүд учраас бодлогын залгамж халааг эрх зүйн болон институтийн баталгаатай болох замаар тогтвортой хэрэгжүүлэх үндсийг бүрдүүлэх ёстой гэж үздэг.

Гашуунсухайт, Ганцмодны боомтын дэд бүтцийг олон улсын стандартын дагуу өргөтгөөд, хил гаалийн нэгдсэн удирдлага болон цахим шилжилтийг бүрэн нэвтрүүлэх замаар илүү үр дүнтэй хэрэгжүүлэх бололцоотой. Нүүрс химийн болон одоо алт боловсруулах үйлдвэрүүдийг дотоодын хөрөнгө оруулалт, олон улсын хамтын ажиллагаанд тулгуурлан хөгжүүлэх шаардлагатай. Ерөөсөө л ган, зэс үйлдвэрлэж байж улс хөгжсөн Японы, Солонгосын бүх улс бол одоо бүх юмны түүхий эд болсон төмөргүйгээр улс хөгжихгүй, зэс орчин үеийн критикал металл боллоо цахилгааны. Энэ хоёр бол тэргүүн зэргийн зорилт байх ёстой. Тэгэхдээ бидний бодит ажил бас зөрүүтэй байгаа юм. Алт-3 дахь хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Алт худалдан авах тогтолцоог илүү уян хатан болгож хэрэгжүүлэх шаардлагатай. Одоо оны эхний одоо хүртэл 3.4-хөн тонн алт Монголбанканд тушаагдсан байгаа нь өнгөрсөн онуудтай харьцуулахад чамлалттай үзүүлэлт ээ. Ингэж Төв банкныхаа алтны нөөцийг нэмэгдүүлэх замаар валютын нөөцийг нэмэгдүүлэх нь бол Монгол төгрөгийн худалдан авах чадварыг тогтвортой байлгах, инфляцаас ангид байх гол нөхцөлт болно оо.

Ийм учраас нийт олборлолтын 40-50 хувийг албан ёсны худалдан авалтад зориулж, жижиг бичил уурхайчдын эрх зүйн орчныг сайжруулах, татварын уян хатны нөхцөлөөр хангах нь бол алтны нийлүүлэлтийг тогтвортой байлгахад чухал нөлөө үзүүлнэ гэж үздэг. Алт-3 хөтөлбөрийг зөв хэрэгжүүлбэл валютын орлого нэмэгдэнэ. Уул уурхайн салбарын ажилчдыг ер нь тогтвортой байдлыг хангаж ажиллана.

Гэхдээ энэ мэдээж ур чадвар, чадвартай хүн одоо ажлаа хийж чадаж байгаа хүн болгон ажиллах ёстой.

Ер нь бас уул уурхайн салбарын аюулгүй байдал, эрүүл мэндийн хамгаалалтыг олон улсын стандартад нийцүүлж сайжруулах шаардлагатай. Мэргэжлийн сургалт дахин сургалтын тогтолцоог бэхжүүлэх, орон нутгийн ажилчдын оролцоог дэмжиж, тэднийг сургалтад хамруулж байх, тэдний оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж үздэг. Хөдөлмөрийн гэрээг ил тод шударга болгох асуудлыг иргэдээс, орон нутгийн иргэдээс их тавьдаг. Тэдний орон сууц, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын багц дэмжлэгийг хуульчлан баталгаажуулах шаардлагатай, нэн ялангуяа говийн бүсэд. Ийм учраас энэ бол ингээд нэг цогц бодлого болох байх.

Тийм учраас дотоодын нийт бүтээгдэхүүнийг ойрын үед нэмэгдүүлж энэ хүндрэлийг даван туулахын тулд уул уурхайн салбар бол зонхилох үүрэгтэй, энэ салбарын бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой байдлыг хангах бол тэргүүний зорилт байх ёстой гэдэг таны бодлоготой санал нэг байна.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан гишүүн тодруулж асууя.

Ц.Туваан: Баярлалаа бас одоо хэлсэн асуултууддаа тодорхой хариулт авлаа. Тэгээд залгамж чанарыг барьж ажиллана гэдэг үгийг бас сонсож авлаа. Таны үгэнд бас гарчихлаа. Энэ бичил уурхайчид гээд нэг одоо ад үзэгдээд явдаг тиймээ. Зарим үед бас муухайгаар хэлэгддэг ийм хүмүүс байдаг аа. Тэгээд энэ бас таны уугуул нутагт ч их бий, төвийн бүсэд ч их бий. Тэгэхээр энэ хүмүүс дээр бас ажиллуулах ялгаагүй Монгол Улсын иргэд тиймээ. Хуулийн дагуу ажиллуулах энэ бодлогыг бас үргэлжлүүлээд авч явна аа гэдэг үг гарлаа. Тэгээд энэ үгэнд чинь бас талархаж байна.

Д.Амарбаясгалан: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшигч Гомбожавын Занданшатар таныг дэмжиж байгаагаа илэрхийлж байна. 1990 он гарснаас хойш бид нар эрх чөлөө гэж маш олон зүйл ярьж өнөөдрийг хүртэл 35 жил явж ирлээ. Яг үнэндээ эрх чөлөөний шинэчлэл Монгол Улсад хэдий түвшинд хийгдэж байгаа вэ гэдгээ бид нар бас эргэж нэг дүгнэх цаг хугацаа болсон юм болов уу гэж ойлгож байгаа. Иргэдийн маань хувьд, ард түмний маань хувьд бас хүлээлт их өндөр байна. Тэгээд энэ ард түмний хүлээлтэд нийцсэн, дээрээс нь таны өөрийн саяын хэлсэнчлэн хэлдэг биш хийдэг үнэн Ерөнхий сайд байна аа гэж хэлж байгаа явдалд бас туйлын талархалтай байна.

Энэ хөгжлийн үндсэн чиглэлүүдийг бид нар их сайн бодож, харж хийх ёстой болов уу гэж бодож байгаа. Нэгдүгээрт бид нар эдийн засгийн эрх чөлөөтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна. Өнөөдөр бид 14 мега төсөл энэ эдийн засгийн эрх чөлөөтэй л холбоотой асуудал. Нөгөө талдаа бүсчилсэн хөгжилтэй холбоотой асуудал бол мөн адилхан эдийн засгийн эрх чөлөөтэй холбоотой. Бид нар аж ахуйн нэгжүүдээ дэмжих бодлогыг зайлшгүй явуулах шаардлагатай. Хөдөө орон нутагт ажлын байр бий болгох шаардлага байна. Үүний тулд бид нар татвар төлөгч бизнес эрхлэгч иргэн аж ахуйн нэгжүүдийг дэмжих томоохон реформын шинжтэй үйл ажиллагааг зайлшгүй хийх шаардлагатай болжээ. Эдийн засаг хүндэрч байна. Хамгийн түрүүнд бизнес эрхлэгчдийгээ түшээсэй гэж хүсэж байгаа.

Бид нар татвар нийгмийн даатгалын шимтгэлийн реформыг та хийнэ ээ гэдгээ хэллээ. Энэнд маш талархалтай байна. Аж ахуйн нэгжүүд маань маш сайнаар хүлээж авах болов уу гэж бодож байгаа. Энэ нүсэр бүтэцтэй холбоотой асуудлууд байна. Өнөөдөр хувийн хэвшил рүүгээ төрийн үйл ажиллагаа тодорхой хэмжээний чиг үүргийнх нь дагуу хувийн хэвшлийг дэмжих хэлбэр дээр явж байж улс орон хөгждөг болохоос биш хувийн хэвшлийнхээ хийж байгаа бизнес үйл ажиллагааг төрийн өмчит компани, Үндэсний хороо, зөвлөл, комисс гэж байгуулах нэрээр эсвэл аливаа нэг агентлаг байгуулах нэрээр төр булааж авдаг энэ хэлбэрээс татгалзаасай гэж хүсэж байгаа юм. Энэ бол нэг талдаа төрийн нүсэр бүтцийг ялангуяа цэгцлээсэй. Энэ данхайсан төрийн чөлөөлөлтийн хийгээсэй гэдэг ийм хүсэл эрмэлзэл аж ахуйн нэгжүүдийн хувьд бол ний нуугүй хэлэхэд байна.

Бид нар энэ яам, агентлаг, үндэсний хороонуудыг бүгдийг нь цэгцлэх шаардлагатай байна. Давхардсан бүтэцтэй холбогдуулаад чиг үүргийн давхардлаас улбаатайгаар үүсэж байгаа үл ойлгогдох асуудлаас улбаатайгаар энэ улс эх орны хөгжил гацаж байгаа зүйлүүд байна. Нөгөө талдаа бид нар анхдагч хэрэглээний эрх чөлөөг бид хийх шаардлагатай байна. Эрчим хүчний эрх чөлөө, шинэчлэл, эрчим хүч өнөөдөр ямар асуудлууд үүсэж байгаа билээ үүнийгээ бид нар бодох ёстой байх. Эрүүл мэнд, ногоон хөгжлийн асуудлууд, баялгийн хуваарилалтууд гээд олон асуудлуудыг зайлшгүй бид нар бас шийдвэрлэх шаардлагатай ийм түүхэн цаг хугацаанд энэ шинэ Засгийн газар байгуулагдах болж байх шиг байна.

Тэгээд төсвийн тодотголыг та ирэх долоо хоногт оруулж ирнэ ээ гэсэн учраас хийгээд явна аа гэдэгт бүрэн дүүрэн итгэлтэй байна. Танд амжилт хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Ерөнхий сайдад нэр дэвшигч орж ирж байна. Бид нар бас хэдэн ч Ерөнхий сайдын нүүр үзээд л бас Улсын Их Хурал дээр ингээд хэлэлцүүлэг болж байдаг. Яг нэр дэвшиж байгаа үедээ бүгдээрээ л их гоё, гоё, сайхан сайхан зүйлүүдийг бүгдээрээ л ярьдаг. Жишээ нь одоо Ардчилсан намын төлөөлөл жижүүрийн нэг байнгын хэдэн үгүүдтэй. Тэр маань дандаа эсрэг тийш нь явж байдаг. Тэр нь төсвөө багасгая л даа. Наадхыг чинь багасгачихвал иргэдэд иргэдийн бизнес эрхлэх орон зай нэмэгдэх гээд байна шүү дээ. Төсвөө тэлээд байхлаар чинь мөнгөний нийлүүлэлт чинь ихсээд инфляц бодит орлого чинь буураад байна шүү дээ. Төрийн өмчит компаниа багасгая л даа. Тэгэхгүй болохоор авлига чинь ихсээд байна шүү дээ гээд л бид нар одоо баахан л зүйл ярьдаг, яг үнэндээ яг эсрэгээрээ л хийгддэг.

Тэгэхээр би бараг одоо энэ удаад бүүр үүнийг эсрэгээр нь хэлмээр санагдаж байгаа юм. Үгүй ээ энэ тэр төрийн өмчит компаниа бараг бүгдийг нь төрдөө аваад, улсын төсвөө улам томруулаад одоо өөр хийх ёстой зүйлүүд юу байна зөвшөөрөл лицензүүдийг одоо бүгдийг нь асар их болгоод, авлигалын үндэс суурийг нь одоо хурдан бий болгоод ер нь аливаа юм тэгээд нэг ийм очих цэгтэй хурдан очвол дахиад тэндээс нэг өөдлөг дэвшдэг ёроолоосоо дээшээ өндийх байлгүй дээ. Бараг одоо арга ядвал нэг эсрэгээр нь хүртэл одоо хэлмээр. Бараг ингэж хоёрын хооронд явж байснаар бол эсрэгээр нь хийчихвэл бараг энэ улс орны холын хувь заяанд илүү хэрэгтэй. Зөвхөн энэ засаг захиргаа гэхэд явсаар явсаар бид нар бүгдээрээ гоё

сайхан зүйл ярьдаг, явсаар явсаар байгаад эцэст нь Улаанбаатар төвтэй Улаанбаатараас бүгдийг шийддэг. Энэ эрх мэдлийн төвлөрлийг дагаад автомашины төвлөрөл, хүний төвлөрөл, түгжрэл, утаа бүх нийгмийн асуудлууд нь хуримтлагдчихсан. Гэтэл бид нар ярих бүхэндээ яг эсрэгээр нь гоё л ярьдаг.

Тэгэхээр үүнийг яг энэ дээр одоо бид нөхцөл байдлаа хэдүүлээ одоо яаж үнэлэх юм бэ. Яг бодитой яаж алхам хийх юм бэ гэдэг л ийм зүйл байна. Тэр гадна, дотнын хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулалт гэдэг зүйл явсаар байгаад Оюутолгойг хасвал одоо гаднын хөрөнгө оруулалт гэдэг зүйл байхгүй болж хувирлаа. Дэлхий нийттэй холбогддог харилцдаг тэр харилцаа маань хаачих юм. Одоо тэр валютын ханш энэ олон олон зүйлүүд маань үнэндээ буруу тал руугаа ингээд явчихлаа. Тэгээд шинэ Ерөнхий сайдаас магадгүй томилогдох байх. Шинэ Ерөнхий сайдаас эдгээр дээр та нэг чин сэтгэлийн чинь яг бодит магадгүй бид нар дараагийн төсөв өргөн барихаас эхлээд л энэ бүгдийг бүгд маргааш, нөгөөдөрхөнөөс эхлээд бодит нөхцөл байдал харагдаж эхэлнэ. Энэ дээр та нэг яг нэг биелж болох бодитой зүйлээсээ ганц нэгийг нь бас хэлээч. Одоо үнэндээ бол хэчнээн гоё сайхан зүйл бид тал талд ярьдаг. Яг эсрэгээр нь яваад л энэ хүрсэн. Саяын зүйлүүд, одоо бүгдээрээ энэ дотор нэг ч зүйл татвар нэмэхгүй л гэдэг татвар яг иргэд дээр очих татвар тас эсрэгээрээ нэмэгдэж л байдаг.

Тэгэхээр энэ бүх нөхцөл байдлууд дээр та яг хийж чадах зүйлээсээ энэ олон зүйлүүдийг бүгдийг нь хийнэ гэж одоо худлаа. Тэгэхээр энэ дотор чадах зүйл юу байна, ач холбогдлын эрэмбэ гээд...

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Улс төрийн гадаад, дотоод орчин нөхцөл хүнд байгааг хүн болгон сайн мэдэж байгаа. Бид нар зөвхөн яриад зогсохгүй Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс авхуулаад зөндөө асуудлыг хамтраад шийдэж явж байгааг манай Цогтгэрэл гишүүн бид сайн мэдэж байгаа. Гэхдээ би нэг л зарчмыг баримтална гэдгээ онцолж хэлмээр байна. Үнэн л байхыг эрхэмлэнэ. Би ер нь үнэн л байхыг боддог, байгаа маань ч тэр, алдаа маань ч гэсэн тэр ил тод, худал хуурмагаар ховлох бучилж худлаа ярихыг хүсэхгүй.

Ийм учраас би маш тодорхой нэг зүйл хэлж байгаа нь бол ойрын хугацаанд амжуулаад ирэх долоо хоногт багтвал тоонууд хэцүү байна. Төсвийн тодотголыг өргөн барина, хэмнэлтийн тодотгол хийнэ. Эндээс төрийн оролцоо, төсвийн хэмнэлтийн бодлого маань тодорхой харагдана. Татварын бодлогыг ил тод, шударга, өрсөлдөөнтэй, одоо тэгш шударга байх зарчимд нь хэлэлцүүлж өөрчилнө. Татварын бааз суурийг өргөтгөж, нэг татвар төлдөггүй НӨАТ гээд одоо зарим нь төлдөггүй, зарим нь төлдөг энэ татваруудыг нийтээрээ хамрагдсан татварын бааз суурийг өргөжүүлсэн бодлогыг шинэчилнэ. Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлнэ.

Энэ бүх бодлого маань бол эхний ээлжид хэрэгжих ийм бодитой алхмууд байх болно гэдэгт эргэлзэх хэрэггүй. Харин ч энэний баталгаа нь таныг би бас Эдийн засгийн бодлогын зөвлөлд Ардчилсан намын бүлгийн дарга, Ардын намын бүлгийн дарга ер нь намуудын төлөөлөл ороод Ерөнхий сайдын дэргэд төр, хувийн хэвшлийн одоо яриа хэлэлцээг өрнүүлдэг, намуудын төлөөлөлтэй ийм зөвлөл байгуулахыг эрхэмлэж байна. Тэр дотроо эдийн засгийн эрх чөлөөг нэмэгдүүлэхийн тулд зөвшөөрлийн тоог цөөлнө. Зөвшөөрлийн тухай хууль батлагдсан байгаа

бидний үед батлагдсан, та ч оролцсон. Энэ Зөвшөөрлийн тухай хуулийг одоо зургаа дахин багасгаж одоо дэлгүүр байгуулахад л 24 зөвшөөрөл авдаг байсныг 4, 5 зөвшөөрөл авдаг болгосон. Бас танхим мэргэжлийн холбоодод тэр зөвшөөрлийг шилжүүлэх гэх мэтчилэн энэ цогц өөрчлөлт бол бизнесээ дэмжих ийм бодит бодлого байх болно.

Ийм учраас энэ бүх ажлуудыг ингэж тооцож нуршаад байлгүй ажил хэрэг болгохын тулд бас манай Цогтгэрэл дарга ч гэсэн өөрөө энд оролцоод бас энэ бизнесийн дарамт, эдийн засгийн эрх чөлөө бодлогын талаар ярьдаг хүн байна. Санал бодлоо нэмүүлээд ажиллаарай гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууя.

Б.Түвшин: Ингээд шинэ Ерөнхий сайдын маань нэр дэвшиж байгаа энэ хугацаа бол гадаад, дотоод эдийн засгийн хувьд бол нэлээн хүнд орчин гэж ингэж бүгдээрээ л яригдаж байгаа. Нэг талаас тийм, одоо нүүрсний үнэ 44 хувиар унасан, үнийн хувьд ч буурч байна, тоо хэмжээний хувьд ч буурч байна. Энэ байдлаараа явах юм 2.3-2.5 их наядаар улсын төсөв тасрах эрсдэлтэй гээд яригдаж байгаа. Гэхдээ үүнийг нөгөө талаас нь харвал боломж байхгүй юу. 2020 он буюу одоогоос яг 4 жилийн өмнө манай Монгол Улсын нийт төсөв 13.9 их наяд байсан, урсгал зардал 10.8 их наяд байсан. Сая 2025 онд төсвийг 33.4 их наядаар баталсан. Урсгал зардлыг 25.3 их наядаар баталсан. Энэ 4 жилийн дотор гэхэд л зөвхөн урсгал зардал 2.5 дахин нэмэгдчихсэн байгаа. 2020 онд төр явж л байсан. Төрийн үйлчилгээнүүд хүрдгээрээ хүрч л байсан. Урсгал зардал үндсэндээ 2.5 дахин нэмэгдчихээд байдаг. Өнөөдөр худал хуурмаг явдал, хулгай зэлгий л ихсэж байгаа болохоос биш энэ бүтээмжтэй байдал алдагдчихсан.

Тийм учраас танд асуух зүйл нэгдүгээрт байгаа. Энэ урсгал зардлыг ерөөсөө богино хугацаанд 20 хувь, дунд хугацаандаа 50 хувь хүртэл бууруулаач ээ. Ингэж байж манай Монгол Улсын төсөв эдийн засаг гадаадын энэ одоо уул уурхайн хамааралтай үнийн бууралтаас хамгаалагдах юм байгаа юм. Өнөөдөр 25, 26 их наядын одоо бид нар урсгал зардалтай байхад энэ нүүрсний үнэ алт, зэсийн үнэ жоохон хөдлөх төдийд л бид нар байнга ийм эмзэг байдалтай байна. Хоёрдугаарт, тийм их хэмжээний урсгал зардалтай байхад хөрөнгө оруулалт хийх ямар ч орчин бүрдэхгүй. Энэ тал дээр нэг тодорхой хариулт өгөөч.

Хоёрдахь асуулт нь өнөөдөр иргэд, аж ахуйн нэгжийн татварын болон нийгмийн даатгалын ачаалал дээд хэмжээндээ туллаа. Үүнийг та 20 хувиар бууруулж чадах уу ойрын үед. Ер нь бол энэ дээр эрс шийдэмгий арга хэмжээ авахгүй л бол одоо бизнес аж ахуйн нэгжүүд иргэдүүд бүсээ чангалаад одоо тартагтаа туллаа шүү.

Гуравдугаарт хөдөө аж ахуйн тухай ярьдаг. 170 гаруй малчин өрх 400 гаруй шууд одоо тэр хөдөө аж ахуй дээр байдаг нүүдлийн малчин иргэд байж байна. Ноос ноолуур, махыг нь бүгдийг нь бид нар худалдан авах нэгдсэн тогтолцоо байхгүйгээс дөнгөж улирлын шинж чанартай Оросын ч бай, Хятадын ч бай ченжүүд орж ирдэг. Эд нар нь худалдан авахдаа үр ашгийг нь тэндээ авчихдаг, малчдад өгөөж байдаггүй. Үндэсний хүнсний тогтолцоо, үндэсний одоо энэ нүүдлийн мал аж ахуйн тогтолцоогоо хийж байж бид нар энэ үр өгөөжийг нь малчдадаа хүргүүлэх боломжтой. Энэ тал дээр та ямар бодлого баримталж ажиллах вэ гэдэг асуудал.

Сүүлийн асуулт. Парламентын засаглалыг хэрхэн...

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Төсвийн тодотголыг ирэх долоо хоногт өргөн барина. Урсгал зардлыг бууруулах асуудлаар бол энэ урсгал зардлын өсөлтийн дийлэнх хэсгийг нь цалин хөлсний нэмэгдэл эзэлж байгаа. Нийгмийн даатгал, халамжийн тэтгэвэр тэтгэмжийн өсөлт энэ бүхэн нийлээд бараг л 1 их наяд. Үүнийг одоо бууруулахад бол хүндрэлтэй. Нэгд олгож байгаа цалин хөлсийг иргэд тэтгэвэр тэтгэмжийг бууруулахад хүндрэлтэй. Одоо багш, эмч нарын цалин нэмье гээд л ярьж байгаа болохоос биш бууруулъя гэж нэг ч хүн ярихгүй. Харин 2025 онд бусдаар гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн урсгал зардал бол 1.9 их наяд төгрөгийн зардал байгаа. Бараа үйлчилгээний зардал 1.2 их наяд байгаа. Хөрөнгө оруулалтын 7.6 их наяд төгрөгийн зардлуудад таналт, хэмнэлт зардлын бууралт хийх нь чиглэлийг бол баримтлахаас өөр замгүй байгаа.

Нөгөө талдаа бол татварын хувьд бол энэ бүсээ чангалж байгаа үед, төр бүсээ чангалж байгаа үед ингэж зардлаа бууруулж байгаа үед татварыг тэгээд тэд тэдэн хувь бууруулчихна гэж шууд хэлэх боломжгүй ээ. Ер нь бол харин ч импортын зарим хэрэглээн дээр нөгөө валютын ханшийг өсгөөд байгаа энэ импортын зарим хэрэглээн дээр тухайлбал одоо өндөр үнэтэй виски миски гээд оруулж ирдэг энэ 270 сая долларын архи, тамхи импортоор авч байна. Энэ дээр одоо импортын татварыг нэмэгдүүлэх, энэ автомашины татвар Улаанбаатарын түгжрэлээс авхуулаад энэ тансаг үнэтэй, өндөр үнэтэй автомашинуудын татварыг бас анхаарах гэх мэтчилэн ийм бодлогын төлөвлөлтүүдийг хийлгэх зайлшгүй шаардлага болно. Нийт ард иргэдийнхээ масс дээр учруулах татварын дарамтыг бууруулаад, харин одоо тансаг хэрэглээ гэж нэрлэж байгаа хэт өндөр үнэтэй хэрэглээн дээр татвар оногдуулах, архи, тамхин дээр татвар импортын архи, тамхин дээр татвар оногдуулах ийм бололцоо, ийм шаардлага бол гарна гэж бодож байна.

Ер нь бол малын түүхий эдийг үнэ цэнтэй болгохын тулд боловсруулалтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн ноолуур, арьс ширээ боловсруулаад гаргадаг болох, түүхийгээр нь гаргадаг болох гээд олон цогц хөтөлбөрүүд “Цагаан алт” хөтөлбөрийн түвшинд хэрэгжиж байгаа. Гэхдээ энэ дотор мал аж ахуйн салбарын бүтээмж маш муу байгаа. Манай экспортын 94 хувь нь нүүрс, алт, зэс, жонш гээд одоо уул уурхайн бүтээгдэхүүн. Харин дөнгөж 6 хувь нь мал аж ахуйн бүтээгдэхүүн. Энэ 6 хувийн дийлэнх нь ноолуур түүхийгээр нь боловсруулаад гарч байгаа нэг 327 орчим сая долларын түүхий ноолуур. Дээр нь жоохон мах экспортолж байна. Ингээд үндсэндээ бол манай экспортын салбар маань тэр чигээрээ уул уурхай болчихсон. 1990 онд бол 80 хувь нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн экспортолдог байсан юм байна лээ.

Тийм учраас энэ мал аж ахуйн салбараа дэмжих бодлого маань өөрөө мал аж ахуйн салбарын бүтээмжтэй, нийгэм эдийн засгийн нөхцөл байдалтай нь уялдаж цогц өөрчлөлт хийхгүйгээр малын түүхий эдийн ашиглалтыг сайжруулах боломжгүй болчихоод байгаа юм. Судалгаагаар малчдын аж ахуйн орлого, малчдын мал аж ахуйн орлого, ер нь нийт орлогынхоо 52 хувийг одоо 50 гаруй хувийг махнаас, 40 хувийг ноолуураас гарч байгаа юм. Өөр нөгөө сүү, сүүн бүтээгдэхүүн, арьс ширнээсээ олж чадахгүй байна. Жишээ нь улсын хэмжээнд 19 сая ширхэг арьс шир бэлтгэх боломжтой гэсэн тооцоо байдаг боловч малчид ердөө талыг нь л худалдан борлуулж чадаж байна. Жилдээ өөрөөр хэлбэл 10 сая орчим арьс шир нэхий

хаягдаж байна. Малчдын дөнгөж 17 хувь нь индексжүүлсэн даатгалд хамрагдаж байна. Ингээд ер нь малчдынхаа талаар хийж байгаа энэ малчин өрхийн аж ахуйгаас сардаа олж байгаа нэг 630 орчим мянган төгрөгийн орлого гэж тооцвол нөгөө улсаас олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгө энэтэйгээ уялдаад нөгөө амиа аргацаасан байдлаасаа салахгүй дийлэнх малчид нь. Тэгэхээр мал аж ахуйн салбарт бол бүтээмжийн хувьсгал хийж өөрчлөлт хийхгүй бол...

Д.Амарбаясгалан: Банзрагчийн Түвшин гишүүн тодруулж асууя.

Б.Түвшин: Мал аж ахуй бүтээмжгүй гэж байгаа чинь бид нарын зохион байгуулалтын асуудал л даа. Малчин өрх болгоноос шууд одоо үйлдвэр лүү түүхий эд материалыг нь татах тээвэр логистикийн зардлууд бол асар өндөр гарна. Түүнийг харин нэгдсэн тогтолцоо системд оруулж, үндэсний логистикийг хийгээд эдийн засгийн бүтээмжтэй тэр тогтолцоо руу шилжүүлэх асуудал ярьж байгаа. Та үүнийг бас сайн судлаад үзээрэй гэдгийг бас хэлэх байна.

Хоёрдугаарт, татварын асуудал дээд хэмжээндээ тулсан. Энэ бүтээмжийн асуудал ярьж байгаа шүү. Одоо тухайлбал энэ олон жилүүдийн дотор бид нар валютын ханшийг өсгөөд байгаа ганцхан зүйл нь шатахуунаа дотооддоо үйлдвэрлэдэг болох л асуудал шүү дээ. Тэгэхээр энэ татварыг одоо хэрэглээ буруулахаасаа илүү дотооддоо бүтээмжтэй явуулах хэрэгтэй. Тэр урсгал зардал бол үр ашиггүй байгаа нь инфляцыг нэмэгдүүлж байгаа гэдгийг хэлэх ёстой. Харин Сангийн яаман дээр сүүлийн үед судалгаа хийгээд, урсгал зардлыг огцом бууруулах хэд хэдэн хувилбар бас боловсруулчихсан явж байгаа. Нэлээн боломжийн хувилбарууд бас байгаа гэж харж байгаа. Та түүн дээр бас ажиллаж, энэ урсгал зардлыг огцом бууруулна аа. Ер нь үүнийг цаашдаа...

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга нэмж хариулъя.

Г.Занданшатар: Ер нь энэ мал аж ахуйн тогтолцоо маань байна шүү дээ нэг малчин шогшиж очоод Улаанбаатарт ч юм уу, аймгийн төв орж ноос ноолуур, мах, арьс ширээ боловсруулах бололцоогүй учраас хоршооны тухай эрх зүйн шинэчлэлийг Улсын Их Хурлаас хийсэн юмаа. Тэгэхдээ энэ Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хууль мөн холбооны хууль гэж цогц байгаа. Энэ бол дэлхий нийтийн жишиг бол энэ мал аж ахуй, түүхий эд бэлтгэлийн тогтолцоо үйлдвэрлэгчтэй холбох тогтолцоог бол манайх шиг нүүдлийн мал аж ахуйтай энэ улсад ийм бүтэц бий болгож байж хэрэгжүүлэхээс өөр зам байхгүй. Ингэж байж бүтээмж дээшлэхгүйгээр нэг малчин угаасаа энэ онолын хувьд амиа аргацаасан аж ахуй, бүтээмж дээшлүүлэх бололцоогүй байдаг ийм салбар байгаа юм.

Ийм учраас энэ дээр тодорхой чиглэл нь энэ хоршоожуулалд, олон улсын жишиг ч тэр хуучин нэгдлийн тогтолцоог сэргээх гээд байгаа юм биш. Түүхий эд бэлтгэлийн тогтолцоо үйлдвэрлэгчтэй холбогдох тогтолцоог чанар стандартыг бий болгохгүйгээр үйлдвэрлэл түүхий эд бэлтгэн нийлүүлэгчийн харилцаа тогтохгүй. Ийм ч учраас шинэ гарч байгаа...

Д.Амарбаясгалан: Банзрагчийн Түвшин гишүүн дахин тодруулж асууя.

Б.Түвшин: Хоршооны тухайд та бас их болгоомжтой ярихгүй бол энэ чинь нүүдлийн мал аж ахуйгаа эрхэлдэг иргэдийн ажил хөдөлмөрийн хуваарилалт руу орох гээд байгаа. Харин таны хэлж байгаагаар яг тэр нэг малчин тодорхой үйлдвэр

логистик руугаа нэгдсэн системээр хүрч бүтээмжтэй ажиллах тухай энэ бодлогуудыг бас бодож явах нь бас зүйтэй байгаа гэж ингэж бодож байна.

Түрүүний тэр Сангийн яаман дээр байж байгаа зардлуудын асуудал дээр би бас тодорхой түвшинд бас хамтраад ажиллахад бэлэн байгаа. Урсгал зардлыг одоогоос 20 хувиас дээш хувиар бууруулж байж бид нар энэ уул уурхайн баялгийн үнийн бууралтаас эдийн засгаа тогтворжуулах энэ бодлого руу шилжих юм байгаа юм шүү гэдгийг танд бас хэлье.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Ер нь Адам Смитийн ч гэсэн аль ч тодорхойлолт бол хөдөлмөрийн хуваарилалтыг ч тэр нэг малчин хийж чадах зүйл, малчдын бүлэг хоршоо хийж чадах зүйл гээд энэ бол энэнээс өөр зам байхгүй гэдэг нь онол практикийн түвшинд ч гэсэн батлагдсан зүйл учраас яг нүүдлийн мал аж ахуйг бүтээмжийг дээшлүүлбэ гэвэл тийм л чиглэл гарах байх. Үүнийг харин оновчтой болгох асуудал яригдана. Энэ талаар одоо та бас судалж хамтарч ажиллавал сайн байна. Урсгал зардлын хувь чиглэл ч гэсэн ойлгомжтой. Нөгөө баялгийн хараал гэдэг шиг түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалаад орлого буурна, урсгал зардал хэт өсчихсөн учраас энэ гап зөрүү өсөж байгаа. Энэ бол таны санал зөв боловч цалин, тэтгэвэр, тэтгэмжийг бууруулах ямар ч бололцоогүй гэдгийг л бид ойлгоно. Урсгал зардлын ихэнх нь дийлэнх нь цалин тэтгэвэр, тэтгэмж байх учраас.

Зүгээр бүтээмжийн шинэчлэлээр 1.7 их наяд. Тэр саяын урсгал зардлуудыг танах тийм бололцоонууд бол янз бүрийн яг тоон дээр чөтгөр детальд байдаг учраас тоонд байдаг учраас тэрний талаар та бас саналаа хэлээд төсвийн тодотгол дээр бас оролцоод ажиллаарай. Дараа 7 хоногт өргөн барина.

Д.Амарбаясгалан: Ренчиндоржийн Батболд гишүүн асуулт асууя.

Р.Батболд: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Занданшатар даргыг бол ер нь дэмжиж байна. Тэгээд нэг 3, 4 асуулт асууя. Ер нь гишүүдийн асуулт бас давхцаад байх шиг байна. Энэ нэгдүгээрт энэ та эдийн засгаа солонгоруулах тал дээр таны бодол ер нь ямар байна вэ гэдэг. Тэгээд үүнтэй уялдаад энэ хүнд үйлдвэр байгуулах, боловсруулах үйлдвэр дэмжих тал дээр хэрхэн ажиллая гэж бодож байгаа вэ гэдэг нэгдүгээр асуудал.

Хоёрдугаарт нь, энэ Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар бол 14 мега төсөл гэж оруулж ирээд тэр зарим нь хэрэгжээд явж байгаа, эхэлчихсэн яваа. Тэгэхээр энэ төсөл хөтөлбөрүүд дээр бас уул нь дэмжих юм, бас дэмжмээргүй ч юмнууд харагдаад байгаа юм. Тэгээд энэ 14 төслийн талаар таны бас бодол ямар байгаа болов оо гэж.

Гуравдугаарт нь, энэ мега төслүүд маань бүгдээрээ энэ гадаадын зээл тусламж эсвэл бондын хөрөнгөөр хэрэгжихээр байгаад байгаа. Ер нь би бол өөрөө бас энэ гадаадын зээл тусламжийн ашиглалтыг сайжруулах тал дээр бас ажлын хэсэгт ороод ажиллаж байгаа. Энэ нэг зарим гишүүдийн өргөн барьсан хууль дээр би одоо хамгийн түрүүлээд гарын үсэг зурсан хүнийх нь нэг байгаа юм. Тэгэхээр яг ингээд дэмжээд явчихъя гэхээр энэ хэрэгжүүлэх явцдаа энэ бодлогын алдаа гараад байна гэж хэлэх гээд байгаа юм. Жишээлэх юм бол энэ нийслэл дээр хэрэгжиж байгаа энэ бондын төслөөр хэрэгжиж байгаа Сэлбэ төслийн асуудал яваад байдаг.

Энэ нь нийтдээ нэг 2.5 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй. Энэ барилга угсралтын ажлын төсөл байгаад байдаг. Гэтэл энэний үндсэн одоо гүйцэтгэгч нь болохоор гаднын компани орж ирчхээд үндэсний үйлдвэрлэдэг бүтээн байгуулдаг компаниуд маань орж чадахгүй ийм асуудалтай тулаад байдаг. Энэ бол уул нь маш их хөрөнгө юм байгаа юм л даа. Энэ чинь одоо манай улсын энэ 2025 оны жилийн төсвийн 7-8 хувь нь шахуу, дотоодын нийт бүтээгдэхүүний 3 орчим хувьтай ийм том төсөл яваад байгаа.

Тэгэхээр ийм дотооддоо мөнгөө аваад үлдчих боломжтой ийм төслүүдийн хэрэгжилт дээр алдаа гараад байгааг ер нь засаж залруулах тал дээр ямархуу бодолтой байна вэ гэдэг асуулт байна. Сүүл эцсийнх нь асуулт болохоор энэ ер нь Ерөнхий сайд ер нь энэ Пүрэв, Баасан гаригийн Улсын Их Хурлын чуулганаар нэг Ерөнхий сайдын цаг гээд эхний цагийг нь гаргаад нэг мэдээлэл хүргээд, тэгээд энэ гишүүдтэй ярилцаад явж байх боломжтой юу. Та үүнийг ер нь юу гэж бодож байна вэ. Ийм боломж байгаа юу. Та ингэж ажиллаж болох уу гэдэг ийм 4 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Эдийн засгийг солонгоруулах уул уурхайн бус салбарыг дэмжих, тэгээд жижиг, дунд бизнесийг дэмжих хамгийн зөв шийдэл бол бизнесийн орчныг сайжруулах явдал юм. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, татвар зээлийн бодлогоор дэмжих энэ шаардлагатай.

Тэгэхээр өөрөөр хэлбэл хөдөлмөрлөж байгаа бүх хүнийг ажлын байр бий болгож байгаа баялаг бүтээгч болгоныг дэмжсэн бодлого л хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үздэг. Тэгээд 14 мега төслийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд тогтвортой залгамж халаатай бодлогыг эрх зүйн болон институтийн түвшинд баталгаажуулж ажиллах шаардлагатай. Зарим нь одоо хэрэгжээд явж байгаа. Зарим нь хүндрэлтэй байгаа төслүүдийг санхүүжилт боломж, шаардлагаар нь эрэмбэлэх шаардлагатай гэж би дээр хэлсэн.

Ер нь манай энэ таны хэлсэн энэ үндэсний үйлдвэрлэлийг дэмжих асуудал бол саяын тэр барилгачид Сэлбэ дэд төв болон бусад асуудлууд дээр Нямбаатар дарга, нийслэлийн удирдлагуудтай бас ярилцсан. Ер нь бол Барилгачдын ассоциатай яриад, туслан гүйцэтгэгчээр оруулж, үйлдвэрлэгчдээ бол дэмжиж ажиллахаар ингэж тохирсон гэж надад хэлсэн. Энэ асуудлыг бид хянаж ажиллах болно. Мөн ТҮЦ эрхлэгчдийг ч гэсэн тэр тодорхой одоо бодлогоор дэмжиж ажиллахаар тохирсон гэж ярьсан. Тэгээд барилгын ассоциацид бол том компаниуд нэгддэг. Консорциум болоод дараагийн багцад нь өрсөлдөхөөр болсон гэсэн. ТҮЦ-ийн 350 иргэн байгаа тэрний 40 хүн нь ажилд орсон, үлдсэн иргэдэд нь нөхөн олговор олгох үүрэг чиглэлийг өгсөн. Тэгээд хамтран ажиллаад уулзалтууд нь хийгдээд надад эргээд мэдэгдье гэсэн ийм хариулт өгсөн байгаа.

Тэгээд үндсэн гүйцэтгэгчидтэйгээ тохироод одоо тэр туслан гүйцэтгэгч дээр бол Барилгачдын холбоотой тохирсон гэж мэдээлэл өгсөн. Тэгээд яах вэ энэ ер нь цаашдаа бол үндэсний үйлдвэрлэл дотоодын үйлдвэрлэлээрээ хийж, валютын гарах урсгалыг аль болох хязгаарлаж энэ чиглэлээ барих шаардлагыг бол тэргүүн зэрэгт тавьж ажиллах болно оо.

Д.Амарбаясгалан: Батболд гишүүн тодруулж асууя.

Р.Батболд: Тийм. Нөгөө энэ барилга ассоциатай тохирсон юм шиг байна лээ нийслэлийн удирдлага. Тэгэхээр энэ барилгын ассоциаци барилгачдын холбоо гэдэг нь нэг тусдаа байгууллагууд яваад байгаа юм. Тэгээд Барилгачдын холбоо гээд одоо энэ бид нарын гадаа суулт хийгээд байгаа улсууд маань бид нар 100 мянган барилгачдын эрх ашгийг хамгаалаад яваад байгаа юмаа. Бид нар юмаа хиймээр байна аа. Барилгын ассоциаци болохоор бид нар нэг 20 хувь дээр нь яаж ийж байгаад орчихно оо гэсэн байдалтай нэг тохиролцсон гэсэн ийм мэдээлэл өгөөд байгаа. Тэгэхээр энэ хоёр байгууллагыг бас та тусад нь авч үзээд асуудлыг нэг жоохон ул суурьтай авч үзээрэй гэж хүсье.

Д.Амарбаясгалан: Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн асуулт асууя.

Ч.Лодойсамбуу: Баярлалаа. Өнөөдөр ямар ч байсан ингээд шинэ Ерөнхий сайдаа бид нар угтаж авах юм шиг байна. Нэгэнт томилогдож байгаа бол бас хэдэн асуулт бас хэдэн захиас байна. Нэгдүгээрт хэдийгээр Ерөнхийлөгч Их Хурлын чуулганы хуралдаанд орж ирж Үндсэн хуулийн өөрчлөлт байхгүй гэдэг талаар мэдээллээ өгсөн боловч ерөөсөө эргэлзээ тайлагдахгүй байна. Занданшатар дарга маш тодорхой хариулаад өгөөч. Одоо танай Засгийн газраас энэ хугацаанд бүрэн эрхээ хэрэгжүүлж байх хугацаандаа ямар нэг байдлаар засаглалын хэлбэрийг солих талаар ард нийтийн санал асуулгыг оруулж ирэх үү? Тодорхой хариулт.

Хоёрдугаарт, энэ олон улсын байгууллагуудын төсөөллийн энэ индексээр энэ ардчиллын индекс, хэвлэлийн эрх чөлөөний индекс ингээд унаад байгааг голлох шалтгааныг та яг юу гэж үзэж байна? Голлох шалтгааныг.

Гуравдугаарт сая Үндэсний статистикийн хорооны статистик тоонуудыг хараад байж байлаа. Монголын одоо айлуудын айл өрхүүдийн дундаж орлого 1.8 сая төгрөг, дундаж зарлага бас 1.8 сая төгрөг. Өөрөөр хэлэх юм бол энэ тоог харах юм бол нэг талдаа орлого маш өндөр байна, нөгөө талдаа доор байгаа нь бүүр дордсон байна. Өөрөөр хэлэх юм бол та яг энэ тоог харах юм бол яг 0 цэг дээрээс одоо эхэлж байна. Энэ өрхийн орлого, энэ зарлагын харьцаа таны энэ ажиллаж байх үед хэрхэн өөрчлөгдөх вэ, яаж сайжрах вэ? Жоохон хэмжигдэх нэгжтэй хэдүүлээ нэг ярилцъя гэж бодоод байна. Одоо хэдийгээр томилогдох гэж байгаа ч гэсэн тодорхой хариулт энэ дээр хэлээч. Таны үед хэд болох вэ? Энэ валютын ханш инфляц гэдэг нэргүй, одоо ийм нэргүй татварт үнэхээр дарлуулж байгаа. Энэ бол нөгөө нэг өнгөрсөн удаагийн Засгийн газрын авч хэрэгжүүлж байсан буруутай буруу алдаатай бодлогуудын л үр дүн. Баахан мөнгө нийлүүлэлтүүд, баахан буруу шийдвэрүүдтэй холбоотой.

Тэгэхээр энэ инфляцыг хэрхэн барих юм. Валютын ханшаа тогтоон барьж яг дийлэх үү, чадах уу? Өрхийн амьжиргаатай холбоотой энэ ажлын байр шүү дээ одоо өрхийн орлого гэдэг чинь ерөөсөө ажлын байрыг яаж нэмэгдүүлэх юм. Энэ цалин орлоготой байхад нь яаж ер нь яг анхаарах юм, бодитой ингээд нэг ажлуудыг та хэлээд өгөөч. Та одоо томилогдож байгаа хүний хувьд. Төрийн өмчийг хувьчилна гэж хэлж байна. 50 хувь гэж хэлж байна. Хаанаас эхлэх юм, яг хаанаас. Танд одоо бодол байгаа байх. 50 хувь гэж хэлж байна гэдэг бол нэгэнт зорилго төлөвлөгөө нь бол гарчихсан байгаа гэж бодож байна.

Ингээд сүүлд нь одоо энэ Ухаа худагтай холбоотой сүүлийн үед яригдаад байгаа энэ. 2007 оны гарсан Их Хурлын тогтоолыг ерөөсөө биелүүлээгүйгээс болсон л асуудал юм байна лээ л дээ Засгийн газар нь. Энэ дээр яг ямар байр

суурьтай байгаа вэ? Тэгэхгүй бол буруу ойлголтууд яваад байна. Хэдэн гишүүд хамгаалаад байгаа юм шиг. Ер нь ийм парламент баялгийг эзэмшигчдийг хамгаалаад байгаа юм шиг ойлголт байна. Үүнийг залруулаад өгөөч.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Нэгдүгээрт, бид бас Үндсэн хуулиа сайн судлах хэрэгтэй гэж бодож байна. Үндсэн хуулийг өөрчлөх гээд дур зоргоороо авирлах Засгийн газар хувь институт байх ямар ч бололцоогүй ийм эрх зүйн орчинд бид ажиллаж байгаа. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд одоо төрийн бүх эрх мэдэл ард түмнээс эх сурвалжтай учраас ард түмний санал санаачилгагүйгээр аль эсвэл дур зоргын шинж чанартайгаар нэг нам, нэг хэсэг бүлэг хүмүүс Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах боломжгүй. Заавал энэ журмын тухай хуулиас гадуур хийж байгаа үйлдлийг төрийн эсрэг гэмт хэрэг төрийн эсрэг гэмт хэрэг гэнэ ээ гээд үзчихсэн. Тэгэхээр ийм санаачилга гаргах нь бол өөрөө бүр Үндсэн хуулийн эсрэг гэмт хэрэгт тооцогддог улс орнууд

Хоёрдугаарт нь, аливаа тийм өөрчлөлт чинь өөрөө шинэ Үндсэн хууль байхгүй юу. Засаглалын хэлбэрийг өөрчилнө гэвэл Үндсэн хуулийг цоо шинээр нь бичих болно. Үүнийг ард түмнээр хэдэн жил хэлэлцүүлэхийг мэдэхгүй. 1992 онд Үндсэн хууль батлахдаа бүтэн жил хэлэлцүүлсэн.

Гуравдугаарт нь, энийг эцсийн эцэст Улсын Их Хурал шийдвэрлэнэ. Ард нийтийн санал асуулга явуулах саналыг нийт гишүүдийн 3-ны 2-оор буюу 84 гишүүний саналаар, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг 94 гишүүн байх аа 4-ний 3-аар гишүүд та бүхэн шийднэ. Энэ ярилцахгүйгээр нэг хүн Үндсэн хууль өөрчлөөд л Ерөнхийлөгчийн засаглал тогтоогоод л эсвэл Ерөнхий сайдын засаглал зогсоогоод байх ямар ч бололцоогүй. Тэгээд энэ бол дэлхий нийтийн ардчиллын чиг хандлагад ч тэр одоо дур зоргын шинж чанартай ийм хандлагаар Үндсэн хууль өөрчлөх бололцоо бол манай улсад нэн ялангуяа ийм эрх чөлөөг эрхэмлэдэг ийм ардчилсан улсад боломж тохиромжгүй. Энэ үлгэрт бол би итгэдэггүй. Энэ хангалттай байх гэж бодож байна

Хоёрдугаарт нь, бол энэ орлого ардчиллын индекс юунаас болж буураад байна гэж. Ардчиллын индекс жишээлбэл, хэвлэлийн эрх чөлөөний индекс буурснаас буурч буурч байж болно оо. Хэвлэлийн эрх чөлөөний индексээр 2023 оны байдлаар 180 орноос 88-д байсан бол 2025 оны байдлаар 21 байраар ухарч, 109 дүгээрт эрэмбэлэгджээ. Та хэвлэлийн хүн. Хэвлэл мэдээлэлд байгаа өнөөдөр мөнгөний оролцоо, хэвлэл мэдээллийн салбарт байгаа өнөөдрийн одоо улс төрчдийн оролцоог бүүр тодорхой хэлбэл энэ хэвлэлийн эрх чөлөөний индексээ унасан нэг гол шалтгаан нь улс төрчид хэвлэл мэдээллийн хэрэгслийг эзэмшдэг нөхцөл байдал бол энэ нь хэвлэлийн эрх чөлөө унах нэг шалтгаан болсон.

Хоёрдугаарт нь, сонгуулийн шударга байдал байна, эрх чөлөөний индексүүд байна, авлигалын төсөөллийн индексүүд байна. Энэ бүх асуудлууд дотроо шалгуур үзүүлэлтүүдтэй. Энэ болгон дээр анхаарч ажиллаж байж бид энэ индексээ сайжруулах бололцоотой. Тэгэхээр энэ бол зөвхөн индекс хөөхөөсөө гадна чанарын үзүүлэлтүүдийг бид бодитой харж өөрчлөлт оруулахын тулд Улсын Их Хурлын гишүүдийн ч тэр, манай 4 дэх засаглал болсон Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль одоо өргөн бариад хэлэлцэгдэж байгаа. Энэ бүхэн дээрээ одоо гишүүд маань илүү тодорхой заалтуудыг оруулж, хаа хаанаа хариуцлага сахилгаа

нэмэгдүүлж байж бид хүний эрх ардчиллын индексээ сайжруулж чадна гэж бодож байна. Энэ бол бас дан ганц нэг хүний Ерөнхий сайдын санаачилга дээр хэрэгжих боломжгүй олон талт ардчиллын хүчин зүйлээс хамаарна.

Өрхийн орлого ер нь тэгш бус байдлыг бууруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд бол нэгдүгээрт макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах буюу инфляцыг бууруулах шаардлагатай. Инфляц байнга өсөөд байхаар энгийн иргэдэд л хамгийн их ачаалал бий болгодог. Энэ инфляцын цаад шалтгаан нь төлбөрийн тэнцэл байдаг. Төлбөрийн тэнцэл импортоор их юм аваад байх тусам валютын ханшийг өсгөнө, валютын ханш өсөхөөрөө импортын инфляцаа өдөөнө.

Ийм учраас энэ бизнесийн орчин хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ийм бодлого шаардлагатай. Ингэж байж л бид тогтвортой өрхийн бодит орлогыг дэмжиж чадна. Тэгэхгүй бол өрхийн зардал орлогоосоо илүү буюу нийт өрхийн 69 хувь нь зээлтэй байна. Цалингийн зээлээс авхуулаад одоо орон сууцны зээл хүртэл. 69 хувь нь зээлтэй байна. Энэ өнөөдрийн бодит байдал.

Ийм учраас үүнийг өөрчилж тодорхой одоо энэ ажил эрхлэлт хөдөлмөрийн үнэлэмжийг сайжруулах, татварын реформ хийх, нэмэгдсэн өртгийн албан татварыг реформ болон энэ цогц реформуудыг хийх нь үүнтэй уялдаж хэрэгжих ёстой гэж бодож байгаа юм. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих асуудал. Суурь үндэс нь бол одоо бүх үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж байж ажлын байр бий болно, баялаг нэмүү өртөг бүтээгдэнэ. Үүнийгээ дагаад одоо өрхийн орлого нэмэгдэх ийм чиг хандлага даа. Тэгээд ажилгүйдлийг бууруулахын тулд эхний алхам бол сая...

Д.Амарбаясгалан: Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн тодруулж асууя.

Ч.Лодойсамбуу: Нэг ийм эргэлзээ буруу мэдээлэл тарчихсан байгаа дээр танаас бүр залруулга хүсээд байна. Одоо энэ Ухаа худагтай холбоотой яригдаад байгаа юм. Нэг хүн бол ингээд л монголчууддаа баялгийг нь олж өгөх гээд л жигтэйхэн хичээгээд, тэгээд нөгөө баялгийг нь авчихсан хэсэг нь жигтэйхэн эсэргүүцэж дайн зарлаад түүн дээр нь Монголын парламент хамгаалалт болж яваад, тэгээд нөгөө хүнээ аваад хаячихсан юм шиг ийм ойлголт төрүүлчихсэн, төрүүлчихсэн. Яг бичиг баримтын он цагийг нь ингээд харахаар 2007 онд Монгол Улсын Их Хурал Монгол Улсын Засгийн газартаа үүрэг өгчихсөн юм байна лээ. Энэ стратегийн орд газруудыг эзэмших компаниудтай явж хэлэлцээр хий, тэгээд энэ Ашигт малтмалын хуультай нийцүүлж орж ир гэж. Тэр ажлаа хийгээгүй юм байна лээ. Тэр ажлыг нь та одоо хийх үү? Энэ дээр нэг тодорхой та нэг хэлээд өгөөч, байр сууриа хэлээд өгөөч. Тэгээд дахиад тодруулъя.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Монгол Улсын Ерөнхий сайд бол хуулийн биелэлтийг Улсын Их Хурлын өмнө хариуцдаг ийм төрийн албан тушаалтан. Хууль биелүүлэх үүрэгтэй. Хууль тогтоох байгууллага нь Улсын Их Хурал. Энэ Улсын Их Хурлаар баталсан Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийг хэлбэрэлтгүй биелүүлж хэрэгжүүлэх нь Ерөнхий сайдын үүрэг байх ёстой. Энэ баялгийн шударга хуваарилалт, олон нийтийн эрх мэдэл, итгэлцэл төрийн эрх мэдэлд сөргөөр нөлөөлдөг энэ асуудал бол ашигт малтмалын орлогын шударга бус хуваарилалт ил тод бус байсныг л харуулж байгаа. Ийм учраас бүх юмыг ил тод

болгох хэрэгтэй. Энэ цаана байсан бүх юмыг одоо хөрөнгө албан тушаалтны хөрөнгө орлогоос авхуулаад ил тод байдал бол асуудлыг шийдэх нэг гарц мөн.

Ер нь баялгийн өгөөжийг тэгш хүртээх механизмыг бэхжүүлж, нийгмийн шударга байдлыг сэргээх бодлого баримтлахын тулд одоо энэ стратегийн ордуудтай хэлэлцээ хийх ажлыг ард түмний өмнө нээлттэй ил тодоор зохион байгуулна. Энд Улсын Их Хурлын гишүүд, Лодойсамбуу...

Д.Амарбаясгалан: Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн дахин тодруулъя.

Ч.Лодойсамбуу: Тэгээд үлдсэн минутад нь танд захиасаа хэлье. Ер нь бол PR-аа бодолтой хийгээрэй Занданшатар дарга аа. Та бас одоо ер нь хэвлэлд их цочимтгой шүү. Цочимтгой хүн огцом үйлдэл хийдэг, огцом үйлдэл нь хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байдаг, нийгмээ харанхуй болгож байдаг. Тийм учраас энэ хар бараан PR, худал хуурмагаар засаглах гэсэн байдлаас бүр тэс эсрэгээр нь ил тод нээлттэй ажиллаарай гэж нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ төр сэтгүүл зүй хоёрын хооронд байгаа энэ мөнгөн холбоосыг тас цохиорой, тас цохиорой. Одоо энэ төсвийн мөнгөөр хэвлэлийнхнийг угждагийг болиулаарай. Энэ дээр бүр манлайлж ажиллаарай гэж танд хэлэх гэж байгаа юм. Хэвлэлийн эрх чөлөөний нэртэй Хэвлэлийн эрх чөлөөний эсрэг бүр ийм заалтуудтай өмнөх Засгийн газрын өргөн барьсан Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг буцаан татаарай. Тэгээд бизнесүүдтэйгээ өстэй юм шиг ажилладгаа болих хэрэгтэй. Сая үндэсний үйлдвэрлэлүүдээ ярьж байна. Үндэсний үйлдвэрлэлүүдээ хайрлаж ажиллаарай гэж захъя.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Чөлөөтэй, хариуцлагатай, ёс зүйтэй хэвлэл мэдээлэл бол ардчиллын нэг дархлаа, засаглалын нэг багана мөн. Тиймээс би хэвлэл мэдээлэлд ямагт нээлттэй байж, ямар ч хаалтын гэрээ байгуулж ирээгүй. Миний бүх юм нээлттэй байдаг, алдаа оноо маань ил тод байдаг. Нум сум харвасан ч гэсэн, алхаж гишгэсэн ч гэсэн миний алдаа болгон ард түмэндээ нээлттэй байж ирсэн. Цаашдаа ч гэсэн энэ нээлттэй байдлыг ямагт эрхэмлэж ирнэ. Харин бусдыг харлуулах, үнэнийг гуйвуулах, иргэдийг талцуулах замаар ашиг хонжоо олох зорилготой үйлдлийг ард түмний татварын мөнгөөр угждаг үзэгдэл яавч хэрхэвч байж болохгүй ээ. Манай хэвлэл мэдээллийн салбарынхан Лодойсамбуу гишүүн та бүхэн маань энэ хэвлэлийн мэдээ эрх чөлөө дээрээ харин манлайлж санаачилж энэ хараат бус чөлөөт хэвлэл мэдээллээ ардчиллын нэг дархлаагаа хөгжүүлэх талаараа бас энэ хууль дээрээ бас санаачилгатай ажиллаж, энэ заалтуудаа оруулж ажиллаарай гэж хүсэж байна. Хэвлэлийн эрх чөлөөний хууль уу?

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Одоо та Улсын Их Хурлын гишүүний хувьд энэ хууль дээрээ санаачилга манлайллаа аваад ажиллаад, энэ ер нь хэвлэл мэдээлэл маань төрийн мөнгөөр угждаг, хаалтын гэрээ байгуулдаг, харлуулдаг, гуйвуулдаг, ард түмнийг талцуулдаг ийм асуудал байвал үүнийгээ таслан зогсоох заалтыг оруулах шаардлагатай. Ер нь Ази тивээс анх удаа Монгол Улс манай парламент Хүний эрх хамгаалагчийн тухай хуулийг баталсан. Хүний эрх хамгаалах асуудал бас хэвлэл мэдээлэлтэй ч холбогдоно. Ийм учраас хэвлэл мэдээллийн хуулийг бол одоо Улсын

Их Хурлын ширээн дээр байгаа учраас та бүхэн хэлэлцэж байна. Би шийдэх, Засгийн газар оролцох асуудал биш ээ гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд ээ. Энэ сүүлийн хэд хоног ингээд ажиглаж байхад Ерөнхий сайдад одоо нэр дэвшүүлэх марафоны дээрээс нь сайд нарт нэр дэвшиж байгаа ч улсууд юм уу бие биеэ ер нь яасан их харлуулдаг юм. Энэ сошиалаар, хэвлэлээр. Үгүй ээ, одоо тэгээд ер нь яг нэр цэвэр Ерөнхий сайд хийчихээр нэр цэвэр сайд хийчихээр хүн энэ Монгол төрд байгаа юм уу. Ингэж одоо бие биеэ харлуулна гэдэг чинь энэ наанадаж төр, ард иргэдийн төрдөө итгэх итгэл, төр иргэдийн холбоо, дээрээс нь зөвхөн бид өөрсдөө парламент энэ дотор сууж байгаа гишүүд, намууд ингэж харлуулаад байхлаар энэ Монгол төрийн нэр хүнд ямар байх юм. Нэг ийм бодол төрж байлаа.

Тэгээд Занданшатар гишүүнээс нэг 5 их тодорхой асуулт асууя. Та бол одоо бас Төрийн албаны туршлагатай хүн. Гэхдээ энэ сүүлийн 10 жил 2016 оноос өнөөдрийг хүртэл Монгол Ардын Нам дангаараа засаглаад 10 жил боллоо. Өнөөдрийн энэ ард иргэдийн байгаа байдал Монгол орны өнөөдрийн энэ иргэдийн амьдралын чадвар энэ бүх зүйл бол яалт ч үгүй тантай, танай намтай холбоотой, алдсан байж болно. Одоо алдаагаа засах чиглэлээр дараах 5 чиглэлд яг юу хийх вэ.

Нэгдүгээрт авлигагүй төр. Ер нь бол авлига бол эрх мэдэлтэй намд, эрх мэдэлтэй хүмүүст л байгаа шүү дээ. Энэ манай улс бол үндсэндээ Монгол Ардын Намын хурган дарга нарын хулгай нүүрлэсэн улс болж хувирлаа. Огт бизнес хийгээгүй байж байж баахан төрөөс төрсөн тэрбумтнууд тэр Ривер Гарден, Скай Гарденд амьдарцгааж байна. Би бас тэр энэ чиглэлийн судалгаа хэчнээн төрийн албан хаагчид тэнд амьдарч байгаа судалгаа хийгээд байгаа хүн л дээ. Та авлигатай тэмцэж чадах уу? Авлигатай тэмцэнэ гэдэг бол та намтайгаа тэмцэнэ ээ гэсэн үг. Яг энэ чиглэлээр юу хийх вэ тодорхой.

Хоёрдахь нь, 2016 онд байсан төрийн албан хаагчдын тоо өнөөдөр байгаа төрийн албан хаагчдын тоо, цалингийн фонд 8 дахин цалингийн фонд нь 8 дахин ер нь 192 мянгаас одоо 231 мянга төрийн албан хаагчдын тоо. Төрийн өмчит болон орон нутгийн өмчит компаниудад 58 мянга. Ингээд үндсэндээ нийт Монгол Улсын ажиллах хүчний 18.2 хувь нь төрд ажилладаг хийгээд төрөөс хамааралтай болчихлоо. Энэ данхар бүтцийг яаж оновчтой, бүтээмжийн менеж энэ төрийн салбарт бүтээмжийн менежментийг хэрэгжүүлэх вэ хоёрдахь асуулт.

Гурав дахь нь, Төр гэдэг бол үүсмэл зүйл ээ. Бид бизнес эрхлэгчид татвар төлөгчдийн мөнгөөр амь зогоодог нөхдүүд. Зүгээр ний нуугүй хатуухан хэлэхэд бол арай биеийн амрыг харж, амь зогоож байгаа гэж хэлэхэд бол бараг хилсдэхгүй шүү. Тэгээд энэ бизнес эрхлэгчдийнхээ ачааллыг, эрх зүйн орчныг, бизнесийн орчныг...

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Гомбын Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт, авлигагүй төр. Би өмнө нь бас хариулж байсан. Алтангэрэл гишүүний асуултад. Улсын Их Хурлын даргаар ажиллаж байхдаа Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулж, Авлигалын эсрэг багц хуулийг баталсан. Төрийн өндөр албан тушаалтай

авлига авбал бүх насаар нь одоо ялын дээд хэмжээ оногдуулдаг болсон. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг шинэчлэн баталсан. Тэрэн дотор одоо яригдаад байгаа тэр үндэслэлгүй хөрөнгөжих, орлогоосоо давсан зарлагыг хянах зохицуулалтыг бий болгож, хөрөнгө хураах ялыг тэнд оруулсан юмаа.

Тэгэхээр одоо бол энэ хуулийн хэрэгжилт л хамгийн чухал шаардлагатай байгаа юм. Дабль стандартыг биш, зохистой шударга хэрэгжүүлдэг байх шаардлагатай байгаа юм. Ер нь авлигалын хэргээр ялласан тоо, хураасан хөрөнгийн хэмжээ бол асар их нэмэгдсэн. Энэ тодорхой тоо баримтууд бас байдаг юм. Манай Авлигатай тэмцэх газрын ажил дээр бас тодорхой ахиц дэвшил ер нь тоон үзүүлэлтийн хувьд нэлээн 109 гэмт хэргээс 210 гэмт хэрэг шийдэгдсэн гэх мэтчилэн. Ер нь бас бүр тодорхой ярих юм бол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хууль батлагдсанаараа одоо энэ Хөгжлийн банкны, нүүрсний, эмийн, ногоон автобусны зэрэг 4 удаагийн түр хороо байгуулж нээлттэй сонсгол хийж байсныг та бүхэн мэдэж байгаа байх. Энэ бол манай парламент ёсны хувьд түүхэнд бол цоо шинэ хуудас нээсэн энэ парламентын хяналт шалгалтын, ард түмний мэдэх эрхийг хангасан юм болгож гаргасан.

Энэ 30 жилийн хугацаанд ерөөсөө авлигал нэг өдөр бий болчихсон юм биш харин үүнийг ил болгосон байхгүй юу. Хуудсыг нь сөхөөд харсан чинь дотор нь яасан их шавж хорхой байна гэж хардаг шиг энэ ил тод байдлыг бий болгосон парламентын хяналт шалгалтын нээлттэй сонсголын зарчмуудыг бий болгосон. Тийм учраас энэ бол авлигатай тэмцэх ажил бол намынхаа гишүүдтэй ч, Улсын Их Хурлын гишүүдтэй ч олон асуудал хөндөгдөж найз нөхөдтэйгөө ч гэсэн хэлэлцэж, яригдаж шийдэж ирснийг өнгөрсөн парламент дээр шийдэгдсэн олон асуудлуудаас тавих арга байгаа. Тэгэхдээ энэ бол амаргүй ажил аа. Энэ бол авлигатай бол попролтоор тэмцэхгүй ээ. Авлигатай бодит үйл хэргээр тэмцэх ёстой.

Төрийн алба данхайсан асуудал бол ер нь цомхон гэж бас хэлэх бол алсын хараа хөтөлбөрт бол зохистой гэдэг үгээр орсон. Сургуулийн тоо нэмэгдээд байна, цэцэрлэгийн тоо нэмэгдээд байна, хүүхдийн тоо өсөөд байна. Үүнийгээ дагаад цэцэрлэг, сургуулийн тоо нэмэгдэж байгаа, дагаад багш нарын тоо нэмэгдэж байна. Эмнэлгийн тоо нэмэгдэж байна, эмч нар, сувилагч нарын тоо нэмэгдэж байна. Ийм учраас бид зохистой, бүтээмжтэй, үр ашигтай төрийн албыг л бий болгохыг зорих энэ шинэчлэлийг хэрэгжүүлнэ гэж тусгасан байгаа. Төрийн өмчийн компаниуд одоо орон нутгийн 419, хотын 200 хэдэн төвлөрсөн компаниуд байдаг. Эднүүсийг цэгцлэхээс авхуулаад энд байгаа ил тод нээлттэй бодлого хэрэгжүүлэх, төрийн өмчийн компаниудын 50 хувийг хувьчлах бодлого хэрэгжүүлэх бол энэ авлигатай тэмцэх суурь нөхцөлүүд байх гэж бодож байна. Ийм учраас энэ талаар бас тодорхой санал санаачилгуудыг та бүхнээс авч ажиллах болно.

Энэ цахимжуулах бол энэ бүтцийг авлигатай тэмцэх ч нэг үндэс юм байгаа юм. Бас төрийн албаны энэ данхар бүтцийг бууруулах ч нэг гол чиглэл байгаа юм. Өөрөөр хэлбэл дижитал пүүст буюу илүү цахимжуулах хүний оролцоогүй дижитал тендер шалгаруулдаг, цахимаар тендер шалгаруулдаг, цахимаар баримт бичиг олгодог ийм цахимжуулах явдал бол төрийн албаны ачаалал бүтээмжийг ч сайжруулах, нөгөө талдаа авлигатай ч тэмцэх ийм том шинэчлэл болно. Тийм учраас дижитал бүүст буюу цахимжилтыг эхэнд тавьсан Засгийн газар байхыг зорьж ажиллана гэж бодож байгаа.

Д.Амарбаясгалан: Гомбын Ганбаатар гишүүн тодруулж асууя.

Г.Ганбаатар: Яах вэ одоо бас нэг 2 зүйл байгаа юм. Таны миний өмнө үг хэлсэн асуусан 12 гишүүдийн хариултад хэлж байхад би анхааралтай сонсоод сууж байлаа. Та үндсэндээ ирэх долоо хоногт төсвийн тодотголыг өргөн барих гэж байгаа юм байна. 2 аравны их наядаар танана, хэмнэлтийн бодлого хийнэ, эдийн засгийнхаа бүтцийг өөрчлөлт хийнэ ээ гэж байна. Ер нь яах вэ үндсэндээ эдгээр бодлогуудаас гадна энэ монгол хүний амьдралын чанарыг сайжруулах гэж байгаа хамгийн чухал зүйл бол бид нэг жоохон нэмүү өртөг шингээгээд манай улс бол хөдөө аж ахуйн орон. Мал аж ахуйн салбарт энэ түүхий эд ноос ноолуур, уул уурхайн салбартаа тэр жонш өөр бүх л зүйлээ нэмүү өртөг шингээж ажлын байр бий болгоход ганц садаа болж байгаа юм бол АМНАТ-аа. Энэ талаар ямар бодлого баримтлах вэ?

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг бол ер нь баялгийн татвар гэж өөрчилж энэ роялти гэдэг үндсэн утгатай нийцүүлж, үүнийг орон нутагт тодорхой хувийг үлдээдгийг илүү хуульчилж, ард иргэдийн хяналтад оруулж, энэ Үндсэн хуулийн 6.2-ыг амилуулах, үндэсний баялгийн санг хөрөнгөжүүлэх үндэс бол Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт шинэчлэл хийх замаар хэрэгжих ёстой гэж ойлгож байгаа. Ер нь баялгийн татварыг шинээр бий болгох шаардлага гарч ирж болно. Тэгээд энэ талаар бас нэн ялангуяа говиос сонгогдсон гишүүдтэйгээ энэ томоохон төсөл хөтөлбөрийг жишээлбэл усны төслийн хөтөлбөр хэрэгжүүлэгч маань бас л энэ төсвийн бодлоготой, татварын бодлоготой уялдах шаардлага гарч ирэх байх. Энэ чиглэлээр бид та бүхэнтэй хамтарч ажиллахад бэлэн байна.

Д.Амарбаясгалан: Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

Б.Мөнхсоёл: Сайн байцгаана уу? Бүгдийн өдрийн амгаланг айлтгая. 5 асуулт асуултан дундаас үгээ хавчуулаад хэлчихье гэж бодож байна. Нэгдүгээрт нь бүгдээрээ мэдэж байгаа. Иргэд одоо түрүү оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг үнэлж дүгнэхдээ хүний эрх болон иргэдийн амьжиргааны түвшин маш доогуур байна гэдгийг санал нийлж дүгнэсэн.

Хоёрдугаарт болохоор иргэд одоо ажил хийгээд байгаа боловч бас ядуурсаар байна аа гэдэг энэ том асуудал байна. Тэгэхээр бүгдээрээ яг зөвхөн мега төслүүд энэ тэр гэхгүйгээр шинээр үүсэх Засгийн газар иргэдийн амьжиргааг дээшлүүлэх дээр яг ямар бодитой ажил хийх вэ? Энэ дээр тодорхой асуулт хариулт авъя.

Хоёрдугаарт, эрчим хүчний салбар ялангуяа ер нь төрийн өмчит үйлдвэрийн компаниудын засаглал үр ашгийг улс төрчдөөс ангижруулах ийм бодлого байгаа. Тэгээд түүн дээр бол одоогийн байгаа мөрийн хөтөлбөрт орсон одоо Засгийн газрын үйл аж ажиллагааны хөтөлбөрт орсон нэг зүйл юу вэ гэхээр төрийн өмчит компаниудыг одоо хяналтыг нь сайжруулах, нийтийн одоо нээлттэй компани болох талаар зорилго орсон үйл ажиллагаа орсон. Тэгэхээр энэ тал дээр таны байр суурь ямар байгаа вэ?

Гуравдугаарт нь, эрчим хүчний реформын хүрээнд олон одоо ажлууд төлөвлөгдсөний нэг нь тухайлбал одоо эрчим хүчний янз бүрийн эх үүсвэрүүд,

ухаалаг тооцоолуур, тооцоолжуулалт энэ яасан хэцүү үг вэ гэх мэт одоо асуудлуудыг улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж ийм ажил орчихсон байгаа. Тэгээд даан ялангуяа бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Хамгийн сүүлийн ДЦС 3 дээр гарсан осол аваар. Юуны түрүүнд үүнийг одоо засварлах шаардлагатай байгаа. Энэ төсвийг энэ одоо зарцуулах мөнгийг төсвөөс гаргах боломж одоо тийм ажил төлөвлөгдөх үү, хийгдэх үү гэдэг ийм тодорхой асуулт байна.

Дөрөвдүгээрт нь боловсролын салбартай холбогдуулаад бас асуумаар байна. ХҮН намынхан бас энэ салбарт нэлээн ажил хийсэн. Түүнчлэн өмнөх Засгийн газар 2026 оныг боловсролыг жил болгож зарлаж байгаа шүү дээ тиймээ. Түүнтэй холбогдуулаад олон ажил үйл ажиллагаа төлөвлөгдсөний нэг нь одоо орон нутгийн боловсролын хамрагдалтыг сайжруулах, цахим боловсролын чанарыг нэмэгдүүлэх гэх мэт тодорхой ажлууд төлөвлөгдсөн. Түрүүнд бас төсвийн тодотгол хийхдээ 2.3 их наяд төгрөгийг хэмнэнэ ээ, танана аа гээд хэлчихсэн. Энэ дотор нийгмийн салбар хамрагдах уу, боловсролын салбарын урсгал зардал, хөрөнгө оруулалт орох юм биш биз дээ гэдэг ийм асуулт байна.

Хамгийн сүүлд нь бас нэг тулгамдсан асуудал байна. Энэ бол зөвхөн минийх ч биш бүх одоо улс төрчдөд тулгамдаж байгаа асуудал. Сошиалаар улс төрчид бие биеийгээ намнаж байна. Үг хэлэх, үзэл бодлоо эрх чөлөөг хумьж байна аа. Янз бүрийн байдал үүсэж байна. Энэ дээр яг энэ сошиал орчин дахь хүний эрхийн зөрчилтэй өөрөө хэрхэн яг бодитойгоор тэмц...

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт сошиал орчинд хүний эрхийг хамгаалах тухай хууль зайлшгүй шаардлагатай юм байна гэдэгтэй би одоо 100 хувь эвлэрч эхэлж байна, эхэлж байгаа. Ер нь хүүхдийн эрхийг ч хангах асуудал, энэ олон улсын жишгийг дагаад сошиал орчноор мэдээллийн дайны өргөн хүрээнд явуулж байгаа байдал, мэдээллийн аюулгүй байдлын асуудал ер нь сошиалаар хагаралдуулдаг, сошиалыг дагадаг, сошиалаар төр шийдвэр гаргадаг болчих юм бол Монголын төрийн дархлаа алдагдана. Фэйк ньюс буюу одоо хуурамч мэдээлэл, энэ хагаралдуулах сонирхолтой гадаадын тусгай албадын үйл ажиллагаа ч гэсэн сошиал дайн хэлбэр мэдээллийн дайнаас психологийн дайн руу шилжсэн. Нөлөөллийн үйл ажиллагаанаас төрд нөлөөлөх хэмжээнд хүрсэн ийм ажиллагаа явуулж байгаа нь одоо Давосын эдийн засгийн чуулганаас энэ 21 дүгээр зууны хамгийн том эрсдэл бол цөмийн бөмбөг ч биш хиймэл оюун ухаанаар залуурдсан сошиал медиа гэдэг ийм дүгнэлт гарчихсан. Одоо хиймэл оюун ухаан юуг ч хийж болж байна шүү дээ. Хэнийг ч бүжиглүүлж, хэнийг ч дуулуулж, дүрс, дуу хоолой бүх юмыг дуурайж болж байгаа болчихсон. Ийм юм гаргаад л одоо хүнийг дуу хоолойг ч дуурайгаад л, ямар ч юм, хэнийг ч хагалж болно, гэр бүлийг ч салгаж болно, төр засгийг ч хагаралдуулж болно. Юу ч хийж болох хэмжээнд энд одоо 5 дугаар үеийн дайны хэрэгсэл болж нэрлэгддэг болсон.

Ийм учраас энэ сошиал орчинд нэн ялангуяа хүүхдийн эрхийг хамгаалах, хүний эрхийг хамгаалах асуудал бол дэлхийн улс орнуудын одоо гол тулгамдсан асуудал болоод түрүүчээсээ шийдэж эхэлж байна. АНУ хүртэл энэ сошиал медиа хиймэл оюун ухаан бол 2 үзүүртээ илд байна гэдгийг хүлээн зөвшөөрчихсөн. Ийм учраас энэ чиглэлээр манай Улсын Их Хурлын гишүүд бас санаачилгатай ажиллаж байгаа юм байна лээ. Наранбаяр гишүүн сошиал орчинд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль Боловсролын яамнаас санаачилсан юм байна лээ. Танай

ХҮН намын сонгогдсон гишүүн. Ингээд энэ Цахим шилжилтийн яам саналаа өгөөд Улсын Их Хуралд өргөн баригдахаар төлөвлөгдөж байгаа юм байна лээ. Торолгүй больё гэж байгаа юм билээ. Энэ санаачилгыг би дэмжиж байгаа.

Хэвлэн нийтлэх эрх чөлөөнөөс энэ бол тусдаа асуудал. Үг, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг ямагт дэмжинэ. Гэхдээ гадаад, дотоодын тусгай алба, зохион байгуулалттай бүлэглэл сошиалаар төр засгийн бодлого шийдвэрт гаргуулах хүний эрхэнд халдах энэ явдлыг төр засаг зөвшөөрч болохгүй. Зохицуулах шаардлага дэлхий даяараа бий болчихсон ийм хууль эрх зүйн орчин бүрдүүлж байгааг бид хараагүй юм шиг өнгөрөөж болохгүй. 150 гаруй орон ийм сошиалын зохицуулалтын эрх зүйн орчныг бүрдүүлчхээд байна. Монгол Улс хоцорчихсон байгаа.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга гүйцээж хариулах уу?

Г.Занданшатар: Энэ төсвийн төрийн хэмнэлтийн бодлого дотор бол нөгөө DOGE буюу Government Efficiency буюу Засгийн газрын бүтээмжийг нийтлүүлэх талаар нэлээн судалгаанууд хийгдсэн юм байна лээ. Тэгээд боловсролын салбарт бол цахимжуулалт, энэ зайн сургалт, хиймэл оюун ухааныг боловсролд ашиглах энэ цоо шинэ дижитал боловсролын И боловсролын шинэ платформыг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа. Боловсролын салбарын хөрөнгө оруулалтыг танах асуудал төсвийн тодотголын хэмнэлтэд одоогоор тусгагдаагүй байгаа гэдгийг онцолж хэлье.

Д.Амарбаясгалан: Занданшатар даргын микрофоныг 1 минутаар нэмж өгье.

Г.Занданшатар: Ер нь 3 дугаар цахилгаан станцад болсон дэлбэрэлт бол ер нь энэ эрчим хүчний салбарын үр ашиг, төрийн өмчийн компаниудын үр ашиг, авлигал, хариуцлагын асуудлын илрэл нь бол эндээс харагдаж байна гэж бодож байгаа юм. Ийм учраас бид нар бид бол энэ эрчим хүчний үйлдвэрлэлд нэн ялангуяа энэ цахилгаан станцууд, эрчим хүчний компаниудын үр ашгийг сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэх, ил тод байдлыг хангах, засаглалын менежментийн байдлыг шийдвэрлэх шаардлагатай. Энэ эрчим хүчний энэ онцгой стратегийн салбар дээр олон толгойтой удирдлага байж болохгүй. Хариуцлага эзэнтэй, бас ил тод, нээлттэй ийм удирдлагын тогтолцоог бүрдүүлэхгүйгээр энэ цаашдаа энэ эрчим хүчний аюулгүй байдлын асуудал ноцтой хэмжээнд хүрсэн. Энэ жилдээ засварлаж чадах юм уу, үгүй юм уу.

Энэ 10 хэдэн жилийн өмнө 40 сая доллароор засварласан турбин...

Д.Амарбаясгалан: Мөнхсоёл гишүүн тодруулж асууя.

Б.Мөнхсоёл: Ер нь бол аль болохоор асуултыг давтахгүйг хичээж байгаа. ХҮН намын зөвлөл дээр бас асуултууд асуусан. Одоо нэг сонирхолтой асуулт асууя. Бас иргэдэд сонирхолтой байж магад. Тэр юу вэ гэхээр намчирхалжилт энэ үгнүүд яасан урт үгнүүдийг жоохон яагаад байна шүү. Тэгээд талцалт хуваагдал одоо ихсэх юм бол энэ байдлыг хэрхэн даван туулах вэ? Энэ үүсэх одоо байгуулагдах Засгийн газрыг хэр удаан насална гэж төсөөлж таамаглаж, тооцоолж байгаа вэ гэж сонирхож асууя.

Дараагийн нэг сануулж хэлчихье бас. Тэр нь юу вэ гэхээр орон нутгийн сонгуулийн систем тогтолцоонд бас Улсын Их Хурлын сонгуульд оруулж ирсэн нөгөө давуу талууд бий болсон дэвшлээ орон нутгийн сонгуулийн системд бас оруулж ирээрэй хэмээн захъя.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Ер нь орон нутгийн сонгууль ер нь аливаа сонгуулийн хууль дээр ер нь парламент суудалтай бүх намууд хамтарч тэгш шударга сонгууль явуулах өрсөлдөөнт сонгууль явуулах нөхцөлийг хангахад хамтарч ажиллах ёстой. Сонгуулийн хуулийг батлахад одоо бүгдээрээ оролцож ажиллана гэж бодож байна. Тийм учраас аль болох төлөөллийн чадавхтай иргэдийн жинхэнэ хүсэл эрмэлзэл төлөөллийг хангаж чадахуйц сонгуулийн хуультай болох чиглэлээр орон нутгийн сонгууль дээр ч гэсэн энэ чиглэл нь зөв байх гэж бодож байна.

Зүгээр энэ талцал хуваагдлын хувьд бол би хэлээд байгаа юм. Тэр эвлэрэхдээ бид хуваагдахын хүрд, эвдрэхдээ бид хуваагдахын хүрд, эвлэрэхдээ бид үржүүлэхийн хүрд байсан түүхтэй ард түмэн. Дэлхий гаднаа ийм хүйтэрч, ийм гадаад орчин нөхцөл хүндэрч байгаа үед бид тогтвортой байхыг, тэгээд эвтэй байхыг бидний түүх сургаж байгаа. Ийм учраас бүхий л хүчин чадлаа эвлэрлийг олохын төлөө, эвлэрлийн төлөө бүх намуудтайгаа хамтран ажиллахыг эрхэмлэж...

Д.Амарбаясгалан: Тэгээд энэ орон нутгийн сонгуулийн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуудлаар ер нь улс төрийн намууд, парламентад суудалтай намууд бас санал солилцож байгаа. Ялангуяа хөдөө орон нутагт, сумын түвшинд явагдаж байгаа орон нутгийн сонгуулийг 100 хувийн пропорциональ элементээр явуулдаг болох, яг сумын ард иргэдийн дунд нэр хүндтэй иргэдийг нам харгалзахгүйгээр яг жагсаалтаар иргэд маань өөрсдөө чөлөөтэй сонгож чаддаг болох тэр боломжийг бий болгож өгөөч ээ гэдэг асуудал орон нутгийн иргэдээс бас их ирсэн.

Ер нь парламентад суудалтай намууд бол энэ дээр санал нэгдэж байгаа. Сумын түвшний сонгууль бол нэг тойрог. Тэр дотроо сумынхаа нэр хүндтэй иргэдийг иргэд нь чөлөөтэй сонгож чаддаг болох энэ боломжийг бий болгож өгөөч ээ гэдэг асуудал бас яригдаж байгаа. Тэгээд энэ чиглэл дээр Улсын Их Хурлын түвшинд ажлын хэсэг гарч мэдээж одоо Засгийн газраас тодорхой саналуудыг авч, цаашдаа энэ орон нутгийн сонгуулийн хуулийг батлах нь зүйтэй гэсэн ийм байр сууринаас хандаж байгаа.

Мэдээж одоо парламентад суудалтай намууд байгуулагдаж байгаа Засгийн газрыг бодлого үйл ажиллагааных нь хувьд тогтвортой байх чиглэл дээр бодитой дэмжиж ажиллах зайлшгүй шаардлагатай. Засгийн газар тогтворгүй байна гэдэг бол төрийн бодлогын тогтворгүй байгаагийн илэрхийлэл болж эхэлнэ. Тэгэхээр энэ байгуулагдаж байгаа Засгийн газрыг, томилогдож байгаа Ерөнхий сайдыг бодлогоор дэмжиж ажиллах чиглэл дээр бас энэ парламентад суудалтай улс төрийн намууд аль аль талаасаа анхаарч, хамтарч ажиллах нь зүйтэй гэж бодож байна. Занданшатар даргыг ч гэсэн бас парламентаас дэмжлэг аваад ажиллаж байгаа тохиолдолд парламентад суудалтай намуудтай яг парламентын түвшинд илүү нягт хамтарч ажиллаж, өөрийнхөө бодлого зорилгыг ойлгуулж, дэмжлэг авч ажиллаж байх нь зүйтэй шүү гэдгийг бас энэ ташрамд хэлэхийг хүсэж байна.

Лутаагийн Энхнасан гишүүн асуулт асууя.

Л.Энхнасан: Баярлалаа бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Ингээд Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшиж байгаа Занданшатар даргыг дэмжиж байгаагаа үүгээр илэрхийлье. Тэгээд ер нь бол өнөөдөр эдийн засаг ч хүнд байна, энэ улс төрийн ч хүнд ийм ээдрээтэй үед та Засгийн газраа байгуулах гэж байна. Тэгэхээр илүү хариуцлагатай ийм Засгийн газар байгуулагдана гэж би итгэж байна. Иргэд ерөнхийдөө энэ одоо байгуулах гэж байгаа Засгийн газар маань хэр удаан байх вэ, тогтвортой байх вэ гэсэн асуултыг их асууж байна. Энэ дээр бас ер нь бид өнгөрсөн хугацаанд олон сайд, олон амлалт, олон эхлэл сонслоо. Тэгэхдээ бол яг бодлогын тууштай байдал үнэт зүйлсийн залгамж жоохон хомс байна уу гэж бодож байна.

Тэгэхээр та энэ удаа таны тэргүүлэх энэ Засгийн газар тогтвортой байж чадах уу? Бодлогын тогтвортой байдал ил тод байх хариуцлагын механизмыг та хэрхэн, яаж харж байгаа вэ? Ер нь бол өмнөх Засгийн газар илүү улс орныхоо эдийн засгийн энэ асуудал мега төсөл энэ тэрд илүү анхаарч ажилласан. Харин би одоогийн энэ шинээр байгуулагдах гэж байгаа Засгийн газар илүү Монгол хүнийхээ хөгжил, хүн амынхаа бодлого дээр илүү анхаараасай гэж хүсэж байна. Яагаад ингэж хэлж байгаа вэ гэхлээр түрүүн манай гишүүд ч бас ярьж байна. Ер нь боловсрол, эрүүл мэндийн салбар дахь төсвийг нэмэгдүүлээсэй, 6 хувьд хүрээсэй гэж хүсэж байна. Тэрнээс ч илүү байж болно.

Та түрүүн бас ингэж одоо Дэлхийн эрүүл мэндийн байгууллага бол эрүүл мэндийн салбарын төсөв нийт төсвийн 6 хувь байх ёстой гэж ярьж байна. Тэгэхээр одоо яг Эрүүл мэндийн даатгал ямар байдалтай байна гэхлээр Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ улам явах ёстой. Гэтэл одоо сангийн орлого бол эмч, сувилагч, төрийн албан хаагчийн бас цалин урамшуулалд явж байна. Энэ нь хэр зохицтой вэ? Та дараачийн долоо хоногт хэрвээ төсвийн тодотголд орох юм бол энэ эмч, эмч нар, сувилагч, төрийн албан хаагчийн энэ цалин урамшууллын төсөвт тусад нь тусгах тийм боломж байна уу? Тэгвэл Эрүүл мэндийн даатгалаас очих, иргэдэд очих үйлчилгээ бол нэмэгдэх юмаа.

Хоёрдугаарт, таны хувьд Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог та яаж шинэчлэх ямар нэгэн бодлого баримтлах уу? Даатгалын сангийн тэнцлийг та...

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Ер нь иргэд бол Засгийн газрын насжилт, тогтвортой байдалд өндөр хүлээлттэй байгаа. Ер нь Засгийн газар бас төрийн бүх эрх мэдэл ард түмнээс эх сурвалжтай учраас ард иргэдийнхээ итгэлийг хүлээж мэдрэмжтэй, хурдтай, ухаалаг удирдлагатай, тогтвортой бодлого гэсэн 3 тулгуурт түшиглэх шаардлагатай гэж бодож байгаа. Энэ улс төрийн хэлбэлзэл намын дотоод зөрчил тэмцэлгүйгээр бүхий л намуудын дотроо хүний нам ч ХҮН нам ч тэр, Ардчилсан нам ч тэр, Ардын нам ч гэсэн Монгол Улсынхаа эрх ашгийн төлөө нэгдэж ажиллаж чадвал Монголын төр тогтвортой байна. Ард түмний аж амьдрал сайжирч, амьжиргааны чанар дээшилнэ.

Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчлэхдээ бол даатгалын сангийн зарцуулалтын үр ашиг, ил тод байдлыг үнэлж, санхүүгийн тогтвортой байдлыг

хангах шаардлагатай. Ер нь энэ эрүүл мэндийн салбарын ажлын цалин хөлсний талаар гаргаж өгсөн мэдээллээс үзэхэд сүүлийн 5 жилийн хугацаанд нэрлэсэн дүнгээр эрүүл мэндийн салбарын төсөв 2.4 дахин өссөн байгаа юм. Цалингийн хэмжээг дунджаар 2.2 дахин нэмэгдүүлсэн гэсэн дүнтэй байгаа. Одоогийн төсвийн нөхцөл байдал бол төсвийн урсгал зардлаа хэмнэх, төсвийн хэмнэлтийн горимд шилжих, зардлаа нэмэх биш танах шаардлагад ороод байгааг та бүхэн бол ойлгож байгаа байх. Эмнэлгийн дарга удирдлагуудад чөлөөтэй ажиллах эрх олгох, санхүүгийн эрх чөлөө олгох тэр хэмжээгээрээ өөрсдөө менежментийн орлогын нэмэлт эх үүсвэр олох, тэр хэмжээгээр цалин урамшууллаа нэмэх ийм боломжийг бас олгох шаардлагатай.

Эрүүл мэндийн даатгалын зардал оны эхний 5 сарын байдлаар бол 23 хувиар нэмэгдэж 1.1 их наяд төгрөгт хүрсэн байна лээ. Энэний 90 орчим хувь нь бол эмнэлгийн үйлчилгээний зардалд шингэж байгаа. Ер нь анхан шатны эрүүл мэндийн байгууллага, сум, өрхийн эмнэлгийн санхүүжилт ер нь хүндрэлтэй байгаа. Энэ чиглэлд бол түлхүү анхаарч ажиллах шаардлагатай байгаа. Томоохон төвлөрсөн хот суурин газруудын эмнэлэг бол хувьсах зардлын санхүүжилт саяны эрүүл мэндийн даатгал, энэ санхүүжилтийн үр дүнгүүдэд бол тодорхой хэмжээгээр ахиц дэвшил гарсан.

Ер нь манай улсын хэмжээнд улсын төсөвт төсөв дэх эрүүл мэндийн салбарын эзлэх хувийг 2028 он хүртэл үе шаттайгаар нэмэгдүүлж 6 хувьд хүргэхээр төлөвлөсөн байгаа. Таны хэлж байгаа 6 хувьд бол 2028 он хүртэл үе шаттайгаар нэмэгдүүлэхээр Сангийн яамны төсөв төлөвлөлт бодлогод туссан байгаа гэдгийг хэлмээр байна. Тэгэхдээ одоогийн нөхцөл байдал бол төсвийг тэлэх биш хумихаас өөр аргагүй нөхцөл байдалд орчхоод байгааг төсвийн орлого үлэмж хэмжээгээр тасарч байгааг та бүхэн энийг ойлгож байгаа байх гэж найдаж байна.

Д.Амарбаясгалан: Лутаагийн Энхнасан гишүүн тодруулж асууя.

Л.Энхнасан: Хөдөө орон нутгаар явахлаар нөгөө эмнэлэг, багш нар аягүй их бас нийгмийнхээ асуудлыг маш их асууж байна лээ. Хөдөө орон нутагт ипотекийн зээлийг нэмэгдүүлэх боломжтой юу? Энэ чиглэлээр ер нь ямар бодлого баримтлах вэ?

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Би өмнө дурдсан Орон сууцжуулалтын банкныг байгуулж нэн ялангуяа эмч, багш нарын орон сууцны хангамжийг сайжруулахад онцгой анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэж байгаа. Ер нь сувилагч, эмнэлгийн ажилтан нарын эмчийн цалинг нэмэгдүүлэх, урамшууллыг төсөвт тусгах нь салбарын тогтвортой байдал, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх чухал алхам юм. Үндсэн цалинг инфляцтай уялдуулж нэмдэг байх шаардлагатай. Ажлын гүйцэтгэлтэй холбох шаардлагатай, ачаалалтай нь холбох шаардлагатай. Ажлын ачаалал, онцгой нөхцөлийн харгалзан урамшууллын санг төсөвт суулгаж, тогтвортой эх үүсвэрээс санхүүжүүлдэг шаардлага байх хэрэгтэй. Бас тэр хэмжээгээр үр дүнгийн санхүүжилтийн тогтолцоонд шилжиж, одоо чөлөөтэй ажиллах, санхүүгийн хувьд ажиллах боломжийг эмнэлгийн дарга удирдлагуудад эмнэлэгт өгөх шаардлагатай гэсэн ийм чиглэлийг барих нь зүйтэй гэж үзэж байгаа. Хөдөө орон нутагт, нэн ялангуяа багш, эмч нарыг тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд орон сууцжуулалтын бодлогыг Орон сууцны...

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Ер нь орон сууцжуулалтын банк бол одоо 3 хувийн ипотекийн зээлийг үргэлжлүүлнэ гэсэн үг нэг талдаа. Нөгөө талдаа орон сууцны барилгажуулалтын асуудлыг сумд нь, аймагт нь, орон нутагт нь дэмжинэ гэсэн үг. Ингээд нийлүүлэлт эрэлт нийлүүлэлт хоёрыг холбож шийдэх замаар, санхүүжүүлэх замаар эмч, багш нар төдийгүй нийт иргэдийнхээ орон сууцжуулалтыг гэр хорооллын орон сууцжуулалтыг дэмжих ч ийм хандлага юм. Тийм учраас үүнийг цогцоор нь ингэж ярьж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Сархадын Зулпхар гишүүн асуулт асууя.

С.Зулпхар: Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүд болон Улсын Их Хурлын даргад энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Монгол Улсын Ерөнхийлөгчид Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Ерөнхий сайдад санал болгож байгаа Гомбожавын Занданшатарыг улс төрийн ажлынхаа туршлагын нь хувьд төрийн албаны одоо туршлагынх нь хувьд хувийн хэвшилд, санхүү, эдийн засгийн, одоо жишээ нь бодлогын чиглэлээр ажиллаж байсан туршлагынх нь хувьд, цаашлаад гадаад харилцаа, геополитикийн мэдлэг, туршлагынх нь хувьд нөгөөтээгүүр энэ эрдэм судлалын чиглэлээрх туршлагынх нь хувьд дэмжиж байгаагаа үүгээр илэрхийлж байна.

Гурван асуулт байна. Сая одоо нэр дэвшигч маань бас санал болгосон. Одоо Ерөнхий сайдад санал болгосон нэр дэвшигч маань хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ ээ гэдэг ийм тодорхой саналуудыг хэлж байна. Үүнийг бол онцгойлон дэмжиж байгаа. Атрын одоо 4 дүгээр аяныг хэрэгжүүлээд бид бас тодорхой хугацаа болж байна. Энэ хугацаанд бол үр дүнгүүд гарч байна. Тэгээд орон нутгаар яваад уулзахаар зэрэг энэ Атрын 4 дүгээр аяны хүрээнд газар тариаланг дэмжих чиглэлээр олгож байгаа зээлийг дунд нь одоо жишээ нь олгочхож байгаа. Тэгээд үүнтэй холбоотойгоор бүсийн өөрийнх нь одоо өрсөлдөх чадвараас хамаараад аж ахуйн нэгжүүд бол энэ зээлийг зарим нь авч чаддаг, зарим нь авч чаддаггүй гэсэн ийм санал ирж байгаа юмаа.

Өөрөөр хэлбэл одоо жишээ нь баруун бүсэд бол газар тариалан харьцангуй одоо сул хөгжсөн учраас төвийн бүстэй ингээд өрсөлдөөд эндээс зээл авахад их хүндрэлтэй байдаг гэсэн ийм саналууд ирсэн. Тэгэхээр цаашдаа одоо Монгол Улсын Засгийн газраас энэ атрын 4 дүгээр аяныг хэрэгжүүлэх хүрээнд бүсийн онцлогтой зээлийн багцуудыг гаргах одоо боломжтой юу? Энэ талаар та ямар санал бодолтой байна гэсэн нэгдүгээр асуулт.

Хоёрдахь асуулт Монгол Улсын Засгийн газар 2025 оны 4 сарын 2-ны өдөр 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгон зарлачихсан. Үүнтэй уялдсан байдлаар Засгийн газрын тогтоол гарчихсан. Тогтоол дээр бүх зүйл их тодорхой байна лээ л дээ. Тэгэхээр бол хэдийгээр одоо төсвийн байдал хүндрэлтэй байгаа ч гэсэн ирэх жилийн боловсролын одоо төсөв дээр ялангуяа одоо жишээ нь мэргэжлийн боловсролыг дэмжих замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийн одоо бодлогыг хэрэгжүүлэхэд анхаарах одоо шаардлага байгаа юм. Энэ дээр та бас ямар бодолтой байна гэсэн асуулт байгаа юм.

Гуравдахь зүйл Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд боомтын сэргэлт гэсэн одоо томоохон зорилт тавиад бид бас тодорхой үр дүнд хүрчихлээ. Энэ бол одоо сайн үр дүнгүүд гарч байна. Тэгэхээр одоо цаашдаа бол боомтуудаа нээх, одоо байнгын ажиллагаатай болгох, хатуу хучилттай авто замаар холбохтой ийм зорилтууд тавигдсан. Тэгэхээр энэ хүрээнд ер нь бас одоо бидний тавьсан зорилтуудыг үлдсэн хугацаанд, одоо ирээдүйд биелүүлэх боломж байна уу гэдэг ийм асуулт байгаа юм. Яг одоо үүнтэй уялдуулаад та бол өөрөө бол геополитик маш сайн мэддэг хүн. Бид хэд ер нь бол дэлхий нийтийн бас одоо геополитиктой уялдсан, гео эдийн засагтай уялдсан байдлаар бүс ба зам энэ одоо санаачилга байна. Шинэ торгоны зам байна, дундын коридор байна, ийшээ нэгдэх одоо боломж бий юу? Ийшээ нэгдэх одоо шаардлага бий юу? Ийшээ нэгдэх одоо бэлтгэлийг бид ойрын хугацаанд хангах боломжтой юу гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Боловсрол бол манай тэргүүлэх салбар мөн. Хүний хөгжлийн үндэс нь боловсролоос эхтэй. Боловсролд оролцуулж байгаа нэг төгрөг бол ирээдүйн 10 төгрөгтэй тэнцэнэ. Ядуурлын ч, соён гэгээрлийн ч, эдийн засгийн ч, нийгмийн ч бүхий л асуудлыг бол боловсролтой шууд холбож тайлбарлаж болно. Тийм учраас боловсролын жил болгосон санаачилга бол энэ нэн ялангуяа хүүхэд залуучуудын орон болох Монгол Улсын хувьд туйлын чухал. Монгол Улсын хэмжээнд нийт 1407 цэцэрлэг, 885 ерөнхий боловсролын сургууль, 70 техникийн болон мэргэжлийн сургуулиуд, 65 дээд боловсролын сургалтын байгууллага, өөрөөр хэлбэл их, дээд сургууль байдаг. Тэгэхээр энэ бүх шатны боловсролын байгууллагууд нийтдээ хүн амын 3-ны 1-ээс их нь буюу 1 сая 256 мянган хүүхэд залуучууд суралцаж байна.

Тийм учраас энд ажиллаж байгаа хүмүүсийн тоо ч гэсэн тэр үүнтэйгээ уялдаад боловсролын салбар бол яалт ч үгүй манай хүн амын хамгийн одоо зонхилох дийлэнх цэгийг хамарч байгаа ийм салбар. Энэ 55 мянган багш энэ салбарт ажиллаж байгаа. Ийм учраас энэ боловсролын тэгш бус байдлыг арилгахын тулд дижитал боловсролын шинэ платформыг бий болгох. Улаанбаатар хотын чадалтай эрдэмтэй багш нар математик, суурь боловсрол, хүмүүнлэгийн ухаан, хэл усны энэ боловсролыг одоо улс орон даяар цахимаар заадаг. Дижитал боловсролын платформыг хиймэл оюун ухааны боловсролыг гар утаснаас суралцах ийм шинэ программ төсөл хөтөлбөрүүд дэлхий даяар нэвтэрч байгаа, хиймэл оюун ухаан нэвтэрч байгаа. Ийм учраас хиймэл оюун ухааны боловсролтой уялдуулсан ийм боловсролын тогтолцоог энэ боловсролын жилийн гол нэг чиглэл болгож хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Манай Зулпхар гишүүн бол Алсын хараа 2050-ийг боловсруулахад боловсролын салбарт төдийгүй төрийн удирдлагын чиглэлийн энэ зохистой, бүтээмжтэй, үр ашигтай төрийн албыг бий болгох, боловсролын салбарын шинэчлэлийн урт хугацааны бодлого хөтөлбөрийг боловсруулахад идэвхтэй оролцсон ийм доктор судлаач хүн. Та бас энэ боловсролын жилийн чиглэлээр, бүсчилсэн хөгжлийн чиглэлээр саяын хэлж байгаа асуудлуудын чиглэлээр бас хамтарч ажиллаж, санал оноогоо өгч, энд бас нягт хамтран ажиллахыг ажлын хэсэгт идэвхтэй ажиллахыг бас хүсэж байна.

Ер нь энэ хүнсний хувьсгал хөдөө аж ахуйг дэмжих зээлүүд ч гэсэн бүсчилсэн хэлбэрээр олгогддог байх. Боомтын сэргэлтийг байнгын ажиллагаатай өндөр үр

ашигтай болгохын тулд боомтын эдийн засгийн үр өгөөж нэвтрүүлэх чадварыг сайжруулах шаардлагатай. Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулаад энэ атрын 4 дүгээр аяныг ч гэсэн бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулж энэ хүртээмжтэй зээл, хөнгөлөлттэй татварын бодлогоор нэн ялангуяа баруун бүс, алслагдмал бүс нутагт хөдөө аж ахуй тэр дотроо газар тариалангийн үйлдвэр атрын 4 дүгээр аяныг дэмжих бодлогыг бүсчлэн хөгжүүлэх ийм бодлогыг боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуултаа асууя. Уучлаарай.

Ө.Шижир: Улс төр, бас хувийн байгууллага, төрийн байгууллагад ажиллаж байсан ийм туршлагатай хүн бас Ерөнхий сайдаар томилогдох гэж байна. Тэгээд сая бас манай Их Хурлын гишүүд хэллээ. Хүнд нөхцөл байдлууд бас биднийг хүлээж байна. Ер нь бол одоо сүүлийн 10 жил дараалж Монгол Ардын Нам дангаараа одоо засагласан. Сүүлийн 11 сарыг эс тооцвол таныг 2019 онд Монгол Улсын Улсын Их Хурлын даргаар томилогдож байх үед Монгол Улсын 2020 оны төсөв бол 11.5 их наяд төгрөг байсан. Одоо ингээд 6 жилийн дараа 33.4 их наяд буюу 3 дахин өссөн. Төсөв 3 дахин өссөн, иргэдийн орлого 3 дахин өсөөгүй ээ.

Ингээд улсын төсвөө дагасан эдийн засагтай болоод улсын төсвийн тэлэлт нь урсгал зардал болоод ингээд бид нар одоо хойд хормойгоороо урд хормойгоо нөхдөг, олсон орлого нь зардалтай дөнгөж яг дөнгөн данган таардаг ийм улс болсон. Одоо ингээд сүүлийн 6 жилийн хугацаанд улсын төсвийн одоо тэлэлт 3 дахин явсан. Иргэдийн орлого бас 3 дахин нэмэгдээгүй ээ гэдгийг би танд хэлэх гэсэн юм. Мөн бид нар өдөр тутам үнийн өсөлтийн дунд амьдарч байна. 2020 оноос хойш өнөөдөр жил бүрийн одоо дундаж өсөлтүүдийг тооцож үзэх юм бол 55 орчим хувьтай гол нэрийн бараа бүтээгдэхүүний өсөлт ингээд өсчихсөн. Эсрэгээрээ Монголчууд бидний орлого олдог гол түүхий эдийн маань орлого тасралтгүй цаашид ийм буурах бас ийм чиглэлтэй байгаад байна.

Инфляц 8.3 хувь байгаа бол одоо 2 оронтой тоо руу орох бас ийм нөхцөл байдалд ирж байна. Засгийн газрын одоо өр бол 34.6 их наяд буюу түүхэн дээд хэмжээндээ хүрсэн. Өнгөрсөн хугацаанд монгол төгрөгийн худалдан авах чадвар валютын буюу америк ам.доллартой харьцуулах чадвар 800 төгрөгөөр одоо даруй суларлаа. Ингээд ийм нөхцөл байдлуудыг бид нар бас одоо та хүлээж авч байна. Ингээд Их Хурлын дарга түрүүн яриан дунд бас төсвийн давхардлуудыг байхгүй болгосон. Та одоо жишээ нь Эрчим хүчний яам, Эрчим хүчний үндэсний хороо, Эрчим хүчний зохицуулах газар гээд ингээд нэг чиглэлд ингээд 3, 4 давхардсан байгууллагууд байгаа. Мөн олон энэ үндэсний хороодуудыг бас эргэж хараарай гэж хүсэх гэсэн юм.

Тэгээд сайн муу нийлж сав дүүргэдэг гэдэг шиг бас та түрүүн яриандаа хэлж байна. Миний алдаа оноо бүгд ил байдаг аа гээд. Одоо иргэд өөрийн үзэл бодлоо илэрхийлснийх нь төлөө эсвэл сэтгүүлчид хэвлэл мэдээллийн байгууллагууд хэвлэн нийтэлснийх нь төлөө хохирдог, цагдаагийн байгууллагад дуудагддаг, дарга цэрэг нь гомдоод байдаг бас ийм байж болохгүй ээ.

Тэгэхээр би танаас одоо асуулт гэх юм уу, амлалт гэх юм уу нэг юм авмаар байна. Та өөрийн бүрэн эрхийнхээ хэрэгжүүлж байх хугацаанд та болон таны Засгийн газрын гишүүд үзэл бодлоо илэрхийлсэн хэвлэл мэдээллийн ажилтан сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагуудыг, иргэдийг нэг ч удаа хуулийн

байгууллагад гомдол гаргаж өгөхгүй ээ гэж та амлаж чадах уу? Энэ бол өөрөө ардчиллын бас аягүй маш том суурь зарчим шүү. Тийм учраас та энэ дээр одоо амлалт өгч чадах уу? Одоо юу гэдэг юм одоо та бол ил тод, таны бүх юм ил тод болно. Бүгд ил тод явагдах болно. Таны одоо буруу шийдвэр бодлогыг эсэргүүцэж одоо муухайгаар бичсэн...

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Бид бол нэг амлалт өгөөд байдаг биш, ажил хэрэгч ийм Засгийн газар байхыг л эрхэмлэнэ. Ер нь амлалт олон янз аа. Ер нь бүүр тодорхой хэлбэл Занданшатарыг юу гэж ч хэлж болно. Гэхдээ Занданшатарыг шүүмжлэх гэж байгаа юм гээд хүний эрхийг хэлмэгдүүлж, одоо гэр бүл, үр хүүхэд бусад зүв зүгээр гэмгүй хүмүүсийг хэлмэгдүүлж, иргэдийн хүний эрх, эрх, эрх чөлөөг хумьсан тийм аливаа бодлогыг бол зөвшөөрөхгүй ээ. Хуулийг дээдэлж ажиллана. Хуулийн засаглалыг хэрэгжүүлж ажиллана. Мэдээж төрийн өндөр албан тушаалтан бол одоо бодлогын мэтгэлцээн, ажил хэрэгч шүүмжлэлийг бол анхаарч авч ажиллах ёстой.

Ийм учраас төрийн нэр хүнд, ард түмний итгэлцлийг дааж ажиллах нь хамгийн чухал. Хамгийн гол нь хаа сайгүй л би бас түрүүн Лодойсамбуу гишүүнд ч хэлсэн. Хууль дээдэлж ажиллах нь л хамгийн чухал гэдгийг л би онцлон тэмдэглэж хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн тодруулж асууя.

Ө.Шижир: Яагаад үүнийг асуугаад байна вэ гэхээр сүүлийн судалгаагаар 233 сэтгүүлчийг хамруулсан судалгааны дүгнэлтэд 3 сэтгүүлч тутмын нэг нь ямар нэгэн байдлаар хуулийн байгууллагад дуудагдаж байсан гэсэн ийм дүгнэлт гарсан юм байна лээ. Тэгэхээр энэ өөрөө та түрүүн нөгөө нэг хэвлэл мэдээллийн индекс ярьж байсан энэ үзүүлэлтүүд хойшлоод байна гээд үүнтэй бас холбоотой байх л даа. Тэгэхээр би тэр түрүүн дахиж хэлж, одоо давтаж хэлэх гэж байгаа юм бол ер нь хүн одоо хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, редакц нар одоо таны зарим бодлоготой санал зөрөлдөөгүй, санал зөрөлдсөн эсрэг байр суурьтай байсных нь төлөө ямар нэгэн байдлаар та хуулийн байгууллагад нэг ч битгий хандаарай. Энэ бол өөрөө ардчилал, хүний эрх, эрх чөлөөний бас үндсэн суурь юм шүү гэж хэлэх гэсэн юм. Тэгээд танд ажлын амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууя.

Д.Пүрэвдаваа: Энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Асуултууд давхацсан учраас эдийн засгийн чиглэлийн олон асуулт асууя гэж бодож байсан. Тэгээд тэр чиглэл рүүгээ нэлээн тодорхой хэдэн асуултыг асууя гэж бодож байна. Нэгдүгээрт энэ төрийн худалдан авалтыг нууцад авч байгаад одоо худалдан авалт зохион байгуулдаг ийм асуудлууд байна. Энэ хүрээнд жишээ татаад нэг 2 жишээ татах юм бол Улаанбаатар хотын одоо гэр хорооллын энэ утааг бууруулах зорилгоор төрийн нууцад авч байгаад энэ түлшний үйлдвэрийг худалдаж авсан гэж ойлгож байгаа. Ногоон автобусыг худалдаж авсан гэж ойлгож байгаа. Тэгээд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд буюу төрийн 3 өндөрлөг санал нэгдээд, тэр худалдан авалтыг зохион байгуулдаг гэж ойлгосон.

Тэгэхээр өнгөрсөн хугацаанд энэ жишээгээр энэ түлшний үйлдвэрийг олон улсын тендер зарлаад заавал Хятад Ард Улсын бүтээгдэхүүн биш энэ технологийн

хувьд одоо хөгжсөн Герман, Япон гэх мэт одоо орны тэр үйлдвэрийг авч болоогүй юм болов уу? Та тэр худалдан авалтад нь оролцсон байдаг эсэхийг бас мэдэж болдог юм болов уу гэж нэг асуумаар байна. Цаашдаа энэ төрийн худалдан авалт нууцаар явах нь хэр зохистой байдаг юм. Таны байр суурь. Ер нь энэ Ерөнхий сайд болсныхоо дараагаар хэр их хэмжээний худалдан авалтыг та ингээд нууцад авч ер нь ажиллая гэж боддог юм бэ? Ингээд энэ нэг асуулт.

Хоёрдахь нь болохоор зэрэг 2024 оны жилийн эцсийн аудит бол хийгдээд дууссан. Жил болгон одоо 3 дугаар сард эхлээд энэ аудитын тайлангууд нэгтгэгддэг. Миний ойлгосноор санамсаргүй байдлаар би нэг 20 орчим байгууллагын аудитын дүгнэлтийг авч харлаа. Тэгэхэд одоо Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Зам тээврийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яам, дээрээс нь Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэс Монгол компани, Эрдэнэс Тавантолгой, Монголын төмөр зам, Төрийн орон сууцны корпорац гэх мэт 20 аж ахуйн нэгжийг ерөнхийлөн захирагчийн одоо төсөв нь хязгаарлалттай дүгнэлт гарсан байна.

Ард түмний татвараар бүрддэг төсвийг одоо зориулалт бусаар зарцуулсан байна гэдэг дүгнэлт гарсан байна. Та энэ дээр хэр их хэмжээний одоо хязгаарлалттай дүгнэлт гарсан талаар тоон мэдээ байна уу? Эдгээр асуудал дээр ямар хариуцлага тооцох вэ гэсэн байр суурьтай байна вэ?

Тэгээд нэмэлт нэг минутаа авчихъя шууд. 14 мега төсөл гээд байгаа өмнөх Засгийн газрын. Миний ойлгож байгаагаар мега төсөл гэдэг бол тухайн улсад эдийн засгийн бөгөөд санхүүгийн хувьд тогтвортойгоор үр өгөөж өгдөг...

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье. Нэмэлт минут тодруулахад зориулсан дэгийн хуультай. Тийм учраас тодруулж асуусан тохиолдолд өгнө өө. За Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Д.Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээр асуулт төрийн худалдан авалт. Төрийн худалдан авалт ил тод байх нь бол авлигыг бууруулж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх түлхүүр, бүх худалдан авалтыг цахим системээр нээлттэй зарлаж, гэрээний биелэлт, гүйцэтгэлийг олон нийтэд мэдээлдэг байх ийм зарчмыг тогтоох шаардлагатай гэж үздэг. Ил тод байдал л энэ төрд итгэх итгэлийг сэргээнэ. Бүр цаашилбал энэ хиймэл оюун ухаанаар тендер хүртэл сонгон шалгаруулдаг болсон байна. Ийм технологийн дэвшлийг ашиглах нь зүйтэй.

Төрийн худалдан авалтыг үндэслэлгүйгээр нууц зохион байгуулах нь авлига хэт үнэлгээ, үр ашиггүй зардлын гол эх үүсвэр болдог. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл гэдэг байгууллага бол бодлогын зөвлөмж гаргадаг л байгууллага болохоос биш ямарваа нэгэн худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг, чиглэл өгдөг субъект бишээ. Энэ гүйцэтгэх эрх мэдлийн субъект бишээ. Үндэсний аюулгүй байдалтай холбоотой тодорхой асуудлуудыг хуулийн дагуу төрийн онцгой шаардлагатай цөөн төслийг хуульд заасан хүрээнд нууцалж болно. Жишээлбэл одоо төрийн онц чухал объект барих ч байдаг юм уу. Дотор нь одоо юм хум суулгачхаж магадгүй зэвсэг техник худалдан авах ч байдаг юм уу. Төр болсон хойно одоо нүцгэн гүйгээд байж болдоггүй. Төмөр ил цагаан сүү хоёрыг энгэртээ хадгалж явдаг ийм субъектийн хүрээнд бол огт нууцгүй төр гэж байж болохгүй ээ. Тэр нууцлалын шалтгаанаар далимдуулж тийм зохион байгуулалттай ажил хийж болохгүй. Үүнийг бол хатуу хаах хууль хяналтын тогтолцоо зайлшгүй шаардлагатай.

Үүнийг хянадаг тогтолцоо нь одоо тагнуулын байгууллага ч гэсэн, тусгай хяналтын дэд хороо ч гэсэн төсөвт байдаг. Өөрөөр хэлбэл гүйцэтгэх ажил гэх мэтчилэн нууцлалын төрийн эрх мэдлийн хүрээнд хэрэгжүүлдэг ийм тодорхой нууцлах ажиллагаатай худалдан авалтууд байдаг. Энэ бол ил тод байдал бол төрийн бүх юмыг ийм юмыг ил болгож болохгүй гэсэн зүйлүүд бий.

Ийм учраас энэ хоёрыг бол хоёр ялгаж салгаатай авч үзэх нь үндэсний аюулгүй байдалд онц ач холбогдолтой. Төрийн нууцлалыг хангах шаардлагатай ийм худалдан авалтаас бусад худалдан авалтууд бол ил тод одоо санхүүгийн үр ашигтай чанартай байх энэ зарчим баримталж, энэ шаардлагатай бол Худалдан авалтын тухай хуульд өөрчлөлт оруулах чиглэлийг баримтлах ёстой юмаа гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Пүрэвдаваа гишүүн тодруулж асууя.

Д.Пүрэвдаваа: Хоёрдахь асуулт амжсангүй бололтой. Ялангуяа тэр аудитын дүгнэлтүүд мэргэжлийн байгууллага болох Улсын Их Хурлаас томилогддог Үндэсний Аудитын газар миний түрүүний дурдсан одоо байгууллагууд хязгаарлалттай дүгнэлт авсан байна. Тэдгээр дээр та ер нь нийт хэчнээн хэмжээний одоо төсвийн ерөнхийлөн захирагч байдаг юм, тэдгээрээс одоо хэд нь хязгаарлалттай дүгнэлт авчихсан байна аа. Ер нь энэ улсын төсвийг одоо буруугаар зарцуулсан, тогтоогдсон этгээдүүд дээр та ямархуу арга хэмжээ авч ажиллах вэ гэдгийг маш тодорхой хариулж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга нэмж хариулъя.

Г.Занданшатар: Би гүйцээгээд хариулчихъя. Бас энэ худалдан авалтад би ер нь тийм худалдан авалтад оролцож байсангүй ээ. Улсын Их Хурал бол гүйцэтгэх эрх мэдэлд оролцдог, нөлөөлдөг албан тушаал ч биш. Тийм учраас ямар нэгэн хэлбэрээр худалдан авах ажиллагаанд оролцож байгаагүй. Тендерийн тухай хууль буюу худалдан авах ажиллагааны тухай хуулиар, хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник байгууламж, ажил үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авах ажиллагааг одоо тодорхойлдог. Энэ нууцад хамааруулах асуудлыг Тагнуулын ерөнхий газрын тодорхойлолт зөвшөөрлөөр шийдвэрлэдэг юмаа.

Тэр аудитын дүгнэлтийн хувьд бол аудит бол Улсын Их Хурлын харьяа байгууллага. Улсын Их Хурал энэ хуулийн биелэлтийг яаж хэрэгжүүлж байгаа Засгийн газарт хяналт тавьдаг механизм нь ингээд Эрүүгийн хуулийн эрүүгийн зөрчил гэж үзвэл Авлигатай тэмцэх газар хууль хяналтын байгууллагад шилжүүлдэг. Эрүүгийн шинж чанартай биш хариуцлага захиргааны журмаар авах шаардлагатай гэвэл Засгийн...

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Тийм учраас би одоо ажил аваагүй байгаа учраас яг ямар хязгаарлалттай дүгнэлтүүд гэдэг талаар мэдээлэлгүй байна. Хэрвээ тийм эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр захиргааны хариуцлага хүлээлгэх шаардлагатай арга хэмжээнд хуулийг зөрчлөөс нь шалтгаалаад холбогдох арга хэмжээ, хариуцлагыг тооцож ажиллах болно. Энэ бол хариуцлагын, хариуцлагатай Засгийн газар

байгуулах суурь нь энэ аудит төрийн хяналт шалгалтын тогтолцоо мөн. Хуулийн дагуу л хариуцлага хүлээлгэж байх ёстой.

Д.Амарбаясгалан: Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Занданшатар дарга бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт сонгуулийн тогтолцоог маш их том зориг гаргаж хувь улс төржих амбицыг маш том эрсдэлд оруулж хийж чадсан. Тэгээд тийм учраас танд бас талархал илэрхийлье. Бид нар Улсын Их Хурлын сонгуулийн 1 дүгээр тойрог хангайн бүсэд хамт өрсөлдсөн. Хэдий богинохон хугацаа байсан ч гэсэн залуучуудад бас шударгаар өрсөлдөөд жалга довын бохир улс төр хийлгүйгээр цэвэр өрсөлдсөн. Тэгээд сонгуульд унасан ч гэсэн бас унаж босож болдгийг харуулж, энэ улс төрд одоо ингээд хатаагдаж, хат суусан чанараараа дахиж одоо ингээд Ерөнхий сайд болохоор орж ирж байгаа танд бол бас амжилт хүсье.

Тэгээд таныг Ерөнхий сайдаар томилогдох юм бол танай Засгийн газрыг мэргэжлийн Засгийн газар гэж байгуулаасай гэж хүсэж байгаа. Учир нь бол бид нар өнгөрсөн хугацаанд дан дээлтэй, давхар дээлтэй гэж яриад энэ Улсын Их Хурлын гишүүдээ сайдад томилоод одоо бүүр сүүлдээ дан байтугай бүүр хэдэн давхраар нь ч гэсэн гишүүдээ сайд болгож үзээд Монгол Улс олигтой үр дүнд хүрч хөгжиж чадаагүй. Тэгээд одоо бодит байдлыг нь ингээд орж ирээд харахад бол нэг дэх өдөр намын бүлгүүд хуралдаж байна. Хоёрдахь, гуравдахь өдрүүдэд ажлын хэсэг, Байнгын хороод хуралдаж байна. Дөрөвдэх өдөр, тавдахь өдөр чуулган хуралдаж байна. Сүүлдээ 126 гишүүнтэй болсон чуулган бүүр хонож өнжин хуралддаг болсон. Сайд нар тэнчээ Засгийн газрын ажлыг хийгээд байх цаг завын хувьд бол маш их. Одоо тийм хязгаарлагдмал байдал нөхцөл байдал харагдаад байгаа юм.

Тэгэхээр танай Засгийн газрыг дан дээлтэй мэргэжлийн Засгийн газар цомхон ажиллаасай гэж хүсэж байгаа. Энэ дээр бас нэг таны байр суурийг тодруулъя гэж бодож байгаа юмаа. Тэгээд асуулт нь төгрөг үнэ цэнтэй байхад та юу хийх боломж бололцоо байна гэж харж байна. Малын гаралтай түүхий эдийг үнэ цэнтэй болгоход юу хийх боломжтой гэж та үзэж байна. Хавтгайрсан халамжийг зоригтойгоор бууруулахад таны эр зориг юу хийж чадах вэ гэсэн иймэрхүү асуултуудад хариулт өгөөч ээ.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт давхар дээл гэдэг олон асуудлуудыг олонтоо хэлэлцээд нэгэнтээ шийдсэн асуудал. Улс төрийн шийдвэр гарчихсан гэж ойлгож байна. Ер нь энэ бол Үндсэн хуулийн 39.3, 4-д зааснаар Ерөнхий сайдын бүрэн эрх мэдлийн асуудал болж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр шийдвэрлэсэн. Энэ бол ямар бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх вэ, ямар үр дүнд хүрэх вэ гэдэгтэй л холбоотой асуудал. Түүнээс биш одоо юу гэж нэрлэх нь гол биш. Би түрүүн Төрийн байгуулалтын байнгын хороон дээр хэлсэн. Муур хар юм уу, цагаан байх нь гол биш ээ. Хамгийн гол нь хулгана барьдаг байх хэрэгтэй гэдэг үг бий. Тэгэхээр хамгийн гол нь энэ Засгийн газрын эцсийн зорилго бол ард түмний аж амьдралыг сайжруулах, хөгжил дэвшлийг авчрах явдалд л чиглэх ёстой.

Ер нь хавтгайрсан халамж гэж ярьдаг. Тийм учраас энэ халамжийн хавтгайрсан бодлого нь төсвийн дарамтыг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийн

урамшууллыг бууруулж, эдийн засгийн бүтээмжид сөргөөр нөлөөлдөг. Ер нь халамжийг зорилт бүлэгт нь шилжүүлэх хэрэгтэй. Зарим нэг одоо нэр төдий бодлогуудыг өөрчлөх хэрэгтэй байна. Одоо цалинтай ээж гээд л нэрлэдэг. Тэгтэл 50 мянган төгрөгийг ч юм уу одоо амьжиргааны баталгаажих доош юуг цалин гэж нэрлэх юм гээд хуулиараа тодорхойгүй асуудал байж байна. Зарим хүмүүс шүүмжилдэг юм. Энэ хүүхдийн мөнгө 1.7 их наяд төгрөг, маш олон сургууль, цэцэрлэг, цахилгаан станц барьчих мөнгө. Ингээд жил болгон ханшийг өсгөөд, импортыг дэмжээд ингээд зарцуулагдаад байна гэдэг. Хүүхдийн мөнгө бол халамж биш, хүн амаа дэмжсэн бодлого, хүний хөгжлийг дэмжсэн, хүүхдийн хөгжлийг дэмжсэн бодлого гэж бодож байгаа. Үүнийг харин илүү үр ашигтай болгох тал дээр ирээдүй өв сан хуримтлалыг бий болгох дээр бид анхаарч ажиллах ёстой.

Ер нь төгрөгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхийн тулд, инфляцыг хянахын тулд экспортыг л өсөх ёстой юм байгаа юм. Айлаар зүйрлэвэл одоо гадагшаа зардаг юмаа л нэмэгдүүлэх хэрэгтэй. Гадаадаас авдаг юмаа бага болгох хэрэгтэй. Импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих хэрэгтэй. Экспортын орлогоо өсгөх хэрэгтэй. Ингэж байж нөгөө валютын нөөц нэмэгдэл болж байж валютын ханш тогтвортой, төгрөг үнэ цэнтэй байна. Үүнийг л үйлдвэржилдсэн орон болно гэж байгаа юм. Үйлдвэржилтийн бодлогыг амжилттай хэрэгжүүлж байж л үйлдвэржсэн улс л ажлын байр бий болж ажлын орлого нэмэгдэнэ, амьжиргааны түвшин дээшилнэ, ажил эрхлэлт нэмэгдэнэ, тэгээд төгрөг үнэ цэнтэй байна. Үндэсний үйлдвэрлэл, төгрөгийн үнэ цэн, үндэсний валютын үнэ цэн хоёр бол хоорондоо салшгүй шууд холбоотой ийм үйлдвэрлэл.

Тийм учраас дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, төсвийн сахилга бат, төсвийн бодлого, төсвийн хариуцлага, мөнгөний бодлогын тогтвортой байдлыг хангах нь төгрөгийн ханшийг хамгаалах төгрөг үнэ цэнтэй байх үндэс суурь болдог. Тийм учраас энэ бол дан ганц төсвийн бодлого Засгийн газраас гадна Монголбанкны мөнгөний бодлого. Энэний үнэ цэн нь өөрөө хүү, мөнгөний үнэ нь өөрөө хүү нь юм. Тэгэхээр энэ хүүгийн, хүү бага байж байж үндэсний үйлдвэрээ дэмжинэ. Одоо энэ орчхоод байгаа чөтгөрийн тойрог шиг инфляц өндөр, инфляц нь импортоос шалтгаалдаг, валютын ханшаас шалтгаалдаг. Тэгээд ханшийн өсөлт нь эргээд үнийн өсөлтдөө нөлөөлдөг, зээлийн хүүгээ өндөр байлгадаг энэ тойргоос л зоригтой шийдлээр гарах шаардлагатай байгаа юм. Ингэж байж төгрөг үнэ цэнтэй болно.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Ийм учраас энэ үйлдвэржилтийн байнгын хороог Улсын Их Хурал дээр байгуулсан одоо нефтиэ дотооддоо үйлдвэрлэдэг болмоор байна. Хүнсээ дотооддоо үйлдвэрлэдэг болж хүнсний хувьсгал хиймээр байна. Аж үйлдвэржилтээ дэмжмээр байна. Мига төслүүд дотроос экспортыг дэмжих үйлдвэрлэлийг эхний ээлжид хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Ингэж байж эдийн засгийн өсөлт хангагдаж төгрөгийн тогтвортой байдал хангагдана. Халамж өөрөө манай улсын хувьд өрхийн орлогын тодорхой түвшинд хүрчихсэн учраас өрхийн зарлагад том нөлөө үзүүлэхээр ингээд суучихсан байгаад байгаа юм. Үүнийг л одоо бид эргэлтэд оруулж байх зайлшгүй шаардлага. Халамжаас хөдөлмөрт импортоос экспорт ийм бодлого руу чиглэх нь бол одоо энэ эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн бодлогын гол чиглэл байх ёстой. Энэ маань харин хаягдаад байгааг л засах шаардлагатай.

Д.Амарбаясгалан: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууя.

Ж.Чинбүрэн: Энэ өдрийн мэнд хүргэе. Нэр дэвшигч эрдэм мэдлэг боловсрол тодорхой юм байна. Улс төрийн 30 гаруй жилийн бас намтар түүх одоогийн бас одоо энэ Их Хуралд өвдөг шороодсон энэ тэр бол одоо улс төрч хүний хувьд бол энэ байдаг л зүйл гэж бодож байгаа юм тиймээ. Ер нь тамирчин хүн дандаа олимпын аварга байгаад байдаггүй шүү дээ. Тэгэхээр би бол бас харин давуу тал байгаа болов уу л гэж бодож байна. Тэгэхээр би бас Занданшатар нэр дэвшигчийн асуух гэж байгаа зүйл бол ер нь орон нутгийн сонгууль, Улсын Их Хурлын сонгуульдаа орон нутагт үзээд ингээд яасны дараа танд юу бодогдож байв аа?

Дараагийн нэг зүйл бол таныг 8 дахь удаагийн парламентын сонгуулиа бүрэлдсэн парламентын дарга байх үед бид бас их чухал зүйлүүд дээр хамтарч ажилласан. Ялангуяа эрүүл мэндийн салбарын эрх зүйн шинэчлэлийг хийх ажлын хэсэг байгуулан ажиллаж, тэгээд нэлээдгүй олон хууль тогтоолуудыг бид баталж чадсан. Үүнтэй холбоотойгоор бас бид эмийн чанарын асуудлыг түр хороо байгуулан эмийн чанартай холбоотой асуудлыг нэлээдгүй нухацтай ярилцсан. Болохгүй байгаа зүйлүүдийг ил гаргасан. Өнөөдөр бид Улсын Их Хурлаас 12 зүйл заалт тогтоол өгөөд байгаа боловч хэрэгжилт нь одоо хүртэл байхгүй байна. Үүнтэй холбоотойгоор бас Их Хурлын хууль, тогтоол Засгийн газар үүнийг ер нь юу гэж үзэх ёстой юм бэ? Та үүнийг байр сууриа хэлээч ээ.

Гуравдахь зүйл бид эрүүл мэндийн салбарын санхүүжилт бол бас тийм ч их бага биш ээ. Та түрүүн бас хэлсэн Бейсен гишүүний асуухад бас хариулж байна лээ. Нэлээдгүй их хувиар нэмсэн шүү дээ. Бид бол одоо ер нь 4 дахин нэмчхээд байгаа Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийг. Тийм учраас үүний зарцуулалтын оновчтой байдал үрэлгэн биш хэрэглээнд суурилсан хүн бүрд хүртээмжтэй байх энэ тогтолцоог яагаад хийж чадаагүй гэж бодож байгаа вэ? Ер нь Эрүүл мэндийн даатгалын сан маань Эрүүл мэндийн яамны харьяа байх нь зөв юм уу? Энэ дээр таны байр суурь ямар байх вэ? Ийм 3 асуулт асууя.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Эрүүл мэндийн даатгалын сан гэдэг бол 3 талын оролцоотой, төлөөлөлтэй, хяналттай, нийгмийн эрүүл мэндийн төлөөх сан байх ёстой. Өөрөөр хэлбэл эв санааны нэгдлийн зарчмыг хангасан ийм хуулийн үзэл санаатай сан хөрөнгө гэж бодож байна. Өөрөөр хэлбэл зөвхөн Эрүүл мэндийн яамны харьяанд байх ёсгүй ээ энэ. Яагаад гэвэл энэ ажил олгогчдын төлж байгаа нийгэмд Эрүүл мэндийн даатгалын шимтгэл ажилтны төлж байгаа Эрүүл мэндийн даатгалын шимтгэл ийм хоёр талаас тогтсон гурван талт механизмын үндсэн дээр сангийн менежмент явж байх ёстой. Зарцуулалт хөрөнгө оруулалт нь шийдэгдэж байх ёстой ийм сан.

Эмийн чанарын асуудал нь бол хяналтын сул тогтолцоо, хуурамч бүтээгдэхүүний эргэлт, импортын стандартгүй байгаатай холбоотой эм эмнэлгийн хэрэгслийн бүртгэл шалгалтыг олон улсын стандартад нийцүүлэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл эфтэй гээд одоо нөгөө Food and Drug Administration гэж байдаг. Тэрэнтэй энэ хүнс болон эмийн хүний амаар орж байгаа энэ бүх зүйл бол өндөр хяналттай байж байж хүний эрүүл мэндийг хамгаалах энэ бодлого нь нэгдсэн стандарттай хэрэгжих ёстой. Энэ зарчим систем рүү шилжүүлэх шаардлагатай гэж бас Их Хурал дээр олонтоо яригдаж байсныг та мэдэж байгаа.

Эрүүл мэндийн хүртээмжийг бий болгохын тулд анхан шатын тусламжийг бүх бүс нутагт чанартай тэгш хүргэх, хүний нөөцийн хомсдолыг эмчийн хомсдолыг шийдвэрлэх шаардлагатай байгаа. Эмнэлгийн санхүүжилтийг гүйцэтгэлд тулгуурлаж хийх, даатгалын сангаас чанартай үйлчилгээний худалдан авалтыг дэмжих бодлого одоо их чухал байна. Эрүүл мэндийн яамны харьяанд байлгах нь бол Эрүүл мэндийн даатгалын санг энэ яамны харьяанд байлгах нь бол ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй. Сан нь хараат бус, бие даасан мэргэжлийн удирдлагатай байж санхүүжилтийн үр ашиг ил тод байдлыг хангах нь зөв бодлого болно. Ийм ч учраас 3 талт механизмтай ийм институт шүү дээ. Их Хурлаар томилдог энэ 3 талт удирдлагын механизмыг. Үүнийг бол нээлттэй сонсголоор томилдог болсон. Ингэж энэ нээлттэй сонсголоор томилогдсон удирдлага бол сангийн хөрөнгийн үр ашиг. Эрүүл мэндийн даатгалын сангийн хүртээмж орлогыг нэмэгдүүлэх учиртай.

Эцэст нь тэр Улсын Их Хурлын сонгуулийн асуудал бол Черчиллийн хэлсэн үг ч байдаг. Ер нь би 4 удаа Улсын Их Хуралд сонгогдож ажилласан. Өмнө нь бол одоо Улсын Их Хуралд тэгчихлээ ингэчихлээ гэж бодогдохоосоо илүү парламент маань ийм олон намын төлөөлөлтэй. Бидний хийсэн одоо манай Их Хурлын дарга байна, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ байна. Бидний одоо хамтын манлайлал дор хэрэгжүүлсэн энэ улс төрийн реформын үр дүнд парламент олон намын төлөөлөлтэй эмэгтэйчүүдийн квот өссөн. Эмэгтэйчүүдийн төлөөлөл, залуучуудын төлөөлөл хангагдсан экспертүүд орсон ийм парламенттай болсонд би бидний хамтын бүтээлэг хүүхдийн энэ үр дүн сайн байгаад л баярласан. Улс төрийн реформын золиос нь бол тэрнийг хэрэгжүүлэгч нар нь байдаг тийм жам ёс байдаг. Тэгэхдээ үйлийн үр хаалга андуурдаггүй ээ гэсэн нэг үг байдаг.

Ийм учраас өнөөгийн нөхцөлд бид ухрах эрх байхгүй. Маш хүнд нөхцөл улс төрийн нөхцөл байдал. Ийм учраас энэ хэрэгжүүлсэн реформынхоо үр дүнг гаргах, бодитой болгох, Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийг ард түмэнд үр өгөөжтэй болгох ийм зорилгоор өнөөдөр би нэр дэвшиж байгаа гэж ойлгож байгаа.

Д.Амарбаясгалан: Чинбүрэн гишүүн тодруулж асууя.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Тэгэхээр ер нь одоо Занданшатар нэр дэвшигч таныг бас дэмжиж байгаа. Тэгээд Засгийн газар байгуулагдаад маш шуурхай яаралтай өдөр хоног алдалгүй төрийн үйл ажиллагаа зогсох ёсгүй ажиллах ёстой. Тийм учраас нөлөөлөлд авталгүй илүү мэргэжлийн сайн Засгийн газар бүрдүүлж, үйл ажиллагааг нэг хоног ч гэсэн алдагдуулахгүй, ард иргэдийн нуруун дээр үүрэгдээд байгаа энэ инфляц дээрээс нь энэ үнийн өсөлт, дээрээс нь энэ одоо цахилгаан станц дэлбэрчихсэн, одоо намар болчихсон энэ бүх ачааг одоо яаралтай үүрэх энэ ажлаа эхлэх үйл ажиллагаагаа түргэн хурдан эхлүүлж амжилттай явуулахыг хүсэн ерөөе.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Гомбожавын Занданшатар нэр дэвшигчээс Монголын Засгийн газрууд тэргүүлэх эрэмбээ зорилгоо тодорхойлж бас нэршлүүд өгдөг. Эвслийн Засгийн газар, Шинэчлэлийн Засгийн газар, Шийдлийн Засгийн газар, Эв нэгдлийн Засгийн газар, Хурдтай хөгжлийн төлөөх зориг Засгийн газар гээд. Таны бодлогын тэргүүн эгнээнд ямар одоо тодотголтой байх вэ? Эндээс жирийн иргэдэд энэ бүх нарийн мэдээлэл бол хүрч очиж чаддаггүй ч гэсэн энэ Засгийн газрын

зорилгыг агуулсан тэр үгнээс, тэр тодорхойлолтоос энэ Ерөнхий сайд ямар манлайллын зарчмыг хэрэгжүүлэх гээд байгаа юм бэ гэсэн толь нь харагддаг. Энэ дээр хариулт авъя.

Хоёр, 68 Гишүүнээс 19 дэх гишүүн өмнөх гишүүд бодлогын асуултууд их асуусан учраас танаас үнэт зүйлсийн асуулт асууя. Таныг одоо Ерөнхий сайдаар томилогдоод ажиллахад таны гол баримтлах манлайллын зарчим чинь юу юм бэ? Олон зүйлийг зөв хийж чадахаас илүүтэйгээр хандлагын манлайлал асар чухал. Монголчууд хэлдэг. Азарганы дэл хаашаа адууны зүг тийшээ гэж. Тэгэхээр удирдагчийн энэ манлайллын зарчмын гол түлхүүр үгнүүд түлхүүр зарчмууд юу байх вэ? Жишээлбэл танхимын гишүүддээ ямар шаардлага тавих юм бүгдийг нь хөрөнгө орлогын мэдүүлгээс гадна орлогоо яаж нотлох вэ ч гэдэг юм уу, яг тодорхой баг бүрдүүлэхдээ ямар шаардлага тавих вэ?

Дараагийн асуулт Монгол Улсын Ерөнхий сайд гэдэг бол 2 мянга илүү жилийн төрт ёсны түүхтэй, Монгол төрийн алтан жолоо цулбуурыг асар том хариуцлагатай үүрч байгаа улс төрийн зүтгэлтэн. Энд таны давуу тал бас сул тал юу байна? Та өөрөө үүнийг юу гэж харж байна?

Бодлогын хэдэн асуулт байна. Нэг, Засгийн газрынхаа яамдын тоог бууруулах уу? Иргэд бол үүнийг хүсэж байна. Эхнээсээ яамдынхаа тоог 20-иос дотогш нь чадвал 15-17 руу оруулах юм бол иргэдийн дэмжлэгийг шууд авна. Өөрөөр хэлбэл төр хэмнэлт энэ бодлогын үр дүнтэй байдлаа гүйцэтгэх засаглалаасаа эхлэх нь асар чухал. Энэ дээр хариулт авъя.

Хоёр, хүний эрхийн асуудал. Зүй бусаар асар олон хүний амь нас эрсдэж байгаа улирлын чанартай утаа, үер. Энэ зүйл дээр сэтгэл хөдлөл биш суурь судалгаатай ажиллах тал дээр та ямар бодолтой байна? Дараагийн асуулт, Эрүүл мэндийн төсвийг улсын төсвийн 6 хувьд хүргэж чадах уу? Дараагийн асуулт, боловсрол хот хөдөөгийн ялгаа байна. Хүүхэд эцэг эх нь хөдөө хотод хаана аж төрж байгаагаас шударга бус байдлын тэгш бус гарааны боловсролоос эхэлж байгаа. Энэ дээр та ямар бодлого баримтлах вэ? Тав. Та авлигатай нүд цавчилгүй, нам харгалзахгүй тууштай, хуулийн хүрээнд популизм хийхгүйгээр тэмцэж чадах уу? Зургаа Бизнес эрхлэгчдэд татварын орчин, нийгмийн даатгал дээр та яг ямар байр суурьтай байх вэ? Эдгээр асуудал дээр маш товч үгээр тодорхой хариулт авъя. Дараа нь тодруулъя.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Ямар нэршилтэй байх вэ Засгийн газарт. Ширчингийн Сүхбаатарын Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт, Засгийн газар бол ямар нэршилтэй байх нь гол биш гэж би бодож байгаа. Муур хар юм уу, цагаан байх нь юу гэж нэрлэх нь гол биш хамгийн гол нь хулгана барьдаг байх хэрэгтэй гээд би түрүүн хэлсэн нь үр дүнтэй, эвийг эрхэмлэсэн, ард түмнийхээ төлөө байдаг, ард түмнийхээ тэгээд хамтарч асуудал шийддэг, ард түмэнтэйгээ ойрхон Засгийн газар байх л ийм зорилт дэвшүүлж ажиллана гэж бодож байна. Ер нь үнэт зүйлийн хувьд бол бид нэг Монгол бүгдээрээ л нэг Монгол. Нэгдмэл үнэт зүйлтэй. Ийм нэгдмэл үнэт зүйл бий болгохгүй бол аливаа улсын нэг идеологи үнэт зүйл гэж байна. Америк дрийм гэдэг шиг. Одоо америк мөрөөдөл, хятад мөрөөдөл дэлхийн ардчиллын үнэт зүйлсийг эрхэмлэсэн

нэг нэгдмэл үнэт зүйлтэй. Энэ хоёр, гурван мянган жилийн төрт ёсны түүхтэй Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын хамгийн гол угийн үндэс нь монгол хүн бүрийн үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бий болгох явдал юм гэж бодож байна.

Өнөөдөр бол монгол үндэстэн нийтээрээ нэг Монгол болж сөрөн тэсвэрлэх чадавхаа сайжруулах явдал бол үндэсний аюулгүй байдлын асуудал, иргэн бүрийн анхаарах асуудал болсон. Ийм учраас нэг Монгол гэдэг үнэт зүйл бол энэ Засгийн газрын үнэт зүйл байх ёстой гэж би бодож байгаа юм.

Яамдын тоог бууруулах ч гэсэн тэр одоо алга ташуулахдаа гол биш ажил үр дүнтэй байхдаа л чиглэж энэ Засгийн газар ажиллах ёстой. Хүний эрхийн тэмцэлд бол эцсийн цэг гэж үгүй ээ гэж хэлсэн. Хүний эрхийн дэд хороотой хамтарч хүний эрхийн комисс ч бий. Засгийн газар бол хууль биелүүлдэг байгууллага учраас хуулийн биелэлт, хэрэгжилтийг хангахад хүний эрхийн мэдрэмжтэй байлгах нь ойлгомжтой. Засгийн төрийн механизмыг ажиллуулдаг байгууллага. Харин хүний эрхийн хяналт тавьдаг комисс нь Улсын Их Хурлын харьяанд Улсын Их Хурлын дэд хорооны дэргэдээ ингээд ажиллана. Үүнийг бол дэд хорооноос санал гаргаад хүний эрхийн маш олон аспектүүдээр хамтран ажиллах бололцоотой. Түрүүн би тодорхой хариулсан.

Эрүүл мэндийн төсөв 6 хувьд 2028 онд хүрэх зорилтыг энэ Засгийн газраас дэвшүүлсэн юм байна лээ. Тэр чиглэлийг барьж ажиллана. Авлигатай тэмцэж чадах уу гэж байна. Би дээр хэлсэн. Улсын Их Хурал парламентын хяналт шалгалтын хуулийг баталж, ард түмний мэдэх эрхийг хангаж, одоо түрүүн хэлсэн ногоон автобусны, нүүрсний, Хөгжлийн банкны гэх мэт дөрөв, таван эмийн чанарын гэх мэт одоо олон нээлттэй сонсгол зохион байгуулж, парламентын хяналт шалгалтын эрх мэдлийг нэмэгдүүлсэн. Энүүгээрээ би зүгээр үгээр биш үйлдлээрээ авлигатай тэмцэх манлайллыг харуулж чадсан. Үйлдлээрээ тэмцсэн ийм улс төрч гэж би өөрийгөө баттай хэлж чадна. Яагаад гэхээр энэ хугацаанд авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан. Авлигалын эсрэг багц хуулийг баталсан. Эрүүгийн хуулийг авлигын гэмт хэрэгтэй тэмцэх ялын бодлогыг чангатгасан, ялын дээд хэмжээ оногдуулдаг болсон. Хөрөнгө хураах хууль чинь тэнд бодитой туссан.

Ийм учраас энэ зүгээр попролтоор ч юм уу, үг хэлээрээ биш бүх асуудлыг парламент ёсны түүхэнд цоо шинэ хуудас нээсэн алхмууд болж, маш олон хулгай луйврын схемүүдийг телевизээр нотлох баримттай нь дэлгэж байсан энэ сонсголудаар. Гэм буруу үйлдсэн эсэхийг зөвхөн шүүх тогтоодог. Энэ бол парламентын буюу ард түмний мөрдөн шалгах хэлбэрийг Монголд нутагшуулсан ийм анхны чиг хандлага болсон. Тиймээс би бол авлигатай, хулгайтай тэмцэх улс төрийн зориг манлайллын үгээрээ биш, үйлдлээрээ манлайлж харуулж ирсэн улс төрч өө гэж боддог оо.

Татварын реформын хувьд би бас тодорхой чиг баримжаатай хүн. Би нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг нэмэгдүүлэх замаар, 5 хувьд хүргэх замаар татварын тэгш төлдөг зарчмыг нутагшуулж, энүүгээрээ татварын орлого ч гэсэн нэмэгдэнэ гэдэгт итгэлтэй байгаа. Харин тансаг хэрэглээний татвар тэр архи, тамхины татвар, өндөр орлогын татваруудыг бий болгож, энэ ард иргэдийн төлөө төлөөд байгаа 7 буудлын Долгор эмээгийн төлөөд байгаа тэр татварыг бууруулаад, харин долоо, 800 саяын одоо...

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэболд: Манай Улсын Их Хурал дахь Хүний эрхийн дэд хороо бас энэ Жендерийн байгууллагатай хамтарч ажилладаг. Тэгэхээр ер нь засгаа бүрдүүлэхдээ ч тэр, цаашдаа гүйцэтгэх засаглалын тодорхой ажил хариуцах томилгоонууд дээрээ ч гэсэн энэ жендерийн тэгш мэдрэмжтэй байдлыг бас харгалзан үзээсэй гэж хүсэж байна. Энэ дээр таны байр суурийг сонирхъя. Энэ 6 асуудалд яах вэ одоо бүгдийг нь хариулж амжихгүй ч гэсэн дараах 6 асуудалд бас одоо энэ дараа дараагийн асуулт хариулт дээр бас өөрийн итгэл үнэмшлээ илэрхийлээсэй гэж хүсэж байгаа. Яагаад гэвэл энэ бол протоколд үлдэх ёстой байх аа. Монгол төрийн сайд Ерөнхий сайд тодрох гэж байгаа учраас. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах нэг экспортын орлогыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, бизнесийн орчныг сайжруулах, иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, дэд бүтцийн хөгжлийг эрчимжүүлэх, салбарын бүтцийн өөрчлөлт гэсэн энэ 6 зүйл богино, урт хугацааны бодлогуудаа иргэдэд ойлгомжтойгоор, олон улсын түншлэлтэй одоо сайн хөгжүүлж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж ажиллахыг хүсэж байна. Энэ дээр бас товчхон байр сууриа хэлээч ээ.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Нэг минутад багтааж хариулахад нэлээн олон асуулт байгаа учраас би танд амжихгүй бол цаасаар дараа нь тодорхой асуулт, хариултыг хүргүүлэх болно. Жендерийн тэгш байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах, сонгуулийн жендерийн квотыг оруулах асуудлаар одоо алтай дамнасан тогтвортой байдлын яриа хэлэлцээ, жендерийн эрх тэгш байдлаар би 2023 оны 6 сард олон улсын хурал зохион байгуулж, тэндээс бас Улсын Их Хуралд зөвлөмж хүргүүлж, энэ жендерийн квотыг нэмэгдүүлэх, 2028 онд 40 хувь болгох энэ санаачилга ажлуудыг Сонгуулийн хуульд тусгуулах чиглэлээр ажилласан. Манай эмэгтэй гишүүд үүнийг сайн мэдэж байгаа.

Ийм учраас тэндээс та жендерийн мэдрэмж, эмэгтэйчүүдийг дэмжих бодлогын талаар миний хийж хэрэгжүүлсэн ажлуудаас энэ талаар тодорхой харж болох байх гэж бодож байна. Бусад 6 асуултын талаар бол энэ 30 секундэд хариулж амжихгүй учраас би танд.

Д.Амарбаясгалан: Нэг минут нэмчихсэн байгаа.

Г.Занданшатар: Энэ 6 асуулт бол макро эдийн засгийн тогтвортой байдал, манай энэ импортын эдийн засаг, нүүрсний экспорт, экспортын нөхцөл байдлаас шалтгаалаад хүндрэлтэй байгаа талаар зөндөө ярьсан. Тэгээд энэ 6 асуудлаар би дэлгэрэнгүй танд мэдээлэл өгье. Ажлаа авч байгаад өгье. Энэ бол нэлээн цогц том бодлогын асуудлууд учраас Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай хууль оруулж ирэхдээ энэ талаар тодорхой мэдээлэл өгье гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууя.

О.Батнайрамдал: Та бүхэндээ энэ оройн мэндийг хүргэе. Монгол Улсын Ерөнхий сайдад 34 дэх Ерөнхий сайдад нэр дэвшиж байгаа Гомбожавын Занданшатар даргыг бол хувь хүний хувьд дэмжиж байгаа. Анх Занданшатар даргатай 2014 онд санаж байна. Стэнфордын их сургуульд зочин судлаач байхад нь очиж танилцаж байсан. Мэдээж өндөр боловсрол, мэдлэг, туршлагатайн хувьд

бол ярих юм байхгүй дэмжиж байгаа. Тэгэхээр танд би нэг 2 цогц асуулт байгаа юм. Энэ завшааныг ашиглаад асуумаар байна л даа.

Нэгдүгээрт, Оюу Толгойтой холбоотой. Ер нь Монгол Улсын эдийн засгийг том зургаар нь сүүлийн 20 жилийн одоо туршид аваад үзсэн ч гэсэн хамгийн ач холбогдолтой нь бол Оюу Толгой төсөл явсаар ирсэн. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хэмжээг нь аваад үзсэн ч гэсэн. Тэгэхээр бид нар 2009 онд Оюу Толгой тэр хөрөнгө оруулалтын гэрээ байгуулснаас хойш даруй 16 жил буюу яг хагас нь өнгөрсөн байна. Одоо яг Оюу Толгой дээр бас нэг нөхцөл үүсээд байгаа нь одоо Оюу Толгой бүлэг стратегийн ордын одоо нийт тэр хүдрийн нөөцийн нийт Оюу Толгойн бүлэг ордын нийт баялгийн нөөцийн 32 хувь нь оршиж байгаа энэ Онтре ХК-тай одоо Онтретой одоо шинэ хөрөнгө оруулалтын гэрээ. Яг Оюу Толгойн Орано дээр хийсэн шиг одоо зайлшгүй хийх ийм цаг хугацааны асуудал эсвэл нэг үүлэн чөлөөний нар гэж харагдаад байгаа юм л даа. Тэгэхээр Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар тухайн үедээ бол Оюу Толгой дээр 2.3 тэрбум долларыг бас Монголын талд төлөгдөх ёстой байсан өрийг тэглэж өв үлдээсэн. Тэгэхээр та энэ Онтре дээр бас шинэ хөрөнгө оруулалтын гэрээ хийх үү?

Хоёрдугаарт, Оюу Толгой дээр бас нэг одоо яг 2025 онд бас нэг үүлэн чөлөөний нар одоо үүлний цаагуур цухуйж байгаа нь бол зээлийн хүүтэй холбоотой. Бид нар Оюу Толгой төсөл дээр 20 орчим тэрбум долларын зээлийн хүү нь өнөөдөр нэг 11.1 хувь байгаа юм. Үүнийг бид сая нийслэлийн одоо саяхан гаргасан бондтой харьцуулах юм бол 3.35 хувиар илүү хүү бид нар нэг ёсондоо хүүгийн хүү төлөөд явж байна гэсэн үг л дээ. Тэгэхээр энэ хүүг дахин авч хэлэлцэх хуулийн одоо эрх бид нар хувь нийлүүлэгчдийн гэрээгээр олгосон эрх нь энэ 2025 оны 12 сарын 31 гээд дуусах юм. Нэг ёсондоо тэр үүлэн чөлөөний нар маань жаргана гэсэн үг. Тэгэхээр энэ 6 сарын хугацаанд бид энэ зээлийн хүү дээр одоо ахиц гаргах шаардлагатай байгаа юм л даа. Тэгэхээр үүнийг та анхаараасай гэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт, ер нь яах вэ Монгол Улсад яг тулгамдаж байгаа гол асуудлууд бол буцаад л байгалийн баялгийн хуваарилалтыг нь одоо нэг ёсондоо бараг л тэмцэл л дээ. Тэгэхээр ер нь бид нар Үндэсний баялгийн сан байгуулж байж ард түмэн рүү олон нийт рүү урсах тэр шуудууг нь нээж өгөх нь өгнө. Тэгэхээр яг энэ Үндэсний баялгийн сангийн хуулийг батлахын тулд Үндсэн хуульдаа тусгаж оруулж байж энэ цаашаагаа ер нь хийгдэх одоо зайлшгүй шаардлагатай байдаг. Тэгэхээр энэ яг тухайн үедээ та бас Улсын Их Хурлын дарга байж байхдаа энэ Үндэсний баялгийн сан...

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга асуултад хариулъя. Нэмэлт нэг минутын зориулалт нь тодруулж асуухад зориулагддагийг одоо гишүүддээ бас. Тэгэхгүй бол одоо минут нь дууссан ч гэсэн нэг минут нэмж авъя гэдэг байдлаар ажил бас сунжирч байгаа. За Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Монгол Улсын Засгийн газар Оюу Толгой Рио Тинтой татварын маргаантай байсаар ирсэн. Би 2017 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ажилд ороод энэ асуудлаар цэг тавьж, татварын газар акт тавьчаад орхичихсон байсныг Оюу Толгойд энэ татварын актыг тавиулж, анхны энэ маргааныг эхлүүлсэн татварын маргааныг эхлүүлсэн юм. Зүгээр сууж байхаар зүлгэж суу гэж тэр татварын актыг тавьсны үр дүнд Дубайн гэрээгээр хориотой тавьж болохгүй гээд бүүр тас хориглочихсон байсныг татварын тэр актыг тавиулсан.

Татварын актыг тавиулсны үр дүнд тодорхой татвар төлөгдсөн. Одоо бусад татвараар нь одоо хүртэл маргаантай явж байгаа. Энэ асуудлаар Рио Тинтогийн төлье гэсэн татвар нь үнэндээ гэм буруугүйн болзолтой ойлголцох агуулгатай тохиролцоо байсан гэж үздэг. Тийм учраас татварын маргаанаар ажлын хэсэг байгуулж би ажиллаж байсан Хэрэг эрхлэх газрын дарга байхад.

Ийм ч учраас дараа нь Улсын Их Хуралд ирээд 102 дугаар тогтоолыг батлуулж, Дубайн гэрээг хүчингүй болгох, энэ татварын маргааныг үргэлжлүүлэх, Оюу Толгойтой цоо шинэ нөхцөл шаардах гэсэн энэ тогтоолыг баталж энэний үр дүнд Дубайн гэрээг хүчингүй болгох энэ Оюу Толгойтой гэрээ хэлцэл шинээр явагдсаныг та сайн мэдэж байгаа.

Ийм учраас ер нь энэ асуудлыг Их Британийн шүүхэд өгөөд, арбитраар явна гэсэн олон асуудлууд байдаг. Онтрегийн хувьд бол би одоо бие дааж өнөөдөр мэдэгдэл хийх боломжгүй байна. Үүнийг судалж байж тэгэхгүй бол гадаад, дотоодод харж байгаа үед ингэж цээжний бангаар ярих нь зохимжгүй. Зүгээр хувийн байр суурь бол тусдаа гэрээ хийх нь зүйтэй гэж боддог. Ер нь үүнийг бас гадаад, дотоодгүй ажиглаж байгаа, гадаад хөрөнгө оруулалттай бас холбоотой асуудал учраас Засгийн газар, Сангийн яам холбогдох яамтай нь нухацтай ярьж байж мөн Улсын Их Хурлаас оролцсон энэ ажлын хэсэгтэй хэлэлцээд, тодорхой шийдэл гаргаж байж ярих нь зүйтэй. Бүх хөзрөө өнөөдөр дэлгээд яриад байх боломж алга.

Д.Амарбаясгалан: Отгоншарын Батнайрамдал гишүүн тодруулж асууя

О.Батнайрамдал: Тэгэхээр Оюу Толгой дээр энэ Онтрегийн асуудал дээр та Засгийн газрынхаа хүрээнд үүнийг бас яаралтай шийдээсэй гэж бас чин сэтгэлээсээ хүсэж байгаа юм. Энэ бас яах вэ нөгөө талаасаа бас бидний хувьд гарч ирж байгаа бас том боломж болов уу гэж харж байгаа юм.

Хоёрдугаарт нь бас танаас түрүүн асуух гэж байсан нөгөө Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Үндэсний баялгийн санг бид нар 6.2 дээр Үндсэн хуульдаа оруулж байсан, тэгээд оруулсан. Тэгэхээр энэ хуулиа бид нар бас мөнгөжүүлж, амилуулж байж бас баялгийн илүү одоо шударга хуваарилалтыг бид нар цаашдаа хийнэ. Тэгэхээр энэ дээр бас таны бас байр суурийг сонсмоор байна, сонсьё.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга нэмж хариулт өгье.

Г.Занданшатар: Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг оруулж байхад ард түмний зөвлөлдөх санал асуулгаар ард түмний гаргаж байсан санал дээрээс үндэслээд Үндсэн хуулийн 6.2-т заасан одоо байгалийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд тэгш, шударга, хүртээмжтэй, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга, хүртээмжтэй байх Үндэсний баялгийн сангийн хуулийг батална гэсэн агуулгатай заалтыг Норвегийн Үндсэн хуулиас эшилж аваад, тэгээд бид нар оруулж байсан манай Батнайрамдал тэр үед Хэрэг эрхлэх газарт ажиллаж байсан. Энэ санаачилгыг Үндсэн хуульд одоо анх оруулсан хүний хувьд үүнийг хэрэгжилтийн төлөө би уйгагүй ажиллана. Энэ бол бидний хүсэл мөрөөдөл. Энэ Норвегийн сан шиг ийм Үндэсний баялгийн сантай болчих явдал бол Монгол Улсын эдийн засгийн тусгаар тогтнол, аюулгүй байдлын тулгуур багана болох учраас энэ бол одоо миний зөвхөн хүсэл мөрөөдөл төдийгүй, энэний санаачилга ард түмнээс эх сурвалжтай учраас зөвлөлдөх санал асуулгаар энэ байгалийн баялагтаа яаж үр өгөөжтэй байх

вэ гэдгийг олон шөнө бодож энэ Үндэсний баялгийн сангийн агуулгыг Үндсэн хуульд суулгасан хүний хувьд...

Д.Амарбаясгалан: Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууя.

П.Батчимэг: Түрүүн бас бүлгийн хурал дээр хэд хэдэн асуулт тавьсан. Тэгээд зарим нэг асуултад арай гүйцэд хариулт авч чадсангүй гэдгийн үүднээс нэг асуулт асууя. Сонгуулиас сонгуульд улс төрийн намууд ер нь төр цомхон байна, төсөв хэмнэлттэй байна, татвар бууруулна, үргүй зардлыг багасгана гэсэн тийм нэг баахан юу асуудал ярьж ярьж гарч ирчхээд, яг Засгийн газар шинээр байгуулагдах явцад салхины одоо чиглэл өөрчлөгдчихдөг. Ер нь өмнөх Засгийн газрын байдлаас үе үеийн Засгийн газрын бүтцээс харахад тухайн яамдын үйл ажиллагаа, чиглэл, яамдын нэр, хэн сайд болохоос хамаарч өөрчлөгдөөд байгаа юм шиг тийм сэтгэгдэл төрдөг юм. Тэрийг одоо нуухгүй. Тэгэхээр та яг үүнтэй бас санал нийлэх үү?

Одоо энэ байгуулагдах шинээр байгуулагдах Засгийн газрын бүтэц чинь хэр оновчтой, хэр одоо нүсэр биш, цомхон, ийм арвилан хэмнэлттэй бүтэц байх вэ? Иргэдийн амьдралын чанар өдрөөс өдөрт муудаж, айл өрхийн дундаж орлого 2.3 саяд хүрэхгүй байгааг та хүлээн зөвшөөрөх үү? Өмнөх Засгийн газрын хувьд гол стратегийн мега төслүүд гэж төслүүд дээр одоо ач холбогдол өгч, анхаарал тавьж, иргэдийнхээ зүг, өдөр тутмын амьдрал одоо орлого ашиг нэмэгдүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх. Одоо ажлын байр байлаа ч гэсэн ажиллах хүчний хомсдолд орчихсон, боловсон хүчний хомсдолд орчихсон, гадаадад гараад явчихсан энэ олон мянган иргэд, залуусаа эргэж буцааж эх оронд нь, гэр бүлтэй нь эх оронд нь амьдруулах энэ боломж бололцоогоор төр хангаж чадахгүй байгааг та хэрхэн одоо ямар бодлого барьж, энд ажиллах вэ?

Том том стратегийн асуудлаа хэт анхаараад, өдөр тутмын амьдралын чанарт нөлөөлөх, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх энэ байдлуудыг орхигдуулсан энэ байдлыг одоо та ер нь юу гэж дүгнэж байгаа юм? Тэгээд одоо сая хэмнэлтийн тодотгол, төсвийн тодотгол гээд ярилаа. Гэхдээ л энэ үргүй цацаж, үргүй төсөв одоо байгааг бол энэ шинэ Засгийн газар цаашид ер нь он гартал ер нь яаж дааж ажиллах юм бол. Одоо энэ өмнөх Засгийн газрын төсөв захиран зарц...

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Пүрэвийн Батчимэг гишүүний асуултад хариулъя. Ингээд яамдын нэрс өөрчлөгдөөд л, бужигнаад л, ингээд нэмээд л, цөөлөөд л таалагдах гээд ингээд давхиад байх нь бол бас алсын хараатай бодлого биш ээ гэж боддог. Хүнд зориулаад ч байгаа юм шиг аль эсвэл хүнд таалагдах гээд ч байгаа юм шиг биш зардлын хэмнэлт төрийн бодлого хэрэгжүүлэх ажилтайгаа л уялдаж ажиллах ёстой гэж бодож байна. Тэгээд ингээд л яам солигдоод л нэг нэг үсэг өөрчлөгдөхөд л баахан бланк хэмнэгдэнэ, тамга тэмдэг өөрчлөгдөнө, ширээ сандал зөөнө. Ингээд л нааш цааш зөөсөөр байгаад л тэгээд ажилтайгаа ч танилцаж амжилгүй бужигнаад л ахиад л 6 сар ч болж ажилдаа суралцах гээд л ингээд бужигнаад байдаг байдал бол жинхэнэ тогтворгүй байдлын нэг шалтгаан болдог гэж боддог.

Тийм учраас аль болох тогтвортой байдлыг хангаж онцын шаардлагагүй илүүдэл эрхтнүүдийг тайрч л ажиллах нь зайлшгүй шаардлагатай болов уу гэж бодож байгаа. Ер нь ажлын байртай холбоотой, ажиллах хүч олдохгүй байгаатай холбоотой асуудал туйлын үнэн.

Ийм учраас миний зүгээр нэг бодол бол гадагшаа явж байгаа хүндээ эргэж ирэх болзол нөхцөлтэй хэрэгжүүлж ирсэн Солонгосын, Японы бодлогууд бол эргэж ирэхэд нь хөнгөлөлттэй зээлээр одоо антрепренёршип буюу одоо нөгөө аж ахуй эрхлэхэд нь дэмжлэг үзүүлдэг, ур чадвартай болоод ирэхэд нь тухайн ажлын байраар гэрээгээр явуулдаг үүнийг нь мэргэжлийн холбоо зохион байгуулдаг. Ноос ноолуурын салбарт ажиллаад ирэхэд, барилгын салбарт ажиллаад ирэхэд буцаад ирэхэд нь тэрнийг нь зээл хөрөнгө оруулалт орон сууцны бодлогоор дэмждэг. Ийм брэйн серкулэйшн буюу одоо бол брэйн дрэйн гэж буюу одоо ингээд хүнээ гадагш нь алдаад байгааг буцааж эргэлтэд оруулдаг брэйн линк гэж буюу холбодог ийм олон улсын нэн ялангуяа Солонгос зэрэг улсуудын ажиллах хүчнээ буцааж авчирдаг, талант авьяасуудаа буцааж авчирдаг энэ бодлогыг бол одоо Зөгийн үүр хэлбэр гэдэг нэртэй бас хэрэгжүүлж байсан бодлогууд ч бий. Үүнийг илүү цогц инженерч, эмч чадвартай боловсон хүчнээ буцааж авчирдаг Монголынхоо хөгжилд хувь нэмэр оруулдаг энэ бодлогыг хэрэгжүүлэхгүй бол Монголд үндсэндээ ажиллах хүчний хомсдолд орох, бүүр байгаа залуучууд нь Монголоосоо явах, зугтах ийм чиг хандлагатай болсонд хамгийн сэтгэл эмзэглүүлсэн ийм асуудал болж байгаа. Бизнесийн хүрээнд ч төдийгүй улс төрийн хүрээнд энэ бол Монгол Улсын зайлшгүй анхаарах ёстой бодлогоо гэж боддог. Энэ дээр тодорхой бодлого хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ хариуцсан сайд нь тийм шаардлага тавьж ажиллах болно гэж бодож байна.

Хэрэглээний сагс багцдаа анхаарахгүй хэт том том юм яриад ингээд яг ард түмний аж амьдрал, карма хот, үнэ цэн рүү анхаарахгүй байгаа гэдэг ийм яриа шүүмжлэл маш их байгаа нь бодит үнэн. Өнөөдөр үндсэндээ одоо ковидын үеэс үүдэлтэй үнийн өсөлт, ард түмний амьжиргаа, цалингийн бодит өсөлт, хэрэглээнд бол ямар нөлөө үзүүлж байгааг хүн бүхэн мэдэж байгаа учраас би дэлгэрүүлж хөөргөдмөөргүй байна. Тэгэхдээ ер нь иргэдийн амьжиргааны чанарыг сайжруулахын тулд орлогын бодит өсөлтөд анхаарч, өндөр бүтээмжтэй ажлын байруудыг бий болгоход анхаарах шаардлагатай. Ажиллах хүчний хомсдолыг бууруулж, гадаадад ажиллаж байгаа иргэдэд татвар зээлийн уян хатан бодлого бүрдүүлж эх орондоо эргэж ирэхийг нь дэмжсэн ийм зөгийн үүр гэж нэрлэж байсан энэ бодлогыг сэргээж хэрэгжүүлэх ёстой гэж бодож байна. Ажлын байр нэмэгдүүлэх нь бол эдийн засгийн эрэлт, бизнесийн орчин, хөрөнгө оруулалтын түвшнээс шууд хамаарна.

Ийм учраас энэ яг л яриад байдаг юмнуудыг дахин давтмааргүй байна. Үүнийг бодит ажил хэрэг болгох нь л хамгийн чухал байгаа юм. Яг бодит үр дүн гаргасан ийм ажлууд байгаа учраас бас яриад байх нь бол ярихаасаа хийх нь илүү чухал шүү гэдгийг л би онцлоод байгаа нь ийм учиртай байна.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Монгол Улс бол хагас Ерөнхийлөгчийн засаглал хэрэгжүүлж байгаа дэлхийн 23 улсын нэг юмаа. Парламентын засаглалтай Монгол Улс нь Ерөнхийлөгчийн институцийг төрийн байгуулалдаа багтааснаар холимог хэлбэрийн төрийн тогтолцоог сонгон хэрэгжүүлж байгаа гэж судлаачид дүгнэсэн байдаг. Угаасаа ч ийм. Хагас Ерөнхийлөгчийн засаглал хэмээх нэр томъёог анх Дивержей судлаач 1980 онд гаргаж байсан. Ерөнхийлөгчийг бүх нийтийн сонгуулиар сонгодог. Үндсэн хуулиар олгогдсон хүчтэй эрх мэдэлтэй. Парламентаас Засгийн газарт итгэл үзүүлэх Ерөнхийлөгчөөс одоо итгэл үзүүлэх энэ хэлбэрүүд бол агуулагдаж байдаг. Үүгээрээ одоо бас Ерөнхийлөгчийн хагас тогтолцоотой гэж дүгнэсэн байдаг. Манайх

ер нь хүмүүс парламентын тогтолцоотой гэж боддог боловчиг манайх сонгодог парламентын тогтолцоо огтоос байхгүй. Манайх бол яг холимог тогтолцоотой байгаа.

Занданшатар даргаас Улсын Их Хурлын дарга байсных нь хувьд сонгодог парламент, парламентыг төгөлдөржүүлэх тал дээр бодлого эдиологи нь ямар байгаа вэ гэдгийг асуумаар байна. Хагас Ерөнхийлөгчийн тогтолцоонд Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдтай гүйцэтгэх эрх мэдлийг хуваан хэрэгжүүлдэг ээ гэсэн одоо ийм онолтой байдаг. Энэ тогтолцоог хэрэгжүүлж байгаа улс орнуудад энэ Засгийн газрыг огцруулах шалтгаанууд дотор хамгийн одоо томоохон шалтгаан нь бол Засгийн газар ажиллаж чадахгүй байна. Засгийн газар Ерөнхийлөгчид хяналт тавьж чадахгүй, Ерөнхийлөгч нь Засгийн газартай хамтран ажиллаж чадахгүй гэсэн шалтгаанаар Засгийн газрууд бол огцордог гэсэн онолоороо л явж байна.

Манай Монгол Улс бол одоог хүртэл ажилласан 90 оноос хойш ажилласан Ерөнхий сайдуудыг авч үзэхэд дундаж хугацаа 1.5 жил байдаг гэж угаасаа статистик нь байгаа. Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн итгэл үзүүлэх асуудал дээр сонгодог парламентыг төгөлдөржүүлэх гэдэг ийм итгэл үзүүлэх албан тоот дээр нь одоо бас үг өгүүлбэр байсан. Чуулган дээр асуултад хариулахдаа сайд нар маань намайг дэмжихээ, одоо сайд нар маань эсрэг ажилласан, Ерөнхийлөгчийн дэмжлэг байхгүй болсон гэдэг ийм асуудлыг ч гэсэн одоо бас ярьсан.

Тэмүүжин гишүүд нарын гишүүд нар Ерөнхийлөгчийн засаглалтай холбоотой албан тоот бас гаргаж ирээд, гарын үсэг зураад нийгэмд ч гэсэн одоо энэ асуудал яригдаж эхэлсэн. Тухайн үедээ бол би бас гайхаж байсан. Яагаад ер нь энэ Ерөнхийлөгчийн засаглалын асуудлыг яриад унав аа гэж. Тэгээд Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ унасан. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга шинэ Ерөнхий сайдаар одоо нэр дэвшээд ороод ирж байгаа.

Занданшатар даргаас бага хурал дээр асуусан та надаа процессын хариу хэлсэн. Та эдиологийн хувьд надаа хариулж өгөөч ээ. Тэгээд Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын хувьд биш Халтмаагийн Баттулга Ерөнхийлөгчтэй байх үеийн Улсын Их Хурлын дарга Занданшатар болон Стэнфордын зочин судлаачийн хувьд.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Аюушийн Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр би энэ талаар нэг тоо ямар ч албан тушаалд байсан би нэг л байр суурьтай хүн. Ийм ч учраас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг анх санаачилж 2017 оны зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулахад Аюушийн Ариунзаяа гишүүн тодорхой хэмжээгээр статистикийн даргын хүрээнд түүвэр сонгох, шалгаруулахаас авхуулаад идэвхтэй оролцсон учраас сайн мэдэж байх учиртай гэж бодож байна.

Тэгэхээр яах вэ миний уншиж судалж байснаар бол Симай Президеншил буюу Симай парламент эд нарыг одоо холимог засаглалын ийм холимог нөхцөл бол 21 биш түүнээс хавьгүй олон улс байдаг юм. Энэ улс дэлхийн ардчилал бол ардчилсан засаглалууд 3 үндсэн ерөнхийлөгчийн засаглал, парламентын засаглал, холимог засаглал гэсэнд хуваагдана. Хуучин постсоциалист улсууд бол ихэвчлэн холимог засаглалыг сонгосон нь учиртай. Нэг газар эрх мэдлийг хэт төвлөрүүлэх нь дарангуйллыг бий болгох эрсдэлтэй гэж үздэг учраас холимог засаглалыг сонгосон

юмаа гэж тухайн үеийн Шапиро гээд манайд зөвлөгөө өгч байсан Америкийн эрдэмтэн. Торостен Штайн гээд Германы эрдэмтэдтэй уулзаж байхад хэлж байсан юм. Яагаад гэвэл Германы Ваймарын Бүгд Найрамдах Улс, ардчилсан Ваймарын Бүгд Найрамдах Улсын унасан шалтгаан бол Гитлерийн ардчилсан сонгуулиар гарч ирээд л Ерөнхий сайд хүн шүү дээ тиймээ. Канцлер буюу Ерөнхий сайд.

Ийм учраас эрх мэдлийг нэг дор төвлөрүүлэхгүйн тулд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд энэ эрх мэдлийн хуваарилалтыг бол ингэж хуваасан. Одоо ингээд манайх дуртай энэ том хөрш орнуудын дунд байдаг улсууд бол нэг хүнээс хэт хамааралгүй байх засаглалыг сонгосон байдаг юм. Финлянд байна. Одоо хуучин Чех, Польш, Австри улс ч гэсэн тэр Австри, Унгарын .. дараа тэгээд энэ улсуудад бол Чех улсад гэхэд жишээлбэл ард түмнээс сонгогдсон Ерөнхийлөгчтэй бүүр 2 парламенттай. Манайд бол Ерөнхийлөгч Дээд танхимын үүрэг гүйцэтгэнэ ээ гэж Чимэд гуай Үндсэн хуулийн зарчмыг хэлсэн байдаг. Тийм учраас энэ парламентын ардчилал дээр бол эргэлзээгүй.

Ийм ч учраас 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн гол зорилго бол парламентын энэ холимог засаглалын 2 хэлбэр байгаа юм. Премьер Президеншил буюу Ерөнхий сайд давамгайлсан Ерөнхий сайд илүү голлох үүрэгтэй холимог засаглал. Президеншил Премьер буюу Ерөнхийлөгч давамгайлсан засаглалтай Франц гэх мэтчилэн улсууд бол Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдаа томилдог, санал болгодог ийм улсууд. Манайх шиг энэ Ерөнхийлөгч нь томилдог, нэр дэвшүүлдэг байсныг 2000 оны Үндсэн хуулиар өөрчлөөд илүү Премьер президеншил рүүгээ нийцсэн өөрчлөлтийг 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хэрэгжүүлсэн юм. Харин Ерөнхийлөгчийн хууль энэ органик хуулиудаа санал болгож оруулаагүй, энэ ялгааг органик хуулиудаар энэ зааг ялгааг илүү тодорхой болгоогүй, энэ шүүх эрх мэдлээс авхуулаад хэрэгжүүлсэн энэ өөрчлөлтүүдээ тууштай хэрэгжүүлээгүй. Ийм органик хуулийн түвшинд үүнийгээ боловсронгуй болгох шаардлагатай. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амьдралд хэрэгжүүлэх асуудлууд бол үргэлжилж байна.

Аливаа өөрчлөлт нэг жилийн дотор биш 8 жил тогтвортой хэрэгжиж үр дүнгээ гаргана гэж Чимэд гуай бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн журмын тухай хуульдаа үзсэн юм байна лээ. Нэг оруулсан өөрчлөлтийг 8 жил ахиад хөндөж чадахгүй. Ерөнхийлөгчийг хаанаас ч өөрөөр сонгох бололцоо Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн журмын тухай хуулиа дагах юм бол боломжгүй. Энэ хөндчихсөн заалт байхгүй юу. Хөндсөн заалтыг 8 жил хөндөж болохгүй ээ гээд Журмын тухай хуульд дурдсан. Үүний тулд Журмын тухай хууль өөрчлөх хэрэгтэй болно. Журмын тухай хуулиас гадуур Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт ярих юм төрийн эсрэг гэмт хэрэг болно гээд тэр тухай хуульд заачихсан. Үүнийг Их Хурал өөрөө өөрчилж байж энэ тухай асуудал яригдана.

Ийм учраас энэ эдеологийн ч биш, үзэл баримтлалын ч биш Үндсэн хуулийн эрх зүй. Бидний та ер нь гараа тавьж байгаа тангараг өргөчихсөн Үндсэн хуулийн ч, Үндсэн хуулийн амин сүнс зарчим нь энэ. Ийм учраас үүнийгээ бид нөгөө Үндсэн хуулиа судалж үндэслэлтэй ярихгүй бол бас нэг ийм өөрөө өөрсдийнхөө дунд итгээд, өөрсдийнхөө парламентын засаглалын нэр хүндийг унагаад байж болохгүй ээ гэдгийг би бас онцолж хэлмээр байна. Тийм учраас...

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Үндэсний статистикийн хорооны дарга байхдаа 2017 онд тантай хамтарч Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар явуулсан анхдугаар зөвлөлдөх санал асуулгын дүн үр дүнгийн тайлан бас миний гарт байна. Тухайн үедээ бид нар асуудал үнэхээр хүнд байгаа учраас, засаглал тогтворгүй байгаа учраас, засаглал хоорондын хямрал байгаа учраас үнэхээр энэхүү асуулгадаа 2 дугаар бүлэг дээр үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх энэ чиглэлд ажил үүргийн давхардлыг арилгах үүднээс Ерөнхийлөгчийн эрх үүргийг тодорхой болгох, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 6 жил байх, улируулан сонгохгүй байх, Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлын өргөтгөсөн хуралдаанаас сонгодог байх буюу Улсын Их Хурал аймаг, нийслэл хотын ИТХ-ын нийт гишүүдээс одоо бүрдүүлнэ ээ гэсэн ийм одоо асуулт байсан. Үүн дээр үндэслээд Ерөнхийлөгчийг одоо бүрэн эрхийн хугацаа нэг удаа сонгогддог байх, 6 жил байх гэдэг асуудлыг нь авчхаад харин яг адилхан нэг өгүүлбэрээр байгаа хамгийн сүүлийн хэсэг буюу Улсын Их...

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Тэгээд маш тодорхой дахин хэлье. Миний үзэл баримтлал Үндсэн хуулийн талаар баримтлах хандлага тодорхой. Үндсэн хуулиа бид сахин хамгаалах үүрэгтэй. Дээдлэхтүн, сахигтун гээд Үндсэн хуульд заачихсан мэдэгтүн гээд заачихсан, тэгээд мэдэх хэрэгтэй байгаа юм. Тэгэхээр энд бол 2 танхимтай болох санал дэмжигдээгүй юм. Нэлээн учирлаж яриад ч гэсэн тэр. Өргөтгөсөн бүрэлдэхүүнээс Герман шиг болох санал дэмжигдээгүй юм. Ард түмнээс бол тэр саналыг авах бол хэцүү юм байна лээ.

Тийм учраас энэ одоогийн засаглалын хэлбэрийнхээ бид одоо Премьер Президеншил парламентын засаглалтай улс гэдэг юугаараа явна аа. Австрийг асуугаарай. Австри ард түмнээс сонгогдсон Ерөнхийлөгчтэй парламентын засаглалтай гэж явдаг юмаа. Сая Австрийн ерөнхийлөгч нь ирээд хэлж байсан. Ерөнхий сайд Ерөнхийлөгч нь ч Ерөнхий сайдаа нэр дэвшүүлдэг. Гэхдээ эрх мэдэл нь парламентдаа хадгалагддаг.

Ийм учраас бид Үндсэн хуулийн үзэл санаа, үзэл баримтлалаа хамгаалж, мэдэж хэрэгжүүлэх нь одоо манай парламентын засаглалаа бэхжүүлэх, төгөлдөржүүлэх, үүнийгээ улам бэхжүүлэх энэ гол үндэс бол...

Д.Амарбаясгалан: Ариунзаяа гишүүн ахиж тодруулъя.

А.Ариунзаяа: Яг таны хувийн одоо идеологи үзэл санааны хувьд та сонгодог парламентаа ер нь дэмжиж байгаа юм байна, хамгаалж байгаа юм байна гэж ойлголоо. Хэзээ нэгэн цагт Монгол Улс зоригтой энэ одоо чиглэл рүүгээ орж чадна байх аа гэдэгт итгэлтэй байна. Итгэлтэй байна ч гэж дээ ер нь найдаж байна. Бид нар одоо тэгж байж л бас илүү одоо зөв хөгжил рүүгээ орно оо гэдэгт би эргэлздэггүй. Энэ анхдугаар зөвлөлдөх санал асуулгын хүрээнд бас явуулсан нэг асуудал энэ давхар дээлийн асуудал байдаг. Та бас энэ парламентын чиг үүргээр гэхээс илүүтэй Ерөнхий сайд илүү эрхэм мэдэлтэй, парламентын кабинетын гишүүдээ өөрөө бүрдүүлдэг.

Тэгэхээр та хэрэвзээ Улсын Их Хурлын гишүүдээс буюу давхар дээлтэй сайд нартай болох юм бол дэд сайд нарын асуудлыг зайлшгүй оруулж ирэхгүй бол ажил ердөөсөө явахгүй ээ маш хүнд ээ. Тэгэхээр энэ дээр ч гэсэн та бас анхаарч өгөөсэй.

Жендэрийн тухай хуулиа бас одоо мөрдөөсэй гэдэг одоо сүүлийн ийм захиасыг хэлье дээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ариунзаяа гишүүн захиас хэллээ. Жуковын Ж.Алдаржавхлан гишүүн асуулт асууя.

Ж.Алдаржавхлан: Оройн мэнд хүргэе ээ. Занданшатар даргаас гуравхан асуулт байна. Нэгдүгээрт хүн болгоны хүсэн ярьж байгаа энэ Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнийг маш цомхон байлгаач ээ гэдэг асуулт байгаа тийм ээ. Тэгээд ер нь хэдүүлээ ний нуугүй сайхан ярилцаад Занданшатар дарга аа, энэ Засгийн газрынхаа бүтцийг 23 сайдыгаа нэг нэлээн багасгамаар байгаа юм. Одоо сайд болохгүй л бол ингээд амьсгал нь давчдаад л, амь нь тасарчих гээд байгаа хүмүүс манай энэ шинэ 126 дээр байхгүй байх аа гэж би итгэж байгаа. Тэгээд салбар салбар дамжаад явж байгаа сайд нарыгаа ч гэсэн энэ удаа бас өнжүүлээсэй гэж хүсэж байна. Тэгээд энэ хамтарч намууд хэрвээ танай Засгийн газарт орох юм бол тэр намын дарга гэж хүн орж ирээд Шадар сайд хийгээд байна шүү дээ. Тэр хүнийг тэр бодлогын яам хариуцуулмаар байгаа юм. Тэр хүнд зориулж дахин тийм шинэ одоо албан тушаал гаргахгүйгээр бодлого руу Эдийн засгийн хөгжлийн яам ч юм уу одоо ямар нэгэн тийм бодлогын яамыг хариуцуулж тэр хүмүүсийг ажиллуулмаар байгаа юм. Та энэ дээр ер нь нэг ямар бодолтой байна. Үүнийг бас нэг сонсьё

Хоёрдугаарт нь, таныг Их Хурлын дарга байхад би нэг Улаанбаатар хотын засаглалын шинэчлэлийг хийх төлөвлөгөө саналаа оруулж танилцуулж байсан тийм ээ. Тэгээд тэр маань одоо Хот тосгоны хууль болж батлагдаад сая 6 сарын 1-нээс хэрэгжих гэж байсан чинь манай нөгөө Засгийн газар маань бас бэлтгэлээ сайн хангаж чадахгүй байсаар байгаад сая жилээр хойшилчихлоо. Та одоо Засгийн газрын тэргүүн болох юм бол энэ хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах чиглэлээр нэлээн эрчтэй ажилламаар байна аа. Яг үнэндээ бүтэн жил манай Засгийн газрын хариуцсан ажил хариуцсан хүмүүс юу ч хийхгүй байсаар байгаад энэ хуулийг хойшлуулсан зарим хүмүүс бүр үүнийг хэрэгжүүлэхийг хүсэхгүй байгаа юм.

Тийм учраас та одоо Засгийн газрын тэргүүн болох юм бол энэ хот тосгоны хуулийн хэрэгжилтийг яаж богино хугацаанд хангах чиглэлээр манлайлж ажиллахаа бас надад нэг хэлж өгвөл их сайн байна гэж.

Гуравдугаарт нь, энэ орон сууцны үнийн өсөлт одоо дийлдэхээ болилоо. Залуу гэр бүл маань байртай болъё гэдэг хүсэл мөрөөдөл бүр замхрах тийшээ хандаж байна. Төрөөс 6 хувийн хүүтэй орон сууцын ипотекийн зээл гаргаад байдаг. Эсрэгээрээ нөгөө барилгын компаниуд маань үнээ ерөөсөө буулгаж өгөхгүй. Магадгүй үнэ өсөж байгаа байх. Нэг ийм кредит тавивал яасан юм. Та мэдээж Монголбанканд ажиллаж байсан хүн. Засгийн газраас тодорхой хэмжээний метр квадратын үнийн бодит үнийг гаргаад үүнээс дооших орон сууцуудыг л төрийн ипотекийн зээлд хамруулна л гэхгүй бол одоо бүх зээл чинь нөгөө тансаг хэрэглээ рүү явчихсан. Нөгөө залуу гэр бүлийн авах гэж байгаа ипотекийн зээл маань өөр хүнд очоод, өөр тийшээ яваад байна. Тэгээд хүрэлцээгүй болж байгаа юм үнэ нэмэгдэх тусмаа. Тэгээд маш их оочер дугаар үүсэж байгаа.

Тийм учраас Монголбанктай хэдүүлээ хамтарч ажиллаад 3 сая ч юм уу, 4 сая ч юм уу энэнээс доош л орон сууцуудыг бид нар төрөөс дэмжинэ ээ гэдэг тийм ипотекийн зээлийн хөтөлбөрт тийм оруулбал яасан юм бэ гэсэн надад одоо бас нэг ийм санал байна. Энэ гуравт хариулж өгөөч ээ гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Алдаржавхлан гишүүн маш чухал асуудал хөндлөө. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн нэг чухал зүйл бол энэ орон нутгийн удирдлагын, тэр дотроо хот, тосгоны эрх зүйн байдлын тухай асуудал. Монгол Улс маань Улаанбаатар улс болж хувирах гээд хөдөө орон нутаг маань эзгүйрэх гээд ганцхан хоттой улс шиг болоод байсан учраас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр аймгийн төвүүдийг бүгдийг орон нутгийн чанартай хот болгох, улсын чанартай хотуудыг бий болгох төвлөрлийг сааруулах үндсэн санааг хийсэн.

Тэгэхээр энэ хууль маань бол одоо тууштай хэрэгжүүлэхийн төлөө олон улсын энэ сиди сидизм гэдэг энэ агуулгатай хот төлөвлөлтийн энэ цоо шинэ соёл хандлагыг төлөвшүүлэхэд нэлээн соён гэгээрлийн ажил нэлээн шийдэл хэрэгтэй юм билээ. Бид нүүдэлчин ард түмэн учраас хот байгуулалтын ийм туршлага дутмаг. Социализмын үеийн хот байгуулалт бол төлөвлөлтөөр байгуулагдаж байсан учраас энэ доороос санаачилга гаргахад байгуулагдаж байдаг ийм туршлагагүй учраас дүүргүүд хот болж хувирахаас өгсүүлээд ийм соёлын чиг хандлагын өөрчлөлтийг, тэгээд төвлөрлийг сааруулж, эрх мэдлийг хотдоо, орон нутагтаа шилжүүлж байж энэ бодлого тодорхой шийдэгдэнэ. Үндсэн хуулийн 53.2-т нэг ийм заалт байдаг юм. Ер нь сум, дүүрэг, нийслэл бол эдийн засгийн нийгэм эдийн засгийн цогцолбор мөн гэсэн. Үүнийг бол корпорэйт боди буюу одоо корпорацийн шинж чанартай эдийн засгийн нэгж гэсэн агуулгыг Чимэд гуай бол бас арай буруу орчуулчихсан юм, энэ цогцолбор гээд орчуулчихсан юмаа гэж хэлж байсан.

Тэгэхээр энэ өөрөө эдийн засгийн хувьд биеэ дааж авч явах чадвартай одоо сумын төв ч гэсэн суурь нь хот болж хөгжих ёстой, аймгийн төв хот болж хөгжих ёстой энэ өөрөө корпоративны шинж чанартай, корпорацийн шинж чанартай, татвар орлогоороо өөрөө бүрдүүлдэг, хүн амынхаа тайван амьдрах нөхцөлийг хангадаг ийм цогц нэг реформ хэрэгжих хотын талаар нэг цогц реформ хэрэгжих ийм шаардлага энэ цогцоороороо хэрэгжүүлэхэд одоо манай Алдаржавхлан гишүүн бол олон санаачилга гаргаж байсан. Үүнийг бол дэмжиж хамтарч ажиллах бололцоотой.

Орон сууцны санхүүжилтийн арга хэмжээний хувьд бол би орон сууцны банк байгуулах ийм хөтөлбөрийг боловсруулсан байгаа юм. Орон сууцны банк гэдэг маань нийлүүлэлт талаасаа дэмждэг. Тэр бага үнэтэй, цөөхөн квадрат метртэй орон сууцыг үйлдвэрлэх талаас нь, нийлүүлэлт талаасаа. Эрэлт талаасаа тэр багш, эмч нар одоо найдвартай тогтвортой орлоготой тэр эрэлтийг хангадаг. Энэ бол Солонгосын их сайн жишээ загвар юм байна лээ. Ингэхгүй бол манайхан ч чөлөөт зарчмаараа явахаар одоо энэ тансаг гэдэг юм уу орон сууцууд, ер нь орон сууцны нийлүүлэлт, үнийн өсөлт энэ бүх байдал бол энэ замбараагүй яваа нь бол өөрөө л бас манай орлогын хэт ялгаатай байдлын олон зөрчлийн нэг эх сурвалж. Тэгээд нэг эрэлт нийлүүлэлт бол нэг бодлого болж хэрэгжих хэрэгтэй. Ипотекийн банк, ипотекийн зээл, орон сууц, барилгын корпорацийн санхүүжилт, одоо барилгынхны асуудлыг ч гэсэн яриад байна. Нөгөө барилгынхаа ажилтай байх асуудлууд энэ бүхнийг нэгдсэн бодлого төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлэх бололцоотой. Одоо энэ барилгын компаниуд ажилгүй болчихлоо. Сэлбэ дэд төв гээд байгаагий чинь санхүүжилтээр нэгдсэн журмаар шийдвэрлэх бололцоотой.

Ийм учраас энэ орон сууцны санхүүжилтийн корпорацийг орон сууцжуулалтын банк болгож тэгээд тэр корпоративтай уялдуулах замаар хөрөнгө эх үүсвэрийн

баталгаа гаргадаг, өөрөө орон сууц чинь эргээд ирээдүйн хөрөнгө болдог, ассет болдог үүнийг эргэлтэд оруулдаг, бонд гаргадаг. Ингээд энэ замаараа бол гэр хорооллыг ч орон сууцжуулах, хөдөө орон нутагт ч гэсэн орон сууцжуулах ийм том хөдөлгөөнийг орон сууцжуулалтын банкны зарчмаар хэрэгжүүлж болно гэсэн. Би одоо өөрөө банкир байсан хүний хувьд ийм итгэл үнэмшил байгаа. Үүнийг хэрэгжүүлэхийг зорьж байгаа юмаа.

Д.Амарбаясгалан: Алдаржавхлан гишүүн тодруулж асууя.

Ж.Алдаржавхлан: Миний эхний асуултад би ингэж асуугаад байгаа шүү дээ. Нөгөө хамтарч намууд одоо орж ирэх юм бол тэр намын дарга заавал Шадар сайдын суудалд ингээд дэмий шахуу албан суудал гаргаж өгч байснаас бодлогын яам хариуцуулаад манлайлж ажиллах боломжийг нь гаргаж өгвөл яасан юм бэ гэж байгаа юм нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Засгийн газрынхаа бүтцийг жоохон хумиад сая Ариунзаяа дэд сайдын асуудал хөндөгдөх ёстой хэрэв бүтэц хумигдвал. 20, 30 сайдтай хэвээрээ бол дэд сайд ерөөсөө хэрэг байхгүй. Тийм учраас энэ хамтрах намууд дээр ямар одоо бодлогын арга хэмжээ авах юм бэ. Энэ дээр нэг санал хэлчхээч ээ.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Энэ саналыг маш чухал санал гэж бодож байгаа учраас тодорхой хариулсангүй. Энэ асуудлаар Засгийн газар хэрвээ би томилогдох юм бол хариуцлага нэгдүгээрт учиртай.

Хоёрдугаарт, томилогдчих юм Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай хуулийг оруулж ирэхдээ тодорхой танилцуулъя гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Занданшатар даргыг бас Их Хурлын даргаар ажиллаж байхад НҮБ-ын хөгжлийн хөтөлбөртэй Улсын Их Хурал, ТАЗ-ийн хамтарч хийсэн 6 жилийн том судалгаа дүгнэлт бас бэлэн байдаг. Алдаржавхлан гишүүнд хариулахад. Ер нь одоо бол өнөөдөр Монголын төр өөрөө ард иргэдийн асуудал болчихлоо гэдэг дүгнэлтийг бүх түвшинд, одоо хүн болгон л хийж байна шүү дээ. Улс төрчид хийж байна, улс төрийн намууд хийж байна, ард иргэд хийж байна. Төр цомхон, чадварлаг илүү бүтээмжтэй байх ёстой. Төр өөрөө бага зардалтай байх ёстой. Төр өөрөө аж ахуй үйлдвэрлэл үйлчилгээний ажлаас хол байх ёстой. Ард иргэдэд одоо ажлын байр, орлого олох тэр боломжийг төр өөрөө бүрдүүлж өгөх ёстой. Өмнүүр нь орж булааж хийдэггүй байх ёстой гэдэг олон асуудал энд хөндөгдөөд байгаа юм.

Тэгэхээр яг энэ судалгааны дүгнэлтээр Занданшатар дарга маргааш бүтэц бүрэлдэхүүний хуулийн төсөл орж ирэхдээ ер нь бүтцийн илүү цомхон чадварлаг байх магадгүй төрийн одоо дахин инженерчлэлийн санал санаачилгыг гаргаж оруулж ирэх ахиад таны хэлж байгаа одоо цахим үйлчилгээ төрийн үйл ажиллагаанд нэвтрэх тусам төрийн процесс нь илүү цөөхөн болох ёстой. Олон шат дамжлагатай байдаггүй байх гэдэг дээр бас анхаарах ёстой. Ахиад одоо энэ яам, агентлаг, орон нутгийн түвшинд давхардчихсан бүтцүүд байж байдаг тийм ээ. Яамандаа бодлогын газар байж байдаг, дэргэд нь тэр бодлогыг хэрэгжүүлдэг агентлаг байж байдаг. Нийслэл аймгийн түвшинд яваад ирэхээр ахиад салбар нэгжүүд гарч ирээд ингээд иргэдэд үйлчилгээ үзүүлж байгаа энэ төрийн

байгууллагуудын давхардал, олон давхардсан процесс гэдэг өөрөө өнөөдөр ард иргэдэд тулгамдсан асуудал болчихоод байгаа юм. Тэгээд энэ бүгдийг илүү цогцоор нь шийдэж чадах юм бол төсвийн зардал багасах, татвар төлөгчдийн мөнгийг үргүй шамшигдуулдаг энэ байдал эрс багасах боломжтой гэдэг талаас нь харж бас та бүтэц бүрэлдэхүүний хуулиа хуулийн төслөө өргөн бариарай гэдгийг бас энэ ташрамд хэлэхийг хүсэж байна.

Пүрэвжавын Ганзориг гишүүн асуулт асууя.

П.Ганзориг: Ер нь энэ ард иргэд, аж ахуйн нэгжүүд, гадаад дотоод хөрөнгө оруулагчид гээд энэ бүх талаас харахад Монгол Улсын төр, засгийн бодлого нэгд тодорхой, хоёрт тогтвортой, гуравт, уялдаа холбоотой салбар хоорондоо байгаасай гэж хүсэж байгаа юм. Мэдээж энэ Засгийн газар 2024 онд бас үйл ажиллагааны хөтөлбөрөө батлаад тодорхой тэргүүлэх чиглэлүүдээ гаргаад салбар болгонд баримтлах бодлого гаргаад баталчихсан байгаа. Тэгээд энэ дээр бас яг хэрэгжүүлэх хугацаанд ялангуяа Засгийн газрын түвшинд уялдаа холбоо хангах дээр их анхаарч ажиллахгүй бол болохгүй нь ээ.

Тэгэхээр нэгдүгээрт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт эдийн засгийг одоо эдийн засаг дахь төрийн оролцоог багасгахад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ ээ гээд тодорхой заачихсан хэдий ч яг энэ дээр бодитой бас хийж байгаа юм бас дутмаг байсан. Тэгэхээр энэ дээр яг бодитой одоо таны хувьд ямар ажлууд төлөвлөж байгаа вэ? Тухайлбал Засгийн газраас энэ хувийн хэвшлийн татварын дарамт ачааг бууруулъя гээд хуулийн төсөл өргөн барьчихсан байж байгаа. Их Хурал руу орж ирэх байх. Тэр татварын хөнгөлөлт чөлөөлөлттэй холбоотой хууль дээр ямар бодолтой байна.

Хоёрт, ер нь халамжаас хөдөлмөр рүү шилжих тухай одоо яриад олон жил боллоо. Яг хөдөлмөр эрхэлж байгаа, баялаг бүтээж байгаа, ажлын байр бий болгож байгаа хэсгүүд дээрээ бас бодитой ажлууд юу хийх вэ? Одоо түрүүн бас дурдлаа. Энэ Сэлбэ дэд төв гээд энэний орон сууцны хороолол дээр монголчуудын өөрсдөө орох боломж нь аягүй бага болчихсон. 5 мянган компанитай, 100 гаруй мянган хүн ажилладаг хамгийн их ажиллах хүч шингээдэг барилгын салбар хятадуудаар барилгаа бариулахаар ингээд 20 хувьд нь монголчууд орох нөхцөлтэй байж байгаа. Энэ чинь өөрөө төр засгийн бодлого уялдаа холбоогүй байна аа, дотоодын үйлдвэрлэл аж ахуйн нэгжүүдээ дэмжихгүй байна гэсэн ийм л байдлаар харагдаад байна л даа. Тухайлбал энэ дээр та яг ямар бодлогууд барих вэ?

Тэгээд ер нь таны Засгийн газрын одоо гол ялгарах онцлог юу байх вэ? Өмнөх Засгийн газраас, өмнөх засгийн газруудаас одоо яг тэргүүлэх чиглэл нь юу байх вэ гэдгийг бас асууя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: 18 цаг дөхөж байна. Тэгэхээр өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудлаа дуустал чуулганы хуралдааныг үргэлжлүүлэх саналтай байна. Татгалзаж байгаа гишүүн байна уу? Алга байна. Тэгвэл чуулганыг сунгалаа.

Занданшатар дарга асуултад хариулъя.

Г.Занданшатар: Пүрэвжавын Ганзориг гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр улсын хэмжээнд төрийн өмчит 129 компани, орон нутгийн өмчит 429 компани байгаа юмаа. Тэгээд нийтдээ үндсэндээ одоо 540 орчим улсын үйлдвэр аж

ахуйн газар байна. Үүнийг би одоо 2 дахин цөөлж, хувьчлахыг нь хувьчилж, үр ашгаар нь ангилж татан буулгахыг нь буулгах нь зүйтэй гэсэн ийм чиглэл баримталж байгаа.

Ийм учраас ойрын хугацаанд Төрийн өмчит компанийн тухай хууль, төрийн өмчийн компаниудын шинэчлэлийн хөтөлбөрийг Улсын Их Хурлаар оруулж хэлэлцүүлнэ. Энэ дээр манай Пүрэвжавын Ганзориг нарын гишүүд төр дэх эдийн засгийн оролцоог багасгах, төрийн өмчит компаниудын менежментийг сайжруулах чиглэлээр нэн ялангуяа томоохон компаниудыг нээлттэй сонгон шалгаруулалтын Канад загвар буюу үр ашигтай ажилладаг одоо энэ зарчим менежментийн гэрээний зарчмыг бол бас нэвтрүүлэхийг зорьж байна. Тэгэхдээ бол энэ чиглэлээр бид бас нэлээн тодорхой судалгаа тооцоонуудыг гаргаж, үр ашгаар нь ангилах шаардлагатай юм байна лээ.

Бидний хувьд энэ Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийн хувьд бол энэ барилга угсралтын ажил бол 801 тэрбум төгрөгийн ажил хэрэгжинэ. 2026 онд 507 тэрбум төгрөгийн ажил хэрэгжинэ гэсэн ийм төлөвлөгөөтэй юм байна лээ. Тэгээд энэ маань бас тавигдаж байгаа шаардлага, санхүүжилт дансанд байршуулах мөнгө энэ тэр бол дотоодын компаниудад оролцох нөхцөл хязгаарлагдмал байна гэсэн асуудал ярьж байгаа. Санхүүжилт мөнгөө бас өөрсдөө босгох, үр дүнгээр нь санхүүжүүлэх ийм систем гараад нэгэнт зарлачихсан юм билээ. Ингээд хотын удирдлагуудтай ярихад бол Барилгачдын холбоо, барилгын ассоциаци гэж 2 байгууллага байгаа. Барилгачдын холбоо нь бол туслан гүйцэтгэгч дээр орох, барилгын ассоциаци нь бол энэ 2 дахь багцыг зарлахад нь тусдаа орох ийм сонирхлоор ажиллаж байгаа гэж ойлгосон. Энэ чиглэлээр бид хяналт тавьж, хотын удирдлагад хэрвээ томилогдож сонгогдох юм бол бид анхаарч чиглүүлж ажиллахаар ярилцаж байгаа.

Ер нь эдийн засагт хувийн хэвшлийн оролцоог хэмждэг үзүүлэлт бол дотоодын ДНБ-д эзэлж байгаа хувийн хэвшлийн эзлэх нэмэгдэл өртөг, нэмүү өртөг гэдэг үзүүлэлт байдаг. Энэ үзүүлэлт 2024 оны байдлаар 74.1 хувь байна. Үүнийг нэмэгдүүлж байж бид эдийн засагт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ гэж тооцож байна. Энэ чиглэлээр бол хувийн хэвшлийн хийх боломжтой ажлыг төр хийхгүй байх, өмнүүр нь оролцохгүй байх зарчим баримтална. Төрийн зарим үйлчилгээний чиг үүргийг хувийн хэвшил мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх ийм хуулийг Мэргэжлийн холбооны тухай хуулийг баталсан байгаа. Одоо Танхимын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулиуд батлагдсан. Ингэж байж эдийн засгийн эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх ийм томоохон шинэчлэл хийж чадна гэж бодож байгаа. Энэ чиглэлээр бол төрийн зарим чиг үүргүүдийг хувийн хэвшилд шилжүүлэх бодитой, дорвитой алхмуудыг төлөвлөж ажиллана.

Төрийн өмчит компаниудын тоог цөөлж, хувьчлалыг эрчимжүүлж, засаглалыг сайжруулна гэсэн 3 зорилт бол олон нийтийн хяналттай, чадварлаг, үр өгөөжтэй байх бодисын өөрчлөлтийг хийх шаардлагатай. Тухайлбал одоо Эрдэнэтийн стратегийн орд газруудын 10 хувийг ард түмэнд эзэмшүүлэхээс авхуулаад нээлттэй ил тод байдлыг нь хангахаар ямар үр ашиг гарсан бэ гэдгийг Монгол шуудан компанийн жишээн дээр би онцолж ярьдаг юм. Үр ашиг нь эрс нэмэгдсэн паблик компани тэр чинь 34 хувийг нь паблик болгоход билүү 49 хувь, 51 хувь гээд ингээд энэ үе шаттай компаниудыг илүү стратегийн компаниудыг ч гэсэн олон нийтийн болгох чиглэл нь бол үр ашгийг нэмэгдүүлж, ил тод байлгах, засаглалыг сайжруулах гол механизм.

Д.Амарбаясгалан: Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн. За уучлаарай. Пүрэвжавын Ганзориг гишүүн тодруулж асууя.

П.Ганзориг: Би ялангуяа энэ бизнесийн орчныг таатай болгоно, татварын дарамт ачааллыг бууруулна энэ дээр яг Засгийн газраас өргөн барьчихсан хуулийн төсөл дээр ямархуу бодлого барих вэ гэдэг асуулттай холбоотой бас саналаа хэлчихье гэж бодож байна. Яах вэ тодорхой хариулт бол авсангүй. Тэгэхдээ энэ одоо сүүлийн 3 жил 2021 оны эцсийн байдал, 2024 оны эцсийн байдлаар хувийн хэвшлийн буюу аж ахуйн нэгжүүдийн улсад төлөх татварын өр 3 дахин өсчихсөн. Өөрөөр хэлбэл 2021 онд 1.2 тэрбум их наядын өртэй байсан бол 2024 оны эцсээр 3.6 их наяд болчихсон. Үүнийг бас хурааж авахын тулд тодорхой хэмжээнд данс хааж, татвараа бол төсвөө бүрдүүлдэг. Тэгэхээр данс хаадаг нь 10 дахин өсчихсөн. 2 мянган данс хаадаг бол 20 мянга болчихсон. Тэгэхээр энэ бол татварын ачаа дарамт их байгааг илтгэж байгаа бас нэг үзүүлэлт учраас бас Ерөнхий сайдаар томилогдоод явсан тохиолдолд үүнийг бас онцгой анхаарч ажиллаж өгөхийг хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн асуулт асууя.

П.Мөнхтулга: Оройн мэнд хүргэе. Сая сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан парламентаас анхны Засгийн газар нь 126-аас байгуулагдаад сая огцорлоо. Жил хүрэхгүй хугацаанд дараагийн Засгийн газар байгуулагдаж байна. Монгол Улсын Засгийн газрын дундаж наслалт 1.5 байдаг. Тэгээд ер нь гадаад орчиндоо ч гэсэн бид нар төгрөгийн ханш энээ тэрээ Монгол Улсын үнэлэмж ингээд улс төрийн тогтвортой байдлаасаа болоод бид нар олон улстай хөл нийлүүлж алхаж, ямар нэгэн хэлэлцээр, хөрөнгө оруулалт, урт хугацааны бодлогоо нэгтгэж чаддаггүй ээ. Энэ удаагийн Засгийн газрыг бас одоо дангаараа байгуулах юм уу, хамтраад явах юм уу үүнийг бол таны эрх мэдлийн асуудал байх. Гэхдээ энэ тогтвортой байдал дээрээ та хэр анхаарч байгаа вэ?, бодлого чинь ямар байгаа вэ?

Хоёрт, бид энэ Засгийн газрын тогтворгүй байгаа байдал нь ихэнх нь энэ уул уурхайгаас хамааралтай энэ ороо бусгаа эдийн засаг, энэ эдийн засгийн тогтворгүй байдлаасаа ер нь ард түмэн бизнес эрхлэхэд хэцүү. Татварын орчин тогтвортой бус, улс төрийн шийдвэрүүд тогтвортой бус энэ бүх байдал бол уул уурхайн бүтээгдэхүүний орон, уул уурхайн үнийн өсөлт уналтуудаас бид нарын Засгийн газар дам нөлөөтэй унаж босоод байгаа.

Тэгэхээр эдийн засгаа солонгоруулна гэж бид нар олон жил үе одоо анх энэ байнгын парламентад ажилласнаас хойш, Үндсэн хуультай болсноос хойш л бид нар олон төрлийн тулгуур эдийн засагтай болно гэж ярьж ирсэн. Тэгтэл өнөөдрийн байдлаар бид нар уул уурхайгаас хамаарсан хэвээрээ л байна 90 хувь нь. Мал аж ахуй одоо манай дотоодын нийт бүтээгдэхүүний арван нэгхэн хувь нь. Тэгтэл хөдөлмөрийн зах зээлийн 21 хувь нь мал аж ахуйн салбарт ажиллаж байна. Та бид хоёр саяхан хангайн бүсийн тойрог дээр хамт өрсөлдөөд л явж байсан хүмүүс. Иргэдийн малчдын амьжиргаа ямар байгааг бид нар мэдэж байгаа. Малын гаралтай түүхий эд өнөөдөр жалганд хаягдаж байгаа. Сонгуулийн үеэр мөрийн хөтөлбөр дээрээ бид нар малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрийг барина, бид нар малчдынхаа амьжиргааг дээшлүүлнэ, аж үйлдвэржсэн хөдөө аж ахуйн мал аж ахуйн орон болно оо, эдийн засгаа солонгоруулна гээд явсан. Таны хувьд Их

Хурлын дарга байж үзсэн, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга байж үзсэн. Одоо Засгийн газрыг тэргүүлэх гэж байна. Танд туршлага дутахгүй, мэдлэг дутахгүй.

Тэгэхээр та бүх институцэд ажилласан хүний хувьд хөдөө аж ахуйн бодлогоо яах юм бэ? мал аж ахуй энэ 21 хувь хөдөлмөрийн зах зээл малчдынхаа амьжиргааг яаж дээшлүүлэх юм бэ, яаж боловсруулах үйлдвэртэй болох юм бэ. Энэ дээр тодорхой хариулт хэлж өгөөч.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Ер нь төр бүгдийг мэднэ, төр бүгдийг зохицуулна гэдэг хандлага аль хэдийн хоцрогдсон. Хөдөө аж ахуйг ч төр мэднэ, малчдын амьдралыг ч төр мэднэ гэж биш. Малчид чинь танд бол одоо мал яаж маллахаа марксизмаар заалгахгүй ээ гээд хэлдэг. Зүгээр мал аж ахуйн салбарыг өөд нь татах ноос ноолуур, арьс шир, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг үнэд оруулахын тулд боловсруулах аж үйлдвэрийг дэмжихийн тулд тэрнийгээ борлуулах зах зээлтэй болгох асуудал нэгдэх зорилго байгаа юм. Ноос ноолуур арьс ширэн бүтээгдэхүүн гадаадад зарагддаг, гадагш нь экспортолдог зах зээлтэй болох хэрэгтэй. Тэгэхгүй бол энэ 70 сая малын түүхий эд бүтээгдэхүүнийг 3.5 сая хүнтэй Монгол Улс шингээж чадахгүй байгаа. Ийм учраас экспортын зах зээлийг нээх нь мал аж ахуйн салбарыг дэмжих нэг дэх хандлага болно

Хоёрдугаарт нь, түүхий эд бэлтгэлийн тогтолцоо, шинэ хоршоо хөдөлгөөнийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлж мал аж ахуйн түүхий эд бэлтгэлийн тогтолцоог хэрэгжүүлэх. Энэ үндсэн дээрээ малын эрүүл мэнд чанарыг сайжруулах. Одоо махаа экспортлохын тулд мал маань эрүүл байх шаардлагатай. Арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүнээ одоо боловсруулж эцсийн шатны бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд нэмүү өртөг шингээх шаардлагатай. Одоо “Цагаан алт” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэ орон нутгаас хүсэлтүүд ирүүлж, энэ орон нутагт байгаа хоршоодоо дэмжих, энэ мал аж ахуйгаа дэмжих цогц бодлогыг хэрэгжүүлж байхад энэ дээр гишүүд маань ч гэсэн санаачилгатай ажиллах хэрэгтэй. Одоо уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувь бол 27 хувь болж өсөж, харин хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь 7.3 хувь болж буурсан. Энэ 2003 онд хөдөө аж ахуйн дэд сайдаар намайг ажиллаж байхад дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувийг хөдөө аж ахуйн салбар үйлдвэрлэдэг байсан юм.

Эдийн засгийг солонгоруулах асуудал бол 308 мянган малчдын орлогыг нэмэгдүүлэх буюу түүхий эдийн нийлүүлэлтийн сүлжээ боловсруулалтыг сайжруулах, нэмүү өртөг шингээх энэ үйлдвэрлэгчдийг дэмжих л ерөөсөө бодлого. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороон дээр бодитой ажиллах хэрэгтэй. Энэ бүхнийг л бодитой хэрэгжүүлж байж бид нийгэм, эдийн засагт нь малчдынхаа нийгэм эдийн засгийн болон орлогын эх үүсвэр бодитой асуудлыг шийдэж чадна. Одоо малчдадаа хувийн зээл өгч байна. Малчдын талаар тодорхой бодлого хэрэгжүүлж чадаж байна.

Тийм учраас энэ бүхнийг бид бодитой хэрэгжүүлэхийн тулд энэ мал аж ахуйн бодлого, хоршоожуулалтын бодлого, Малчин өрхийн нэгдсэн холбооны хуулийг бодитой хэрэгжүүлж, энэ нийлүүлэлтийн сүлжээ, түүхий эд бэлтгэлийн сүлжээ борлуулалтын гадаад зах зээлийг нээх ийм цогц бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байгаа юм. Одоо Дарханы нэхий эдлэлийн үйлдвэр дээр очоод үзээрэй. Ноос ноолуурын үйлдвэрүүдээр яваад үзээрэй. Нэг шат ахичихсан байгаа

шүү ноос ноолуур. Манайх бол одоо түүхий эдээ 320 сая доллароор ноолуураа түүхийгээр нь экспортолдог болчихсон бол одоо ямар ч байсан угаагаад самнах бүрэн хүчин чадалтай боллоо. Дараа нь утас хийх, ээрэх, бүр цаашилбал эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд 1 тэрбум доллароор экспорт нэмэгдэх. Дээр нь олон мянган ажлын байр нэмэгдэх ийм бололцоотой. Ганц ноолуур “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд хэмжихэд бол үүнийг орон нутагт бодитой хэрэгжүүлэхэд манай гишүүд ч гэсэн онцгой анхаарч ажиллах шаардлагатай байгаа юмаа.

Шат болгон дээр нь зээл өгч байгаа энэ боловсруулалтын. Шинэ Зеланд улс гэхэд одоо манайхтай ойролцоо 23 сая орчим хоньтой. Гэтэл хонины ноосны экспортоосоо л 400 сая доллароор орлого олдог. Бид тэгтэл ноосноосоо бараг экспортын орлогогүй шахам байж байна. Энэ бүхнийг өөрчлөх цогц өөрчлөлт хөдөө аж ахуй нэн ялангуяа мал аж ахуйн салбарт шаардлагатай байгаа.

Д.Амарбаясгалан: Мөнхтулга гишүүн тодруулж асууя.

П.Мөнхтулга: Хэрвээ та Ерөнхий сайдаар ажиллахаар бол хөдөө аж ахуй мал аж ахуйн салбартаа анхаарч өгөөрэй. Ер нь бол бид, та түрүүн олон яриан дээр таны яриан дээр гарч байсан. Тэр нь малчдад амьжиргаа тааруу, эдийн засгийн орлого муу, түүхий эд нь үнэд хүрэхгүй байгаа учраас хот руу нүүх нүүдэл Улаанбаатар гэдэг улс болчихсон гэдэг үг таны ярианаас гарч байсан. Тэгэхээр энэ хотжилт төвлөрөлт, эдийн засгийг орон нутагт эргэлтэд оруулах энэ ажил дээрээ Ерөнхий сайдаар сонгогдвол ажиллаж өгөөрэй.

Тэгээд нэг асуулт нь тогтвортой байдлын асуултад та хариулж амжсангүй. Тэрэн дээрээ хариулт авъя. Тэгээд стратегийн нэг 4 ордын ажлын хэсэг Их Хурлаас байгуулагдчихсан байгаа. Энэ дүгнэлт ажлын хэсэгт дүгнэлт гарах байх. Ер нь энэ 4 орд дээр таны байр суурь ямар байдаг юм бэ?

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Ер нь энэ Засгийн газар бол ард түмэнтэйгээ ойр байх ёстой. Ерөнхий сайдын хувьд ард түмнийхээ талд зогсоно оо. Ер нь ардчилал гэдэг бол ард түмний төлөө, ард иргэдийнхээ оролцоотой, тэдэнтэй зөвлөлдөж, ард иргэдтэйгээ хамт байхыг хэлдэг. Ийм учраас энэ Засгийн газар тогтвортой ажиллана. Ард түмэнтэйгээ хамт байгаа нөхцөлд итгэлтэй байгаа. Харин тэрэн дээр ямар шийдвэр гарахыг та бүхний мэргэн ухаан, Улсын Их Хурлын гишүүдийн мэргэн ухаан шийднэ.

Стратегийн ордын газрын талаар би бол олон удаа хэлсэн. Баялагтаа эзэн Монгол үзэл санааг 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр одоогийн Ерөнхийлөгч Ерөнхий сайдаар ажиллаж байх үед, намайг Их Хурлын даргаар ажиллаж байх үед энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тов тодорхой зааж өгсөн Үндсэн хуулийн 6.2-ын заалт. Үүнтэй уялдуулж баталсан Үндэсний баялгийн сангийн тухай хуульд стратегийн орд газруудын төрийн эзэмшлийн хувь АМНАТ энэ сангууд миний менежмент үүнийг яаж бүрдүүлэхийг тов тодорхой заачихсан. Үүнийг л хэрэгжүүлэхийн төлөө би бүх хүч чадлаараа ажиллана. Одоо нэг 1.3 их наяд орчим төгрөг өнгөрсөн 2024 оны гүйцэтгэлээр баялгийн санд төвлөрсөн шиг санаж байна. Одоо бол үүнийгээ улам нэмэгдүүлэх, менежментийг нь оновчтой хийлгэх. Ингээд үүнийг хамгийн гол нь ард түмэндээ өгөөжтэй байх бодлого бол байгалийн баялагтаа эзэн баялагтаа эзэн Монгол энэ хөтөлбөрийн үндсэн үзэл санаа юм.

Ер нь бид нар бусдад таалагдах гэж богино настай шийдвэр гаргадгаа л болих хэрэгтэй. Үр дүн нь чухал. Эцсийн дүндээ ард түмний аж амьжиргаа сайжирсан уу, ядуурал буурсан уу гэж асуугаад байна шүү дээ. Тэр нь гол эцсийн зорилго байх ёстой болохоос биш богино хугацаанд таалагдаж, алга ташуулахтай асуудал гол нь биш ээ гэж би боддог.

Д.Амарбаясгалан: Хажекберийн Жангабыл гишүүн асуулт асууя.

Х.Жангабыл: Улсын Их Хурлын гишүүд та бүхэнд оройн мэндийг хүргэе. Монгол Улсын Ерөнхий сайдын томилгоог бид хэлэлцэж байна. Гомбожавын Занданшатар дарга таныг бүрэн дүүрэн дэмжиж байна. Яагаад гэхээр та олон жил улс төрийн тогоонд чанагдсан, туршлагатай, эв эеэ хичээж ажиллаж чаддаг. Төрийн өндөр албан тушаалд бас томилогдож ажиллаж байсан тийм хүн болохоор одоо дэмжиж байна. Надад нэг асуулт, нэг санал байна.

Эрчим хүчний салбар элгээрээ мөлхсөн гэдгийг хүн болгон мэдэж байгаа. Бид Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг яриад байгаа хэрнээ эрчим хүчээр хангаж чадахгүй нөхцөл байдалтай байна. Өмнөх энэ Засгийн газрын сайд нар, Жавхлан сайд байж байна, Бямбацогт, Туваан, Одонтуяа, Дэлгэрсайхан, ер нь Ардчилсан нам Ардын нам гэлтгүй сайд нар бол сайн ажилласан. Тэрэн дотроо Чойжилсүрэн сайд бас эрчим хүчний салбарыг боломжийн сайн удирдсан гэж үзэж байгаа. Яагаад гэхээр Чойжилсүрэн сайд ер нь эрчим хүчний салбарын өнөөгийн байдлыг аливаа хуралдаан ард түмэнд ил тод, нээлттэй, илэн далангүй танилцуулж байдаг, үнэнийг л хэлдэг. Эрчим хүчний салбар бол 4 толгойтой болчихсон гээд хэлээд байгаа, асар хүнд байгаа. Энэ чуулган нэгдсэн чуулган нь байр сууриа илэрхийлдэг гишүүд ч байгаа, Энхцэцэг гишүүн байна. Одоо Эрчим хүчний тухай хуулийг санаачлаад явж байна. Цэнгүүн гишүүн бас байр сууриа байнга илэрхийлдэг, Золжаргал гишүүн байна, Очирбат гишүүн байна. Эрчим хүчний бие даасан байдлыг яаж хэрэгжүүлэх вэ. Сэргээгдэх эрчим хүчийг яаж одоо хөгжүүлэх вэ. Энэ тал дээр байнга одоо байр сууриа илэрхийлж байдаг олон хүн санаа зовдог. Эрчим хүчний салбарын нөхцөл байдал хүнд байгаа нь үнэн.

Тэгэхээр одоо би юу хэлэх гээд байна гэхээр хэрэвзээ эрчим хүчний одоо сайдыг солихоор бол Чойжоо сайдаас дутахааргүй улс төрийн зоригтой, туршлагатай, ноён нуруутай, салбараа сайн мэддэг сайдыг та томилуулан ажиллах нь зүйтэй гэдгийг л хэлэх гээд байна. Ер нь салбартаа тэргүүлэгч нарыг татан авч сайд нараа сонгоосой л гэж хэлэхийг хүсэж байна. Ийм нэг ийм хүсэлт байна.

Асуулт баруун бүсийн эрчим хүчний систем бас эрсдэлтэй.

Х.Булгантуяа: Жангабыл гишүүн нэг минут нэмж өгье.

Х.Жангабыл: Баруун бүсийн одоо хэрэглээний 80 хувийг бид ОХУ-аас импортлон авч байгаа. Дотооддоо 20 хувийг л импорт одоо үйлдвэрлэж байгаа. Тэгэхээр Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц баригдаж байгаа. Барилга угсралтын ажил нь бараг 4 жил үргэлжилнэ. 4 жилийн дараа ашиглалтад орсны дараа бас баруун бүсийн эрчим хүчний хэрэглээг хангаж чадахгүй. Тэгэхээр баруун бүс бүсээр сонгогдсон одоо энэ гишүүд шинээр эрчим хүчний эх үүсвэрийг нэмж барихаар өөрөөр хэлбэл Ховд гол дээр усан цахилгаан станц нэмж барихаар тийм

судалгааны ажлууд хийхээр төлөвлөж байгаа юм. Энэ ажлыг та дэмжиж ажиллах уу, дэмжих үү ийм нэг асуулт байна.

Х.Булгантуяа: Баруун бүсийн эрчим хүч, эрчим хүчтэй холбоотой Занданшатар дарга хариулья.

Г.Занданшатар: Ер нь эрчим хүчнийхээ бид нийт хэрэглээний 76 хувийг дотоодоос хангаж байгаа. Нийтдээ 193 сая долларын эрчим хүч гадаадаас импортолдогийн дийлэнх нь баруун бүсэд оногдож байгаа. Ийм ч учраас бид Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг бид Хэрэг эрхлэх газрын дарга байхад манай Ерөнхийлөгч Ерөнхий сайд байх үеэс эхлээд одоо олон жил судалж ярилцаад, хамгийн тохиромжтой бас би өөрөө очиж үзэж байсан. Тэр Ховд гол дээр баригдах усан цахилгаан станц бол баруун бүсийн эрчим хүчний хэрэглээг бүрэн хангах ийм чадавхтай төсөл болно. Дээр нь Баянхонгор аймгийн Байдрагийн усан цахилгаан станцыг бол эдийн засгийн үр ашигтай гэж тооцож байгаа. Тэгэхдээ бид бол Бөөн цагаан нуурт үзүүлэх байгаль орчны экологийн үнэлгээг заавал эцэслэн хийж байж эхлүүлнэ гэсэн ийм шаардлага тавьж байгаа.

Ингээд энэ сэргээгдэх эрчим хүчний нийт чиг хандлага бол дэлхий нийтийн чиг хандлага болж байгаа. Үнэ өртөг нь ч хямдарч байгаа. Нарны зайн эх үүсвэрийг байгуулах судалгааг Эрчим хүчний яам амжилттай хэрэгжүүлсэн. Монгол Улс дэлхийд байгалийн баялгаараа төдийгүй нарны эрчим хүчний нөөцөөрөө бас тэргүүлдэг улсуудын нэг. Ийм учраас сэргээгдэх эрчим хүчний хандлага бол манайх энэ эрчим хүч импортлогчоос эрчим хүч экспортлогч улс болох ийм бүрэн бололцоотой. Сэргээгдэх эрчим хүчний болон одоо дулаан эрчим хүчний ийм нөөц бололцоотой улс. Ийм учраас энэ чиглэлээр нь бол нэлээн томоохон хөгжлийн бодлого дэвшлүүлж, эрчим хүчний хараат бус байдлаа хангаад зогсохгүй эрчим хүч экспортлогч улс болох зорилтыг дэвшүүлж нэн ялангуяа одоо уур амьсгалын өөрчлөлт карбон трейдинг гэж байгаа энэ үед бид сэргээгдэх эрчим хүчний томоохон төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын хөрөнгө оруулалтын замаар шийдвэрлэж, эрчим хүчний хараат бус байдлаа хангах ийм бүрэн бололцоотой.

Боловсон хүчний бодлогын асуудал бол энэ Ерөнхий сайдын бүрэн эрхэд хамаарах бөгөөд томилогдсон тохиолдолд яригдах асуудал байх аа гэж бодож байна. Баруун бүсийн эрчим хүчний хэрэглээг бол энэ Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц 100 хувь хангаад зогсохгүй энэ нийтдээ бол нэг 795.9 тэрбум төгрөгөөр баригдаад 2030 онд ашиглалтад орох ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Үүнийг бол бүрэн дэмжиж ажиллана.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүү.

Ц.Баатархүү: Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байна. Сүүлийн 10 жил Занданшатар дарга Монгол төрийн хамгийн хариуцлагатай ажил албанд томилогдож ажиллаж байсан ийм хүн. Хөгжил дэвшлийн сайн зүйл ч тантай хамааралтай, саарал зүйл ч бас тантай хамааралтай гэдгийг онцолж хэлмээр байна.

Ер нь энэ судалгааны байгууллагууд, хэвлэл мэдээлэл, улс төрчид асуудлыг шийдэх ёстой төр засаг иргэдийн өмнө байгаа гол гол асуудлыг шийдэх ёстой төр засаг өөрөө асуудал болсон байна гэдэгтэй та санал нийлж байна уу? Өнөөдөр

Улсын Их Хурал иргэдийнхээ өмнө тулгамдсан эдийн засгийг сайжруулах, орлогыг нэмэгдүүлэх энэ чиглэлээр хууль хэлэлцэх ёстой байтал төрөө төвхнүүлэх тухай асуудлыг энд ярьж байна л даа

Хоёрдугаарт нь, иргэдийн хамгийн одоо шүүмжлэлтэй хандаж байгаа зүйл бол энэ хариуцлагын асуудал. Бид нар бүгдээрээ мэддэг. Олон янзын гэмт хэргийн шинжтэй зүйлийг олон нийтийг талцуулж хүргэчихээд, асуудлыг нь шийддэггүй, мухарладаггүй. 60 тэрбумын хэрэг, нүүрсний хулгай, жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлийн асуудал, боловсролын сангийн зээлийн асуудал гэх мэт энэ асуудалд нэр холбогдсон ийм хүмүүст ёс зүйн хариуцлага хүлээлгэж та кабинетдаа авахгүй байж чадах уу гэдэг ийм 2 дахь асуултыг асуумаар байна.

Гурав дахь асуулт бол Чингэлтэй, Сүхбаатар дүүргийг төлөөлж миний бие Улсын Их Хуралд сонгогдсон. Нийслэлчүүдийн хувьд тулгамдсан асуудлыг бүгдээрээ ярьж байна. Гэр хорооллын дахин төлөвлөлт дээр орон сууцны, орон сууцны яг ямар бодлого барьж ажиллах юм бэ гэдгийг та бас тодорхой нэг тайлбарлаж өгөөч ээ гэж бодож байна.

Дөрөвдүгээр асуудал. Энэ газрын эзэн бол тэрбумтан байх ёстой гэж би боддог. Сүүлийн 20 жил иргэддээ газар өмчлүүлэх хуулийн хүрээнд нийт иргэдийн 20 хувь л газартай болсон. Гэр хороололд амьдарч байгаа, аймгуудад амьдарч байгаа, хөдөө суманд амьдарч байгаа иргэдийн гол өмч нь бол энэ газар. Газрын харилцаа, газрын реформ дээр та яг ямар байр суурьтай байх юм бэ? Өнөөдөр тусгай хамгаалалтын бүсэд байдаг ууланд нь ам амаар нь газар аваад, отог нэртэйгээр зөвшөөрөл аваад хаус хороолол барьчихсан. Гэтэл жирийн одоо иргэн хуулийн хүрээнд өөрийнхөө 0.7 га газрыг авч чадахгүй ийм хэмжээнд байна. Иргэд нь өмчтэй болох гэхээр хаалттай, эрх мэдэлтэй хүн хууль зөрчөөд өмч хөрөнгөтэй болж...

Х.Булгантуяа: Баатархүү гишүүнд нэг минут нэмж өгье.

Ц.Баатархүү: Тэгэхээр Улаанбаатар хотын асуудал Туул голын урд тал, Туул голын хойд тал гэж хуваагдчихаад байна. Хүн амынх нь 50 хувь энд амьдарч байна. Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах энэ эрхээ эдэлж чадахгүй байна аа. Хотод нүүгээд ирсэн хүмүүсийн буруу гэж байхгүй ээ. Амьдралын чанараа дээшлүүлье, боловсрол, хичээл сургуульд ойртъё, хүүхдээ нэг сайн хүн болгоё гээд энд ирсэн. Тэгэхээр Улаанбаатарчуудын асуудалд яг ямар бодлогоор хандах юм бэ гэдэг ийм асуудал байгаа.

Хамгийн сүүлд нь засаглал төрийн менежментэд дижитал шилжилтийг нэмэгдүүлэх чиглэлд онцгой анхаарч ажиллах юм байна. Дэлхий нийтийн хандлага бол хиймэл оюуны хэрэглээ, цахим шилжилт энэ цахим хуваагдлыг бууруулах чиглэлд бүгд анхаарч байна. Энэ асуудалтай бол би санал нэгдэж одоо нийлж дэмжиж байна. Хамгийн гол асуудалд энэ цахим шилжилт бол технологи биш, бод...

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Баатархүүгийн асуултад Занданшатар дарга хариулъя. 4 номерын микрофон байсан уу.

Г.Занданшатар: Баатархүү сайдын асуултад хариулъя. Нэгдүгээрт, иргэдийн зовлон бол энэ хариуцлагагүйн зуд болсон. Түүнээс төр өөрөө болоогүй гэж бодож байна. Монголын төр ард түмнийхээ талд байдаг, ард түмнийхээ төлөө байх ёстой

энэ зарчмаа алдсан бол ард иргэддээ зовлон болж байгаа бол тэнд ажиллаж байгаа сайд, төрийн албаны түшмэдүүд бүгд үүндээ анхаарал дүгнэлт хийх шаардлагатай.

Ер нь дижитал пост гэдэг Засгийн газар дэлхий даяараа нэвтэрч эхэлж байна. Энэ бол хиймэл оюун ухаан. Дижитал цахим шилжилтийг технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа ашигласнаар цаг зардал хэмнэх, цаас хэмнэх төдийгүй иргэдэд хөнгөн шуурхай авлигагүй төрийн үйлчилгээ болгох ийм жишиг. Энэ талаар одоо тэрбум модны төсөл дээр ч, мөн иргэдийн нэг цонхны үйлчилгээн дээр ч гэсэн Баатархүү сайд бас хамтарч ажиллаж олон сайхан санаачилга дэвшүүлж байсан. Гүрж Эстонийн жишээг ярьж байсан. Үүнийгээ бид ажил хэрэг болгох ёстой. Энэ дээр бид хамтарч ажиллах ёстой, хиймэл оюун ухааныг цахим шилжилтийн бодлогоор хэрэгжүүлэхэд үндэсний хиймэл оюун ухааны стратегийг батлах дата төв бий болгох цахим шилжилт хийх ийм зайлшгүй шаардлагатай. Төрийн үйлчилгээний дата төвүүдийг нээлттэй болгоод Эй Пи Ай хэрэгжүүлэхэд энэ Улаанбаатар хотын түгжрэлийг шийдэхэд ч гэсэн том дэвшил болох ёстой.

Хоёрдугаар асуудал. Гэр хорооллыг орон сууцжуулахад бол газрын реформ чухал аа. Та бас нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ажиллаж байсан туршлагатай хүн. Газрын өмчлөлийг нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор баталгаажуулж нэг мөр өмчийн гэрчилгээ олгох, Өмчийн тухай хуулийг баталж, өмчийн хамгаалалт, өмчийн эрхийн асуудлыг нэг мөр шийдэх, Газрын тухай хууль, Иргэний хуульд тулгуурлах ийм цогц шаардлагууд бий. Бүсчилсэн төлөвлөлт сая Алдаржавхлан гишүүний ярьж байгаа нийслэлийн дүүргүүдийн заримыг хот болгох, төвлөрлийг сааруулах энэ цогц бодлого бол үүнтэй уялдах ёстой.

Энэ чиглэлээр Сангийн яамны баталгаа гаргахгүйн тулд Орон сууцжуулалтын банк гэж би яриад байгаа энэ зарчим бол өөрөө бонд гаргаад, өөрөө санхүүжүүлээд, өөрөө тэр орон сууцаа барьцаалчих учраас ирээдүйд баригдах орон сууц учраас энэ хөрөнгийн бүтэн эргэлт болдог учраас санхүүжилтээ ч босгоно, иргэдийнхээ эрэлтийг ч хангана, нийлүүлэлт буюу барилгын компаниудаа ч хангадаг ийм тогтолцоог бол нэлээн сайн би судалсан. Монголбанкны чиглэлээр ажиллах зорилтоо судалж байхад үүнийг бол Монголд бүрэн хэрэгжүүлэх бололцоотой. Гэр хорооллыг барилгажуулах, орон сууцжуулах бололцоотой. Энэ орон нутгийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг бол ОУВС, Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр санхүүжүүлэхээр ярилцаж байсан. Энэ бол урагшаа явж байгаа байх гэж бодож байна.

Ингээд гэр хорооллоо барилгажуулахад Улаанбаатар дээр улам сайхан болох тусам улам нэмэгдээд байх биш. Хархорин, шинэ суурьшлын бүсүүд хотуудаа дэмжих бодлогыг орон сууцжуулалтын банкаар орон нутагт хэрэгжүүлж эхлэх замаар Улаанбаатарын талын төвлөрлийг сааруулах бодлогыг давхар хэрэгжүүлж байж энэ бодит үр дүн гарна. 2024 оны байдлаар бол 733 мянга 394 иргэн газар өмчилж эзэмшиж байгаа гэсэн ийм мэдээллийг Газар зохион байгуулалтын газраас гаргасан байдаг. Улаанбаатарт гэхэд 236 мянга 345 иргэн газар эзэмшиж байна. Иргэдийн газрын өмчийн үнэ цэнийг нэмэгдүүлж өмчлөх эрхийг нь баталгаажуулж байж энэ нь нөгөө Эрнандо де Сотогийн хэлээд байдаг капиталын эргэлтэд орох, капиталын нийгэм иргэдийн амьжиргаа, хөрөнгийн эргэлтийг сайжруулах энэ бодь баталгаанд ордог, эдийн засгийн эргэлтэд ордог, банк бол ассоциаци, ассоциаци буюу одоо ийм эргэлтэд ордог нөгөө орон сууцжуулалт хэрэгждэг ийм бодит нөхцөл бүрдэнэ.

Ер нь бас энэ Улаанбаатар хот бол бас төлөвлөлтгүй байсны л энэ хар гай. Одоо замбараагүй газар олголт зохион байгуулалтын алдаа. Одоо энэ Гандангийн орчмыг гэхэд өнөөдөр энэ газрын...

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жанчивын Галбадрах.

Ж.Галбадрах: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Занданшатар дарга одоо эдийн засаг улс төрийн ээдрээтэй цаг үед Ерөнхий сайдаар сонгогдох гэж байна. Занданшатар дарга бол өөрөө Их Хурлын дарга хийж байсан хүний хувьд бол маш давуу тал гэж харж байж байгаа. Ийм учраас таныг одоо бүрэн дэмжиж байгаа.

Ингээд гишүүдтэй давхардуулахгүй хэдэн асуулт асууя гэж бодож байна. Үг хэлсэн хүн бүр л дуу нэгтэйгээр ард түмний амьдрал доройтсоныг хэлж байна аа. Хүн амын тодорхой хэсэг ядуурлын тойрогт бодитой орсныг хэлж байна. Та ядуурлын энэ тойргоос иргэдээ гаргах гарцыг юу гэж харж байгаа вэ. Ерөнхий сайд болоод иргэдээ ядуурлаас гаргах чиглэлд хамгийн түрүүнд ямар алхам хийх вэ? Ер нь Засгийн газраас авч хэрэгжүүлэх бодлогоо та эрэмбэлсэн байгаа юу гэдэг нэгдүгээр багц асуултыг асууя.

Хоёрт нь, та Улсын Их Хурлын дарга байх үедээ Япон лугаа хөгжье гэдэг ийм уриалга гаргаж олон эрдэмтэд, судлаачид, туршлагатай хүмүүстэй ажил хэрэгч уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг хийж байсныг би одоо сайн санаж байгаа. Тэндээс та яг юу сурч авсан бэ? Ерөнхий сайд болоод тэр сурсан зүйлээсээ тодорхой ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна вэ?

Дараа нь Монголчууд бид өнөөдөр ёс суртахууны доройтолд орсон гэдэгтэй та санал нийлэх үү? Энэ доройтлоос бид иргэдээ яаж гаргах вэ? Энд ямар алхам хийх нь чухал гэж та боддог вэ энэ хувийн бодлыг сонсьё. Мөн одоо ажил хэрэгч мэргэжлийн Засгийн газар байна гэж та хэд хэдэн удаа хэллээ. Энэ Их Хуралд бол ийм мэргэжлийн буюу салбар салбарын экспертүүд жагсаалтаар орж ирсэн байгаа. Ийм ажил хэрэгч хүмүүс байгаа. Та энэ гишүүдтэй хэрхэн хамтарч ажиллах вэ? Санал онолыг нь одоо хэрхэн сонсож байх тийм одоо арга зүй гэх юм уу тийм хэрхэн төлөвлөж байна вэ гэдгийг асууя.

Эцэст нь бол энэ Л.Оюун-Эрдэнэ сайд маань 2026 оныг боловсролыг дэмжих жил болгон зарласан. Энд одоо олон мянган багш нар их баяртай байсан. Түрүүн Зулпхар гишүүн тэргүүтэй хэд хэдэн хүмүүс энэ боловсролын жилд хөрөнгө оруулалтыг хасахгүй биз дээ гэж асуулаа. Та ч одоо улс орны үндсийн үндэс бол боловсрол оо. Боловсролоос бид нар хөрөнгө оруулалтаа хасахгүй ээ гэж хэлж байна. Үүн дээрээ та баттай зогсож чадна биз дээ гэдгийг бас нягталж асууя. Бид бол одоо сургуулийн багт хүртээмж, чанарын талаар сургалт одоо чанартай явуулах нөхцөл бүрдээгүй байна гээд 108 сургууль, 95 цэцэрлэгийг ойрын 3 жилд мөн насжилттай холбоотой 60 гаруй сургууль, цэцэрлэг барихаар төлөвлөсөн. Мөн 14 мянган багш дутагдана гэсэн тооцоо судалгааг бид ингээд хийчхээд ер нь боловсролын реформ бол сургуулийн реформоос эхэлнэ. Тэгээд сургууль дээр хийх ийм дэлгэрэнгүй судалгаануудыг хийсэн байгаа. Энд нэг хариулт аваад дараа нь нэмэлт асуулт асууя.

Х.Булгантуяа: Занданшатар даргын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Галбадрах гишүүний асуултад хариулъя. Ядуурлаас гарах жор бол маш энгийн ойлгомжтой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих явдал аа. Халамжаар биш хөдөлмөрөөр ажил эрхлэлтийг дэмжиж байж ядуурлаас гарна. Ажил эрхлэлтийг дэмжих явдал бол ажил олгогчийг дэмжиж байж ажлын байр бий болгож байж, ажил олгогч, баялаг бүтээгчдийг дэмжиж байж энэ ажлын байр бий болно. Үүнийг нэг талаасаа бас Японы хөгжлийн загвар гэж нэрлэдэг.

Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих цогц бодлогын хэлбэрийг, нөгөө талаасаа энэ одоо Эдийн засгийн бодлогын зөвлөл япон загвар бол дотоодод нэмүү өртөг бий болгох, чанар, сахилга бат, инновацад тулгуурлах явдал. Төр нь ил тод, хувийн хэвшил нь хүчирхэг иргэд нь өндөр боловсролтой, нийгэм нь эв нэгдэлтэй байх загварыг Япон загвар гэдэг. Популизмаар биш тогтвортой бодлогоор энэ замд гарна. Ядуурлаас гарах эхний алхмуудыг эрэмбэлбэл одоо энэ ажил эрхлэлтийг дэмжих, ажил орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, боловсрол, эрүүл мэндийн хүртээмжийг сайжруулах. Энэ боловсрол бол энэ ажил эрхлэлтийг дэмжих ажил орлоготой байхын бас нэг нөгөө талынх нь үндэс нь. Нийгмийн хамгааллын системийг шинэчлэх, халамжаас хөдөлмөрт шилжих, иргэдийн амьдралыг сайжруулах суурь нөхцөл нь бол орлого нэмэгдүүлэх явдал юм.

Ийм учраас энэ боловсролыг дэмжих жил болгон зарласан нь эцсийн дүндээ ажил эрхлэлтийг дэмжих боловсролыг илүү прагматик одоо нөгөө ёстой муур гэдэг шиг хар, шар муур гүйдэг биш ажил эрхлэлтийг дэмждэг энэ боловсролын тогтолцоо зөвхөн онолын биш ийм боловсролын тогтолцоо энэ уялдаж байж энэ нөгөө Япон лугаа адил хөгжье гэдэг загвар маань шийдэгдэнэ. Энэний хамгийн бас нэг Японд ч Азийн соёлын загвар бол энэ ёс суртахууны доройтол, ёс суртахууны боловсролын талаар та бид 2 их ярилцаж байсан. Ёс суртахууны хичээлийг ерөнхий боловсролын сургуулиас эхлэх бидний өнгөрсөн энэ 30 жилийн бас нэг гажуудал бол хуучин ёс суртахууны хэм хэмжээг хэрэггүй гээд хаячихсан, шинэ ёс суртахууны моралийн хэм хэмжээг тодорхойлоогүй идеологи нэг монголын нэгдмэл үнэт зүйл, уламжлалт үнэт зүйл, уламжлалт ёс суртахуун. Энэ үнэт зүйлүүд хаягдаж жудаг ёс гээгдэж байгаа явдал бол нийгмийн ёс суртахууны доройтлын одоо хамгийн гамшиг мөн.

Ийм учраас хүний хөгжил бол манай Засгийн газрын хамгийн том мега төсөл байх болно оо. Хүний хөгжил бол ёс суртахуун, боловсрол, эрүүл мэнд. Хүн хүчтэй хөгжилтэй байж байж улс мега хүчирхэг болно. Монгол Улс дахин хүчирхэг болгохын тулд Монгол хүн илүү хүчирхэг ёс суртахуунтай, эцэг өвгөд, өвөг дээдсийнхээ үнэт зүйл эх оронч үзэл дээр тулгуурласан нэг Монгол нэгдмэл үнэт зүйлтэй байх явдал юм. Энэ бол боловсролын реформоор боловсролыг дэмжих жил илүү үр дүнтэй хэрэгжихэд таныг бас энэ чиглэлийн эксперт мэргэжилтний хувьд идэвхтэй хамтран ажиллана гэдэгт итгэж байна Засгийн газар бол хариуцлагатай байх явдал, ажил хэрэгч байх явдал. Мэргэжлийн гэдэг маань зөвхөн сайдын түвшинд биш энэ боловсролын бодлого нь нийт бодлого нь одоо мэргэжлийн түвшиндээ энэ хуулиа хэрэгжүүлдэг байх явдалтай холбогдоно гэж бодож байна. Энэ чиглэлээр одоо манай Галбадрах гишүүн боловсролын том экспертийн хувьд боловсролын салбарыг дэмжих энэ хууль эрх зүйг бодитой хэрэгжүүлэхэд батлагдсан хуулиуд дээр шинэчлэл хийхэд бас хамтарч санаачилгатай ажиллахыг хүсэж байна.

Х.Булгантуяа: Галбадрах гишүүн нэмж тодруулъя.

Ж.Галбадрах: Баярлалаа. Их тодорхой хариултууд авлаа. Тэгээд та ирэх долоо хоногоос ер нь төсвийн тодотгол хийнэ гэж бас хэлсэн. Тэр ажлын хэсэгт би

бас орох саналтай байна. Боловсролын ирэх 2026 оны төсвийн төлөвлөгөө хөгжлийн төлөвлөгөөнд бас хэд хэдэн зүйлүүд маань, сургууль барих зүйлүүд маань шат дараатай бас орсон байгаа. Тэгээд тэр чиглэлээр бол одоо бас тайлбараа хийж оролцъё гэж ингэж бодож байна.

Тэгээд танд ажлын амжилт хүсье. Тэгээд ялангуяа энэ боловсролын чиглэлд хийх энэ бодлогыг таныг ингээд саяын хэлсэн үгэнд маш их хүчтэй сэдэл төрүүлж байна. Ингээд таныг энэ их боловсролд хийх их өөрчлөлтийг манлайлж ажиллахыг танд хүсэж байна. Ажлын амжилт хүсье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Галбадрах гишүүн үг хэллээ. Засгийн газраас төсвийн тодотголыг өргөн барих юм бол Улсын Их Хурлаас ажлын хэсэг гарна. Түүнд бол Галбадрах гишүүн орж ажиллах бас боломжтой байгаа.

Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Тэгэхээр улс төр, нийгэм эдийн засгийн хувьд бас олон сорилт тулсан энэ цаг үед Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс тулхтай, туршлагатай, мэдлэг, ур чадвартай ийм улс төрчийг Монгол Улсын Ерөнхий сайд болгохоор ингээд санал оруулж ирж байна. Занданшатар даргын хувьд бол бүрэн дэмжиж байгаа.

Энэ хүний хөгжил хамгийн том мега төсөл байна. Цалинтай ээж хөтөлбөр, хүүхдийн мөнгө халамж биш ээ гэдэг дээр таны энэ гишүүдийн асуултад хариулж байгаа хариулттай бүрэн санал нийлж, энэ чиглэлийн бодлогыг дэмжиж байна. Надад асуух 3 асуулт байна. Бид нар хүний хөгжлийн асуудлыг авч хэлэлцдэг мөртөө яг бодит байдал дээр хэрэгжүүлэх тал дээрээ дорвитой алхмууд хийж чадахгүй байгаа гэж харагдаж байгаа. Өнөөдөр байгаа хүнээ хөгжүүлэх асуудлаас гадна Монгол улсын энэ хүн ам зүйн бодлогын асуудлыг яах ёстой юм бэ? Та энэ дээр ямар бодлого барих вэ? Хүн амын өсөлт жил ирэх тусам буурч байна. Ялангуяа орон нутагт хүнгүй боллоо. Хүн амын тоо орон нутагт жил тутамдаа 2-10 саяар улсын дунджаар буурч байна. Тэгэхээр төрөлтийг дэмжих, нас баралтыг бууруулах, шилжилт хөдөлгөөнийг хэвийн нөхцөлд хүргэх нөгөө талаар энэ цус ойртолтын одоо асуудал. Монгол хүний удмын сангийн гений асуудлыг шийдэх тал дээр та ямар бодлого барьж ажиллах вэ?

Хоёрдугаарт нь, Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал бас тийм амар биш байна. Өнөөдөр бид уул уурхайн салбарын үндсэндээ 2 бүтээгдэхүүн дээр манай эдийн засаг хамаарч байна. Зэсийн үнэ, нүүрсний үнэ хэлбэлзэхэд бид сандралд ордог. Өнөөдөр нүүрсний үнэ унасан Монгол Улсын төсөв ямар хэмжээнд байгааг хүн болгон одоо бас хэлүүлэлтгүй мэдэж байгаа. Эдийн засгийг солонгоруулах тал дээр аж үйлдвэржилтийн дэмжлэгийг, бодлогыг дэмжиж ажиллана гэж та ярьж байна. Би бол энэ дээр уул уурхай одоо Эрдэс баялгийн яам, Эрдэс баялаг, аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яамны уялдаа холбоо маш сайн зангидагдаж байж нэг яам шиг уялдаж байж энэ ажил явах ёстой болов уу гэж ингэж хардаг юм.

Тэгэхээр энэ уул уурхайн салбараас орж ирж байгаа баялгийг үндэсний баялгийн сангаараа дамжуулаад сан хэлбэрт нь оруулах, данс хэлбэрээр биш. Энэ санг эдийн засгийн эргэлтэд оруулж амилуулах тал дээр та ямар бодлого барих вэ. Уул уурхайн салбар өнөөдөр бодлогогүй болчихсон. Улсын хөгжлийн бодлогыг

тодорхойлох энэ хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулиар минутаа нэмчих үү дарга, нэг минутаа авчихъя.

Х.Булгантуяа: Үүрийнтуяа гишүүнд нэмж нэг минут өгье.

Д.Үүрийнтуяа: Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль батлагдсантай холбоотой Эрдэс баялгийн талаар төрөөс баримтлах бодлогыг 2022 онд хүчингүй болгосон. Энэ хуулиар 8 хөгжлийн хөтөлбөрийг гаргаж Засгийн газар хэрэгжүүлж ажиллах ёстой. Гэтэл энэ дотор уул уурхай, эрдэс баялгийн аж үйлдвэржилтийн салбарын ямар ч хөтөлбөр бодлого байхгүй явж байгаа. Тийм учраас энэ талаар таны бодол ямар байгаа вэ гэдгийг асууя.

Мөн төсвийн тодотголын асуудал та бас яригдаж байна. Хэрвээ Ерөнхий сайдаар томилогдлоо гэхэд тодотголын асуудлыг оруулна гэж ярьж байна. Тодотгол дээр миний санаа зовоодог нэг асуудал бол би өмнө нь ч бас энэ төсөв ярьж байхад бас энэ асуудлыг хэлж байсан. Энэ хөрөнгө оруулалтын ажлууд цаг хугацаа сунжраад магадлалаар үнэ нь өсдөг. Энэ дээр та хасах тодотгол хийх талаар тодорхой алхмуудыг үе шаттайгаар хийж чадах уу? Энэ 3 хөгжлийн төвтэй холбоотой асуудлыг ямар түвшинд одоо авч үзэх ёстой гэж үздэг юм бэ гэсэн ийм 3 асуулт байна.

Х.Булгантуяа: Занданшатар дарга хариулъя.

Г.Занданшатар: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. 2024 оны байдлаар Монгол Улсын хүн амын өсөлт 1.1 хувьд хүрсэн нь бол хүн амын өсөлтийн түвшин шилжилтийн жилүүдийн буюу 90-ээс нэг 2000 оны үеийн түвшинд хүрч буурсан. Энэ бол нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд амьдралынхаа туршид хэдэн хүүхэдтэй болох магадлалыг тооцдог нийлбэр коэффициентын дүнгээр тооцвол 2.5 хувь гэдэг бол сүүлийн 20 жилийн хамгийн бага үзүүлэлт. Ийм учраас энэ төрөлтийг дэмжих, хүн амын өсөлтийг хангах бодлогод онцгой анхаарах зайлшгүй шаардлага болж байна. Энэ бол цэцэрлэг, сургуулийн хүртээмжээс эхлээд нийгмийн халамжийн бодлого, орон сууцжуулалт, татварын цогц бодлогоор шийдэж байгаа шийдэх ёстой ийм хандлага. Хэрвээ нэгэнт ингэж цогц бодлого хэрэгжүүлэхгүй бол төрөлтийг нэгэнт алдчих юм бол нэгэнт буурсан тохиолдолд эргэж өсөх магадлал нь маш бага гэдгийг Япон, Солонгос, Хятад гээд Азийн орнуудын жишээ харуулж байгаа.

Тийм учраас Монгол Улс шиг ийм уудам нутагтай цөөн хүн амтай улсын хувьд хүн амынхаа өсөлтийн бодлогыг тууштай хэрэгжүүлж ирдэг бодлого бол зөвхөн алдарт эхийн одон тэтгэмжээр хязгаарлагдах биш хүн амын төрөлтийг дэмжих, өсөлт хөгжлийг хүний хөгжлөө дэмжих ийм цогц бодлого хэрэгжүүлэхийг зайлшгүй шаардсан үе гэдэгтэй бол одоо санал нэг байна. Уул уурхайн баялаг үндэсний баялгийн сангийн хувьд бол ер нь үндсэн баялгийн сангийн хуулийн концепц бол зөвхөн хадгалаад байх бол ер нь ирээдүй өв сан гэдэг агуулга юу юм бэ? Манайхан нэг ийм зөрүүтэй ойлголт баялгийн сан дээр байгаад байгаа юм. Яагаад баялаг болж байгаа юм бэ. Соурен Вольфанд гэж яагаад нэрлэж байгаа юм бэ гэдэг маань газар доор ингээд өсөж үржихгүй байгаад байгаа хэчнээн үнэтэй ч гэсэн баялгийг газар дээр гаргаад, мөнгө болгоод энэ байнга хөрөнгө оруулалт хийгээд үр төл өгөөжөө өгч байвал Итгэлт баяны хэлдгээр нөгөө сохор зоосыг ч гэсэн сэгсэрвэл үр төлөө өгдөг юмаа гэдэг шиг сэгсэрч байвал Норвегийн сан чинь өөрөө өөрөөсөө үржээд аплъ одоо хөрөнгө оруулалт хувьцааны үр өгөөжөөрөө одоо сүүлийн 5 жил

гэхэд л бараг 2 дахин өсөөд ингээд өсөж үржүүлээд тэгээд тэрнийгээ Ирээдүй өв сандаа өгөөд байгаа нь бол энэ хуримтлалын сан, өсөж үрждэг ийм сан байх хөрөнгө оруулалтын сан байх энэ агуулга нь.

Одоо бол яах вэ манайх бас энэ нийгэм эдийн засгийн нөхцөл байдалтайгаа уялдуулаад тодорхой хэсгийг нь зарцуулж байх хэрэгтэй. Орон сууцандаа байна уу. үүнийг орон сууцжуулалтын банк болгоод эргэлдүүлж Баялгийн сан хэлбэрээ хөгжүүлэх нэг ийм хувилбар байна. Тэгвэл үл хөдлөх хөрөнгийн барьцаагаараа өөрөө өсөж байна. Үл хөдлөх хөрөнгийн үнэ одоо ганцхан хоёрхон жилийн дотор 14.6 хувь өссөн байна. Энэ өөрөө бас капитал ассоциаци. Энэ менежментийг хэрэгжүүлдэг ийм ур ухаан одоо менежмент бол хэрэглэхгүй бол зүгээр ингээд мөнгө дансанд хадгалаад төрийн дансанд хадгалаад байгаа бол Үндэсний баялгийн сан биш ээ. Энэ та өөрөө санхүүч хүн учраас таны харж байгаа өнцөгтэй санал нэг байна.

Тийм учраас үүнийг бол тусгай менежментийн баг томилж одоо яах вэ адаглаад л доллароор хадгалаад байгаа юм болж байгаа юм. Тэгтэл доллар чинь өөрөө диприссшн буюу одоо алтны үнэ өсөж байгаа чинь өөрөө активын үнэ өсөөд цаасан мөнгө, доллар, валют ч гэсэн үнэгүй. Одоо 100 жилүүдтэй харьцуулах юм бол алтны үнэтэй харьцуулах юм бол бүгд тодорхой болно шүү дээ. Ийм учраас алт нь баталгаагүй болсон ч гэсэн энэ дижитал карнси гэдэг юм цахим мөнгө ч бий болж байна. Энэ үед сангийн менежментийг цоо шинэ утгаар нь харахгүй бол зүгээр Баялгийн сангийн үндсэн агуулга нь Норвегийн сан энэ тэр энэ юм шүү. Тэгэхгүй бол зүгээр дансанд доллар хэлбэрээр нь хадгалснаараа үүнийг өв хуримтлал бий болгоод байна гэж үзэхгүй ээ.

Төсвийн тодотголын хувьд бол ирэх долоо хоногт оруулж ирэхээр төлөвлөж байна. Тийм учраас энэ чиглэлээр ядуурлын түвшин 27.1 хувь болсон. Одоо 2025 онд энэ дэлхийн банктэй хамтарч ядуурлын түвшнээс судалгаа тооцох ёстой. Энэ ...

Х.Булгантуяа: Үүрийнтуяа гишүүн нэмж нэг минут.

Д.Үүрийнтуяа: Сүүлийн асуулт дээр бас минут нь хүрсэнгүй шиг байна. Тэгэхээр би энэ төсвийн тодотголтой холбоотой асуудал дээр зарчмын байр сууриа бас дахин илэрхийлье гэж бодоод байгаа юмаа. Ер нь бол бид нар өнөөдөр төсвийн урсгал зардлыг хасаад тав, гурван цаасны томилолтын мөнгө, тав, гурван цаасныхаа тавилга эд хогшлын мөнгө гээд ингээд наанаа хуруу хумсаа хуйхалж ядаж байхад цаана нь энэ төсвийн хөрөнгө оруулалтаар хийж байгаа ажлуудын үнийн өсөлт ямар ч хяналтгүй яваад байгаа шүү. Магадлал хийгдэж орж ирж байгаа. 3 хөгжлийн төвөөр. Хоёрхон жилийн дотор 90 тэрбумын ажил, 60 тэрбумын өсөлт нэмэгдэж, 150 тэрбум болж байгаа ийм олон жишээ кэйс энэ хөрөнгө оруулалтын ажлуудад бий.

Тийм учраас энэ Барилга хөгжлийн төв, Зам тээврийн үндэсний төв, Эрчим хүчний үндэсний төвийн энэ магадлал хийгээд байгаа асуудлууд дээр Засгийн газрын зүгээс тодорхой арга хэмжээ авах ёстой шүү гэдгийг хэлэх гэсэн юм.

Х.Булгантуяа: Үүрийнтуяа гишүүн бараг санал хэллээ тиймээ. Магадлал хийж. Хариулах уу. За тэгье. Занданшатар дарга хариулъя. Төсвийн тодотголтой холбоотойгоор.

Г.Занданшатар: Төсвийн тодотголтой холбоотойгоор ер нь энэ норм стандартыг шинэчлэх үүнтэй уялдаа холбоотойгоор энэ Барилгын хөгжлийн төвөөс хийгдэж байгаа төсвийн үнэлгээ энэ магадлалын зардал өсөж байгаа юмнууд бол нарийвчилсан хяналт шалгалт хийх шаардлагатай гэдэгтэй санал нэг байна. Тодорхой кэйсүүд байвал 150 тэрбум болсон тэр саналуудыг бидэнд ирүүлэхийг хүсэж байна. Энэ одоо шаардлагатай бол хуульд өөрчлөлт оруулах, хянан шалгах энэ ер нь энэ төсөвт зардлыг авчхаад нэмэгдүүлдэг явдлын цаана бол асар том авлига хулгай нуугдаж байж болзошгүй гэсэн ийм болгоомжлол байгааг ойлголоо. Энэ талаар онцгой анхаарал хандуулж ажиллах болно.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат.

С.Эрдэнэбат: Занданшатар даргыг Зөвлөлдөх зөвлөл гээд Их Хурлын дарга байхдаа парламентын ардчиллыг бэхжүүлэх, тоог нэмэх, пропорциональ тогтолцоог оруулах, нийгмийн олон бүлгийн төлөөллийг оруулах гэдэг энэ үзэл баримтлал дээр одоо бас нийгмийн бүлгүүдээс төлөөлж одоо энэ зөвлөлийг байгуулж, үндсэндээ бараг 20, 30-аад саналыг нийт ард түмнээс бид санамсаргүй түүврийн аргаар авч байсан. Маш тодорхой өнөөдрийн одоо хүмүүсийн асуугаад байгаа бүх асуултууд бараг энд орсон байна. Би эргээд ингээд ухаад үзэхэд. Ялангуяа энэ нийгмийн баялгийг шударгаар хуваарилахад төсвийн хуваарилалт, баялгийн хуваарилалт, бүтээн байгуулалт гээд одоо энэ зүйлүүд дээр таны энэ үзэл санаа хэвээрээ байгаа болов уу гэж би бодож байна.

Дээрээс нь парламентын ардчиллыг гүнзгийрүүлэхэд нийгмийн олон одоо бүлгүүдийн төлөөллийг оролцуулах, өөрөө зөвлөлдөх зөвлөлийг бол одоо илүү их бэхжүүлж байж энэ төр засаг өөрөө ард түмэн хоёрын хоорондох зай их ойртож байж одоо нийгэм хөгжинө гэдэг ийм үзэл баримтлалыг бол тухайн үед тавьж байсан. Энэ үзэл баримтлал чинь бол хэвээрээ болов уу гэж би бодож байна.

Бизнесийг дэмжих чиглэлээр одоо нэлээн бол ярилаа. Энэ бол зөв. Гэхдээ аливаа зүйлийг олон талаас нь харна гэдэг үүднээс одоо зөвхөн бизнесийг би бизнесийг дэмжихдээ илүү их хариуцлагатай бизнесийг дэмжээсэй гэж бодож байгаа юм. Цаанаа олон ажлын байрыг бий болгодог, татвараа шударгаар төлдөг, нийгмийн хариуцлагатай. Тэгэхгүйгээр одоо бидний зарим юунд харж байхад энэ лиценз, энэ бүтээн байгуулалтад ордог тендерт орж байгаа хүмүүс ченжийн тогтолцоотой, ажилтай, ардаа тоолохдоо ажилтангүй шахуу, лиценз зардаг, дундаас нь ашиг олдог гадна, дотнын хүмүүстэй. Нөгөө талаар ажлын байрыг одоо бий болгодоггүй, байгальд халтай гэх мэтчилэн. Үүнийг бол одоо нийт утгаар нь бизнесийг дэмжиж байна гэдэг утгаараа бас яваад байх нь бол хэт өрөөсгөл байдаг юмаа, ард түмэнд хамааралгүй. Тийм учраас энэ тал дээр бол одоо та бас анхааръя. Хэрхэн яаж анхаарч ажиллах вэ?

Өөрөөр хэлбэл нийгмийн энэ тогтвортой олон сонирхлын бүлгүүдийн уулзварын цэгийг зөв хатгаж байж энэ нийгэм, төр засаг, ард иргэд, ажил олгогчийн одоо 3 талт механизм гэж бид нар ярьдаг. Дэлхий нийт ч гэсэн нийгмийн ийм шинэ гэрээ, шударга ёсыг, хүртээмжтэй өсөлтийг бий болгож байж энэ улс орны хөгжлийг хэмжих юмаа гэдэг дээр бол их ярьж байна. Тэгээд энэ тал дээр та юу хийнэ гэж бодож байгаа вэ? Сайн ажлын байр гээд ажлын байр бий болгох нь зөв өө. Гэхдээ тогтвортой маш сайн ажлын байрууд хэрэгтэй байна. Гадуур бол ажлын байр бол олон байна харамсалтай нь тогтвортой ийм одоо ажлын байрууд ховор байгаа

учраас залуучууд гадагшлаад байна. Гадаадаас авчрах залуучуудыг бид бүхэн бодлоготой явуулах, буцаж бодлоготой авчрах тал дээр бол одоо ямар ажлууд төлөвлөж байна вэ гэдгийг хэлмээр байна.

Мөн зээлийн асуудал бас нэлээн хүнд байгаа. Хүү өсөөд байгаа, бизнес хөгжих ард иргэдийн цалин хөлснөөс авхуулаад ахмадын энэ тэтгэврийн зээлтэй холбоотой ч гэсэн одоо асуудал нэлээн их дэгдэж байна. Нэг минутаа авчихъя дарга аа.

Х.Булгантуяа: Эрдэнэбат гишүүнд нэг минут нэмж өгье.

С.Эрдэнэбат: Энэ зарим үед төр шийдвэр гаргахдаа огцом шийдвэрүүдийг өөрсдөөс нь асуухгүй, оролцоог нь хангахгүйгээр шийддэгээс болоод үл ойлголцол бий болоод байна. Тухайлбал ахмадын зээлийг одоо 30 хувьд нь олгоод 80 нийт авч байгаа хүмүүсийн 70 хувьд нь одоо хязгаарлах шийдвэр гараад маш олон хүмүүс бас өнөөдрийг хүртэл одоо асууж байна. Энэ тал дээр бол одоо ялангуяа энэ төрийн мөнгө, эдийн засаг, нийгмийн бодлогын одоо энэ зөвлөлүүдэд энэ олон нийтийн төлөөллүүдийг бас оруулж тэр өнцгийг нь бас урьдчилан харах, хараагүй өнцгийг нь харах ийм боломжуудыг хийхэд бас анхаараач ээ гэдгийг бас хэлмээр байна.

Хувьчлал 2 дахин хувьчлал хийнэ гэж байна аа. Одоо төрийн өмчийн компаниудыг өөрчилнө гээд. Яах вэ шууд хэлэхэд амар. Гэхдээ энэний цаана бол одоо бас олон ажилчдын эрх ашиг сөргөөр хөндөгдөх вий. 20, 30 жил ажиллачихсан хүмүүсийг гудамжинд гаргаад хаячих вий дээ гэдэг дээр бол хүмүүс их болгоомжилж байгаа юм. Тийм учраас үүнийг бол одоо бас сонирхогч тэр үйлдвэрчний эвлэл, ажил олгогчийн тэнцвэрийг хангаж энэ шийдвэр дээрээ анхаараарай гэдгийг бас хэлмээр байна.

Х.Булгантуяа: Занданшатар дарга хариулъя.

Г.Занданшатар: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Нийгмийн баялгийн хуваарилалт, үзэл санаа, ер нь энэ ард иргэдийн үзэл санаа зөвлөлдөх ардчиллаар тэнцвэртэй мэдээллүүдийг харьцуулж дүгнээд, ухамсартай шийдэл гаргаж байгаа энэ санал гарсан санал онолуудыг хэрэгжүүлэхийн төлөө л энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт ч гэсэн хууль эрх зүйн шинэчлэлүүд хэрэгжсэн. Ер нь 3 талт механизмын хувьд бол ер нь энэ орон нутгийн түвшинд ч гэсэн тэр, төрийн түвшинд ч гэсэн 3 талт механизмыг энэ маргаан хянан шийдвэрлэхэд 3 талтаар шийдвэрлэдэг. Одоо ажил олгогч, ажилтан, иргэдийн хоорондын асуудлуудыг орон нутгийн түвшинд Засаг дарга нарын дэргэд ийм 3 талт маргаан хянан шийдвэрлэх Зөвлөл байгуулдаг ийм олон гадна дотнын туршлагууд байдаг аа.

Тийм учраас энэ нэн ялангуяа нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалаас авхуулаад энэ олон сангийн менежмент дээр нэн ялангуяа энэ ажил олгогчдын холбоо, үйлдвэрчний эвлэл, сангийн менежментийг зөв оновчтой болгох талаар түүнд хяналт тавих талаар бас их санаачилгатай ажиллах ёстой юм байна гэж боддог. Энэ энэ 3 талт механизмыг үр дүнтэй хэрэгжүүлэх хамгийн яруу тод жишээ нь хуульчлагдсан байгаа. Гэтэл энэ сан Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн маань ашиглалт, үр ашиг ямар байгаа билээ гэдэг дээр бас бодох цаг болсон байна лээ.

Сайн ажлын байр гэдэг бол ер нь ур чадвар шаардсан голцуу аж үйлдвэрийн өөр салбарууд. Одоо байр сайн оёдолчин хүртэл олдохоо болилоо шүү дээ. Худалдааны салбарын ажилтан, үйлчилгээний салбарын ажилтан бол ингээд сайн ажлын байр тогтдоггүй. Одоо Лаберенсцента буюу ажлын байр сайн шингээдэг салбарууд бол аж үйлдвэрийн салбар байдаг. Гэтэл манайд нөгөө үндэсний аж үйлдвэрлэлээ дэмжих, ажил олгогчдоо дэмжих бодлого маань тодорхой биш учраас сайн ажлын байр хомсдоод, гадагшаа залуучууд маань тэрний эрэлд яваад байгаа нь одоо бодит байдал аа. Тийм учраас сайн ажлын байр бий болгоход үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, баялаг бүтээгчдийг дэмжих маань уялдах ёстой. Энэ бол боловсрол, ур чадварын шинэчлэлээс эхэлнэ. Инновац өндөр өртөг шингэсэн одоо мэдээллийн технологийн гээд салбарыг дэмжих тухай хууль гэхэд татварын бодлоготойгоо уялдуулж хэрэгжихгүй хаячихсан учраас л одоо манай өндөр ур чадвартай IT-гийн мэргэжилтнүүд гадагшаа гараад дуусаж байна. Энэ чиглэлийн үйлдвэрчний эвлэл бодлого энэ чиглэлээрээ бас ажиллах шаардлагатай байгаа юм.

Ийм учраас энэ тухайн салбарын үйлдвэрчний эвлэл ажил эрхлэх ажилтнуудыг төлөөлж байгаа салбартайгаа энэ чиглэлээр бүүр 3 талт яриа хэлцлийг тогтмол зохион байгуулж зөвлөлдөж ажилладаг механизмаа хэрэгжүүлэхгүй бол бас энэ парламентын түвшинд ч гэсэн тэр паблик прайв диалоги буюу одоо үүнийг Үйлдвэрчний эвлэл хэрэгжүүлэхийн тулд Зөвлөх зөвлөлийг уул нь байгуулсан юм. Одоо энэ механизмаа ашиглая. Ингэж байж тал талын сонирхлыг жигд хангасан систем бий болгож чадна. Төрийн өмчийн компанийн шинэчлэл хувьчлал бол хүмүүсийг шууд халах биш үр ашиггүй бүтэц, алдагдлыг цэгцлэх бодлогын л асуудал.

Тийм учраас одоо тэр хүмүүсийг халж солиод байхаасаа илүү сайн засаглал, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар зах зээлийн зарчмаар ажиллуулж, цалин хөлсийг нь харин ч тэрний үндсэн дээр нэмэгдүүлж, үр ашигтай ажиллуулахад л чиглэгдэнэ гэж чиглэх ёстой. Түүнээс хариуцлагагүй, үр ашиггүй албан тушаал биш харин бүтээмжид суурилсан ажлын байрыг бий болгох нь Үйлдвэрчний ч эрх ашигт нэгдэнэ ээ гэж бодож байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг.

О.Номинчимэг: Ард олон биднийг ер нь сонгосон иргэд татвар төлөгчид товчхондоо биднээс гуравхан л зүйл ер нь хүсэж байгаа. Нэгдүгээрт эдийн засгийн хувьд бид нар элбэг дэлбэг баймаар байна аа. Хоёрдугаарт, эрүүл аюулгүй орчинд амьдармаар байна. Утаа түгжрэлгүй хотод амьдармаар байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь хүртээмжтэй, сайн баймаар байна. Гуравдугаарт, шударга зөв одоо амьдармаар байна. Шударга ёс байдаг. Хүн биш хууль засагладаг ийм нийгэм байгаасай, ийм улс орон байгаасай л гэж хүсэж байгаа.

Тэгэхээр энэ 3 бол бидний замын зураг, бидний зорилго, бидний үүрэг, аль ч Засгийн газрын ажлын төлөвлөгөө л гэж би харж байгаа. Тэгэхээр энэ 3 зүйл дээр бас анхаарч, үр дүн гаргаж ажиллана гэдэгт Занданшатар даргыг болон түүний бүрдүүлэх Засгийн газарт үүнийг одоо дагаж ажиллана гэдэгт итгэж байна. Үр дүн гаргана аа гэдэгт бас итгэж байна. Яах вэ энэ дээр 2 л зүйл би бас одоо хүсэлт гэх юм уу одоо сануулж хэлмээр байгаа. Нэгдүгээрт бид нар одоо эдийн засгийн нөхцөл байдлаа харах юм бол бас нэлээн тоон үзүүлэлтүүд муу байна аа. Экспортын орлого маань 14.7 хувиар буурсан байна. Өмнөх үетэй харьцуулахад төсвийн

тэнцэл маань хасах руу орчихсон байна. Түрүү жил бол энэ 2.1 их наядын ашигтай байсан.

Тэгэхээр эдийн засгийн одоо энэ хүндрэлээс сэргийлэхийн тулд бид ер нь ямар бодлого хэрэгжих вэ гэдэг дээр бас энэ нэр дэвшигч маань гишүүдийн асуултад нэлээн тодорхой хариулж байна. Ер нь энэ хараад байхад бид нар энэ эдийн засгийн бүтэхгүй зүйл болгон бид нарын гаргаж байгаа популист ийм шийдвэрээс л болж байгаа. Тэгэхээр таныг бас Засгийн газрын кабинетаа бүрдүүлэхдээ ялангуяа Эдийн засгийн хөгжлийн яамны болон Сангийн яам үүнийг толгойлох гэж байгаа сайдуудаа илүү бас үүнийг өргөн хүрээнд харж, ул суурьтай шийддэг, мөн вакумжуулдаггүй, манлайлж ажиллах хамгийн гол нь танд бас түшиг болж галыг чинь хуваалцах ийм хүмүүсээр бүрдүүлээсэй гэж хүсэж байна.

Хоёрдугаарт, бол энэ бодлого шийдвэрээ бид яг олон нийтдээ бас их зөв сайн ойлгуулах ажил дээр хаа хаанаа бид бас анхаарах ёстой байгаа. Ятгаж ухуулах, ярилцаж ойлголцох хоёр өөр өө. Засгийн газар Улсын Их Хуралд ч үйл ажиллагаагаа тайлагнахдаа, иргэд олон нийтэд ч гэсэн бодлого төлөвлөгөөгөө тайлбарлахдаа ухуулга сурталчилгаа пиараасаа илүүтэйгээр илүү ойлголцож, ярилцаж зөвшилцөх энэ зарчмыг бариасай гэж хүсэж байгаа. Ингэж байж бид бас энэ хугацаанд энэ одоо олон намын төлөөлөлтэй парламентад үр дүнтэй бодлогыг бол сайн хэрэгжүүлж чадна гэж харж байгаа учраас энэ байр сууриа илэрхийлж байна.

Х.Булгантуяа: Номинчимэг гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Нацагдоржийн Батсүмбэрэл.

Н.Батсүмбэрэл: Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшиж байгаа танд амжилт хүсье. Та өмнө нь Гадаад харилцааны сайдаар ажиллаж байсан. Монгол Улсын өнөөгийн гадаад бодлогыг та хэрхэн дүгнэж байна вэ? Бид 2 хөрштэй, 2 хөрштэй харилцаж байгаа харилцаа, гуравдагч хөрштэй харилцаж байгаа харилцаа. Үүнд Ораногийн гэрээг та хэрхэн харж байна? Эдгээр хамтын ажиллагаануудыг та цааш нь хэрхэн явуулах бодлоготой байгаа.

Дараагийн асуудал хот хөдөөгийн хөгжил, ядуурлыг бууруулдаг гэдэг. Бид хотоо хэтэрхий хөгжүүлэх гэж оролдоод хөдөөгөө орхигдуулаад, ядуурлыг нэмэгдүүлээд байгаа юм шиг харагддаг. Үүн дээр ч онол байдаг. Тэгэхээр та энэ хот хөдөөгийн хөгжлийн бодлого дээр ямар бодлого гаргах вэ?

Гуравт нь, Засгийн газрын тэргүүнээр сонгогдоод ажиллахад Засгийн газрын өмнөх мөрийн хөтөлбөрийг тодотгох уу? Өөрөөр хэлэх юм бол оролцогч намууд өөрчлөгдвөл энэ мөрийн хөтөлбөрийн зарчмын зөрүүтэй зүйлүүд гарч болзошгүй учраас мөрийн хөтөлбөр дээр та ямар байр суурьтай байгаа вэ? Бүсчилсэн хөгжлийг та юу гэж дүгнэж байна? Энэ бүсчилсэн хөгжлөө хэрхэн бид урагш нь явуулах вэ? Жалгаар тойрсон 330 сумтайгаа, 21 аймгаа тойрсон 21 сумтайгаа бид 21 дүгээр зууны хөгжлийн тухай ярих уу, шинэ загварыг бид цааш нь хөгжүүлэх үү гэдэг дээр та ямар байр суурьтай байна аа?

Дараагийн асуудал энэ эрчим хүчний асуудал. Эрчим хүчний асуудал бид нарын том асуудал болчихлоо. Саяхан энэ 3 дугаар станц дээр том хэмжээний гэмтэл ноцтой хохирол бий боллоо. Үүнийг цахилгаан талаасаа бол нөхөх бодлого гарч байгаа арга хэмжээ авч байгаа юм байна. Дулааны асуудлыг хэрхэн тооцох вэ.

Энэ эвдрэл гэмтлийн ард ноцтой үр дүн байж болох уу? Үүнийг та юу гэж үзэх вэ? Стратегийн ордуудыг яаж үзэж байна. Ард түмний хүлээж байгаа Ухаа худаг, Төгрөг нуур нөгөө овоолгуудыг та юу гэж дүгнэж байна.

Ер нь залуучуудад хэрэгтэй байгаа эх оронч үзэл хүмүүжлийг та хэрхэн үзэж байна? Нийгэмд бас нэг том асуудал бол энэ нийгмийн эрүүл мэндийн асуудал. Залуучуудын сэтгэл зүйн эрүүл мэнд төлөвшлийн асуудал хурцаар яригдаж байна. Үүнийг та яаж Засгийн газартаа шийдэх вэ? Ер нь танаас ард түмний хүлээж байгаа хүлээлт бол маш өндөр байна. Алсын хараатай үр дүн нийгмийн итгэлийг бэхжүүлнэ гэж таны концепц байгаа. Энэ концепцоо та хэрхэн энэ үлдэж байгаа 3 жилд хэрэгжүүлэх вэ? Гол асуудал бол төрд итгэх итгэлээ иргэдийн итгэлийн асуудал байгаа. Үүнийг Монгол Улсын Засгийн газрын тэргүүн манлайлах учиртай. Үүн дээр таны өөрийн үзэл санаа маш чухал аа. Энэ дээр та...

Х.Булгантуяа: Батсүмбэрэл гишүүнд нэмэлт нэг минут. Батсүмбэрэл гишүүний микрофоныг нэмэлт нэг минут.

Н.Батсүмбэрэл: Нэг асуулт үгээр хариулж болох асуулт байгаа. Мэргэжлийн хяналтыг сэргээх үү? Энэ дээр та ямар байр суурьтай байна? Улаанбаатар хотын энэ том төсөл хөтөлбөрүүд эхэлчихсэн явж байгаа. Та үүнийг хэрхэн үзэж байгаа вэ? Нийслэлтэйгээ хэрхэн хамтран ажиллах вэ?

Эцэст нь асуухад энэ боловсролын салбар бол бидний хамгийн том ялзрал, доройтол, эмгэнэлийн суурь юм байгаа юм. 20 дугаар зуунтайгаа хамт үлдчихсэн боловсролын салбар дээр дунд боловсрол дээр, дээд боловсрол дээр, суурь боловсрол дээр та ямар реформ хийх вэ? Үүнд та ямар үзэл санааг бэлтгэж байна вэ? Эдгээр асуултад хариулт авъя.

Х.Булгантуяа: Занданшатар даргын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Нийтдээ 11 асуулт асуулаа. 12 асуулт юм байна. Нэгдүгээрт гадаад бодлогын асуудал бол тодорхой. Монгол Улсын Их Хурлаар батлагдсан гадаад бодлогын үзэл баримтлалыг Засгийн газар биелүүлж хэрэгжүүлж ажиллах учиртай. Өнөөдрийн нөхцөл байдал маш муу, маш ойлгомжгүй гадаад орчинтой бид нүүр тулж байгаа. Жижиг орнуудын болон том гүрнүүдийн бодлогын зөрөлдөөнийг та бүхэн одоогийн орчин үеийн зөрчилдөөнөөс харж байна.

Ийм учраас монгол хүн болгоны одоо сөрөн тэсвэрлэх үндэсний чадавхыг бий болгоход л дотоод, гадаадгүй анхаарах цаг ирсэн гэдгийг би онцлон тэмдэглэхийг хүсэж байна. Энэ үндэсний сөрөн тэсвэрлэх чадварыг монгол хүн, монгол айл гэр бүл монгол аж ахуйн нэгж болгон бий болгож байж бид хоцорч биш, хохирч биш харин урагшаа ахиж хөгжиж дэвшинэ. Үүсэж болох эрсдэлийг ард түмнийхээ нуруунд үүрүүлж, ард түмнийхээ карма хэтэвчийг тэмтэрч биш төрийн үрэлгэн зардлаа багасгаж бүсээ чангалж гарах шийдлийг би сонгоно. Өөрөөр хэлбэл төр өөрийнхөө бүсээ чангалах зарчмыг.

Хоёрдугаарт, Ораногийн асуудал, Ураны асуудлыг бол би байгаль орчны төрийн бус байгууллагуудтай уулзаж ярилцаж байсан. Үүнийг бол хамтарч хөндлөнгийн хяналт шинжилгээ үнэлгээ хийж, хөндлөнгийн лабораторийг байгуулж

энэ дээр одоо энэ хор хохирол экологид үзүүлэх нөлөөллийг нь хянаж, үнэлж дүгнээд үүн дээрээ үндэслэж хамтын шийдвэр гаргаж ингээд эрсдэл үнэлгээний хийсний үндсэн дээр одоо хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа. Мөрийн хөтөлбөр бол бид шинэ Засгийн газар бүрдүүлбэл бүтэц бүтцийн өөрчлөлтийн бүтэц бүрэлдэхүүний тухай хуулиа өргөн барьж батлуулсны дараа үүнтэй уялдуулж мөрийн хөтөлбөрийн асуудлаа та бүхэнд танилцуулна. Энэ хугацаанд багтаагаад дэлгэрэнгүй танилцуулах боломжгүй том нүсэр асуудал гэдгийг ойлгож байгаа байх. Бүсчилсэн хөгжлийн асуудал ч гэсэн тэр, энэ сумдын асуудал ч гэсэн тэр.

Ер нь энэ хот хөдөөгийн ялгааг багасгах талаар авах арга хэмжээ бол орон нутгийн бүтцийн хөрөнгө оруулалт, цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, аж үйлдвэрлэл, аялал жуулчлал хөгжүүлэх, бүсчилсэн хөгжлийн бодлоготой цогцоороо уялдаж хэрэгжих ёстой. Төвлөрлийг бодитой сааруулах ёстой. Эрчим хүчний бие даасан бодлого бол одоо энэ саяын 3 дугаар цахилгаан станц дээр болсон дэлбэрэлтийн асуудлыг хууль хяналтын байгууллагууд ч хянаж шалгагдаж байгаа. Эрдэнэт хүний амь нас эрсэдсэн, маш их хэмжээний хөрөнгө хохирол учирсан. Энэ жилдээ бид дулааны болон эрчим хүчний энэ нөхөн хангалтаа хийж чадах эсэх нь одоо шийдэлгүй хүлээж байна. Ийм учраас Засгийн газар яаралтай байгуулагдаж энэ чиглэлээр ажилдаа орох шаардлагатай байгаа.

Стратегийн орд газруудын талаар ч гэсэн миний баримталж байгаа байр суурь. Үндэсний баялгийн сангийн хуулийг батлахдаа миний оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд тов тодорхой хэлнэ. Тухайлбал Төгрөг нуурын орд газрыг Салхитын мөнгөний орд шиг хууль зөрчсөн үйлдэл болгоныг ил тод болгож улсын мэдэлд Үндэсний баялгийн сандаа авах зарчмыг эрхэм болгоно оо. Эн тэргүүнд тавина аа. Эх оронч үзлийн хувьд бол эх оронч Монгол хөтөлбөрийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт ажиллаж байхдаа бид боловсруулж байсан.

Эх орон үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төрт ёсны үзлийг дээдлэх үнэт зүйл бүхий нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлж, нэг монгол нэгдмэл үнэт зүйлтэй байж байж улс эх оронд үнэт зүйлийн хандлага төлөвшинө. Үүнийг паблик валью гэж буюу одоо олон нийтийн үнэт зүйл гэж тодорхойлдог. Ийм ч учраас би Их Хурлын гишүүнээр ажиллаж байхдаа төрийн албаны ёс зүйн тухай хуулийг санаачилж, төрийн албаны шатыг дээрээс нь эхэлж шүүрдэх ёстой гэсэн зарчмыг баримталж, төрийн албаны өндөр албан тушаалтнуудын ёс зүйн хэм хэмжээг хуульчилсан ийм хуулийг анх баталж хэрэгжүүлсэн. Хувь хүний үнэт зүйл бол бие биеэ хүндэтгэх, эх орноо хайрлах, харилцан туслах...

Х.Булгантуяа: Занданшатар даргын микрофоныг нэмж өгье.

Г.Занданшатар: Ингээд эх оронч үзэл, эрүүл мэнд, боловсрол, Улаанбаатар хотын бодлогууд бол бүгд уялдаа холбоотой. Нийслэлийн талаар баримталж байгаа бодлогын талаар би тодорхой ярьсан. Энэ чиглэлээр нэлээн дэлгэрэнгүй бодлогыг төлөвлөсөн. Нийслэлийн удирдлагуудтай хамтарч ажиллахаар танилцуулсан. Энэ талаар бол бүтэц бүрэлдэхүүний тухай хуулийг танилцуулах үедээ дэлгэрэнгүй танилцуулъя. Энэ 12 асуудал том бөгөөд чухал асуудлууд байгаа учраас энэ мэргэжлийн хяналтыг байгуулах асуудлыг ч гэсэн би эхний ээлжид нь энэ хяналтыг Хэрэг эрхлэх газарт авахаас авхуулаад бүтэц бүрэлдэхүүний тухай хууль хэлэлцүүлэхдээ танилцуулъя. Тэрэн дээр тодорхой байр суурь байгаа.

Х.Булгантуяа: Батсүмбэрэл гишүүн нэмж тодруулъя.

Н.Батсүмбэрэл: Та түрүүн Эрнандо Зотог эшилж байх шиг байсан. Энэ капиталын нууцын нэг юм нь Өрнийн ялгуусан капитализм өөр газар өөдөлдөггүй ээ гээд хэлчихсэн байсан мань эр. Та хамгийн сүүлд Энхтайваны газар зүй гээд ном орчуулсан. Маккендерийн онолоор Зүрхэн газар гээд шинэ л томъёолол байдаг. Монгол улс бол 1943 оны цөөхөн хэдэн тэмээн жингийн замтай Монгол улс биш болсон.

Тэгэхээр Монгол Улсад хөгжлийн ямар идеологи таарна гэж та үзэж байна вэ? Капитал шүтсэн үзэл суртал явах уу, эсвэл нийгмийнхээ чиг баримжааг авч үзсэн үзэл баримтлал явах уу гэдэг дээр та нэг тодорхой байр суурь хэлээч?

Х.Булгантуяа: Занданшатар дарга хариулъя.

Г.Занданшатар: Ер нь Засгийн газрын энэ Засгийн газрын бодлогын залгамж чанарыг л хадгална шүү дээ. Цоо шинэ дугуй зохиогоод л, цоо шинэ бодлого хэрэгжүүлээд байх цаг хугацаа ч тийм. Шинэ санаачилгууд хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал. Ийм учраас одоо нэгэнт батлагдсан мөрийн хөтөлбөр, шинэ сэргэлтийн бодлого дээрээ тулгуурлаж энэ боловсрол Улаанбаатар хот энэ бүх бодлогууд хэрэгжинэ.

Ер нь энэ идеологийн түвшинд ч гэсэн нэг Монгол нэгдмэл үнэт зүйл гэдэг энэ зарчмыг баримтална. Монгол Улсын төрт ёсны түүх бол 2, 3 мянган жилийн түүхтэй. Монголд капитал шүтэхгүй хөгжлийн гарц чадвар бол чадвар шүтэх, инновац шүтэх одоо энэ технологийн эрин зуунд технологи шүтэх модель энэ бол алгасаж экспанент хөгжлийн загвар буюу үсрэнгүй хөгжлийн загвар бол хэчнээн буурай хөгжилтэй орон ч гэсэн технологийн дэвшлийг ашиглах замаар үсрэнгүй хөгжиж болно гэсэн...

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргал.

Ж.Золжаргал: Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2 дахь нэмэлт, өөрчлөлтийг оруулахад нэр дэвшигч өөрөө идэвхтэй санаачилгатай ингэж гол оролцсон хүмүүсийн нэг. 6.1 дээр байгалийн баялаг бол ард түмний мэдэлд гэсэн агуулга, 6.2-т түүнээс олох өгөөжийн дийлэнхийг ард түмэнд одоо хүртэнэ. Тэгээд баялгийн сантай холбоотой ийм өөрчлөлтүүд орсон байдаг. Тэгээд энэ нь энэ нутаг дээр амь амьдралаа зарцуулсан хүмүүсийн үр хойч монголчууд энэ нутаг дээрх байгалийн баялагт эзэн байна аа л гэсэн үг. Энэ утгаараа бол энэ зүй ёсны гэж үзэж байгаа. Нөгөө талдаа хүн хөрөнгө оруулаад ашиглахад ашиг олох боломжтой хангалттай хүрэлцээтэй байх ёстой.

Тэгэхээр бид хангалттай хүрэлцээтэй ашиг олох боломжийг нь эрх зүйн тогтвортой орсноор нь бий болгож өгөөд харилцан хамтарч ажиллах тухай л асуудал байгаа шүү дээ. Гэхдээ энд нэг ялгаа бий. Тэр нь бол эзэн нь хэн байх вэ гэж. Тэгээд эзэн нь монголчууд байх юмаа гэдэг үзэл баримтлалаар би тэр 6.2-ыг оруулсан гэж боддог юм. Энэ эзэн хэн бэ гэдгийг гэрээний аргаар өөрчлөх оролдлогууд бол үе үед л гардаг. Эдийн засгийн утгаараа уг нь ажиллахааргүй болгодог.

Тэгээд эдгээр оролдлогын нэг нь бол ашигт малтмалын ордуудаа бартердах санаа юмаа гэж би үздэг. 4 дүгээр сарын 17-нд Улсын Их Хурал дээр Засгийн газар өргөн бариад Улсын Их Хурал дээр хэлэлцээд дараа нь Уул уурхайн биржийн тухай хуулийг Засгийн газар буцаагаад татаад аваад явсан. Тэр хууль дээр Хил холболтын төмөр замын хүрээнд төлбөрийн нөхцөлийг өөрчлөх тухай өөрчлөлт оруулах гэж байсан болохоос биш аль ч хамаагүй ашигт малтмалын ордыг бартердаж байгаад элдэв янзын төсөл хийх талаар анхнаасаа яриагүй байсан юмнууд орж ирсэн юмаа. Дараа нь ингээд янз бүрийн байдлаар бас өөр 2 ч санаачилга ингээд явж байгаа.

Тэгэхээр энд гэрээний аргаар нөгөө та бүхний хийсэн 6.2-ын өөрчлөлтийг чинь хүчингүй чадамжгүй болгоод эзэн нь хөрөнгө оруулагч байх, нөгөөх нь хүнээр ажлаа хийлгээд үнэ цэнээ хямдруулаад байж байх иймэрхүү оролдлогууд ингээд ер нь гараад л байх бололтой юм байна. Тэгэхээр ингээд зөвхөн ганц нэг төсөл дээр биш ерөөсөө энэ нийт зарчмаар нь аль ч төрлийн ашигт малтмалыг, орд газрыг нь бартердаад тэгээд төслүүд хийлгээд байя гэдэг байр суурь дээр таны ийм хандлага дээр таны байр суурь ямар байдаг вэ гэж асууя аа.

Х.Булгантуяа: Занданшатар даргын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Монгол Улсын Үндсэн хуулийн 6.1-д байгалийн баялаг ард түмний мэдэлд төрийн хамгаалалтад байна гэж угаасаа ийм заалттай. 6.2-т бол энэ байгалийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, ард иргэддээ тэгш хүртээмжтэй байна гэсэн ийм санаа орсон. Тэгэхээр байгалийн баялаг төрийн мэдэлд байх нь бол ингээд ойлгомжтой дэлхий нийтийн зарчим. Гэхдээ бартердах санаа бол маш эрсдэлтэй үнэ тодорхой бус, хяналт сул, авлига ихэвчлэн дагалддаг.

Ийм учраас зөв зам нь бол ил тод тендер бэлэн мөнгөөр бодитой үнэлэгдсэн гэрээгээр баялгаа ашиглах явдал. Яах вэ энэ оператораар ашиглах, ер нь яах вэ баялгийн хараал болон баялгийн зөв менежмент гэж олон улсын судлаачдын бүтээлүүдээс ашиглахад баялгийг одоо төр өөрөө ашиглаж болно. Одоо Тавантолгой шиг, тэгэхдээ энэ эрсдэлтэй, авлигатай, одоо нүүрсний хулгай энэ тэр гээд ингээд асуудлууд төрийн менежментийн бодлогын. Нэг бол гэрээгээр буюу оператораар гүйцэтгүүлээд нэг бол бүхэлд нь зарах бэлэн мөнгөөр тендерээр зарж болно. Тодорхой хувь хэмжээгээр ийм одоо 4 үндсэн хэлбэрийн талаар баялгийн менежментийн шилдэг загваруудыг харьцуулж судалсан байдаг.

Манай орны газар зүйн нөхцөл байдал, бодит байдлыг харгалзаж үзвэл ер нь энэ үнэлгээ ил тод байдал ард түмний хяналт дор энэ ашиглалтыг сайжруулах явдал нь зөв байх. Тэгэхдээ яг ямар кэйс дээр юу ярьж байгааг би сайн мэдэхгүй учраас сайн судалж байж энэ ажил авч байж хэлэхгүй бол одоо цээжний бангаар мэдэмхийрэх боломж алга.

Х.Булгантуяа: Золжаргал гишүүн нэмж тодруулъя. Золжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Золжаргал: Та түрүүн өдөр үг хэлж байхдаа бас үнэн байхыг хичээнэ. Одоо ийм элдэв гоё зүйлээс илүүтэйгээр бодитой ямар ямар төслүүд хэрэгжүүлэх вэ гэж ярьсан. Тэгээд энэ талтай холбоотой нэг зүйл хэлье гэж бодлоо. Одоо ингээд бодит байдал дээр эдийн засаг бол хэцүү л байна. Дээрээс нь энэ өвөл болохоор нөгөө дулаан цахилгааны асуудал гарч ирэх гээд байна. ТЭЦ-3-ын турбин

генератор шатсан асуудлыг хэрвээ та Ерөнхий сайдаар томилогдоод явбал дараагийн удирдах хүмүүсийг нь хүлээлгүйгээр байгаа хүмүүст нь шууд чиглэл өгөөд хурдан шийдэхгүй бол хугацаа байхгүй шүү. Тэр турбин бол Хятадад ч байж л байгаа, Орост ч байж л байгаа. 50м.вт бол байгаа. Амжихгүй гэдэг бол бас жоохон цааргалсан эрсдэлээс айсан ийм үг гэж бодож байгаа. Тэгээд үүнийг яаралтай хийхгүй бол энэ өвөл болоход Улаанбаатарын амьдрал хэцүүднэ ээ гэдгийг хэлмээр байна.

Х.Булгантуяа: Занданшатар даргын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Санал байна. Энэ 3 дугаар цахилгаан станцын асуудал бол яаралтай шийдэх асуудал мөн. Манайд нэн ялангуяа дулааны хангамжийн дутагдалд орно. Энэ бол хамгийн тулгамдсан асуудал. Энэ өвөл хөлдөх үү, үгүй юу гэдэгтэй ч бараг тулгамдаж магадгүй. Ийм учраас яаралтай шийдэх асуудал мөн. Энэ бол 2014 онд билүү бараг 12 жилийн өмнө 40 сая доллароор тэр үеийн үнэ өртөг үнэлгээ бага байх үед хийгдсэн ажил юм байна лээ.

Тэгэхээр улсын онц чухал объектын аюулгүй байдал, тэнд болсон аваар осол эрчим хүчний салбарт өмнө нь гарч байгаагүй ээ. Хятад улсын Хунан үйлдвэрт бүтээгдэхүүн труба генератор бол энэ ДЦС 3-т 3 дугаар станцад нэг ширхэг, Дорнодын цахилгаан станцад нэг ширхэг байдаг. Бөөрөлжүүтийн 150 мега.ваттын турбин одоо энэ ашиглалтад орох энэ дулаан...

Х.Булгантуяа: Занданшатар даргын микрофоныг нэмж авах уу? Занданшатар даргын микрофоныг нэмье.

Г.Занданшатар: Гүйцээгээд товчхон хариулчихъя. Энэ одоо 3 дугаар цахилгаан станц бол 6 сарын 7-ны өдрөөс 0 зогсолтын үйл ажиллагаагаа зогсоогоод, сүлжээнд залгаж өнөөдрийн байдлаар бол 2 турбин 2 зуухтайгаар 40 мв.т-ын хүчин чадал нийлүүлж байгаа. Ер нь олон нийтийн сүлжээнд ч гэсэн тэр уг станцад тохиолдсон аваарын дүнд 1 тэрбумын бүрэн ашиглалтаас гарсан хэдий ч зуухнуудад бол ямар нэгэн гэмтэл учраагүй. Иймээс зууханд үйлдвэрлэх дулааныг хэдий эдийн засгийн эх үүсвэр багатай ч гэсэн шууд хэрэглээнд нийлүүлэх технологийн хувьд бүрэн боломжтой гэж үзэж байгаа. Тэгэхдээ техник, эдийн засгийн үнэлгээ мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж байна. Энэ бүхэн дээр үндэслээд дараагийн шийдэл гарах учиртай. Гэмтлийн хэм хэмжээг технологийн үнэлгээгээр тодорхойлох ёстой. Тэгж байж дараагийн засварын ажиллагааны үнэлгээ юуг засах вэ, юуг өөрчлөх вэ, шинээр барих асуудлууд гарна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Номин.

Ч.Номин: Та бүхэндээ энэ оройн мэндийг хүргэе. Монгол Улсын 34 дүгээр Ерөнхий сайдад нэр дэвшиж байгаа Гомбожавын Занданшатар даргыг дэмжиж байгаа. Миний хувьд танаас тодорхой 3 асуултыг мэдээлэлтэй өгөөд асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт та сая үгэндээ хүний хөгжлийн асуудал бол танай Засгийн газрын одоо хамгийн том мега төсөл байх болно гэж хэллээ. Тэгээд боловсролоос гадна соёл спорт бол одоо хүний хөгжлийн суурь асуудал байдаг. Та үүнийг бас надаар хэлүүлэлтгүй мэдэж байгаа байх. Энэ ч утгаараа Монгол Улсын Ерөнхийлөгч 2020 онд Соёлын яамыг 24 жилийн дараа байгуулсан. Та бас Их Хурлын дарга байх үедээ

соёлын томоохон хуулиуд болох Соёлын тухай хууль, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тухай хууль, Музейн тухай хууль гээд 4 гаруй хуулийг бас баталсан.

Өнгөрсөн 5 жилийн хугацаанд бол Соёлын салбарын бодлого, тогтолцоо хууль эрх зүйн орчин бүрэн болсон. Хүний нөөцийн тогтвортой байдал бүрдсэн, салбарын цалин хөлс бараг ойролцоогоор дал гаруй хувиар нэмэгдсэн. Нөгөө талдаа Монгол соёл дэлхийн тайзан дээр гардаг болсон. Монгол өв соёлоо дэлхий дахинаас татаж оруулж ирдэг. Нөгөө талдаа томоохон бүтээн байгуулалтууд болох ойролцоогоор Монгол Улсын хэмжээнд 80 гаруй бүтээн байгуулалтуудыг хийсэн. Өнөөдөр бид нар дэлхийд бахархаж ярьж байгаа Чингис хааны музей, Хүүхэд залуучуудын театр, Үндэсний номын сан гээд олон зүйлүүдийг бүтээж бий болгосон ийм амжилттай жилүүд байсан. Тэгээд нэг талаасаа бид бүхэн одоо хүнийг соёл оюуны ухамсартай гэж ярьдаг.

Тэгэхээр одоо соёлын салбарын хувьд бол хүнийг оршин тогтнох соёлд бий болгодог, хамтаар амьдрах соёлыг бүтээдэг. Нөгөө талдаа бүтээлч хүн бий болгодог ийм салбар байгаа. Тэгээд би танаас цаашид соёлын салбарт ямар бодлого барьж явах вэ? Соёлын бүтээлч үйлдвэрлэл гэдэг бол өнгөрсөн хугацаанд дотоодын нийт бүтээгдэхүүний 0.4 хувийг эзэлдэг байсан бол өнөөдөр 1.4 хувийг эзлэх хэмжээний ийм шинэ эдийн засаг бий болж байгаа. Тэгэхээр та энэ шинэ эдийн засгийг бойжуулж авч явахад ямар бодлого барих вэ гэдгийг асууя гэж бодож байна.

Хоёрдугаарт, мөн Монгол Улсын олон улс дахь сурталчилгаа бол стратеги бодлого төлөвлөгөөтэй. Соёл, урлаг спортоор дамжуулан Монгол Улсыг сурталчлах нөгөө талдаа хөрөнгө оруулалтын боломжуудыг сурталчлах ажлуудыг бид нар хийсэн. Бид бүхэн ингэснээр олон улсын хэмжээнд соёлын дипломат харилцаа нэмэгдэж, зөөлөн хүчний индекс хүртэл 14 байраар брэйн файнанс дээр нэмэгдсэн. Тэгэхээр та дан ганц дипломат харилцаагаар гэхгүй одоо Говермент Тү Бизнес, Говермент Тү одоо коммунити гэдэг тиймээ. Одоо хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх дээр та ямар байдлаар олон улсын сурталчилгаагаа авч явах вэ?

Хоёрдугаарт болохоор олон улсад Монгол Улсыг таниулах дээр ямар ажлуудыг цаашид нь үргэлжлүүлж авч явах вэ гэдэг асуулт байна. Нэг минутаа нэмээд авчихъя. Дараагийн нэг асуулт бол та түрүүхэн хэллээ. Эдийн засаг...

Х.Булгантуяа: Нэг минут нэмж тодруулга авахаар.

Ч.Номин: Та түрүүн бас хэллээ. Бид бүхэн аялал жуулчлалын бид бүхэн одоо эдийн засгаа солонгоруулах нь чухал аа гэдгийг. Энэ ч утгаараа аялал жуулчлалын салбарыг бол тэргүүлэх чиглэл гэж үзэж байгаа. Өнөөдөр бол залуучуудын Монгол Улсын нийт хүн амын 30 орчим хувийг бүрдүүлж байгаа залуучуудын хувьд бол уул уурхайн салбарт ажиллахаасаа илүү одоо аялал жуулчлал бүтээлч үйлдвэрлэл, таны түрүүн хэлсэн дижитал эдийн засаг дээр ажиллах сонирхолтой байна.

Тэгэхээр энэ одоо бойжуулж авч явах энэ шинэ эдийн засгууд дээр та ямар бодлого барьж авч явах вэ? Яг өнөөдрийн байдлаар бол аялал жуулчлалын салбар бодитоор дотоодын нийт бүтээгдэхүүний 4 хувийг бүрдүүлж байгаа ийм салбар байна. Бид ирээдүйд энэ 10 хувь хүртэлх өсөх боломжтой ийм салбар байгаа. Тэгэхээр та эдгээр салбаруудыг бойжуулж авах бодлогоо тодорхой хэлж өгөөч ээ гэдэг ийм асуулт байна.

Х.Булгантуяа: Занданшатар даргын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Эдийн засгийг төрөлжүүлэх, солонгоруулах бодлогын хүрээнд аялал жуулчлалын тухай хууль, Соёлын багц хуулиуд, тухайлбал соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль дээр нь Дижитал эдийн засгийг дэмжих багц хууль, Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль гээд ийм 3 шинэ эдийн засгийн тухай ойлголтыг хуульчилж концепцыг нь баталсан. Энэ хууль болгонд нь үзэл баримтлал бодлого нь тодорхой бий. Тэрийг та надаас асуултгүй өөрөө сайн мэдэж байгаа. Надаас шалгалт авч хэрэггүй ээ гэж бодож байна. Соёлын сайдаар ажиллаж байсан хүн харин дэмжиж ажиллаарай гэж хүсэж байна.

Ийм учраас энэ олон улсын сурталчилгаа өөрөө аялал жуулчлалын бизнестэйгээ холбогдох ёстой. Бодит үр дүн гаргахын тулд энэ соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын, эдийн засгийн шинэ салбар болгоход зохиогчийн эрхийг баталгаажуулах, хууль эрх зүйн орчныг шинэчлэх, бүтээлч үйлдвэрлэлийн сан байгуулах, хөрөнгө оруулалтыг татах, кино үйлдвэрлэлээс авхуулаад энэ шинэ эдийн засгийн соёлыг бүтээлчээр үйлдвэрлэл болгох хандлага бол Монгол Улсын зөвхөн эдийн засгийн шинэ төрөл салбарт төдийгүй Монгол Улсын тусгаар тогтнолын баталгаа дархлаа болох үндэсний нүүдлийн энэ монгол соёлын одоо ондоошил ижилсэл. Монгол үндэстний ондоошил ижилсэл бол монгол соёлтой салшгүй холбоотой. Дэлхийд байхгүй монгол наадмаас эхлээд энэ агуу их соёл бол Монголын одоо бас дархлаа тусгаар тогтнолын баталгаа юм.

Тийм учраас үүнийг зөвхөн эдийн засаг утгаар нь төдийгүй Монгол Улсын дэлхийн сурталчилгаа бас аюулгүй байдлын баталгаа, монгол үндэстний сөрөн тэсвэрлэх чадавх гэж миний яриад байгаа тэр одоо үзэл хандлагын нэг гол чухал эд эс нь гэж бид ойлгох ёстой. Ийм учраас энэ чиглэлээр манай Номин сайд маань бас хийж хэрэгжүүлсэн ажлаараа залгамж чанарыг хадгалж дэмжиж ажлын хэсэг Улсын Их Хурал дээрээ бас үргэлжлүүлж, энэ хууль эрх зүйн шинэчлэлийг бодитой ажил хэрэг болгоход нь анхаарч ажиллаж хамтарч ажиллахыг хүсье.

Х.Булгантуяа: Номин сайд нэмж нэг минут тодруулъя.

Ч.Номин: Занданшатар даргадаа баярлалаа. Тодорхой хариулт өгсөнд. Миний хувьд бол зөв бодлого цаг хугацааны сорилтыг даваад, урт удаан хугацаандаа үр шимээ өгдөг гэж хардаг. Тэгэхээр би таны хэлснээс цаашид соёлын өвийг хадгалж хамгаалах, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, нүүдлийн соёл иргэншлийг түгээн дэлгэрүүлэх бүх нийтийн соёлын боловсролыг нэмэгдүүлэх, дээрээс нь бол одоо соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх аялал жуулчлалыг эдийн засгийн төрөлжсөн салбар болгож мөн олон улсад Монгол Улсын сурталчилгааг үргэлжлүүлэн авч явж энэ ажил бодлогын хүрээнд тогтвортой байна гэж ойлголоо.

Х.Булгантуяа: Номин сайд санал хэллээ. Улсын Их Хурлын гишүүд ээ, одоо 19 цаг 14 минут болж байна. Бид сая 2 цагаас хойш бас тасралтгүй хуралдлаа. Өнөөдөр бол хэлэлцэх асуудлаа дуустал чуулганы хуралдаан үргэлжлэх болно. Тэгээд 30 минут хэртэй завсарлаад 19 цаг 50 минутад буцаж чуулганы хуралдааныхаа танхимдаа үргэлжлүүлэн хуралдъя.

Манай Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулагчдаас авхуулаад нэг хэдэн минутын завсарлага авахгүй бол бас болохгүй байгаад байна.

19 цаг 50 минутаас үргэлжлүүлэн чуулганы хуралдаан үргэлжлэх болно.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын чуулган үргэлжлэн хуралдаж байна. Одоо асуулт асуухаар Улсын Их Хурлын гишүүн Сонгобайн Замира.

С.Замира: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Ерөнхий сайдад нэр дэвшиж байгаа Гомбожавын Занданшатар гуайг ерөнхийдөө дэмжиж байна. Гэхдээ нэг хэдэн асуулт асууя.

Нэгдүгээрт, та урд нь төрийн өндөр албан тушаал хашиж байсан туршлагатай боловсон хүчний хувьд өмнөх Засгийн газраас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээнүүдийг хэрхэн дүгнэж байна вэ? Хоёрдугаарт, мөн өмнөх Засгийн газрын үед эхлүүлсэн ажлуудыг цаашид үргэлжлүүлэх үү? Гуравдугаарт, одоогийн байдлаар татвар, нийгмийн даатгалын шимтгэл, бас дээрээс нь зээлийн хүү гээд одоо ард түмний нуруун дахь ачаалал маш их хүндэрчихсэн байгаа. Энэ тал дээр ямар арга хэмжээ авах вэ? Дөрөвдүгээрт сая давхардлаа. Тэгэхдээ нэмж асууя. Яамдуудын тоог багасгах уу? Давхардсан удирдлагатай төрийн байгууллагуудыг эмхлэн цэгцлэх үү? Тавдугаарт бол чөлөөт бүс гэж нэг байгуулагдсан байгаа ...нэг байгууллагууд. Гэхдээ нэр нь байгаа болохоос биш одоохондоо бол үйл ажиллагаа нь зогсонги байдалтай байгаа. Үүнийг ажил хэрэг болгох уу? Зургадугаарт, Монгол банкны бодлого нь алдагдсан байна. Үүнд ямар арга хэмжээ авах вэ гэсэн 6 асуулт байна. Нэмж асуухаар байвал нэмж асууна аа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Занданшатар даргын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Сонгобайн Замира гишүүний асуултад хариулъя аа. Зээлийн хүүгийн асуудал бол мөнгөний бодлогын асуудал бөгөөд мөнгөний бодлогын асуудал Улсын Их Хурлын харьяанд Засгийн газарт шууд харьяалагддаггүй Үндсэн хууль болон хууль эрх зүйн хувьд мөнгөний бодлого Засгийн газраас хараат бус байдаг. Энэ зээлийн хүү, бодлогын хүүг уялдуулах, мөнгөний .. буюу мөнгө хэвлэн гаргах эрх одоо Улсын Их Хурлын харьяа Засгийн газраас хараат бус оршдог. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн реформыг хэрэгжүүлнэ ээ гэдгийг би олон давтаж хэлсэн. Ер нь бол татварын талаар нэмэгдсэн өртгийн албан татварыг одоо буцаан олголтыг нэмэгдүүлж, иргэдийн нуруун дээр иргэн бүрийн худалдан авахдаа төлж байгаа орлого ямар орлоготойгоосоо эс хамааран төлж байгаа энэ татварын дарамтыг бууруулах ийм зарчимч зарчмын чиглэл баримталж байгаа.

Нийгмийн даатгалын шимтгэл ч гэсэн нэн ялангуяа үйлдвэрлэгчдэд, бизнес эрхлэгчдэд дарамт болж байгаа. Тэгэхдээ нөгөө талдаа нийгмийн даатгалын сангийнхаа үр ашгийг сайжруулж, сангийн менежмент, зардлын оновчтой байдлыг үр ашигтай байдлыг нь хангахгүй бол өсдөггүй, үрждэггүй нэг ийм сан байгаад тэр нь хулгайд нэрвэгдээд байвал Нийгмийн даатгалын шимтгэлийн энэ тогтолцоо чинь өөрөө энэ олон жил хуримтлагдаад бизнес эрхлэгчдийн нуруун дээр татвар олж байгаа. Энийг л бодлогын түвшинд засах ийм шаардлагууд байгаа.

Монгол банкны бодлого алдагдсан байна аа гэж байна. Монгол банк бас Засгийн газрын харьяат байгууллага биш ээ. Улсын Их Хурлын харьяаны байгууллага аа. Ийм учраас Монгол банкны мөнгөний бодлогын хэрэгжилтийн асуудлыг бол Засгийн газар хариуцаж дүгнэх бололцоогүй ээ. Яамдуудын тоог багасгах уу. Ер нь яамдуудын тоог цөөлөөд л, нэр усыг нь солиод ирэхээрээ л бас дагаад л баахан зардал гардаг. Тэрнээсээ илүүтэй зардал гаргадаг үндэсний хороод зөвлөл гэж 59 үндэсний хороо зөвлөл, 3 одоо яамны статустай хороо байна. Энэ чиг үүргийн шинжилгээ хийж, чиг үүргийн давхардалтай ийм хороодыг цомхотгох нь маш том зардал, илүү үр ашиггүй байдлыг хэмнэх бололцоо гэж эхний ээлжид бодож байгаа. Энэ чиглэлээр судалгаа хийж бүтэц бүрэлдэхүүний тухай хуулийг өргөн барихдаа энэ талаар тодорхой танилцуулах болно.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг. За хүлээж байгаарай Сайнзориг гишүүн. Замира гишүүн тодруулъя.

С.Замира: Баярлалаа чөлөөт бүсийн тухай нэг асуусан юм даа. Одоо ер нь үйл ажиллагаа нэг бол хаагаад наадах ингээд зардал гаргахгүйгээр, нэг бол аминд оруулах хэрэгтэй байна. Энэ талаар ямар бодлоготой байна вэ гэж.

Х.Булгантуяа: Занданшатар дарга хариулъя.

Г.Занданшатар: Энэ чөлөөт бүсүүдийг Чөлөөт бүсийн тухай хуулийн дагуу бие даалгаж ажиллах бололцоог нь олгохгүйгээр одоо Цагаан нуурын ч тэр, Замын-Үүдийн ч тэр, Алтанбулагийн чөлөөт бүс нэрийн төдий байгаа. Энэ бас боомтын шинэчлэлтэй уялдана аа. Нэвтрүүлэх чадвартай уялдана аа. Ийм учраас чөлөөт бүсийн талаар тусдаа бие даасан бодлогыг хэрэгжүүлнэ ээ.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг.

П.Сайнзориг: Баярлалаа. Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшиж байгаа Занданшатар даргаас бас нэг 2, 3 зүйлийг асууя аа гэж бодож байна. Ер нь Засгийн газар Ерөнхий сайдын ажлыг дүгнэхдээ яг хувийн хэвшилд хэчнээн ажлын байр байнгын тогтвортой ажлын байр бий болгосноор нь үнэлэх энэ улс төрийн соёл руу ер нь цаашдаа орвол яасан юм. Энэ тоон үзүүлэлтийг ерөнхийдөө одоо яг авч хэлэлцдэг баймаар байгаа. Ингэж байж ерөөсөө энэ ажлын байрыг бий болгох энэ бодлогын цаана хүний хөгжлийн асуудлаа бид анхаардаг болно оо, хүнээ бэлддэг болно оо. Хүнийхээ хөгжлийг дагаад боловсрол, эрүүл мэнд байдаг юм уу тэр өрсөлдөх чадварын асуудлыг нь бид судалдаг, ярьдаг. Энэ одоо бодлогын асуудлуудаа ярьдаг болно. Энэ ажлын байр бий болгох замаараа энэ ядуурлыг бууруулах асуудал яригдана.

Тэгээд энэ ажлын байрыг бий болгож болох энэ салбаруудынхаа хууль эрх зүйн орчныг бид нар анхаардаг болно. Өнөөдөр яах вэ зүгээр бол уул уурхайн салбар гээд одоо хамгийн том ажлын байр бий болгох салбар байгаа мөртөө эндэх бодлого нь тодорхойгүй, гаднын хөрөнгө оруулагчид хардаг, эргээд одоо бид хэд энэ салбар дахь хувийн хэвшил рүүгээ бас хэтэрхий их одоо яриа хэлэлцээрийн арга бас жоохон нэг л энэ дайсагнасан гэдэг юм уу, хоёр талд гараад л үзэх гээд байгаа юм шиг л ийм хандлагууд жоохон олон нийтийн дунд төрчхөөд байна. Тэгэхээр энэ бодлогыг одоо бас авч явах, тодорхой болгох үүднээс таныг бас энэ ашигт малтмал, уул уурхайн салбарын хууль тогтоомжийг бас одоо яаралтай оруулж ирэх асуудал дээр бас ямар байр суурьтай байх вэ гэдэг зүйлийг бас асууя.

Манайд энэ ажлын байр бий болгох замаар энэ хөрөнгө оруулалтын асуудлыг татна. Энэ хөрөнгө оруулалтын асуудлыг ярихаар хувийн хэвшилтэйгээ л ярина. Тэгэхээр бас Занданшатар даргын үгэнд бас нэг үнэхээр бас баярлаж байгаа зүйл байна. Төрийн өмчит компанийг бас ерөнхийдөө зоригтойгоор танаж бууруулна аа. Ингэж байж өөрөө энэ хувийн хэвшилд бас энэ орон зай нь гарч ирэх юм байгаа юм. Бизнесийн орон зай гарч ирнэ. Тэгэхээр энийг одоо бас таныг үнэхээр зоригтой шийдэмгий алхам аваасай гэж хүсэж байна. Энэ Улсын Их Хурлаас бас энийг нь бодлогын дэмжлэгийг нь яаралтай үзүүлээд явах ёстой. Тэгээд би энэ бизнесийн бас нэг эрх зүйн орчныг сайжруулах нэг 20 гаруй хуулийг Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр өнгөрсөн одоо 2 жилийн өмнө л боловсруулаад байж байгаа. Энийг та нэн тэргүүнд бас нэг татаж үнэхээр одоо шаардлагатай боломжтой бол эдгээрийг нэг бас өргөн барих чиглэлд нь бас Засгийн газрыг бас холбогдох сайдуудыг магадгүй одоо таны доор ажиллах Хууль зүй, дотоод хэргийн сайддаа бас анхаарал чиглэлийг нь өгч ажиллаач ээ гэж би одоо хүсэж байгаа юм.

Алтангэрэл сайдын хувьд яах вэ нэг 2, 3 нь л орж ирлээ. Төлбөрийн чадваргүйтэл болон арилжааны хууль, шүүхийн шийдвэр гүйцэтгэл гээд. Ингэж байж бид нар энэ бизнесийн эрх зүйн орчныг сайжруулна аа. Хоёрдугаарт, хамгийн нэг том юм бол энэ Монгол Улсын Ерөнхий сайд бол энэ Улсын Их Хурлын өмнө хууль тогтоомжийн биелэлтийг хангуулдаг. Таныг хууль тогтоомжийн агентлагийг байгуулж, энэ 5 жил тутам энэ хууль тогтоомжуудын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж Улсын Их Хуралд тайлагнах, энэ хуулийн шаардлагыг хангах энэ тогтолцоог хийж цаашдаа анхаардаг байгаасай гэж хүсэж байгаа юм.

Дээрээс нь энэ хүнс эрүүл мэндийн хяналтыг одоо нэгд...

Х.Булгантуяа: Занданшатар даргын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Сайнзориг гишүүний асуултууд бол бас саналын шинж чанартай учраас зарчмын хувьд дэмжиж байна аа. Нэн ялангуяа ХЗДХЯ-н дээр боловсруулж байсан бизнесийн орчныг боловсронгуй болгохдоо чиглэсэн Дампуурлын хууль буюу төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль. Энэнтэй уялдаад бас танхимын хууль ер нь энэ бизнесийн орчныг тааламжтай болгоход чиглэсэн энэ өмчийн эрхийн Өмчийн тухай хууль, Иргэний тухай хууль зэрэг ийм суурь хуулиуд дээр зайлшгүй шинэчлэл хийж байж энэ өмчийн эрхийг хамгаалах, баталгаажуулахаас авхуулаад бизнесийн орчныг сайжруулахад чиглэгдсэн ийм багц хуулиудыг өргөн барихаар ажиллаж байсан. Тэгээд энэ чиглэлээр Сайнзориг гишүүн, Пүрэвжавын Сайнзориг ч гэсэн бас өөрөө тус яаманд ажиллаж байсан хүний хувьд санаачилгатай ажиллаж тал талаасаа шахаж ажиллах шаардлагатай байх. Шинээр томилогдох Хууль зүй, дотоод хэргийн сайдад чиглэл өгч ажиллах болно. Юуны өмнө өмчийн тухай хууль бол өнөөдөр хамгийн чухал шинэчлэл шаардагдаж байгаа хууль гэж бодож байна.

Хууль тогтоомжийн агентлагийн хувьд бол одоо өнөөдөр хэмнэлтийн тухай ярьж байгаа үед Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн гээд холбогдох газрууд ажлаа хийгээгүйн төлөө бас шинээр агентлаг байгуулаад байх нь ямар шаардлагатай юм бол. Тэгээд л энэ хуулиудын хийдэл, зөрчил, давхардлын асуудал гээд л томоохон төслүүд хэрэгжиж байсан. Үр дүн нь юу болсон одоо энэ хуулиудын зөрчил, давхардлын чиглэлээр хиймэл оюун ухаан хууль боловсруулах чиглэлээр ажиллачихсан үед ийм агентлаг байх шаардлагатай юу гэдгийг болбол

бас бүлгийн хурлын дараа судалж үзэж байна. Зайлшгүй шаардлагатай болбол төсвийн тодотголын үеэр энийг эргэж авч үзье. Үндэслэлээ та тодорхой гаргаж өгөөд төсвийн тодотголын үеэр эргэж ярилцъя аа гэсэн Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай хуулийг өргөн барихдаа энэ асуудлыг хэлэлцье ээ. Саналаа та үндэслэлтэй ингээд танилцуулаад зайлшгүй шаардлагатай гэж үзвэл энэ талаар хэлэлцье ээ гэсэн ийм бодолтой байна аа.

Х.Булгантуяа: Сайнзориг гишүүн нэг минут тодруулъя.

П.Сайнзориг: Баярлалаа. Бас нэр дэвшиж байгаа хүн маань бас дэмжих одоо өнгө аясаар үг хэлж байгаад бас баярлаж байна. Ер нь зүгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны энэ хууль зүйн бодлого дээр нэг 10 хэдхэн хүн байдаг юм. Тэгээд энэ долоо 800 хуулийн хэрэгжилтийг бас үнэлэх асуудал үнэхээр хүн хүчний хувьд хүрэхгүй. Энэ хууль зүйн салбар буюу Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний л бодлого шийдвэр хууль дээр ажилладаг. Тэгэхээр энэ Улсын Их Хурлын өмнө Ерөнхий сайдын хуулийн хэрэгжилтийг хариуцаж байгаа ажил маань энэ өнгөрсөн 30 жил орхигдож явж ирсэн юмаа. Энийг одоо бас яг шинэ Ерөнхий сайд маань одоо бас энийг анхаарч авч үзээсэй гэж хүсэж байгаа юм.

Хоёрдугаарт, энэ бизнесийн эрх зүйн орчин дээр хөдөлмөрийн хуулийн ч юм уу хэрэгжилтийг нэг зайлшгүй авч үзмээр байна. Энэ уул уурхай дээр одоо 3 ээлжтэй болохоос өөр аргагүй нөхцөл байдал руу түлхчихсэн. Энэ өөрөө эргээд ажиллах хүчний хомсдол үнэхээр бий болчихоод байхад заавал одоо 3 ээлжийн төлөвлөж байж энэ уул уурхайнууд явдаг энэ хэмжээгээрээ зардал өсөж байгаа. Энэ хэмжээгээрээ одоо бас энэ уул уурхайн одоо бүтээгдэхүүний орж ирэх татварын нөхцөл байдлууд ч багасаж байгаа гэж үзэж байгаа. Тэгээд ер нь зүгээр эдийн засгийн асуудал дээр та бас онцгой анхаарч эдийн засгийн бодлогын...

Х.Булгантуяа: Сайнзориг гишүүн санал хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүн.

С.Цэнгүүн: Оройн мэнд хүргэе. Тэгээд миний өмнө асуулт асуусан 43 гишүүний асуултуудаас та эрчим хүчний реформ хэр чухал вэ гэдгийг ойлгосон байх гэж бас найдаж байна. Тэгэхээр таны кабинетын бүтэц болон төлөвлөгөөг харж байгаад илүү нарийн асуултуудаа эрчим хүчтэй холбоотой дараа нь асууя гэж шийдлээ.

Тэгээд гишүүдийн асуусан асуулт дундаас таны хариултуудаас хэд хэдэн зүйл бас нэг сонирхолтой санагдаад байна л даа. Та сая ард түмний нуруун дээрээс татварын дарамтыг авч хаях цогц реформ хийнэ ээ гэж хэлсэн. Тэгснээ өнөөдөр ахиад ард иргэдэд учирч байгаа татварын дарамтыг бага болгож тансаг хэрэглээний болон хэт өндөр орлоготой иргэдэд ноогдуулах татварыг нэмэгдүүлж, тэгш шударга нөхцөлийг хангана аа гээд бас хэлчихлээ.

Тэгээд таны бодлоор ер нь энэ хэт өндөр орлоготой хүмүүс гэж та хэнийг хэлээд байгаа юм бэ? Хэт өндөр орлоготой хүмүүс гэдэг чинь бол одоо хувиараа бизнес эрхлэгчид байгаа, бүтээмжтэй чадварлаг ажиллаж чадаж байгаа гүйцэтгэх захирлууд, менежерүүд байгаа. Уул уурхайн салбарт ээлжээр ажиллаж байгаа уул уурхайн салбар буюу Монголын эдийн засгийг авч яваа энэ хүмүүс байгаа юмаа. Тэгэхээр ингээд түүнээс биш бусдаар бол өндөр цалин авах бол манайд боломж бол байхгүй. Харин Засгийн газрын аль нэг яам агентлагт ажиллаж байгаа 1-2 сая

төгрөгийн цалингаас илүү мөнгө авдаггүй хэрнээ тэрбумтан, үр хүүхэд нь үнэтэй гадаадын том сургуулиудад сураад яваад байдаг, хаанаас яаж мөнгөө олдог нь тодорхойгүй хүмүүсүүд л байгаа.

Тэгэхээр төрийн албаны дунд шатны авлигачидтайгаа та тэмцэнэ гэж хэлбэл илүү шударга ёсыг бий болгох юм биш үү гэж би бол харж байна. Одоо ч ил тодоор татвараа татвараа төлөөд яваад байгаа хүмүүсийн тэр татварыг нь ахиж нэмнэ гэж ярих эрх бол байхгүй гэж бодож байна. Илүү бүтээмжтэй сайн ажиллаж байгаа хүмүүсээ бид нар шийтгээд тэгээд нийтээрээ ядуу байх бодлого баримтлаад явах юм уу? МАН өмнө нь ч гэсэн энэ бодлого хэрэгжүүлж байсан шүү дээ. Тэрнийх нь үр дүнд залуучууд нь эх орондоо хийж бүтээе мундаг лаг том больё гэж бодохгүйгээр яришиг гадагшаа явъя л гэж бодоод өнөөдөр бид нар бүх залуучуудаа алдаад явж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ өөрөө таны яриад байгаа либерал бодлого бизнес эрхлэгчдийг дэмжих бодлого биш. Тийм учраас та энэ бодлогоо бас татаж аваарай гэж хүсмээр байна.

Тэгээд хоёр дахь асуулт нь болохоороо энэ манай Монгол Улсын залуучуудаас ирж байгаа асуулт надаар дамжуулж асууж байна. Тэгэхээр чимээгүй тахал болсон хар тамхи мансууруулах бодисын хэрэглээг та юу гэж харж байгаа вэ? Тэгэхээр Монгол улсын хэмжээнд 2017-2022 оны хугацаанд бол мансууруулах эм сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой 939 гэмт хэрэг, 1173 сэжигтэн бүртгэгдсэн байна аа. Энэ тоо улам нэмэгдэж байгаа. Нийт холбогчдын 92 хувь нь 35-аас доош насны оюутан залуучууд, тэгээд хүүхэд багачууд орж байна. Өнөөдрийн байдлаар 200 орчим хүн ял эдэлж байна аа. Тэгэхээр Монгол Улс маань тээвэрлэгч биш бүр хэрэглэгч орон болсон. Тиймээс танаас асууя. Та энэ тал дээр ямар төлөвлөгөө байна вэ? Яаж энэ төрлийн гэмт хэрэгтэй бодитоор тэмцэх вэ? Мансуурах бодисын ангиллыг та бас юу гэж хардаг вэ? Зарим улс орнууд бол кабинас канибас буюу одоо Мариванагийн төрлийг бол зөвшөөрөөд байгаа. Тэгэхээр та Мариванагийн тал дээр...

Х.Булгантуяа: Цэнгүүн гишүүнд нэг минут нэмж өгье.

С.Цэнгүүн: Тэгэхээр та яг шууд Маривана болон Каннабасын төрлийн ургамлууд дээр ямар байр суурь баримталж ажиллах вэ? Тэгэхээр энэ төрлийн асуудлууд дээр бас шууд тодорхой хариулт өгөөч ээ гэж хүсье.

Х.Булгантуяа: Занданшатар даргын микрофоныг.

Г.Занданшатар: Саруулсайханы Цэнгүүн гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт, татварын тогтолцоо тэгш шударга бааз сууриа өргөтгөсөн байх зарчмыг хэлсэн. Энэ бол нэгдүгээрт нэмэгдсэн өртгийн албан татварыг төлдөг нь хохирдог, төлдөггүй нь хождог. Тэгээд төлдөггүй хүн нь илүү орлого олоод байвал энийг л ялгаатай татвар гэж байгаа юм.

Хоёрдугаарт нь хэт өндөр тансаг хэрэглээний татвар гэж хэлсэн. Жишээлбэл яагаад үндэсний үйлдвэрлэлийнхээ архи пивыг ч юм уу хэрэглэхийн оронд хэт өндөр үнэтэй маш өндөр үнэтэй, одоо 270 орчим сая долларын архи, тамхи гаднаас импортоор авч байна. Энэ чинь валютын ханшийг өсгөж байна. Нийт ард түмний нуруун дээр валютын ханшаас үүдэлтэй инфляцыг хөөрөгдөж байгаа. Одоо хэт өндөр хэрэглээ гэдэг дээр импортоор авч байгаа би нисдэг тэрэг ч байдаг юм уу, хэт өндөр үнэтэй машин одоо уул уурхай, эдийн засаг нэмэгдэх тусам лексус дээд

зэрэглэлийн машинуудын импортын хэрэглээ нэмэгддэг. Энэ нь одоо чухам ямар орлоготой гэдгээсээ үл хамаараад.

Ийм учраас энэ болбол Индонез ч бай, Америк ч бай дэлхийн бүх улсуудад либерал эдийн засагтай, аль эсвэл одоо Шведийн загварын улсууд ч гэсэн энэ хэрэглээнд татвар оногдуулж байгаа юмаа. Ийм учраас энэ бол хэт өндөр тансаг хэрэглээний хэрэглээний татвар гэж байгаа шүү. Түүнээс биш би орлогын татвар яриагүй.

Өөрөөр хэлбэл тансаг хэрэглээний татвар болбол жирийн иргэдэд дарамт биш. Тэнцвэрт шударга бодлого, хэт үнэтэй машин, үнэт эдлэл одоо цүнх нь ч байна уу тансаг хэрэглээнд илүү татвар оногдуулаад олсон орлогоороо нийтэд хэрэгтэй боловсрол, эрүүл мэнд зэрэг үйлчилгээг санхүүжүүлэх нь шударга зарчим. Ийм учраас энд цалинг хэлээд байгаа юм биш. Тэр хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийг дэмжинэ гээд байна шүү дээ. Цалингийн татвар энэ ХХОАТ-ын тухай яриа биш. Энэ бол хэт тэнцдэг хэрэглээний импортыг өдөөж байдаг нэн ялангуяа импортын татвар онцгой татвар. Энэ татваруудыг хэлж байгаа юмаа гэдгийг би онцолж хэлж байгаа юм шүү.

Түүнээс биш энэ дэлхийн одоо маш олон улсад 30 гаруй улсад ч гэсэн нэлээн энэ чиглэлээр хамаардаг. Жишээлбэл хэт өндөр үнэтэй тансаг хэрэглээнд тансаг зэрэглэлийн автомашин жишээлбэл Роз Ройс, Роис Мендли ч байдаг юм уу хувийн онгоц одоо хэчнээн нисдэг тэрэг нисэж байна. Тансаг зэрэглэлийн үл хөдлөх хөрөнгө, үнэт шулуун эдлэл, брэндийн цүнх, хувцас, цаг, өндөр үнэтэй дарс, архи зэрэг бүтээгдэхүүнүүдийг хэт өндөр тансаг хэрэглээнд тооцдог. Ард нь мөнгө угаалт явагддаг.

Ийм учраас энэ бол жирийн иргэдийн нуруун дээр дарамт биш. Харин тэр тансаглаад байна гэж шүүмжлээд байгаа ард иргэдийн чинь орлогын ялгаан дээр яриад байгаа шүүмжлэл дээр үндэслэж энэ тансаг хэт өндөр тансаг хэрэглээний татварын тухай яаж байгаа юм. Зүгээр тансаг хэрэглээ биш хэт өндөр тансаг хэрэглээний тухай ярьж байна аа гэж ойлгож байгаа.

Хоёрдугаарт нь чимээгүй хар тахал болсон хар тамхи үндэсний аюулгүй байдлын хэмжээнд очсон. Энэ талаар нууцын зэрэглэлтэй мэдээлэл энэ танхимд хийгдсэнийг та бүхэн сайн мэдэж байгаа. Ийм учраас энэ хар тамхины асуудлаар Монгол Улс зөвхөн дамжуулах биш, тээвэрлэгч биш хэрэглэгч улс орон болсон гэдэг ийм тодорхой дүгнэлт гарсан. Энэ бол маш товч тодорхой мансууруулах бодисын хууль шийтгэлийг зөвхөн хатууруулаад зогсохгүй энийг урьдчилан сэргийлэх, залуучуудаа соён гэгээрүүлэх, эмчилгээний ийм тогтмол бодлого хэрэгжүүлэх ёстой юм байна лээ. Хууль хар тамхины хууль бус хэрэглээг таслан зогсоохын тулд хяналт шалгалт мөрдлөгийг сайжруулах тусдаа ДиЭйАй гэж одоо Драг инфорсмент Организэйшн гэж одоо ийм байгууллагуудтай хамтарч ажилладаг ийм тусгай бүтцийг байгуулах ёстой.

Тийм учраас мансууруулахтай тэмцэх нь зөвхөн хуулийн байгууллагуудын асуудал биш харин соён гэгээрүүлэх, боловсрол...

Х.Булгантуяа: Занданшатар даргын микрофоныг нэмж өгье.

Г.Занданшатар: Ингээд мансууруулах бодисын эсрэг бодлого бол хил гаалийн хяналтыг чангатгах, хууль сахиулах байгууллагуудын чадавхыг сайжруулах, урьдчилан сэргийлэх боловсролыг сургуулиас эхлүүлэх, нийтэд хүргэх, эмчилгээ нөхөн сэргээх тогтолцоог хөгжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх гэсэн ийм цогц арга хэмжээний хүрээнд тусдаа энэ байгууллага байгуулах хэрэгтэй. Одоо манай энэ цагдаа болон тагнуулын газарт байгуулж байгаа хүчин чадавх бол үнэхээр хангалтгүй байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Цэндсүрэнгийн Мөнхтуяа.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ оройн мэнд хүргэе ээ. Монгол Улсын тэргүүлэх салбар гэгддэг боловсролын салбарын асуудал бол зөвхөн энэ нэг салбарын асуудал биш Монголын асуудал гэж би ойлгодог. Занданшатар даргын хувьд ч гэсэн бас багшаар ажиллаж байсан хүний хувьд боловсролын салбарын асуудал дээр бас нэлээн онцгой анхаарна аа гэж танд бол итгэж байна. Тэгээд 3 асуулт байна аа.

Нэгдүгээрт нь мэдээж боловсролын салбарын багш, ажилчдын цалин хөлс. Өнөөдөр Монголын багш нар сая 480 мянган төгрөгийн цалин авч байгаа. Энэ нь ерөөсөө 400 доллар гэсэн үг доллартой харьцуулахаар. Тэгэхээр энэ хүмүүсийн цалинг яаралтай мянган долларт шилжүүлэх асуудлыг 2017 оноос өнөөдрийг хүртэл одоо шаардаж бид нар бас ингээд явж байгаа. Монголын багш нарын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын мянга мянган багш нар 2017 оноос эхлээд энэ багшийн цалинг мянган долларт хүргээ гээд шаардлагаа тавиад явж байгаа. Энэ асуудал дээр бол бас Занданшатар даргыг огт мэдэхгүй гэж бол би бодохгүй байна мэдэж байгаа байх тиймээ, багшийн цалингийн асуудал дээр. Энэ багш нарын цалинг яаралтай мянган долларт хүргэх ийм арга хэмжээг та авч чадах уу зоригтойгоор гэж асууя аа нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт болохоор 2024 оны 4 дүгээр сард Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүхийн ивээл дор Монголын багш нарын 8 дугаар их хурлыг зохион байгуулсан. Энэ их хурлаар, их хурал дээр одоо Оюун-Эрдэнэ сайд байсан, та байсан, Ерөнхийлөгч ч байсан. Тэгээд энэний энэ одоо Их хурлын хамгийн их санал гарч байсан асуудал бол багшийн тэтгэврийн насны асуудал. Эрэгтэй 55, эмэгтэй 50 настай хүсвэл тэтгэвэрт гарах энэ эрх зүйн орчныг бүрдүүлж өгөөч ээ гэж монголын мянга мянган багш нар энэ дээр санал гаргаж байсан. Энийг бол Занданшатар дарга өөрөө мэдэж байгаа байх гэж би бодож байна. Тэгэхээр энэ асуудал дээр бас та нэг анхаарч ажиллаарай гэдгийг бас хэлмээр байна аа.

Гуравдугаар асуудал манай боловсролын салбар бол 100 гаруй мянган багш, ажилчид ажилладаг, сая гаруй хүүхэд сурдаг маш том салбар. Тэгэхээр энэ салбарын одоо багш нар нийгмийн асуудал маш хүнд байдаг. Цалин нь бага учраас өөрийн гэсэн орон сууц өмчилж авч чаддаггүй. Ипотекийн зээлд хамрагдъя гэхээр цалин нь хүрдэггүй ээ банкны шаардлага хангадаггүй ээ. Тийм учраас энэ багш нарын ажилчдын цалин хөлс, энэ байр орон сууцны асуудал дээр та анхаарч ажиллаж чадах уу гэдгийг Мөнхтуяа гэдэг хүний зүгээс биш Монголын мянга мянган багш нарын өмнөөс танаас асууж байна аа.

Тэгээд бас нэг зүйлийг бас хэлмээр байна аа. Хэн нэгэн ч юм уу хэсэг бүлэг хүмүүсийн энэ найрааны юуг одоо энэ гар хөлийг боловсролын салбараас салгаж чадах уу? Тендер тиймээ номын сурах бичгийн тендер, одоо хөтөлбөр, төсөл хөтөлбөр маш олон юмнууд энэ боловсролын салбараар дамжаад хүн...

Х.Булгантуяа: Мөнхтуяа гишүүнд нэг минут нэмж.

Ц.Мөнхтуяа: Тэгээд одоо сүүлийн үед манай Галбадрах гишүүн бас яриад байна л даа. Сургуулийн менежмент гээд. Тэгээд дээрээс нь 95 цэцэрлэг, 108 сургууль барина гэж яриад байгаа юм. Тэгэхээр энэ сургууль, цэцэрлэгт чинь ажиллах боловсон хүчин байгаа юм уу? Сая энэ 2024-2025 оны хичээлийн жилд 4200 багшийн дутагдалтай байсан шүү дээ. Одоо тэгээд сургууль, цэцэрлэг нэмж барьснаараа багшийн хомсдолыг арилгана гэж та үзэж байна уу, эсвэл багшийн нийгмийн асуудал нийгмийн баталгааг нь хангаж байж энэ багшийн хомсдол чинь арилах юм уу гэдэг дээр та ямар бодолтой байна вэ гэдгийг бас танаас асуумаар байна аа? За баярлалаа.

Х.Булгантуяа: Занданшатар дарга хариулъя.

Г.Занданшатар: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя аа. Монгол Улсын Их Хурлаар 2023 онд Боловсролын багц хуулийг баталсан. Боловсролын реформыг эхлүүлсэн. Боловсролын салбарт бодлогын шинэчлэл арга хэмжээний суурь нөхцөлийг энэ хуулиар бий болгосон. Энэ шинэчлэлийн хүрээнд боловсролын чанар, хүртээмж, тэгш бус байдлыг тэгш байдлыг дэмжиж үр ашигтай нөхцөл хангах чиглэлээр бас нэлээн тодорхой өөрчлөлтүүд хийсэн. Тэгээд цалин хөлсийг болбол энэ төсвийн тодотголоор нэмэх боломж хязгаарлагдмал аа. Өнөөдөр төсвийн орлого 2.3 их наядаар дутах төсөөлөлтэй байна. Ийм учраас 2.3 их наядаар төсвийн зардлыг танахаас өөр аргагүй нөхцөл байдал үүсэж байна. Энэ гадаад нөхцөл байдал тарифын дайнаас шалтгаалсан манай экспорт орлогууд унаж байгаатай шууд холбоотой.

Харин 2026 онд бол ер нь энэ боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд одоо яах вэ бүх нэмэгдэл энэ тэрээ тооцоод нөгөө 40 хувийн нэмэгдэл, хөдөө орон нутагт багш нарын дутагдалтай холбоотой 40 хувийн нэмэгдэл энэ тэрээ тооцоод бусад салбарын дундаж цалин нэг 2 сая 332 мянга байхад боловсролын салбарын цалин дунджаар 2 сая төгрөг гэж байгаа юм. Яг нөгөө бусад нэмэгдлүүдээ тооцчихоор. Энийг 6 хувиар жил болгон нэмэгдүүлэхэд 2028 онд багшийн цалинг цэцэрлэгт, ерөнхий боловсролын сургуульд мэргэжлийн боловсрол, дээд боловсролын салбарт бол мянган доллар хүрэх ийм тооцоо судалгаа хийж ажиллана. Ирэх жилд 2026 онд 6 хувиар инфляцтай нь нэмэгдүүлж нэмэх ийм л дотоодтой байгаа юм билээ. Тэгээд энийгээ бүтээмж, үр дүнтэй, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн системд боловсролын салбарт шилжүүлснээр ил багш бас ажилласнаараа, хийснээрээ одоо бусад илүү цаг болон хүүхэдтэй ажилласан цагаараа нэмэлт цалин, нэмэлт урамшуулал авах боломжийг бүрдүүлэх нь илүү үр ашигтай боловсролын тогтолцоонд шаардлагатай чиг хандлага гэж үзэж байгаа.

Багшийн дутагдлын асуудал бол нэн ялангуяа хөдөө орон нутагт цэцэрлэгийн багшийн мэргэжлийн хангалт бол 93 хувьтай, нийт улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн хангалт 97 хувьтай байна гэдэг чинь 2, 3 хувь гэдэг бол нэлээн том дутагдлууд. Тийм учраас багш мэргэжлээр элсэн суралцагчдад тэтгэлэг олгодог энэ зарчмыг хэрэгжүүлж эхэлснээр энэ өснө гэж бодож байна. Тэгэхдээ энэ бол 5 жилийн хугацаатай суралцах учраас энийг энэ 4, 5 жилийн хугацаанд энэ дутагдлыг нэг өдөр тийм амархан нөхчихгүй. Ер нь боловсролын шинэчилсэн хуулиар бол багшийн цалин хөлсийг жил бүрийн инфляцын түвшинтэй уялдуулж нэмэгдүүлдэг байх зохицуулалт хийсэнтэй

холбоотойгоор 2026 оны төсөвт нэмэгдэл хийж байгаа ч гэсэн энэ цалингийн юу төсвийн эрсдэлт нөхцөл байдлаас шалтгаалаад энэ төсвийн тодотгол дээр бол нэмэгдүүлж чадахгүй. Энэ 2025 оны төсөв дээр бол энийг анхаарсан байгаа.

Ер нь багш нарын орон сууц, байр орон сууц, нийгмийн асуудлыг шийдэхэд миний дээр хэлсэн тэр орон сууцжуулалтын банк хот, хөдөөд бий болгож, орон сууцын зээлд хөнгөлөлт үзүүлэх, түрээсийн тэтгэлэг олгох, орон нутагт ажиллаж буй багш нарт зориулсан тусгай дэмжлэгийг бий болгох, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулах бодлого хэрэгтэй байгаа гэж үзэж байгаа. Багш нарын одоо бас нэг чухал асуудал бол энэ тэтгэврийн нас уян хатан байх асуудал. Ур чадвар эрүүл мэнддээ тулгуурлан ажиллах боломжтой одоо багш нарын дутагдалтай үед бол заавал тэтгэвэрт нь гаргахгүй бас ажиллуулах энэ боломжийг нь олгох, хүссэн нь эрт тэтгэвэртээ гарч өөр чиглэлээр ажилладаг боломжийг бий болгох энэ уян хатан тэтгэврийн насны зохицуулалтыг боловсролын салбарт судалж хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Д.Амарбаясгалан: Мөнхтуяа гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнхтуяа: Занданшатар даргад баярлалаа. Боловсролын салбарын гүйцэтгэлийн үнэлгээ гээд нэг холион бантан юм бий болоод одоо ингээд 2 жил тойрч байна. Боловсролын салбарын багш, ажилчид энэ гүйцэтгэлийн үнэлгээн дээр бол үнэхээр муу F гэсэн үнэлгээ тавьж байгаа. Энэ бол ерөөсөө болчихсон юм байхгүй. Гүйцэтгэлийн үнэлгээг 40-60 хүүхдэд нэг багшид өгчхөөд ямар гүйцэтгэл гаргах юм. Ямар ч орчин нөхцөл нь бүрдээгүй тохиромжгүй ийм юм оруулж ирээд тэгээд өнөөдөр багш нар нь ч ядраад, хүүхдүүд ч зүдрээд дээрээс нь үнэлгээний төв гэж нэг холион бантан, Боловсролын яамны одоо Наранбаяр сайдын үед солигдсон үнэлгээний төвийн даргаа сольсон, судалгааны хүрээлэнгийн захирлаа сольсон. Ингээд энэ гүйцэтгэлийн үнэлгээ гэдэг чинь бол хээлтчихсэн байгаа шүү Занданшатар дарга аа. Энийг та бас анхаараарай гэдгийг хэлмээр байна. За баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

Б.Батбаатар: 70 гаруй гишүүд асуулт асууж, нэр дэвшигч Ерөнхий сайдад нэр дэвшигчээс асуулт асууж байгаа учраас товчхон зүйлийг хэлээд ганц хоёрхон асуулт асууя аа гэж бодож байна. Иргэний Зориг Ногоон Нам бол шударга ёс гажуудсан, ардчиллын үйл хэрэг хазайсан тэр цаг мөчид өөрөөрөө төрөн гарсан ийм улс төрийн хүчин. Шударга ёс Иргэний Зориг Ногоон Намыг төрөн гаргах тэр түүхийн цаг мөчид бий болсон ийм нам. Иргэний Зориг Ногоон намын үзэл баримтлал, нийгмийн даацтай хөгжил, эдийн засгийн хүртээмжтэй байдал байгаль экологийн тэнцвэртэй, үндэсний ухамсар соёлоо дээдэлсэн хөгжил дэвшлийн төлөөх ийм ирээдүйн төлөө ажилладаг, тууштай ажиллаж байгаа ийм улс төрийн хүчин.

Тийм учраас салбаруудын болон энэ олон Их Хурлын гишүүдийн асуугаад байгаа олон детальтай асуудлуудыг асуухаасаа илүү Засгийн газар бол төрийн эрх дээд байгууллагад ажлаа тайлагнадаг, эндээсээ томилогддог. Тэгэхээр төрийн эрх барих энэ байгууллагад Иргэний Зориг Ногоон Намын ажиллаж байгаа зарчим бол ард түмний эрх ашиг нэгд нь байх ёстой гэж ингэж л үздэг. Зөв эдийн засаг, зөв тогтолцоо, зөв эрх зүй, шударга ёс байх ёстой гэдэг бол хамгийн сүүлд нь нэг л зүйлээр хэмжигдэж байгаа.

3.5 сая монголчууд аз жаргалтай, ядууралгүй амьдрах ёстой. Ядуурлын түвшин статистик тоогоороо хэд байгааг бүгдээрээ мэдэж байгаа. Засгийн газар бол энэ 3.5 сая монголчуудын энэ газар нутаг дээр эзэд нь байгаа энэ хүмүүсийг ядууралгүй байлгах л тухай асуудал юм. Яван явсаар тэр цэг дээр л бүгдээрээ очих ёстой. Ард түмэн ядууралгүй байвал эдийн засаг зөв байна гэсэн үг. Ард түмэн ядууралгүй байвал боловсрол, эрүүл мэнд бүх зүйл зөв байна аа гэсэн үг. Ядуурлын энэ түвшнийг яг одоо Ерөнхий сайдын ажлыг авч амжаагүй байгаа. Гэхдээ томилогдсоныхоо дараа 100 хоногийн тайлан дээрээ байдаг юм уу, үгүй бол боломжтой бол ядуурлын түвшнийг хэдэн хувиар бууруулах вэ. Найм 900 мянган статистик тоогоор байгаа энэ ядуурлын тоог хэр хэмжээнд аваачих вэ. Үүн дээр тодорхой нэг тоо хэлж өгвөл их сайн байна.

Хоёрт нь Монгол Улс өнө эртнээс өвөг дээдсээс бидэнд уламжлагдан ирсэн Төв Азийн цээжин дэх энэ газар нутаг, энэ байгаль ус, газар дэлхий хэр зэрэг ирээдүйд өвлөгдөж үлдээх вэ. Үндсэн чиглэлдээ энэ ажлыг оруулах вэ гэдэг ийм хоёр асуултыг асууж байна.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье.

Г.Занданшатар: Батын Батбаатар гишүүний асуултад хариулъя аа. Ядуурлын түвшнийг бол Дэлхийн банктэй хамтарсан судалгаагаар тодорхойлдог оо. Энэ судалгаа хамгийн сүүлд 2022 онд хийгдсэн. Тухайн үед 27 нийт иргэдийн 27.1 хувь буюу нийт 913 мянган иргэн ядуурлын шугамаас доогуур орлоготой амьдарч байна аа гэж гаргасан. Тэгэхээр ядуурлын түвшин тэр 27 оноос хойших хугацаанд өссөн байх магадлалтай гэж тооцно. Яагаад гэхээр дэлхийн банкны тооцооллоор хэрэв орлого өсөхгүй үнийн түвшин инфляц өсөх юм болбол ядуурлын түвшин 20 хувиар нэмэгдэхэд 41 хувь болж өсөх буюу ойролцоогоор 468 мянган иргэн ядуурлын түвшнээс доогуур, ядууралд эрсдэлд, ядуурлын ядууралд өртөх эрсдэлтэй гэж тооцсон байдаг.

2025 оны 6 дугаар сард болсон судалгаа тооцооллын урьдчилсан нэг хяналтын үнэлгээний үеэр ядуурлыг бууруулах арга хэмжээ бол зөвхөн халамжаар шийдвэрлэгдэхгүй юм байна аа. Инфляц одоо ковид, дайн байлдааны нөхцөл байдлаас шалтгаалаад өсөж байсан бол одоо энэ тарифын дайнаас болоод шалтгаалаад 2 оронтой тоо руу шилжих эрсдэлтэй болсон. Валютын ханш өсөх эрсдэлүүд байгаа. Тэгэхээр нийгэмд эдийн засагт хүлээлтийн шок өгөхгүйн тулд энэ талаар бол бас дэлгэрэнгүй ярихаасаа илүү гарц шийдлийг нь илүү ярих шаардлагатай гэж бодож байна. Ядуурлыг бууруулах зорилт арга хэмжээ бол хөдөлмөр эрхлэлтийг дэмжлэгтэй л уялдах ёстой. Ажил хийж байгаа хүн болгоноо л дэмждэг одоо ТҮЦ-нээс нь авхуулаад худалдаа арилжаа хийж байгаа бүх хүнээ л дэмждэг байж байж ядууралтай тэмцэнэ ээ.

Бичил бизнес жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох, мэргэжлийн сургалт, давтан сургалт, боловсролын тогтолцоондоо илүү прагматик ажил хэрэгч, аж ахуй эрхлэх антрепренёр сургалтуудыг хэрэгжүүлэх ийм бодитой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байж ядууралтай тэмцэнэ. Саяын ярьж байгаа боловсролын реформ ч гэсэн ядуурлыг бууруулахад чиглэгдэх ёстой. Ийм учраас ядуурлын түвшин манайхтай ижил төстэй орнуудад нэг 20 орчим хувьтай байгаа. Тэгэхээр 20 хувьд хүргэх зорилт бол Засгийн газрын дунд хугацааны зорилт болж тодорхойлогдсон байгаа.

Д.Амарбаясгалан: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуулт асууя.

Х.Тэмүүжин: Нэр дэвшигчтэй холбоотой асуултууд байсан. Гэхдээ хурлын процесстой холбоотой 2 үг хэлмээр санагдаж байна. Өнөөдөр Үндсэн хууль дээр төрийн эрх барих дээд байгууллага бол Улсын Их Хурал аа. Ерөнхий сайдыг томилох, чөлөөлөх энэ бүрэн эрхийг хэнтэй ч хуваалцахгүйгээр эдэлдэг байгууллага нь энэ. Энэ нэг намын хурал шиг явж ерөөсөө болохгүй. Ерөнхий сайдад нэр дэвшигчтэй ярьж байгаа мөртөө Улсын Их Хурлыг удирдаж байгаа дарга нь ч тэр, гишүүд ч тэр, Зандан даргаа л гээд байх юм. Занданшатар дарга аа л гээд байх юм. Нам дотроо дарга байж болно. Энэ танхимд Ерөнхий сайдад нэр дэвшигч. Ерөнхий сайдад нэр дэвшигчээс асууж байна. Хоёрт нь, хоёр ч Улсын Их Хурлын гишүүний амнаас гарлаа.

Ерөнхийлөгч ийм мундаг нэр дэвшигчийг тодруулж саналаа оруулж ирлээ гэж. Үндсэн хуулиар энэ ийм юм байхгүй шүү дээ. Үндсэн хуулиар маш тодорхой заасан байгаа. Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх эрх бол олонх суудал авсан нам. Ерөнхийлөгч бол зөвхөн Улсын Их Хуралд оруулж ирж байгаа. Гэтэл энэ Ерөнхий сайдыг нэр дэвшигчийг Ерөнхийлөгч оруулж ирж байгаа юм шиг яриад эхэлж байна. Би энэ үл ойлгогдох байдлыг хоржоонтой бөгөөд хорон үгээр давхар санаа илэрхийлж байгааг чинь андуу ойлгосон байж магадгүй. Нам дотор болсон үйл явцаа хараад дараагийн Ерөнхий сайдыг сонгуулийн үр дүнгээр биш Ерөнхийлөгч оруулж ирж байна аа гэдэг бухимдлаа Улсын Их Хурлын чуулган дээр дайж хэлсэн байж магадгүй. Хэн нэгний хүн Ерөнхий сайд болох ёсгүй шүү. Монгол Улсын Ерөнхий сайд хэн нэгний гар хөлийн үзүүрт зарагддаг, ордны хуйвалдаанаар орж ирдэг байж болохгүй шүү. Тэрийг хэлж байгаа юм.

Занданшатар гэдэг хүн урдаа хийх ажлаасаа илүүтэйгээр ардаа үлдээсэн мөр ихтэй. Ямар бодлого баримталдаг вэ, ямар хандлага илэрхийлдэг вэ, хувь хүнийхээ хувьд ямар зарчимтай улс төрч вэ гэх мэтчилэн. Би бол 5 зүйл ярья гэж бодсон юм.

Нэгдүгээрт нь хөрөнгө оруулагч нарт, бизнесийн орчинд таагүй бодлогуудыг цөөн бус удаа хэрэгжүүлсэн та бол. Улсын Их Хурлын дарга байхдаа Засгийн газрын өмнүүр орж татвар нэмнэ, төрийн ашиг төр ашиг олдог байх ёстой, төсвийн байгууллагууд бизнес хийх ёстой гэх мэтчилэн мэдэгдэл хийж байсан. Одоо Ерөнхий сайд боллоо. Ийм бизнес эрхлэгчдэдээ халгаатай бодлогыг чинь бол одоо бизнес эрхлэгч даахгүй шүү. Тийм учраас энэ бодлогын алдаагаа битгий дахиж давтаарай гэж хэлж байгаа юм.

Хоёрт нь, таны хандлага цэрэг армид дуртай, зэвсэглэж хүртэл бизнес эрхлэгчдийн уурхай руу дайрч очиж байсан. Бүгд найрамдах төрийн Ерөнхий сайд гэдэг бол дарга аа нэг минут нэмээд асуултаа.

Д.Амарбаясгалан: Нэг минут нэмж өгье.

Х.Тэмүүжин: Бүгд найрамдах төрийн Ерөнхий сайд гэдэг бол иргэний тэр дундаа бүр иргэний дотроо иргэний байгууллын төлөө зүтгэдэг тийм хүнийг хэлдэг юм аа. Та Их Хурлын дарга байхдаа ёсолж байсан, тэрийг би шүүмжилж байсан. Нийтийн танхимын буюу төлөөллийн танхимын спикер цэргийн ааш аяг гаргаж ерөөсөө болохгүй. Зэвсэглэж бизнес рүүгээ дайрч болохгүй. Тийм учраас бүгд

найрамдах төрийг баталгаажуулахын тулд энэ шашны ноёнд цэргийн дэглэмээс холуур явдаг Ерөнхий сайд байгаасай гэж хүсэж байна аа.

Гуравт нь, Улсын Их Хурлын дарга байхдаа та Орос, Монголын парламентын хамтарсан комисс хуралдуулж байсан. Парламент ийм системд орж ерөөсөө болохгүй. Одоо Засгийн газрын тэргүүн боллоо. Монгол Улсын Засгийн газар тусгаар тогтносон улсын Засгийн газар байх ёстой шүү. Хажуу хавирганыхаа улсад наалдаж ерөөсөө болохгүй шүү. Төвийг сахисан...

Д.Амарбаясгалан: Тэмүүжин гишүүн үг хэллээ. Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууя. Занданшатар дарга нэр дэвшигч Занданшатар хариулт өгнө өө.

Г.Занданшатар: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүний асуултад хариулъя аа. Ер нь мөргүй хүн гэж байдаггүй л дээ. Ер нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахын төлөө явж байсныг яг хөрөнгө оруулагчид нь бол мэдээд дэмжээд байдаг юм. Дундуур нь улс төрчид болохоор тэгж Монгол Улсын хуулийг зөрчөөд, хууль шүүхийг авлигадаад, Монгол төрийн дээр сандайлаад сууж байсан БНХАУ-ын 2 иргэн цагдаагийн байгууллага хүртэл хуваагдаад хахуульдаад авчихсан байсныг бид нар таслан зогсоох арга хэмжээ авсныг зэвсэг техник хангинуулсан юм шиг ярих нь утгагүй ээ. Би харин цэргийн бэлтгэл хийж, буудлагын клуб ажиллуулж, цэрэг дайнд бэлтгэсэн аль нэг хөрш улс руугаа ч юм уу, шүүмжилсэн тийм бодлого явуулахыг дипломат хүний хувьд ч тэр эсэргүүцдэг. Харин ч би Гадаад харилцааны сайдаар ажиллаж байхдаа гадаад бодлогын үзэл баримтлалд гуравдагч хөршийн бодлогыг бодитойгоор цаасан дээр тусгаж, гадаад бодлогын үзэл баримтлалыг Улсын Их Хурлаас санаачилж батлуулсан. Тэнд гуравдагч хөршийн бодлогыг тодорхойлж, ардчилал, хүний эрх, зах зээлийн зарчимд нийцсэн үнэт зүйлийн хөршүүдийг бид гуравдагч хөршөө гэж тодорхойлсон.

Монгол Улсын газар зүйн нөхцөл байдал бол бид гадаад бодлогын үзэл баримтлал тодорхойлсноор манай гадаад бодлогын тэргүүлэх чиглэл бол 2 хөрштэйгөө тэнцвэртэй харилцах явдал байдаг аа. Энэ бол Монгол Улсын язгуур эрх ашигт тусгаар тогтнол, аюулгүй байдлын үндэстэй холбогдсон үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал Улсын Их Хурлаар батлагдсан ийм чиглэл хандлага байгаа юм. Ийм учраас би одоо буу зурж байснаас биш буу зэвсэг агсаад, буудлагын тэмцээн зохион байгуулж бэлтгэл хийж явсангүй ээ. Ийм учраас үг үйлдэл хоёр болбол зөрүүгүй байх ёстой тайлбар болбол өөр байх ёстой гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг асуулт асууя.

Х.Ганхуяг: Өмнөх Засгийн газрыг бол бүрэн дүүрэн дэмжиж ажилласан. Бид нар бас яах вэ эдийн засгаа тэлэх чиглэлээр нэлээн олон ажлууд хийсэн байгаа. Татварын багц хууль болон нийгмийн даатгалын багц хууль бол одоо Улсын Их Хуралд өргөн барих гэж байгаа гэж ойлгосон. Нэр дэвшигч Занданшатар даргатай бол өмнөх 4 жилийн хугацаанд бол бас сайхан хамтарч ажилласан. Бид нар бас энэ шинэ парламентыг бий болгох Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлтийг батлуулж чадсан ийм онцлогтой юм.

Тэгээд яах вэ өнөөдөр Занданшатар даргаас нэг цөөхөн хэдэн асуулт байгаа юм. 2019 оны Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхий сайдад одоо Засгийн

газрын бүтцийг бий болгох өөрөө одоо санаачилгаараа бий болгох, сайд нарыг томилох, чөлөөлөх асуудлыг бол бүрэн эрхэд нь өгсөн байгаа. Энэ өөрчлөлт бол яагаад ийм өөрчлөлт орсон бэ гэхээр нийгмийн шударга байдлыг тогтоохын тулд Ерөнхий сайдын бүрэн эрх олгосон. Нийгмийн шударга байдлыг тогтооно гэдэг маань одоо хариуцлага тооцох боломжийг нь олгож байна аа гэсэн үг. Хариуцлага олох боломжийг нь олгож байна аа гээд.

Тэгэхдээ өнөөдрийг хүртэл бол яг хариуцлага тооцсон асуудал бол маш цөөхөн байгаа. Бид нарын хажуугаар одоо хүний үнэтэй амь эрсэдсэн тохиолдлууд зөндөө гарлаа. Өвөл болохоор одоо утаандаа угаартдаг. Цэргүүд нь алба үүргээ гүйцэтгэж байгаад нас бардаг, хотын төвд дэлбэрдэг. Одоо сүүлдээ дипломат албад хүртэл хүн амины асуудал үүсээд л ингээд явж байна. Иймэрхүү байдал цаашдаа үргэлжилбэл энэ тал дээр Засгийн газрыг илүү ил тод болгох, хариуцлагатай болгохын тулд ямар арга хэмжээ авах вэ гэдэг асуулт нэгдүгээр асуулт.

Мөн хоёр дахь асуулт бол энэ Засгийн газрын тусгай сангууд болон төрийн өмчит компаниуд дээр бол ихэнх хулгайнууд гарсан байдаг. Цаашдаа энэ дээр бас ямар яаж ажиллах вэ, хэрхэн яаж ажиллах вэ, ямар хариуцлага тооцох вэ гэдэг хоёрдугаар асуулт. Яг хариуцлагын асуудал болохоор яг гол хариуцлага хүлээх хүмүүс нь хариуцлага хүлээдэггүй. Тэгээд нэг ахлагч, дэслэгч, хошууч гээд л иймэрхүү хэмжээнд л одоо хариуцлага тооцоод явчихдаг асуудал бас одоо нийгэмд бол бас бухимдлыг бий болгоод байгаа шалтгаануудын нэг юм.

Хоёрдугаар асуудал бол Улаанбаатар хотод бол яалт ч үгүй одоо ядуурал ялангуяа одоо энэ хот суурин газарт оршин сууж байгаа иргэдийн энэ ажлын байр, түгжрэл, утаа гээд. Энэ одоо манай нийгмийн гол асуултууд болчихоод байгаа юм. Энэ дээр ямар арга хэмжээ авах вэ, ямар ажлууд хийгдэх талаар асуучихмаар байна. Гурав дахь асуудал бол энэ өмнөх Засгийн газар боловсруулагдсан байгаад өргөн барихад бэлэн болсон байгаа энэ татварын багц хууль, нийгмийн даатгалын багц хуулийг цаашид та үргэлжлүүлж дэмжиж ажиллах уу, үгүй юу гурав дахь асуулт. 4 дэх асуудал энэ Баялгийн сангийн тухай хуультай холбоотой асуудал юм байгаа юмаа. Яах вэ бид нар баялгийн сангийн хуулийг батлахдаа бол хуримтлалын сан руу бол одоо ноогдол ашиг ордог байх хэлбэрээр. Ирээдүй өв сан руу болохоор АМНАТ-аас тодорхой хувь нь ордог байхаар...

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч хариулт өгье.

Г.Занданшатар: Хассуурийн Ганхуяг гишүүний асуултад хариулъя аа. Энэ маш чухал асуудлуудыг хөндөж байна. Засгийн газрын тусгай сангийн ер нь энэ сан зөвлөлүүдийн тоо, түүний менежмент, шийдвэр гаргалтын тогтолцоо, хариуцлагын тогтолцоог бол шинэчилж өөрчлөхгүйгээр тэнд байгаа хулгайг таслан зогсоох. Энийг одоо хэчнээн хууль хяналтын байгууллагад шалгуулж байгаа ч гэсэн одоо маш энэ олон сангууд энэ бүхэн дээр хяналт менежментийг сайжруулахад зохих шинэчлэлийг хийх шаардлагатай юм байна лээ. Хараат бус болгох шаардлагатай юм байна лээ. Ийм учраас энэ чиглэлээр тусдаа одоо хууль эрх зүйн орчин ч бас бүрдүүлэх шаардлагатай. Тэгээд энэ чиглэлд Ганхуяг гишүүн бас ажиллаж байсны хувьд Зөвшөөрлийн хууль дээр бас хамтарч ажиллаж байсны хувьд үнэтэй агаар нэг ийм асуудал гэж ойлгож нээлттэй ил тод болгох чиглэлээр бас анхаарч ажиллах нь шаардлагатай зүйтэй байх гэж бодож байна.

Ер нь 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхий сайд кабинетаа өөрөө бүрдүүлэх хэрэгтэй болсон нь бодлогын залгамж чанар, тогтвортой байдал, манлайллыг сайжруулахад ч гэсэн хариуцлагыг одоо бас хуваарилах асуудалтай. Энэ үндэсний аудит, парламентын хяналтын тогтолцоо, олон нийтийн мэдээлэл, хэвтээ хариуцлагын тогтолцоо гээд олон ийм цогц өөрчлөлтүүдийг хамтад нь хийсэн. Тийм учраас энэ бол ёс зүйн хариуцлагын манлайллын механизмыг ч гэсэн сайжруулах чиглэлээр Улсын Их Хурлын парламентын хяналт шалгалтын хороо, хяналт шалгалтын сонсгол зохион байгуулах энэ бүх боломжууд бол нээлттэй ил тод байдлыг бий болгосон.

Ер нь энэ төрийн өмчийн компанид гарсан хулгай зэлгий, төрийн өмчийн компаниудын менежментийг сайжруулахад ТУЗ-ийн хараат бус ил тод томилгоо, худалдан авалтыг цахимжуулах, хиймэл оюунжуулах, ашиг үр дүнг олон нийтэд нээлттэй мэдээлдэг тогтолцоог бий болгох ашиг сонирхлын зөрчлийн хяналт шалгалтыг чангатгах зэрэг ингээд энэ гарсан аудитын дүгнэлт, хяналт шалгалтын дүгнэлтүүдийн дагуу эрүүгийн хариуцлага холбогдох хууль сахиулах байгууллагуудад хянаж шалгадаг энэ тогтолцоог бий болгох нь бол энэ хариуцлагын тогтолцоог сайжруулах хамгийн чухал арга хэмжээнүүд болно. Ер нь ил тод байдал гэдэг бол хамгийн чухал хяналтын механизм. Уул уурхайн орлогын тодорхой хувийг заавал төвлөрүүлж үүнтэй уялдуулж одоо баялгийн сангийн менежментийг ч гэсэн энэ ил тод нээлттэй байдалтай уялдуулах шаардлагатай.

Улаанбаатар хотын хувьд бол нийслэлийн удирдлагуудтай хамтарч энэ дижитал цахим шинэчлэлтэй холбогдуулсан цоо шинэ төсөл хөтөлбөрийг Улаанбаатар хотын нэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулсан ийм чиглэл гаргахаар бас санал солилцож ажиллаж байгаа. Энийг одоо орон нутгийн удирдлага хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуультай хэлэлцээд тусад нь Улсын Их Хуралд танилцуулж шийдвэрлэх болно. Энэ чиглэлээр манай Ганхуяг гишүүн, Аубакир гишүүн нар бол бас их санаачилгатай ажиллаж байгаа гэж ойлгож байгаа.

Нийслэл хотын хөгжлийн түр хороог Улсын Их Хурлаас байгуулж байсан өнгөрсөн парламент. Энэ бүхэн маань одоо үргэлжилж нийслэлийн түгжрэл утаа зэрэг томоохон асуудлыг шийдэх. Одоо энэ хавар, намар болоод өвөл болоод л энэ утааны асуудал эхэлнэ. Тэгэхээр нийслэлийн асуудлаа нэг нь цогцоор нь харж шийдвэрлэх ийм зайлшгүй шаардлага байгаа. Энэ чиглэлээр манай нийслэлээс сонгогдсон Хассуурийн Ганхуяг нарын гишүүд бас тэр мэргэжлийн нийслэлийн хөгжлийн түр хороон дээр ажиллаж байсны хувьд бас бодлого саналаа гаргаж, орон нутгийн нийслэлийн удирдлагатай хамтран энэ төслийн талаар чиглэлийг тодорхой гаргана аа. Энэ дээр ер нь Улаанбаатар хотын төлөвлөгөө гээд гадаад Жайка Койкагийн зөвлөхүүдтэй хамтарсан нэг тийм тодорхой төсөл хийгдсэн байгаа. Энийг өнөөдөр танилцуулахад нэлээн нуршуу урт болох байх. Жич танилцуулъя.

Д.Амарбаясгалан: Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулж асууя.

Х.Ганхуяг: Нөгөө Татварын багц хууль, нийгмийн даатгалын багц хуультай холбоотой асуудал дээр та нэг байр суурь илэрхийлчхээрэй. Баялгийн сангийн хуультай холбоотойгоор би нэг хоёрхон асуулт үлдчихээд байгаа юм. Энэ юу вэ гэхээр нэгдүгээрт Оюу Толгой, бид нар бол үндсэндээ АМНАТ-ийн 5 хувиас өөр татвар авдаггүй. 2040 он гэхэд ихэнх нөөцөө ер нь гаргаад дуусахаар байгаа. 2050 он хүртэл бид нар ямар нэгэн байдлаар ноогдол ашиг авахааргүй байгаа. Энэ дээр таны байр суурийг сонсчихмоор байна.

Хоёрдугаарт энэ стратегийн ордууд гээд их яригдаад байгаа энийг бид нар энэ хувь эзэмших байдлаар бид нар шийдэх гээд байна уу, эсвэл өсөн нэмэгдэх АМНАТ-аар энэ асуудлыг шийдэх гээд байна уу? Энэ дээр бас таны байр суурийг сонсчихёё.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье.

Г.Занданшатар: Татварын реформын талаар миний бодлого бол тодорхой. Та бас өнгөрсөн парламент дээр би нийт ард иргэдэд 7 буудлын Долгор эмээгээс авхуулаад нийт ард иргэдийн нуруун дээр үүрэгддэг хамгийн том татвар бол нэмэгдсэн өртгийн албан татвар. Энэ нэмэгдсэн өртгийн албан татварын ачааллыг бууруулах нөгөө талдаа татварын дундаж давхаргаа дэмжсэн бодлогыг явуулахад чиглэгдэнэ ээ гэдгийг бол би энэ чиглэлээр энд татварын реформын багц хуулийг шинэчлэн боловсруулаад дахин өргөн барих болно.

Үндэсний баялгийн сангийн хуулийн дагуу АМНАТ, хувь эзэмших ноогдол ашгийн хувилбарыг тухайн төслөөсөө хамаарч хоёуланг нь ашиглахаар Үндэсний баялгийн сангийн хуульд тусгасан. Энэ Рио Тинтотой холбоотой татварын маргааны асуудал ч гэсэн үүнээс уялдаатай. Одоо Эрдэнэттэй харьцуулахад Рио Тинтогийн төлж байгаа АМНАТ бол одоо хэд дахин бага байна шүү дээ. Ийм учраас энийг АМНАТ-аа уялдуулах зайлшгүй шаардлагатай. Хувь эзэмшээд түүнээс олох ноогдол ашгийн талаар...

Д.Амарбаясгалан: Амгаланбаатарын Ганбаатар гишүүн асуулт асууна. Алга байна. Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт алга байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн алга байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна. Алга байна. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууя.

Х.Булгантуяа: Асуулт давхардсан байна.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Оройн мэнд хүргэе. Таныг бол Хөдөө аж ахуйн дэд сайд байхаас авхуулаад мэднэ, сайн мэднэ. Таны мэдлэг чадвар Ерөнхий сайдад хүрэхгүй юм бол байхгүй. Гэхдээ танаас асуух асуулт байна. Яагаад гэвэл эргэлзээ төрүүлээд байна. Таныг Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүхийн Тамгын газрын даргаар ажиллаж байсан учраас энэ хүн Ерөнхий сайдад зүтгүүлсэн. Ерөнхийлөгч Оюун-Эрдэнэд итгэл өгөх эсэх талаар Монгол Улсын парламент хуульд нийцсэн үйл ажиллагаагаа хийгээд асуудлыг хэлэлцэж байх үед орж ирж ёс бусаар авирласан. Тийм учраас танаас хардаж энэ асуултуудыг тавимаар байна аа.

Монгол төрийн залгамж чанар гэж байх ёстой. Өмнөх Засгийн газар чинь одоо манай би говийн бүсээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн. Цогтцэций суманд байдаг Ухаа худгийн ордыг эзэмшдэг Энержи Ресурс гэдэг компани энэ ордыг хууль бусаар авсан гэдэг асуудлыг гаргаад Засгийн газар дээр тагнуул, цагдаа, Хууль зүйн яамтайгаа хамтраад ажлын хэсэг байгуулсан. Тэгээд Улсын Их Хуралд өргөн барьсан. Одоо бол Улсын Их Хурлын мэдлийн асуудал болсныг та мэдэж байгаа байх тийм ээ.

Тэгэхээр та энэ 2 номыг уншсан уу? Энэ 2 номыг уншаад энэ одоо Хууль зүйн сайд Алтангэрэл эмхэтгэж тараасан. Энийг уншсан уу, уншаагүй юу. Уншсан бол та энийг уншаад юу бодсон бэ? Энэ дээр энэ Энержи Ресурс гэдэг компани Монгол Улс агаарын бохирдлыг бууруулах гээд 10 гаруй жил зовж байгаа. Энэ агаарын бохирдлоос болж нас барсан хүмүүсийн тоо жилээс жилд ихсэж байгаа. Эндээс ганцхан компани ашиг олсон байдаг юм 48.4 тэрбум төгрөгийн ашиг олсон байдаг юм. Энержи Ресурс компани улсад маш их татвар төлдөг мундаг компани гэдэг. Яг энэ төрлийн бизнес эрхэлдэг компаниудын улсад одоо төлдөг татвараас 2.5 дахин доогуур татвар төлдөг. Зөвхөн 2000-2024 онд 31 удаа шалгалт хийлгэсэн.

Татварын ерөнхий газрын том татвар төлөгчдийн газраас ингээд АМНАТ-ийг бусдаас арай бага төлөх ёстой гээд 690 тэрбумыг Энержи Ресурс компанид буцаан олгох шийдвэрийг Сангийн яаманд хүргүүлж байсан. Энэ шударга уу. Та өмнөх Засгийн газрын энэ асуудлыг үргэлжлүүлэх үү? За нэг ийм асуулт байна.

Нөгөөдөх нь та Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүхээс хэр ангид ажиллаж чадах вэ? Таны өмнө хийж байсан Монголын төрд хийж байсан гавьяануудыг мэднэ ээ. Гэхдээ яг одоо Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын ерөнхий сайд хоёр нэг дохио зангаагаар, нэг аяар тоглож эхлэх юм бол энэ энэ улсад сайн зүйлийг авчрахгүй. Тэгэхээр та хэр одоо ангид байж чадах вэ?

Д.Амарбаясгалан: За хариулт өгье. Нэр дэвшигч Занданшатар дарга.

Г.Занданшатар: Монгол Улсын Үндсэн хуулиар хууль тогтоох гүйцэтгэх засаглалын эрх, үүргийн цар хүрээ, зааг ялгаа тодорхой заагдсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль энэ хууль дээдлэх зарчмыг баримталж ажиллахад ер нь аливаа би үе үеийн Ерөнхийлөгч нарыг бас мэднэ ээ. Хамтарч ажиллаж байсан бүх үед. Тэр үедээ би дандаа л хууль дээдлэх ёс зарчмыг баримталж ажиллаж байсан. Тийм учраас хуультай зарчимтай зүйл дээр одоо тэрний хүн, энэний хүн гэдэг хардлага аль эсвэл намын хандлага Засгийн газар дээр байж таарахгүй. Ухаа худгийн асуудлаар зарчмын байр суурь улсын баялаг хувийн эрх ашигт зарцуулагдаад, зориулагдаад гэрээ хэлцэл ил тод биш явагдсан бол хууль зөрчсөн бол хатуу хариуцлага тооцох ёстой. Ашиг сонирхлын зөрчил хууль зөрчсөн аливаа гэрээг хүчингүй болгох төрийн эрх ашгийг нэгдүгээрт тавих ёстой.

Тийм учраас энийг бол тодорхой ажлын хэсэг байгуулаад, шалгаад нотлоод, одоо хууль тогтоомжийн дагуу шалгасан бол тэр дагуу л энийг үргэлжлүүлж ажиллана. Хууль зүйн онолын хувьд, ерөнхий онолын хувьд бол Ерөнхийлөгч хуулийн хувьд ч тэр, онолын хувьд ч гэсэн тэр Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Үндсэн хуулийн 1.1, 26.1, 39.1-д зааснаар тус тусын чиг үүрэгтэй, эрх хэмжээний хүрээтэй, энэ эрх хэмжээгээр л хязгаарлагдаж ажиллах учиртай. Ерөнхийлөгч гүйцэтгэх эрх мэдэлд шууд оролцдоггүй харин төрийн бодлого эв нэгдлийг хангах чиглэлээр ажилладаг үндэсний эв нэгдлийг илэрхийлэгч зөвшилцлийн талбар үүсгэдэг. Ерөнхий сайд бол гүйцэтгэх хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцдаг албан тушаалтан. Тэрний хүн энэний хүн гэдэг хаана ажиллаж байснаар нь хаягладаг, заагладаг, хуваадаг, хагаралдуулдаг хандлага бол төрийн албанд зохимжгүй ээ. Мэргэжлийн мерит зарчмаар ажиллах ёстой төрийг улс төрийн сонирхол хувийн ашиг сонирхлын сүлжээ эвддэг. Ийм учраас энэ зарчмыг баримталж ажиллана аа.

Энэ номыг бол надад ирээгүй учраас би уншиж үзээгүй байна, амжаагүй байна. Тэгээд уншиж үзээд танд тодорхой хариу өгье өө.

Д.Амарбаясгалан: Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: Одоо та Монгол Улсын Ерөнхий сайдаар томилогдох нь тодорхой болж байх шиг байна. Дотоод, гадаадын хүчин зүйлээс шалтгаалаад инфляц их өндөр байна. Дээрээс нь манай төсвийн орлого тасарсан. Манай экспортолдог гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн үнэ унасан гээд маш олон зүйл байна аа. Танд маш багагүй хүнд үе байгаа. Тэгээд ийм үед Монгол Улсын Ерөнхий сайд болно гэдэг бол их зоригтой ухаалаг хүний шийдвэр их бол эсвэл их тэнэг хүний шийдвэр гэж би бодоод байгаа байхгүй юу. Тэгэхээр та өөрөө энэ саналыг гаргасан юм уу? Би Монгол Улсын Ерөнхий сайд больё гэж. Эсвэл Монгол Улсын Ерөнхийлөгч таныг болоо гэсэн үү, эсвэл өмнөх Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ чинь та болчихоо гэсэн юм уу? Би эндээс нэг юм бодоод байна л даа. Монголын түүхэнд гашуун түүх байдаг. Үгэнд ор, үгэнд орохгүй бол шоронд ор гэсэн үг байдаг. Тэгэхээр тоглоомын...

Д.Амарбаясгалан: Хариулт өгөх үү хариулт өгье Занданшатар дарга. Нэр дэвшигч хариулт өгнө 6 дугаар микрофон.

Г.Занданшатар: Өнөөгийн улс төрийн эдийн засгийн гадаад, дотоод орчин нөхцөл маш хүнд байгаа. Энэ үед нэг бол их тэнэг хүн, нэг бол их зоригтой хүн энэ ажлыг хийнэ гэж байгаа агуулга нь одоогийн цаг үеийг хамгийн сайн мэдэрч байгаа хүний үг мөн. Гэхдээ энэ цаг үеийг хүнд цаг үе гээд хойш суух эрх бидэнд байхгүй гэж үзэж найз нөхдийн, намын журмын нөхөд, Удирдах зөвлөлийн, Ерөнхий сайдын, Ерөнхийлөгчийн санал манай хамт олны санал дээр үндэслээд гарч ирэхэд нь би татгалзах эрх надад байгаагүй ээ. Энэ бол хамтын шийдвэр, зөвшилцсөн шийдвэр үеийнхний шийдвэр байсан учраас би зугтах эрхгүй гэж бодож, журмын нөхдийнхөө саналыг хүндэтгэн хүлээн авч, энэ хүнд ч гэсэн энэ цаг үед надаас өөр хэн...

Д.Амарбаясгалан: Батжаргалын Заяабал гишүүн асуулт асууя.

Б.Заяабал: Та бүхэндээ оройн мэндийг хүргэе ээ. Юуны өмнө Занданшатар даргадаа таныг дэмжиж байгаа гэдгийгээ бас илэрхийлье ээ. Таны очих ажил амаргүй. Мэдээж та улс төрийнхөө нөхцөл байдал, эдийн засгийнхаа нөхцөл байдал, нийгмийнхээ, ард иргэдийнхээ шаардлага хүлээлтийг мэдэрч байгаа байх. Нийгмийн үндсэн томоохон проблемуудаа ч та бас мэдэж байгаа. Дотор нь бид нар амьдраад явж байна. Энэ утаа, түгжрэлийн асуудлаас өгсүүлээд л олон юмыг ярьж болно. Тэгээд таныг Ерөнхий сайдаар томилогдоод удахгүй томилогдох байх. Ингээд энэ танхимын голд зогсоод хэлэх анхныхаа, бодлогынхоо үгнүүдийг чинь бас тэсэн ядан хүлээж байна. Нэлээдгүй бас шийдэлтэй үгнүүд хэлэх байх аа гэсэн ийм хүлээлттэй байгаа гэдгийгээ бас илэрхийлье ээ.

Өнөөдрийн макро эдийн засгийн байдал ямархуу байгаа вэ гэдэг дээр та болбол нэлээдгүй гишүүд бас өмнө нэлээдгүй ярьсан учраас би энийг бас алгасая. Үнэндээ бол товчхон хэлэхэд ард түмний гар дээр байгаа орлогын хэмжээ огт нэмэгдээгүй мөртөө валютын ханшны бууралттай холбоотой, төгрөгийн сулралтай холбоотой, инфляцтай холбоотой, тог цахилгааны үнэ нэмэгдсэнтэй холбоотой, иргэдийн чинь бодит орлого гар дээр ирдэг бодит орлого буурчихсан байгаа,

буурчихсан байгаа. Тэгэхлээр энэ дээрээсээ та бас онцгой анхаарч ажиллах ёстой гэж ингэж бодож байгаа. Тэгээд эндээс би нэг хэд хэдэн асуултуудыг асууя аа.

Нэгдүгээрт нь, энэ Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлыг харах юм бол богино хугацаанд ч тэр, дунд хугацаанд ч тэр энэ гадаад валютын нөөц ханш дээр бол дарамт хэвээр үргэлжлэхээр харагдаад байна аа. Мэдээж дэлхийн зах зээлийн нөлөөтэй холбоотойгоор энэ уул уурхайн бүтээгдэхүүн ялангуяа нүүрсний үнэ буурсантай холбоотой Монгол Улсад орж ирж байгаа орлогын хэмжээ буурч байгаа. Монгол банк талдаа энэ бодлогынхоо хүүгээ чангатгасан, дээрээс нь валютын нөөцөө нэмэгдүүлэхтэй холбоотой нэлээдгүй арга хэмжээ авч байгаа. Өнөөдрийн энэ валютын ханшийг бол Монгол банк үндсэндээ интервенц хийж явж авчирч байна аа. Гэтэл Засгийн газар тал дээрээ эндээс ямар бодлого явж байна вэ. Та энэ дээр ямар бодлого баримталж явах вэ гэдэг дээр нэгдүгээрт товчхон хариулт өгөхийг танаас бас хүсэж байна аа.

Хоёрдугаарт нь сүүлийн 30 жилийн хугацаанд миний харж байгаагаар энэ төрийн санхүүгийн удирдлага дээр 2 томоохон шинэчлэл хийгдсэн. 2000 оны эхээр энэ төсвийн удирдлага санхүүжилтийн тухай хууль гээд норм нормативд суурилсан зардлын төлөвлөгөө хийдэг ийм одоо төсвийн шинэчлэл хийгдсэн. Хоёр дахь нь одоо бидний энэ яриад байгаа хөтөлбөр үр дүнд суурилсан энэ төсвийн шинэчлэлийн үйл ажиллагаа хэрэгжээд ингээд бараг 10 хэдэн жил дахиад болчихлоо. Ингээд төсөв хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу 5 жилд нэг удаа бас энэ хуулиудыг эргэж хянадаг, хардаг ийм тогтолцоо Хууль тогтоомжийн тухай хуулиар байгаа. Тэгэхлээр энэ та цаашдаа энэ төрийн, төсвийн, төрийн удирдлагын энэ миний менежментийн одоо энэ ямар бодлого цаашаа үргэлжлэх ёстой вэ гэж та бодож байна вэ? Энэнтэйгээ холбоотой бас та бас нэлээдгүй юм уншдаг ийм хүн учраас та бас энэ дээр бас саналаа хэлээч ээ гэдэг ийм асуултыг бас тавья аа. Гурав дахь нь энэ Монгол Улс нэгдсэн төсвийн бодлого алдагдаад байна аа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Нэр дэвшигч Занданшатар дарга.

Г.Занданшатар: Батжаргалын Заяабал гишүүний асуултад хариулъя аа. Заяабал гишүүн бол манай Татварын ерөнхий газрын дарга байсан. Төсөв санхүүгийн бас өргөн мэдлэгтэй хүн. Нөхцөл байдлыг маш сайн мэдэж байгаа. Ямар байгааг. Тэгэхдээ би бас энийг илүү хөөргөж, нийгэмд хүлээлтийн шок үүсгэмээргүй байна. Өнөөдөр эдийн засаг олон улсын нөхцөл байдлаас шалтгаалсан тэтгэврийн, төсвийн орлогын дутагдал цаашдаа гарч болох эрсдэлүүдийн талаар бол бид нарийн хэлэлцэж төсвийн тодотгол хийх шаардлагатай болсон гэдгийг би цөөн үгээр чухам үнэнийг хэлсэн гэж бодож байна. Төсвийн тодотголыг өргөн барихдаа бол хэмнэлтийн тодотгол хийнэ. Төсвийн удирдлага санхүүжилтийн гарц бол үр ашиггүй зардлуудыг танах, хөрөнгө оруулалтыг эдийн засгийн өгөөж, одоо хэрэгжиж байгаа байдлаар нь үнэлж эрэмбэлэх ийм шаардлагатай.

Ер нь тантай бол одоо 100 хувь санал нэг байгаа юм бол Монгол Улсын нэгдсэн төсвийн бодлого алдагдсан. Үүнийг засах шаардлагатай. Орон нутгийн төсвийн хэмжээнд ч тэр, тэр битгий хэл татварын бодлогын хэмжээнд ч тэр, мөн энэ сангуудын зарцуулалтын түвшинд ч гэсэн тэр, төсвийн нэгдсэн бодлого алдагдсан, нэг хувийн гээд олон юмнууд бол бас энэ төсвийн сахилга бат, хариуцлагыг алдагдуулж байгаа гэж өнөөдөр бүсээ чангалсан дээрээ шинэчлэх шаардлагатай. Хамгийн гол Засгийн газраас анхаарах асуудал нь Монгол банкнаас үл хамаарах асуудал нь манай эдийн засаг уул уурхайгаас хэт хамааралтай, экспорт 94 хувь уул

уурхайгаас хамааралтай. Тэгээд уул уурхайн бүтээгдэхүүнийхээ циклийг дагаад үнэ өсөхөөр зардлаа дагаад өсгөчихдөг, урсгал зардлаа өсгөчихдөг, буурахаар одоо ингээд төсвийн хүндрэлд ордог. Ийм циклийн шокт эмзэг. Энэ эдийн засаг маань эдийн засгаа төрөлжүүлэх гэсэн бидний яриа одоо нөгөө үнэ ханш өндөр байх үед тансаглал хэрэглэж байгаад одоо үндсэндээ эргээд хөрсөн дээрээ бууж байгаа ийм хүнд цаг үе.

Ийм учраас Төсвийн тухай хууль үйлчлээд 12 жил болсон ч одоо төсвийн байгууллагын удирдах санхүүжилтийн тухай хуулийн бодит үзэл санаа бол одоо өнөөдөр алдагдаад байна. Ийм учраас энэ бодлогыг ч гэсэн бид анхаарч чиглэлд өөрчлөлт оруулах ёстой. Одоо бол эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг хувийн хэвшилтэйгээ хэлэлцэж хамтарч даван туулах ийм сонголт бидний өмнө бодитой тулгарсан. Хувийн хэвшилдээ өсөж дэвших бололцоог нь олгох, татварын реформ хийх, төсвийн хэмнэлтийн тодотгол хийж бүсээ чангалах, ард иргэдийн нуруун дээр учирч байгаа энэ дарамтыг багасгахад чиглэнэ.

Өөрөөр хэлбэл төсвийн үр ашиггүй зардал их бага хэмжээгээр импортыг хөөрөгдөөд зарим хөрөнгө оруулалтууд ч гэсэн хөөрөгдсөн импортын дарамт нь иргэд дээр инфляц ханш болж буугаад байгаа учраас төсвийн зардлыг танах нь зөвхөн үр ашигтай болгож байгаа хэрэг биш. Иргэд дээр учрах инфляцыг ч гэсэн төсвийн бодлогоор хязгаарлах, төсвийн алдагдлыг илүү санхүүжилтийг бууруулах ийм мөнгөний бодлогын уялдаа холбоог зохицуулах ийм л шаардлагын үүднээс гарч байгаа юм. Түүнээс биш энэ чинь нэг их алдагдалтай төсөв, алдагдалгүй төсөвтэй гол нь биш, төсвийн алдагдал өөрөө зээл тэр нь инфляц болдог учраас мөнгөний бодлоготой уялдуулах шаардлагатай ингэж төлөвлөх шаардлагатай гэж үзсэн.

Д.Амарбаясгалан: Батжаргалын Заяабал гишүүн тодруулж асууя.

Б.Заяабал: Тэгэхлээр би сая асуусан нэг асуултаа бас тодотгоод асуучихъя гэж бодож байна. Энэ валютын ханш гадаад валютын нөөцтэй холбоотой, бүрдүүлэхтэй холбоотой асуудал дээр Засгийн газрын зүгээс, тэргүүний зүгээс та одоо ямар бодлого барьж ажиллах вэ гэсэн ийм асуулт асуусан. Энэ дээр бас тодорхой хариулт өгөхийг хүсэж байна.

Хоёрдугаарт нь энэ нэгдсэн төсвийн бодлого алдагдсаны нэг илрэл нь бол өнөөдөр Монгол Улсын гадаад валютын нөөц 5 тэрбум доллар давчихсан гэж байгаа мөртөө энэ ханш чинь тогтворгүй байдалтай байсан хэвээр байгаа чинь ерөөсөө л нэгдсэн төсвийн бодлого алдагдсаны илрэл ээ. Өнөөдөр орон нутгийн орон нутаг бонд гаргадаг болсон, зарцуулалтаа өөрөө мэддэг болсон, төсвөөс гадуур зохицуулдаг болсон. Энэ чинь эргээд бодитоороо валютын ханш дээр чинь ачаалал болоод байна аа гэдгийг танд хэлье.

Тэгээд та бас өнөөдөр төсвийн тодотголыг хийнэ ээ гэж хэлж байна. Өнөөдөр яг энэ 7 хоногт 7 хоногийн дотор багтаж төсвөө өргөн барина аа, тодотголоо хийнэ ээ гэсэн байна лээ. Энэ 7 хоногтоо амжиж одоо бүрэлдэхүүн чинь батлагдах уу, сайд нар чинь томилогдох уу? Томилогдоогүй байгаа сайд нарын төсвийг хасчихаар асуудал үүсэхгүй юу.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Занданшатар дарга.

Г.Занданшатар: Ер нь төсвийн нэгдсэн төсвийн бодлого алдагдаж буйг засахад бол татварын бааз суурийг өргөтгөх энэ тодорхой хэмжээгээр хөнгөлөлт чөлөөлөлтийг багасгаж үргүй зардлыг бууруулах ийм цогц реформ, төсвийн реформ, төсвийн сахилга батыг сайжруулах шаардлага бол цаашдаа хамгийн чухал зорилтууд болно. Тэгэхдээ энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Засгийн газрыг бид яаралтай Төсвийн бүтэц бүрэлдэхүүний тухай хуулийг тийм учраас яаралтай энэ 7 хоногтоо багтааж, энэ 7 хоногтоо Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилж байж ирэх 7 хоногт төсвийн тодотгол хийх нөхцөл бүрдэнэ ээ. Урьдчилсан тоонууд дээр ажиллаж байна аа.

Ирэх 7 хоногт өргөн барьж хэлэлцэхгүй бол бид наадмаас өмнө төсвөө тодотгож чадахгүйд хүрнэ ээ. Наадмаас өмнө төсвөө тодотгож чадахгүй болбол энэ түүхий эдийн үнээ...

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Тэгэхгүй бол одоогийн төсвөөс төсвийн тэнцэл, төсвийн орлогын тасалдлаас шалтгаалсан санхүүжилт, төсвийн удирдлага санхүүжилтийн хуулийн хэрэгжилт буюу төсвийн удирдлага санхүүжих зарчим бол үндсэндээ алдагдахад хүрнэ. Тийм учраас бид наадмаас өмнө төсвөө тодотгохоос өөр арга замгүй болсон. Бодит нөхцөл байдал ингэж шаардаж байгааг Улсын Их Хурлын гишүүд ойлгож одоо төрийн ажил нэг ч өдөр тасралтгүй шуурхай хэрэгжих ийм бодит нөхцөл, гадаад нөхцөл байдал тарифын дайнаас үүдээд бий болчхоод байгаа гэдгийг бол эдийн засагч хүний хувьд, төсвийн орлого бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байсан хүний хувьд та сайн мэдэж байгаа байх. Тантай очоод уулзаж байхад одоо АМНАТ-ын танайд авлага хэд байгаа билээ тийм ээ. Одоо тэр авлагууд ямар болж байгаа билээ. Ингээд нарийвчлаад тоо ярих юм болбол дандаа шокийн тоо ярих учраас үүгээр цэглээ гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуулт асууя.

Г.Уянгахишиг: Оройн мэнд хүргэе ээ. Тэгэхээр гишүүд маань ерөнхийдөө нэлээн олон салбар салбарын асуултуудыг асуулаа. Үүнтэй давхцуулахгүйгээр яг нэг 2 тодорхой асуудлыг асуумаар байна. Та бол банк санхүүгийн салбарыг сайн мэдэх хүний хувьд бол хөрөнгийн зах зээлийн эдийн засагт үзүүлэх нөлөөлөл одоо хөгжүүлэхийн чухлыг бол сайн мэдэж байгаа.

Өнөөдрийн эдийн засгийн нөхцөл байдал, мөнгөний бодлого, хөрөнгө оруулалтын бодлогын талаар ер нь хэр одоо ямар бодолтой байгаа вэ гэдэг тал дээр тодорхой асуултуудыг асуух гээд байгаа. Та хэлсэн. Тансаг хэрэглээний татварыг нэмнэ ээ гэж байгаа. Өөрөөр хэлэх юм болбол тансаг хэрэглээнд зарцуулагдаж байгаа тэр хөрөнгө, тэр мөнгийг дотооддоо буюу хөрөнгийн зах зээл рүү ухаалаг хөрөнгө оруулалт руу удирдаж чадах юм болбол энэ өөрөө гадагшаа валют урсахгүй байх, дотоодын үйлдвэрлэлээ дэмжих, хөрөнгө оруулалтуудаа тэлэх энэ боломжийг бий болгох нэг арга хэрэгсэл болж байгаа. Үүн дээр хамгийн гол нь бид нар төрөөс юугаар дэмжиж чадах юм бэ гэхээр татварын бодлого.

Санхүүгийн зохицуулах хороо болон Арилжаа эрхлэгчдийн холбооноос болон одоо яг энэ хөрөнгийн зах зээлд оролцогчдын зүгээс татварын багц хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд саналуудаа хүргүүлсэн байна аа, ирүүлсэн байна аа. Гэтэл Сангийн яамнаас тэр саналуудаас төсөлдөө тусгасан зүйл алга аа. Тэгэхээр миний

асуулт юу вэ гэхээр энэ хөрөнгийн зах зээлийг дэмжих тал дээр Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооныхоо бодлогыг дэмжиж ажиллахгүй байна уу даа гэсэн ийм бодол төрж байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр таны баримтлах бодлого ямар байх вэ нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуултын хувьд Монгол банкны хуримтлагдсан алдагдал 7.5 их наяд болжээ. Нөгөө талаасаа хуульд заасан пассив активын харилцаа харьцаа өнөөдөр хүнд нөхцөл байдалд ороод байна аа. Тэгвэл энэ талаар Монгол банкны Хяналтын зөвлөлөөс өгсөн дүгнэлтэд Засгийн газарт олгосон зээл нь Төв банканд санхүүгийн эрсдэл учруулж буй тул цаашид энэ төрлийн зээлийн нөхцөл гэрээ болон эргэн төлөлт дээр анхаарах улмаар төсвийн шинжтэй үйл ажиллагааг санхүүжүүлэхээс эрс татгалзах шаардлагатай гэдэг ийм дүгнэлтийг өгсөн байгаа. Тэгэхээр энэ тал дээр буюу Монгол банкныг алдагдалд оруулах хэмжээнд төсөв рүүгээ хольж хутгах энэ асуудал дээр бас таны бодлого ямар байх вэ гэсэн ийм үндсэн 2 асуулт асуумаар байгаа юм.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье.

Г.Занданшатар: Гончигдоржийн Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Хөрөнгийн зах зээл бол санхүүгийн зах зээлийн, банк санхүүгийн зах зээлийн хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг төдийгүй энэ зээлийн хүү бууруулах дундаж чинээлэг давхаргыг хөгжүүлэхэд хамгийн үр ашигтай тогтолцоо гэж үздэг. Тийм ч учраас бид бас хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх талаар өнгөрсөн 4, 5 жилд бол тодорхой бодлогыг хэрэгжүүлж Монгол Улсын хөрөнгийн зах зээл бол дэлхийд хамгийн өндөр өсөлттэй хөрөнгийн бирж болж хөгжиж байсан нь саяхан. Үүний тулд бид юуны өмнө энэ арилжааны банкнуудыг IPO гаргаж хувьцаалах, нэг хөрөнгө оруулагчтай банкнууд бизнест хэт хутгалдах, бизнесийн шударга өрсөлдөөнийг боомилох олон хүчин зүйлийг нөхцөлдүүлж байсан учраас банкнууд бол хувьцаат компани болж, паблик компани болж хувьцаагаа гаргаснаар бас хөрөнгийн зах зээл идэвхэжсэн.

Ер нь хөрөнгийн зах зээл бол одоо хамгийн сэргэлттэй байгаа ийм зах зээл болсон. Цаашдаа энэ компаниуд зөвхөн зээлээр биш акц хувьцаа гаргаж IPO болж энэ хөрөнгө босгодог энэ чиг хандлага руу сул чөлөөтэй хөрөнгийг татаж эргэлтэд оруулдаг энэ чиг хандлага бол хөрөнгийн зах зээл, санхүүгийн зах зээл хөгжихөд мөн зээлийн хүү буурахад хамгийн чухал хүчин зүйл нь болж байгаа юмаа. Монгол банкны алдагдал Монгол банкны асуудал бол Засгийн газрын эрх мэдлийн асуудал биш ээ. Энэ бол тусдаа. Улсын Их Хурлын харьяа байгууллага. Улсын Их Хурлаас Монгол банкны алдагдал бодлогыг тодорхойлдог, хараат бус байдлыг нь хангадаг мөнгөний иймээс энэ Монгол банкны актив пассивтай холбоотой асуудал бол Засгийн газрын биш Улсын Их Хурлын харьяанд байдаг учраас бид одоо тодорхойлж хэлж, ярилцах бололцоогүй. Таны бүрэн эрхийн асуудал аа гэж үзэж байна.

Д.Амарбаясгалан: Уянгахишиг гишүүн тодруулж асууя.

Г.Уянгахишиг: Ер нь бол Санхүүгийн зохицуулах хороо болон Монгол банк Их Хуралд харьяатай байгаагүй харьяаллын байгууллага гэдгийг бол ойлгож байгаа. Гол нь саяын миний хэлсэн Монгол банкны хяналтын зөвлөлөөс гаргасан тэр дүгнэлт дээрх дүгнэлт буюу Засгийн газар, Монгол банкны хоорондын харилцааны талаар би асуулт асуугаад байгаа байхгүй юу. Өөрөөр хэлэх юм болбол

яг Монгол банк хэвийн үйл ажиллагаа явуулаад, мөнгөний бодлогоо тодорхойлоод, төгрөгийн тогтвортой ханшийн тогтвортой байдлыг хангаад ингээд явахад Засгийн газрын зээлийн асуудлууд орж ирээд байна. Засгийн газраас жишээлэх юм болбол хуримтлалын сангийн хөрөнгийг Ирээдүйн өв сангийн хөрөнгийг Засгийн газарт байршуулаад тэнчээнээсээ буцаагаад ипотекийн хямд эх үүсвэрийн зээлийг гаргаад байдаг. Гэтэл тэр хоёрын зөрүүгий чинь буцаагаад Монгол банк төлөх асуудал үүсэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ болбол цэвэр одоо юу гэдэг юм Засгийн газарт хамааралгүй асуудал гэж үзэж болохооргүй байгаа юм.

Нөгөө талаасаа яг энэ хөрөнгийн зах зээлийн хувьд болбол би яг саналаа хэлмээр байгаа юм л даа. Энд микрофон ашиглаад бас хэлчихье гэж бодож байна. Анхдагч арилжаа сайн байгаа...

Д.Амарбаясгалан: Нэг минут нэмж өгье.

Г.Уянгахишиг: Энэ дээр хамгийн гол нь хоёрдогч арилжаа яагаад сайн явж чадахгүй байна вэ гэвэл биржийн бус зах зээлээ бид нар дэмжмээр байна аа. Тэнд хамгийн их бонд, хамгийн их хөрөнгө оруулалтын асуудал явагдаж байгаа. Гэтэл тэрэн дээр нөгөө 10 хувийн татвар, ноогдол ашиг дээр нь ч 10 хувь, хүүгийн орлого дээр ч 10 хувь, арилжаа хийсний буюу капиталгийн такс бас 10 хувьтай байгаа. Энэ нь яг татварт нөлөөлөх нөлөөллөөрөө айхтар өндөр хувь биш мөртөө энэ нь өөрөө хоёрдогч арилжаанд буюу хөрөнгийн зах зээлд оролцох хөрөнгө оруулагчдын идэвхийг сулруулаад байгаа юмаа. Энэ тал дээр болбол яг оруулах тодорхой саналуудаа Сангийн яаманд өгсөн боловчиг татварын багц хуульд тусгагдахгүй байна аа. Тэгэхээр энэ нь өөрөө төсөв одоо хэлэлцэгдэж эхлэхээс өмнө энэ асуудал яригдахгүй бол 2026 онд энэ дахиад л хэвээрээ үлдэх гээд байгаа байхгүй юу. Тийм учраас энэ тал дээр бас анх анхаарч өгөөсэй гэдэг ийм саналтай байгаад байна.

Д.Амарбаясгалан: Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

М.Бадамсүрэн: Нэгдүгээрт энэ макро түвшинтэй холбоотой инфляцыг бууруулах бодлогын арга хэмжээг Монгол банкны одоо хүү, бодлогын хүү нэмэгдүүлэхээс гадна Засгийн газрын түвшинд ямар арга хэмжээ авах вэ? За мэдээж Засгийн газрын урсгал зардлыг бууруулахаас гадна нэгд, хоёрдугаарт нь энэ ирэх оны төсөвт хөрөнгө оруулалтыг тусгахдаа Ерөнхий сайдын хувьд яг нэг бүрчлэн энэ дээр онцгой анхаарч, нийгэм эдийн засгийн ач холбогдлоор нь одоо эрэмбэлэхэд та бас анхаарч өгөөч ээ. Тэгээд тухайлбал, одоо импортыг орлох, экспортыг дэмжих, эрчим хүчний зэрэг хөрөнгө оруулалт дээр түлхүү анхаарах, боловсрол, эрүүл мэнд, өрх айлын одоо орлого олохыг нэмэгдсэн ийм одоо төслүүдэд анхаарах хэрэгтэй. Тэгэхгүй бол яг ямар зүйл яваад байна гэхээр ингээд нэг 14 мега төсөл гэххээд тэгээд яг тэр иргэний одоо өрхийн орлогод нь яаж нөлөөлөх гээд байгаа юм бэ гэдэг бол тийм бас тодорхой биш байгаад байна аа.

Хоёрдугаарт нь бол төсвөөс болон энэ хүнээс хамаарахгүйгээр энэ дэмжлэгүүдийг яаж уялдуулж зохион байгуулах вэ гэдэг дээр асуулт байна. Тухайлбал одоо нөхөн сэргээгдэхгүй энэ уул уурхайгаас энэ нөхөн сэргээгддэг одоо хүнс, хөдөө аж ахуйн салбар луу байнгын дэмжлэг үзүүлэх энэ системийг яаж одоо угсарч өгөх вэ? Мөн одоо хүн бүрийн хийж чадах өрөх, бичил бизнес одоо энэ жижиг бизнесийг яаж энэ одоо Үндэсний баялгийн сангаас гэдэг юм уу, яаж одоо байнгын ингэж одоо төсвөөс бол үүнээс хамаарахгүйгээр ийм одоо хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр нэмэгддэг, энэ нь одоо байнга арвиждаг ийм зүйл рүү одоо шилжүүлэх вэ.

Ирээдүйгээсээ зээлж ашиглаж байгаа баялгийн өгөөжийг одоогийн хүүхдүүдийн хөгжил, эрүүл мэнд боловсролд ер нь яаж зарцуулах вэ?

Мөн одоо Үндэсний баялгийн сантай энийг яаж одоо уялдуулах вэ. Баялагтаа эзэн байх талаар. Газрын хэвлийн баялгийг одоо ашиглаж байгаа аж ахуйн нэгжүүдийг бол төрийн нийтийн өмч одоо ашиглаж байгаа гэдэг Үндсэн хуулийн агуулгаар нь худалдан авах ажиллагаа, туслан гүйцэтгэх ажиллагааг нь болбол бүгдийг нь нээлттэй ил тод болгох шаардлагатай байна аа. Энэ дээр худалдан авахын хуульд болон эсвэл бусад хуулиар энэ бүх одоо уул уурхайн компаниудыг худалдан авах ажиллагааг нь ил тод болгох ингэж байж авлига, ашиг сонирхлоос ангид байна. Ингэж байж орон нутгийн жижиг, дунд одоо бизнес эрхлэгчид, орон нутгийн иргэдэд болбол дэмжлэг болно. Энэ дээр ямар бодлого баримтлах вэ?

Стратегийн ордоос гадна стратегийн бусад одоо гэж хэлж болох чухал ашигт малтмал гэж хэлж болох энэ зүйлүүд дээр ямар бодлого гаргаж, энэ салбартаа яаж одоо хайгуулыг нэмэгдүүлж, яаж хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх талаар бодлогын арга хэмжээ авч ажиллах вэ? Мөн одоо газрын тосны үйлдвэрийн түүхий эдийн нөөцийг тогтоох асуудал бол ихээхэн чухал байгаа. Энэ тал дээр энэ ажил ерөөсөө одоо ахиц дэвшил урагшлахгүй байна. Энэ дээр одоо та томилогдвол ямар арга хэмжээ авах вэ?

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хувьд бүсүүдэд ялгаатай онцлог ямар эрх зүйн бодлогыг хэрэгжүүлэх вэ? Жишээлбэл говийн бүс өөр, баруун бүс өөр. Сая тэр чоно агнах, агнахгүйтэй холбоотой асуудал дээр бас ийм бүсийн ялгаатай байдал гарсан. Мэргэжлийн боловсрол, техник мэргэжлийн сургуулийг хэрхэн яаж дэмжиж, ирээдүйд энэ төслүүдэд хэрэгтэй боловсон хүчнийг бэлдэх вэ?

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Занданшатар дарга.

Г.Занданшатар: Монгол Улсын Их Хурлаар батлагдсан Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хуульд тов тодорхой заачихсан. Өөрөөр хэлбэл энэ чинь нийт зөвхөн стратегийн орд 4 орд ч биш. Нийт уул уурхайгаас оролцож байгаа АМНАТ-ын орлогын тодорхой хувь. Мөн одоо энэ ноогдол ашгууд төрийн өмчит компаниудын ноогдол ашгууд төвлөрдөг. Монгол банк бол яах вэ энэ алдагдлын 70 хувь нь бодлогын хүүний зөрүү, хүүгийн алдагдал байдаг л даа. Тэгэхдээ энэ бүхэн чинь уялдаад энэ хөрөнгийн зах зээл, санхүүгийн зах зээл, зээлийн хүүгийн бодлого, хөнгөлөлттэй зээлийн бодлогууд бол аль болох энэ төсвөөс санхүүжих, түрүүчийн асуулттай зөрөлдөх юм нь бол төсвөөс энэ хүүгийн зөрүүгийн нь санхүүжүүлж байж л энэ өндөр хүүтэй, бодлогын хүү өндөр байгаа үед хүүгийн зөрүүг хангаж байгаа шүү дээ тиймээ.

Тийм учраас Үндсэн хуульд бид тусгахдаа энэ Норвегийн сангийн жишгээр одоо Ирээдүйн өв сан буюу одоо ба ирээдүй иргэн болгонд энэ уул уурхайн баялаг үр өгөөжтэй байхыг заасан. Өөрөөр хэлбэл газар доор байгаа баялаг бол үржихгүй, гаргаж ирээд энийг үржүүлдэг баялаг болж бодит капитал болгоод, хөрөнгө оруулалт болгоод ингээд өсөж байхаар Норвегийн сан бол одоо 10 жилд л 2 дахин нугарч үр ашигтай хөрөнгө оруулалт хийж Апплийн хувьцааг ч юм уу авч, газар доороо хэвтэж байсан бол биет хэмжээгээрээ өсөхгүй бол газар дээр гаргаж ирээд, эргэлтэд оруулж ирээдүй өвдээ үржүүлээд өгч байгаа нь л энэ ирээдүй өв сан баялгийн сангийн гол агуулга юм байгаа юм.

Манайх бол 3 хуваагаад одоо хуримтлалын сан хэлбэртэй ирээдүйн өв сан 1.2 орчим тэрбум доллар болж байгаа байх Швейцарын хүүгээр Монгол банканд байршуулж, үржүүлж байгаа. Энэнээс илүү үржүүлэх бололцоог бас хайх ёстой юм. Энэ бол ирээдүйн өв сан нь. Хуримтлалын сан талдаа одоо энэ томоохон төсөл хөтөлбөрүүдээ хэрэгжүүлэх, мега төслүүдээ хэрэгжүүлэх эх үүсвэр болж хөрөнгө оруулалтын сан хэлбэрээр ашиглагдана. Мөн орон сууц, боловсрол, эрүүл мэндийг дэмжих нөгөө хуучин Хүний хөгжлийн сангийн сангийн загвар. Ийм 3 чиглэлээр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, стратегийн орд газрууд болон нийт уул уурхайн АМНАТ байгалийн баялгийн энэ үр өгөөжийг үр дүнтэй хуваарилах энэ зарчмуудыг тусгасан.

Ер нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар бол 50 хувиас дээш төр эзэмшиж байгаа бол бүх төрийн өмчийн компанийн худалдан авах ажиллагаа зарчим нээлттэй байна. Ийм учраас энэтэй уялдуулж бид энэ эдийн засгийн хүндрэл бэрхшээлтэй үед байгалийн баялгийн ашиглалт менежментээ сайжруулах ёстой. Үүнтэй уялдаатайгаар одоо хамгийн санаа зовоож байгаа асуудал бол нефтийн үйлдвэр баригдах гээд байдаг нефтийн хайгуул эрэл хайгуул олборлолт маань тэр хэмжээндээ хүрэхгүй байгаад байдаг. Ийм учраас нефтийн эрэл хайгуул энэ бодлогоо бас үргэлжлүүлэх шаардлагатай байгаа. Ингэвэл бас нэлээн том дэвшил гарна. Энэ дээр нэн ялангуяа одоо манай Бадамсүрэн дарга бол Дорнод аймгаас сонгогдсон. Энэ нефть энэ уул уурхайн чиглэлээр бие даасан төсвөө бүрдүүлдэг цөөхөн аймгуудын нэг. Аймаг орон нутгийн хувьд аймгийн дарга гэдэг бол ер нь хамгийн их эрх мэдэлтэй орон нутгийн амьдрал аж ахуйг мэддэг хүн байдаг, амьдралдаа ойрхон байдаг.

Ийм учраас энэ уул уурхайтай аймгийн АМНАТ энэ төсвийн бодлогод нөлөөлдөг нөлөөллийг хамгийн сайн мэдэж байгаагийн хувьд энэ төрийн санхүүжилтийн зарчим төсвийн бодлогын санхүүжилтийн талаар бас төсвийн тодотгол дээр бас идэвхтэй орж ажиллахыг бас урьж хүсэж байна аа. Энэ чиглэлээр одоо нарийвчилсан мэдээлэл солилцож ажиллая. Энэ томилогдсон тохиолдолд. Энийг төрийн юу Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай хуулийг хэлэлцэх үеэрээ нарийвчлан хэлэлцье ээ ярилцъя гэж бодож байна аа.

Д.Амарбаясгалан: Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Баярлалаа. Тэгэхээр та Ерөнхий сайдаар томилогдвол энэ Үндэсний баялгийн сангийн мөнгийг ингээд эргэлтэд оруулах хэрэгтэй байна аа л гэж би бол саналтай байгаа. Яагаад гэхээр Ирээдүй өв сан бол ирээдүй үеэсээ зээлж ашиглаж байгаа энэ одоо баялгийг хуримтлуулж байгаа. Гэхдээ энэ мөнгийг бид нар ирээдүйд хүүхдэдээ хадгалахаас гадна одоогийн хүүхдийнхээ ирээдүйн хөгжилд нь, боловсролд нь зориулж эндээс гаргавал илүү өгөөж нь илүү хүрнэ ээ. Өөрөөр хэлбэл байгалийн баялгийн өгөөжийг хүний баялаг болгох энэ концепцыг таныг бас нэвтрүүлж өгөөч ээ.

Хоёрдугаарт нь хөгжлийн санд тодорхой мөнгө хуримтлагдаж байгаа. Эндээс дэд бүтцийн том төсөлд одоо ашиглах гэдэг концепц дээр бол газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлэх ТӨК байгуулахгүй бол гадаадын компанид найдаад газрын тосны түүхий тосыг бид нар бол бүрдүүлж чадахгүй. Тийм учраас энэ рүү хөрөнгө оруулж өгөөч. Мөн хөгжлийн санг сангаас нь өөрөөр хэлбэл нөгөө төрөлжсөн 3 сангийн Ирээдүйн өв сан, Хуримтлалын сангийн нөгөө сан нь хөгжлийн

сангаас нь жижиг бизнесийг дэмжих зээлийн тогтвортой одоо жил болгон зарцуулдаг эх үүсвэрийг нэмэгдүүлж өгөхөд анхаарч...

Д.Амарбаясгалан: За хариулт өгөх үү. Занданшатар дарга нэр дэвшигч хариулт өгье.

Г.Занданшатар: Энэ асуудал Ерөнхий сайд бол энд батлагдсан хуулийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Үндэсний баялгийн сангийн хуульд зааснаар Ирээдүй өв сан бол хөдөлгөөнгүй ээ. Ер нь баялгийн сан бол 3 сангаас бүрдэнэ. Ирээдүй өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн 3 сангаас. Ирээдүй өв сан бол одоо 2030 он хүртэл билүү ингээд зарцуулах эрхгүй ээ Засгийн газар. Энийг Их Хурал шийднэ ээ. Энэ дээр Их Хурлын гишүүд санаачлаад хэрэгжүүлж, дэмжиж, ирээдүй өв сангаа эргэлтэд оруулах, хүүхдийн мөнгийг ч гэсэн 2.7 их наядыг энэнтэй уялдуулж үр хүүхдэдээ үр өгөөжтэй болгох олон хувилбар ярьдаг. Энэ бол нээлттэй асуудал. Хуримтлалын сан бол газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо эрүүл мэнд, боловсрол, орон сууц гээд 3 чиглэлд зарцуулна аа гээд ингээд тодорхой заачихсан. Хөгжлийн сан бол харин хөрөнгө оруулалтын зориулалтаар томоохон төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлэхдээ Улсын Их Хурлаар баталсан мега төслүүдийг том хөтөлбөр хэрэгжүүлэхэд заана аа гээд ингээд заачихсан ийм 3 сан хуульчлагдсан сан байгаа. Тэгээд энэ хууль эрх зүйн хүрээндээ бид Улсын Их Хурал...

Д.Амарбаясгалан: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Оройн мэндийг хүргэе. Өнөөдрийн Монголын нөхцөл байдал алдаа оноо бол тантай шууд хамааралтай гэж би бас бодож байна. За шинэ зүйл гэхээсээ илүүтэй зарчмын одоо асуудлуудыг бас танаас олон нийт залуучууд бас хүлээж байгаа болов уу. Энэ утгаараа би бас зарчмын нэг хэд хэд хэдэн асуултыг танаас тодруулж асууя аа.

Нийгмийн шударга бус байдалтай тэмцэх ажлууд хэрхэн үргэлжлэх вэ? Олон нийт тэр дундаа залуучуудын хувьд хамгийн их одоо хүсэж байгаа асуудал бол энэ нийгмийн тэгш байдал, эрүүл нийгмийг бий болгохын төлөө удаа дараа бас өөрсдийнхөө санаа бодлыг янз бүрийн хэлбэрээр бол одоо илэрхийлсээр ирсэн. Тэгээд өнөөдрийг хүртэл одоо бас олон нийтийнхээ залуучуудынхаа хүлээлтэд хүрч чадахгүй байгаа энэ асуудлын шалтгаан бас үнэн нь юу байна вэ гэдгийг бас танаас тодруулмаар санагдаж байна аа. Тодорхой шийдэл нь бас энэ авлигын асуудлаарх бие даасан шүүхтэй болох тухай асуудлыг өмнөх Засгийн газар дээр бас Засгийн газрын тэргүүн бас дурдаж байсан. Тэгэхээр яг үүнтэй адилхан ямар тодорхой бас шийдлүүдийг хамтдаа хийж болох вэ? Энэ бол одоо олон нийтийн хамгийн их хүсэмжилж байгаа зүйлүүдийн нэг юмаа.

Үүнтэй уялдаад би бас 2 дахь асуулт нь иргэдээ хэрхэн сонсож хэдүүлээ ажиллах вэ? Зөвшилцөл ойлголцлыг бас хэрхэн хийх вэ гэдэг дээрээ тодорхой бас нэг дүгнэлтүүдийг бас хийх нь бас зөв байх аа гэж бодож байгаа юм аа. Тэгэхгүй нийгмийн хуваагдал руу бас улам бүр бас явах ийм эрсдэлүүд байна аа гэдгийг би бас үгэндээ удаа дараа бас хэлээд байгаа. Тэгээд ингээд зарим нь жагсаж л байдаг бусад нь ингээд үндсэндээ одоо мэдсэн ч мэдээгүй юм шиг ингээд явж л байдаг нэг ийм байдлууд бас цаашдаа бий болохгүй байгаасай. Нөгөө талаасаа ямар нэгэн явцуу эрх ашгаа хамгаалахын тулд тодорхой зорилготой жагсаалыг хийгээд тэгээд одоо тэр асуудал нь бас шийдэгддэг ийм бас одоо явцуу байдал руу бас битгий

орчхоосой. Яаж энэ асуудлыг бас зохицуулдаг, иргэдээ сонсдог ийм төр, засгийг бид нар бий болгож болох вэ?

Монголын барилгачдын холбоо 14, 15 дахь хоног руугаа ороод жагсаж байгаа. Нэг талдаа Нямбаатар даргын тавьж байгаа Тендерийн тухай хуулиараа шалгаруулсан тендерийг ингээд харахаар зөв шаардлага, зөв одоо зарчим байгаад байгаа. Нөгөө талдаа бас барилгачид өөрсдөө бас дотооддоо энэ томоохон бүтээн байгуулалтууддаа оролцох энэ хүсэмжлэл нь бас зөв байгаад байгаа юм. Тэгэхээр иймэрхүү асуудлуудыг бид нар хэрхэн шийддэг байх вэ? Олон нийтээ сонсдог Засгийн газрыг хэрхэн бий болгох вэ гэдэг 2 дахь асуулт байгаа юмаа.

Засгийн газрын шинэ бүтэц бүрэлдэхүүн дээр жендерийн тухай асуудал дээр бас би гарын үсэг зурж дэмжсэн. Энэ тал дээр бас ямаршуу байр суурьтай байх вэ? Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хангах үүднээс бүсүүдийн оролцоог бас одоо хэрхэн хангаж тэгш ийм бүтцийг бас бий болгож оруулж ирэх вэ гэдэг асуултуудыг асууяаа.

Д.Амарбаясгалан: За хариулт өгье. Нэр дэвшигч Занданшатар дарга.

Г.Занданшатар: Ер нь парламентын ч тэр, Засгийн газрын ч гэсэн ардчилсан чиг шугам бол ард иргэдээ сонсдог байхад оршино оо. Ийм ч учраас би ди парламент гэдэг платформыг санаачилсан. Ард иргэдээ сонсож хуулийн төслийг хэлэлцдэг болсон. Би зөвлөлдөх ардчилал гэж ард түмэнтэй хэлэлцэж зөвлөлдөж шийдвэр гаргадаг механизмаар энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж 2 удаагийн ард түмнийхээ санал бодолд тулгуурлаж энэ Үндэсний баялгийн сангаас авхуулаад энэ парламентын аргачлалыг төгөлдөршүүлэх эрх зүйн үндэстнийг төрийн бүх эрх мэдэл ард түмнээс эх сурвалжтай байх зарчимд нийцүүлж хэлэлцүүлсэн.

Ингэж ард түмнээ сонсож байж энэ Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг хийгээд энэ 126 гишүүн энэ өөрчлөлтүүд хийгдсэн болохоос биш зүгээр нэг, хоёр, гурван хүн санаачлаад хийчихдэг зүйл биш. Энэ бүх асуудал ардчиллын зарчимд нийцэж ард иргэдээ сонсох ажлыг өрнүүлсэн. Залуучууд бас энийг судалж, иргэдээ яаж сонсдог юм энэ аргачлалыг бас хэрэгжүүлж ажиллаасай, суралцаасай, судлаасай, сургаар биш судалгаа тооцоотой ажиллаасай гэж гэж одоо бид хүсэж энэ ди парламентыг өвлүүлсэн. Жишээлбэл 2017 онд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Зөвлөлдөх санал асуулга явуулаад нийт бүх иргэдийг төлөөлж чадахуйц малчин, тариачин, эмч, багш бүх хүний төлөөлөл, эрэгтэй, эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд энэ бүх хүмүүсийн төлөөлөлтэй бол одоо түүвэр судалгааны аргаар хэлэлцэгдсэн.

Бүх аймагт улс орон даяар аймаг, сумд энэ хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Ингэж сонсож байж энэ зөвлөлдөх аянг зохион байгуулж байж өнөөдөр энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт парламентын ардчиллыг чинь төлөвшүүлэх, бэхжүүлэх, сайжруулах ажлууд хийгдсэн юм шүү. Энэ Үндэсний баялгийн сангийн хууль ч гэсэн тэр. Энэ баялагтаа эзэн байх, авлигатай тэмцэх зарчим, авлигалын эсрэг энэ хяналт шалгалтын түр хороо байгуулдаг. Нээлттэй сонсгол зохион байгуулдаг энэ ажлууд чинь бүгд бас энд энэ зарчмуудаар хэрэгжсэн. Энэ авлигатай тэмцэх ажил бол үгээрээ биш үйлдлээрээ л тэмцдэг болохыг харуулсан гэж би дээр хэлсэн. Тухайлах юм бол парламентын хяналт шалгалтын түр хороогоор ингээд далд байсан

юмнуудыг ил болгодог ард түмний мэдэх эрхийг хангасан нээлттэй сонсголуудыг зохион байгуулдаг болсон.

Хөгжлийн банкны, эмийн, нүүрсний гэх мэтчилэн олон сонсголууд зохион байгуулагдаж, ард түмний мэдэх эрхийг хангаж, нотлох баримтуудыг шинжлэн судлах хэлэлцүүлгүүд өрнөж энэний дагуу одоо илчлэгдэж ил тод болсон. Түүнээс нэг өдөр авлигал бий болчихсон юм биш. 30 жил ингээд бэхэжчихсэн байсан аалзны тор шиг юмыг ил тод болгодог ард түмний мэдэх эрхийг хангасан хэвтээ хариуцлагын тогтолцоог бий болгосноороо энэ систем шүүх засаглал ч гэсэн шахалт үзүүлдэг ард түмний дэмжлэгтэй энэ хяналтын тогтолцоог бий болгохыг энэ мэдэх хэргээр хангасан.

Ийм учраас энэ бүхнийг бид үг үйлдлээрээ харуулсан. Өнгөрсөн парламентаас 10 гаруй гишүүн хэрэгт татагдаж шалгагддаг байсан нь шалгагдаж, одоо эрүүгийн хариуцлага хүлээсэн. Энэ бүхэн чинь хүний өөрийнгүй авлигалтай тэмцэж ирсний баталгаа үр дүн. Бидэнд энэ сурталчлаад байдаг болохоос биш өнөөдөр бүх нийгэм даяараа энэ албан тушаалын хэрэг, авлигал, энэ болохгүй, бүтэхгүй бүх юмтай чинь тэмцэх ёстой юм байна гэсэн сэдлийг төрүүлж залуучуудын нийгмийн ухамсар сэргэж, энэ жагсаал цуглаан, шаардлага тавьдаг болсон. Энэ бол иргэний боловсрол, ардчиллын боловсролын чухал үр дүн болсон гэдэгт би итгэлтэй байгаа. Энэ бүхний үр дүнд өнөөдрийн парламентын ардчилал чинь улам бэхжиж, тогтворжиж, манайх ардчиллын индексээр урагшилж, жендерийн квот сайжирч, жендерийн төлөөлөл парламентад хангагдаж залуучуудын оролцоо нэмэгдсэн ийм өөрчлөлтүүд Сонгуулийн хуулиар чихэх бололцоог бүрдсэн. Энэ бол зөвхөн энэ 76 гишүүний биш МАН-ын лидерүүдийн, манай одоогийн Улсын Их Хурлын даргын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийн энэ манлайлал дор хэрэгжсэн ийм бодитой өөрчлөлтүүд.

Тийм учраас өнгөрсөн бүхнийг хараар бодсоноор биш...

Д.Амарбаясгалан: Ганхүлэг гишүүн тодруулж асууя.

М.Ганхүлэг: Тийм яах вэ өнгөрснийг үгүйсгээгүй ээ. Өнөөдрийн бас нөхцөл байдал тантай одоо бас шууд хамааралтай гэж бас хэлж байгаа нь арай илүү одоо бас тийм шинэ бас өнцгөөр цаашдын ажил юунууддаа бас анхаараасай гэж энэ саналуудыг асуултыг асуугаад байгаа юмаа. Илүү тодруулаад асуусан. Авлигалын асуудал дээр иргэд одоогоо ч, одоо ч гэсэндээ тийм хангалттай сайн ажилласан гэдэг дүгнэлтийг бол би бол өгөхгүй байгаа гэж үзэж байгаа. Шалтгаан нь юу байгаад байгаа юм. Шийдэл нь энэ авлигын асуудлаарх бие даасан шүүх байж болох уу? Энэ дээр та ямар байр суурьтай байгаа вэ гэж асуусан байгаа.

Хоёр дахь нь энэ барилгачдын жагсаал болоод байна л даа. Тэгэхээр яг иймэрхүү жагсаалттай бид яаж харилцах юм бэ гэж асуугаад байгаа юм. Сонсоод болно бол болно, болохгүй бол болохгүй гэдгийг нь хэлдэг нэг ийм одоо ойлгомжтой ийм зарчим бидэнд байх ёстой юу. Засгийн газрын шинэ бүтэц дээр жендерийн асуудлыг яах вэ, бүсүүдийн оролцоог хэрхэн хангах вэ гэдэг ийм асуулт.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт өгье.

Г.Занданшатар: Энэ авлигатай тэмцэх асуудал бол Засгийн газрын үүрэг байдаг. Өөрөөр хэлбэл төрийн өмнө хуулийн биелэлтийг хангуулах үүрэг бол

Засгийн газар Ерөнхий сайдын үүрэг байдаг. Улсын Их Хурлын даргын хувиар ч гэсэн бидний хийгдсэн ажил бол харин Улсын Их Хурлын парламентын хяналт шалгалтын түр хороог байгуулж энэ юмыг ил тод болгож, хийгдэж хэрэгжүүлж байсан ажлын бодит үр дүнг энэний үр дүнд өнөөдрийн болсон парламентын дүр зургийг надтай шууд холбоотой гэж хэлж байгаа бол одоо би тийм гэж хэлнэ ээ. Харин шүүхийн асуудал байгуулснаараа авлигатай тэмцчихдэг юм биш ээ. Авлигатай тэмцэх асуудал бол хууль сахиулах байгууллагууд эрх зүйн шинэчлэл, цогц хөтөлбөрийн үр дүн байх ёстой. Хоёр, гуравхан хүнтэй шүүх байгуулаад хонгил угсарч байдаг тийм түүхийг бид мэднэ. Угсарчихсан гэж шүүмжилж байсныг мэднэ. Ийм учраас энэ бол зөвхөн шүүхийн асуудал биш...

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Энэ барилгачдын жагсаал цуглаантай холбоотой асуудал бол би өмнө нь хоёр, гурван удаа хариулсан. Дахин давтаж хэлэхэд. Нийслэл хотын удирдлагуудын чиглэлээр 2 шийдэл гаргаад ярьж тохиролцоод ажиллаж байгаа. Барилгачдын холбоо бол туслан гүйцэтгэгчээр орж ажиллах. Барилгачдын ассоциаци нь дараагийн тендерүүдэд оролцож, бүтээн байгуулалтын ажилд оролцох ийм чиглэлтэй ажиллаж байгаа гэдгээ хотын дарга мэдэгдсэн. Ер нь энэ Үндсэн хуулийн 39.2 дагуу Засгийн газраа яаж бүрдүүлэх нь Ерөнхий сайдын бүрэн эрх байхаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тодорхойлсон байгаа. Бүтэц бүрэлдэхүүний тухай хууль хэлэлцэх үеэрээ энэ асуудал яригдах учраас тухайн үед нь би тодорхой хэлэлцэх боломж олдох байх гэж бодож байна. Одоогоор одоо томилогдоогүй байгаа учраас дараагийн Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний талаар ярих нь арай энэ эрт байна аа.

Ер нь энэ бүсчилсэн хөгжлийн чиг хандлагыг бол харгалзан...

Д.Амарбаясгалан: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууя.

М.Нарантуяа-Нара: Оройн мэнд хүргэе. Тэгэхээр Монгол Улсын энэ асар их байгалийн баялаг хэрвээ үнэхээрийн одоо Үндсэн хуульд заасны дагуу тэгш хүртээмжтэй иргэн бүрд тэгш хүртээмжтэй ингэж зөв хуваарилагдсан бол өдийд 3.5 сая тэрбумтан биш юмаа гэхэд Монголын хүн амын 3-ны 1 хувь нь ядуурчихсан ийм улс бол байхгүй байх бүрэн боломжтой юм байна гэж би бодож байна. Тэгээд нэр дэвшигч Занданшатар та энэнтэй санал нийлж байна уу?

Үндсэн хуулийн 6.2-т заасны дагуу байгалийн баялаг бүх ард түмнийх байна аа гээд заачихсан. Тэгээд дээрээс нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх одоо дийлэнхийг ард түмэн эдэлнэ ээ гээд заачихсан байдаг. Тэгвэл жишээлбэл ганцхан жишээн дээр ярья. Ухаа худгийн орд байна. 80 хувийн байгалийн одоо 80 хувийн баялгийн нөөцтэй нь тогтоогдсон энэ ордноос Монголын ард түмэн дийлэнх хувийг нь хүртэж чадсан байдаг юм болов уу?

Одоо ингээд энэ Монголын энэ өчнөөн энэ стратегийн орд газрууд энэ одоо олон олон орд газрууд ерөөсөө тэр чигтээ монопол компаниудын хувь эзэмшилд очоод ингээд нөгөө хэд маань эргээд тэр монголчуудын нийтээрээ хүртэх байсан баялгийг хувь завшингуутаа эргээд том том бүтээн байгуулагчид, баялаг бүтээгчид, ажил олгогчид, шилдэг татвар төлөгчид болоод ингээд тэд нарын үйлдвэрлэж

байгаа бүтээгдэхүүн үйлчилгээг нь иргэд, олон нийт өөрөөр хэлбэл нөгөө баялгийн эзэн болох ёстой хүмүүс чинь өөрөө нөгөө хүмүүсийг хөхиүлэн дэмжигч, хөлжүүлэн баяжуулагч энэ одоо худалдан авагчид нь болчихоод байдаг.

Тэгэхээр би танаас нэг зүйл асуумаар байгаа нь яг энэ баялгийг тийм ээ бүх ард түмнээрээ тэгш хүртээмжтэй хүрдэг байсан баялгийг энэ хэдэн монопол нөхдүүдэд олгосон одоо тухайн үед төр засгийн эрх барьж байсан тэр хүмүүст та хариуцлага нөхөн тооцуулж чадах уу? Мөн түүнчлэн энэ байгалийн баялгийг дангаар завшсан этгээдүүдээс нийт ард түмний ашгийг нөхөн авч байгалийн баялгийг нь иргэд олон нийтэд хуваарилах замаар та хүртээж чадах уу?

Ер нь бол Монголын ард түмэн өөрт ноогдох иргэн хүн тиймээ 07 газраа ч одоо авч чадаагүй хэчнээн сая иргэд байж байна. Гэтэл яагаад Монголын энэ монопол хэдэн том том компани, корпорац, группүүд бүхэл бүтэн аймаг, сум дүүргээр нь тиймээ одоо газрын дээрх, доорх баялагтай нь ингээд эзэмшээд байдаг юм бэ. Энийг та таслан зогсоож чадах уу? Ингээд өнөөдөр бас өнөөдрийн энэ хурал дээр их сонин сонин юмнууд. Ингээд 3 минут болчихож байгаа юм уу, ямар хурдан байна? За одоо энэ Монголын ялангуяа залуу гэр бүлүүдийн нэг мөрөөдлийн нэг хөөрхий нэг юм байна аа. Ипотекийн зээл гэдгийг л мөрөөддөг болж хөөрхий. Тэгээд л ипотекийн зээлд хамрагдаж чадахгүй бол гадагшаа гадаад явж наад зах нь Солонгос явж ажил хийх хүсэлтэй ийм одоо иргэд, энэ дундаа ялангуяа хөдөлмөрийн насныхан, хөдөлмөрийн...

Д.Амарбаясгалан: Нэг минут нэмж өгье. Нарантуяа-Нара гишүүнд.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр товчхон явчихъя. Тэгэхээр ипотекийн зээлийг бас энэ одоо үнэхээр нөгөө авах шаардлагагүй гэдгээ нотолж байж олгодог энэ байдлыг болимоор байна аа. Монголын гэр бүлүүд ипотекийн зээлийг, ер нь энэ нийгэм эдийн засгийн хүчин зүйлээс хамааралтай гэр бүлийн бүрэн бүтэн байдал маш их алдагдаж байна. Гэр бүл салах эндээс үүдэлтэй хүүхдийн одоо эрхийн асуудал, хүүхдийн хохирох асуудал маш их болж байна аа. Тэгэхээр энийг бас хэлмээр байна. Дээрээс нь иргэдийн асуусан асуултыг бас дайчихъя. Тэгээд аж ахуйн нэгжийн НӨАТ-ын татварыг 5 хувь болгох, Хувь хүний орлогын татварыг хялбар горим буюу нэг хувийн татварыг хэвээр үлдээхийг одоо иргэд санал дэвшүүлж өгөөч ээ гэсэн ийм юм бас хэлж байна.

Дээрээс нь ахмадуудын зүгээс ахмадын тэтгэврийн зээлийн хүүгийн хөнгөлөлт гэхээсээ илүүтэйгээр тэтгэврийн зээлийг нэмэгдүүлж өгөөч ээ. Тэгэхдээ нөгөө давхар өсдөг үнийн өсөлтийг бас барьж хязгаарлаж өгөөч ээ гэсэн ийм асуултуудыг бас ирсэн байгаа. За дараа нь нэмэлтээр асуултаа асууя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Нэр дэвшигч Занданшатар дарга.

Г.Занданшатар: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя аа. Энэ Үндсэн хуулийн 6.2-т оруулсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бид Норвегийн үндсэн хуулийн жишгээс авч эхний 2 параграфыг боловсруулж оруулсан. Энэ тэр агуулга бол үндэсний баялгийн санг бий болгох ирээдүй ба одоо бүрийн иргэн бүрд үр өгөөжтэй байх, байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлж үр өгөөжийг нь ард түмэн одоо хүртээмжтэй болгох гэсэн энэ санааг Норвегийн Үндсэн хуулиас сануулж бид нар оруулсан юм. Тэгээд энэнийхээ дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг ноднин баталсан юм. Яг энэ агуулгаараа

юу гэж оруулсан юм гэхээр ийм уудам газар нутагтай 1.5 сая км квадрат нутагтай, 3.5-хан сая хүн амтай ийм агуу их баялагтай улс мөртөө яагаад Монгол Улсын ард иргэд нь алтан дээр суусан гуйлгачин гэдэг чинь ядууралтай байгаа юм бэ. Энийгээ зөв ашигладаг болъё, үр өгөөжтэй болгоё гэдэг зорилгоор энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг оруулсан юм.

Зөвхөн дарга нарын ширээ, сандал ярьдаг биш Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр ард түмэндээ өгөөжтэй болгох. Энийг хэрэгжилтийн ажил нь Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг одоо хэрэгжүүлэх гээд стратегийн орд газрууд, АМНАТ гэдэг энэ баялгийн татвартай болъё гэсэн ийм саналууд хэрэгжүүлээд явж байгаа. Ийм ч учраас энэ бодлогоо хэрэгжүүлэхийн тулд би Үндсэн батлагдсан хууль Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө амилуулахын тулд би өнөөдөр бас нэр дэвшиж байгаа нэг шалтгаан зорилго маань үүнтэй уялдаж байгаа юм.

Ийм ч учраас хэн нь ч бай байгалийн баялгийг эзэмшиж байгаа болбол үр ашигтай байх ёстой. Харилцан үр ашигтай байх ёстой. Энэ баялгийн сангийн хуулийн дагуу АМНАТ ноогдол ашиг аливаа хэлбэрээр үр өгөөжтэй болгох энэ зарчмыг тууштай хэрэгжүүлэх яриа хэлэлцээг эхлүүлж, төрийн хатуу зөөлөн арга бүхнийг ашиглаж өгөөжтэй болгоно оо.

Ер нь би орон сууцжуулалтын банктai болъё оо гэдэг санаачилгыг энэ Ирээдүй өв сангийн тухай хуультай уялдуулж орон сууцны банк байгуулах ийм санаачилгыг дэвшүүлж байгаа юм. Залуу гэр бүлийг дэмжихэд ипотекийн бодлогыг уян хатан, нийлүүлэлтийн бодлоготой нь, метр квадраттай нь, эрэлт нийлүүлэлттэй нь уялдуулж хэрэгжүүлдэг солонгосын 70-аад онд хэрэгжүүлсэн Орон сууцжуулалтын банкны Хаусын банк гэдэг банкны загварыг нэвтрүүлж, Ирээдүй энэ хуримтлалын сангийн орон сууцжуулалт эрүүл мэндийн бодлоготой уялдуулсан. Ийм зарчмаар анхны орон сууцад хөнгөлөлттэй нөхцөлд санал болгох, урьдчилгаа төлбөрийн дэмжлэг үзүүлэх, уян хатан зээлийн хугацаатай, бага хүүтэй, зорилтот бүлэгт чиглэгдсэн орон сууцжилтын бодлогыг хэрэгжүүлэхийн тулд ипотекийн банк буюу орон сууцын банкийг байгуулж байж илүү үр дүнтэй хэрэгжүүлж болох юм байна аа.

Тэгэхгүй бол одоогийн барьж байгаа орон сууцад ипотекийн зээл маань бас яг зорилтот бүлэгтээ хүрч чадахгүй байна аа. Ийм бодлогыг хэрэгжүүлж Үндэсний баялгийн сангийн хуулиа илүү үр дүнтэй болгохыг л зорьж энэ өнөөдрийн энэ нэр дэвшилт, энэ хүсэл мөрөөдлөө зорилгоо хэрэгжүүлэхийн тулд энэ асуудлыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө амилуулахыг зорилгоо болгож байна аа.

Д.Амарбаясгалан: Нарантуяа-Нара гишүүн тодруулж асууя.

М.Нарантуяа-Нара: Баярлалаа. Тэгээд таны одоо энэ саяын ярьсан зүйлийг иргэд бас олон нийт сонсоод их баяртай байгаа байх аа. Тэгээд хамгийн гол нь та одоо өнгөрснийг бид нар бас уучлаад орхих юм уу? За одоо яршиг өнгөрсөн хугацаанд бол баялгаа буруу хуваарилчихжээ. Одоогоос эхлээд зөв хуваарилъя гэх юм уу, эсвэл өнгөрсөнд бас хариуцлага тооцох уу гэдгийг асуумаар байна.

Мөн түүнчлэн таны одоо кабинетын тухай асуумаар байна. Та одоо энэ юу Их Хурлын сонгуулийн энэ жагсаалтын жендерийн одоо сөөлжих юунд маш том үүрэг оролцоотой байсан юм байна лээ. Тэгэхээр одоо танай таны байгуулах энэ Засгийн газрын кабинет чинь энэ жендерийн хуулийн тухай хуулийг хэр дагаж мөрдөх вэ. 30

хувь байгаа шүү дээ. Тэгэхээр та хэдэн хувьд хүргэе гэж бодож байна. Та надад яг энэ талаараа хэдэн хувьтай барья гэж бодож байна гэдгээ нэг юу хэлж өгөөч.

Тэгээд за за больё доо. Цаг хүрэхгүй.

Д.Амарбаясгалан: За хариулт өгье.

Г.Занданшатар: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн жендерийн асуудлын талаар асуулаа. Энэ Жендерийн эрх тэгш байдлын тухай Тогтвортой хөгжлийн зорилтын 14 дэх энэ зорилтыг хэрэгжүүлэх талаар олон улсын хурал зохион байгуулж, сонгуулийн хуульд бас квотыг нэмэгдүүлэх талаар бас санаачилга, үр рольтой оролцсон гэдгийг манай эмэгтэй гишүүд сайн мэдэж байгаа. Тэгэхдээ Засгийн газрын бодлого бол бүтэц бүрэлдэхүүний асуудалтайгаа уялдаж ямар мөрийн хөтөлбөр юуг яаж хэрэгжүүлэх вэ гэдэгтэй уялдаж, томилогдсон тохиолдолд Бүтэц бүрэлдэхүүний тухай хууль хэлэлцэхдээ энэ асуудлыг бас нарийвчлан хэлэлцэх байх.

Жендерийн бодлого нь бүх хүйсийн хүмүүсийн эрх тэгш боломжийг хангах тал руу чиглэгдэнэ. Ийм учраас хүчирхийллээс хамгаалах оролцоог дэмжих зөвхөн Засгийн газрын сайд нарт болоод шийдэгдчихдэг юм биш. Харин одоо агентлаг Засгийн газрын бусад бүрэлдэхүүн шаардлагатай бол орлогч сайд нарын түвшинд ч гэсэн энэ асуудлыг хангаж ажиллах бололцоо бүрдүүлэхийг анхаарах болно оо.

Д.Амарбаясгалан: Нарантуяа-Нара гишүүн дахин тодруулж асууя.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр таныг бол одоо энэ баялгийн баялагтай холбоотой тиймээ баялгийг одоо иргэд олон нийтэд тэгш хүртээмжтэй хүртээх тал дээр одоо үнэхээр бас ингээд түүчээлээд, манлайлаад зоригтой ажиллана гэвэл бол би үнэхээр бүх талаар дэмжинэ ээ. Харин та кабинетаа байгуулахдаа энэ одоо өнөөдөр таныг сайхан долоож долдойж байгаа ийм хүмүүсээр биш эргээд хариуцлага хүлээх өдөр ирэхэд хамтдаа зогсоод хариуцлага хүлээж чадах тийм сэтгэл зүтгэлтэй, хариуцлагатай хүмүүсээр кабинетаа байгуулаарай гэж хүсэж байна аа. За амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Дэгээ зөрчөөд Нара гишүүнд нэг удаа илүү тодруулга өгсөн байна. Ганбатын Очирбат гишүүн асуулт асууя.

Г.Очирбат: Оройн мэнд хүргэе ээ. Нэр дэвшигч Занданшатар 34 дэх Ерөнхий сайд болох гэж байна аа. Та бол Монгол төрийн бас түүх. Тэгээд энэ Монгол Улс яг өнөөдрийн байдлаар эдийн засгийн нөхцөл байдал хүндэрчихсэн, залуучууд нь гадагшаа гараад явчихсан, аж үйлдвэрийн салбараа босгодоггүй тэгээд энэ ой санамж одоо танд байгаа байх. Би зүгээр хамгийн тодорхой Та одоо нэг л нэг ийм хариулт өгчихмөөр байгаа юм. Та ер нь урьд нь энэ олон жил 4 удаа сонгогдож, 2 удаа сайд, Их хурлын дарга 2 удаа, одоо Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга ажиллаж байхдаа хийж байсан ажлаа ер нь 10 гэдэг үнэлгээ тавьж байгаад би хэдэн хувьтай ажилласан бэ гэдгээ нэг хэлээд өгчихмөөр байна.

Дараагийнх нь таны өдрөөс хойш яриаг сонслоо. Бид нар экспортоо дэмжинэ ээ. Импортоо орлох дотоодын аж үйлдвэрийн салбарыг бий болгоно оо гэж байгаа юм. Аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхийн тулд ямар маягаар хөгжүүлбэл танд та ер нь хөгжинө гэж бодож байгаа юм. Кластер маягаар явах юм уу, жижиг, дунд

үйлдвэрлэлээ дэмжээд явах гэж байгаа юм уу. Энэ дээр нэг тодорхой нэг бодлогын хариулт өгчихье. Тэгж байгаад би нэг тодруулах гээд байгаа юм. Яагаад гэхээр одоогийн өнөөдрийн энэ аж үйлдвэрийн паркууд чинь өөрсдөө хүнд байдалд орчихсон байгаа.

Дараагийнх нь эрчим хүчний салбар. Эрчим хүчний салбар бол үнэндээ энэ хөгжлийн суурь салбар. Монгол Улсад энэ сэргээгдэх эрчим хүчин дээр хөрөнгө оруулалт оруулъя гэсэн олон улсын олон компаниуд байдаг. Дотоодын, гадаадын аж ахуйн нэгжүүд. Ерөөсөө оруулж ирдэггүй. Би нэг ажлын хэсэгт ажиллаж байгаа. Эдийн засаг, хөгжлийн яаман дээрээс материал байна уу гэхэд материал байхгүй. Тэгэхээр та ер нь энэ эрчим хүчний салбарыг юу гэж бодож байгаа юм?

Би дахиад нэг яг энэнтэй холбоотой нэг тодруулга явах юм. Ер нь олон улс бол иргэд рүүгээ эрчим хүчнийхээ энэ юмыг салбарыг өгөөд тэндээсээ иргэдээ орлоготой болгож байгаа ийм боломжууд бас харагдаж байгаа.

Дараагийнх нь 14 хоног энэ гадаа барилгын салбарынхан 5 мянган аж ахуйн нэгж 100 мянган ажилчдаа төлөөлөөд сууж байна аа. Та энэ хүмүүсийг хүлээж авч уулзах уу? Ерөнхий сайд болбол Энийг одоо манай барилгачдын холбооныхон асуугаад өгөөрэй гэсэн асууя.

Хамгийн сүүлийнх нь төрийн албан хаагч нар. 226 мянга 800 төрийн албан хаагч байна. 20 мянган дарга байна. 10 хүн тутмын нэг нь дарга болсон. Хэлтсийн дарга, тасгийн дарга, ажлын хэсгийн дарга, төслийн нэгжийн дарга даргагүй юм байхаа больсон. Тэгэхээр та энэ дээр ямар бодлого барьж ажиллах вэ?

Хамгийн сүүлийнх нь. Одоогоос 20 одоо нэг 20 хэд хонож байна уу, үгүй юу даа энэ 2026 оны хөгжлийн хөтөлбөр орж ирж байсан. Энэ дээр бол манай Жавхлан сайд бол бид нар төсвийг тодотгохгүй ээ гэдгийг бүр өдөр болгон хэлж байсан. Та өнөөдөр төсвийг тодотгоно оо гэж байгаа. Энэ дээр яг нөхцөл байдал ямар байгаа юм нэг хариулт.

Д.Амарбаясгалан: За хариулт өгье. Нэр дэвшигч Занданшатар дарга.

Г.Занданшатар: Хийж хэрэгжүүлж байсан ажлаа өөрөө үнэлэх нь бол зохимжгүй байх. Түүх ч үнэлэх байх, цаг хугацаа ч үнэлэх байх. Тэгэхдээ би ажиллаж байсан газар болгондоо реформ шинэчлэлийг хэрэгжүүлж байсан юм билээ. Одоо Хөдөө аж ахуйн банкныг Хаан банк болгосон. Хамгийн одоо өнөөдөр үр ашигтай банк байна ажиллаж байсан үед. Гадаад харилцааны салбарт ажиллахад энэ гуравдагч хөршийн бодлоготой гадаад бодлогын үзэл баримтлалыг батлуулж байсан. Улсын Их Хурлын даргаар ажиллахад би Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлж өнөөдрийн парламентын ардчиллыг төлөвшүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан гэж түүхчилж онцолж яривал олон парламентын хяналт шалгалтын хороо тогтолцоог нэвтрүүлсэн гээд одоо хийж хэрэгжүүлсэн ажлууд маань дандаа реформ, ард иргэдийн тэгэхдээ санал бодолд тулгуурласан өөрчлөлт шинэчлэлтийг хэрэгжүүлэхийн төлөө зорьж ажилласан. Энийг түүхийн баримтууд нотолно оо гэж бодож байна.

Аж үйлдвэрийг хөгжүүлэх бодлого аж үйлдвэржилтийн бодлого бол Монгол Улсын харьцангуй давуу тал буюу өнөөдрийн манай газар зүйн байрлал, уул уурхайн нөхцөл байдал дээр нь энэ эрчим хүчний боломж, хүнс үйлдвэрлэх

боломжуудаар тулгуурлах бололцоотой. Яагаад гэвэл зах зээл маань ийм. Ийм учраас эрчим хүчний эх үүсвэр эрчим хүчний бодлого дээр гэхэд манайх нарны болон салхины эх үүсвэрээрээ нүүрс одоо бусад эх үүсвэрийг үл тооцон дэлхийд бас дээгүүр онолгодог ийм нөөцтэй улс. Сэргээгдэх эрчим хүч хэрэглээ бас зэргэлдээ бий. Ийм учраас эрчим хүч экспортлогч улс болох бүрэн бололцоотой. Ногоон эрчим хүчний салбарыг төрөлжүүлэх, технологи инновацыг дэмжих, үндэсний үйлдвэрлэлийн стратегийг боловсруулах ёстой. Энэ дотроо манай аж үйлдвэрийн кластер бол хөдөө аж ахуйн кластер байна. Уул уурхайн кластер байна. Аж үйлдвэрийн паркуудын бодлого бол үндсэндээ бас энэ зах зээлийн бодлоготойгоо уялдахгүй удаашралтай байгаа. Энийг одоо үнэлгээ хийж байж та бүхэн ч гэсэн оролцоод энэ эрчим хүч, аж үйлдвэржилт, уул уурхайн нэмүү өртөг шингээх аж үйлдвэр кластерын бодлогыг нэгдсэн зарчмаар хэрэгжүүлэх бололцоотой гэж бодож байна.

Гуравдугаарт нь энэ барилгачдыг хүлээж авч уулзана аа хэрвээ томилогддог юм бол. Шийдэл гарцыг олж цаашдаа ер нь өөрсдийнхөө барилгачдыг ажил олгогчдыг дэмжих нөгөө ажил олгогч, ядууралтай тэмцэх, халамжаас хөдөлмөрт гэдэг маань эцсийн дүндээ үндэсний үйлдвэрлэгчид, барилгачид энэ бүхнээ л дэмжихэд чиглэгдэх ёстой гэж үзнэ.

Төрийн албаны үр ашиг бүтээмжийг хэмждэг одоо энэ бүтээмжийн менежерүүдээс авхуулаад сүүлд томилогдсон чиг үүргүүдийг бол их тодорхой болгох шаардлагатай болно. Ер нь энэ 208 хуулиар 1028 заалтаар төрийн чиг үүргийг төсвөөс санхүүжүүлдэг. Төр даана гэсэн зарцуулалтыг хуульчилчихсан юм байна лээ. Энийг хувийн хэвшилд шилжүүлэх энэ бодлоготой бас уялдах шаардлагатай. Эрчим хүчний салбарт бие даасан бодлого шаардлагатай гэж үздэг. Ийм учраас сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах, баталгааг нь хангах, эрчим хүч хадгалах систем нөгөө батарей сторержийн систем энэ цогцоороо шийдэл ер нь сэргээгдэх эрчим хүчний зардал өртөг бас хямдарч байна. Батарей хадгалалтын схем бүрдэж байна. Нэлээн том хөрөнгө оруулалтууд, эрчим хүчний сэргээгдэх эрчим хүчний төслүүд хэрэгжүүлэхээр бас яригдаж хэрэгжиж байгаа төслүүд байгаа. Энэ чиглэлээр бас тухайн үед нь танилцуулаад хэлэлцэх болно оо.

Энэ чиглэлээр хувийн хэвшлийн оролцоо, төр хувийн хэвшлийн түншлэл тарифын бодлоготой хандах ийм шаардлагатай гэж үзэж байгаа. Цаг бага учраас товч хариулахад ийм байна.

Д.Амарбаясгалан: Ганбатын Очирбат гишүүн тодруулж асууя.

Г.Очирбат: Харин аягүй тодорхой уул нь өдрөөс хойш та хариулаад байсан. Одоо сүүл рүүгээ ядарч байж бас магадгүй байх. Тэгээд тодорхой бус хариулаад байна. Эрчим хүчний салбар бол яг энэ уул уурхайн салбартай адилхан. Тухайн үед мэдээлэлд ойрхон байсан хүмүүс энэ уул уурхайн салбарын бүх лицензийг аваад дараад ингээд ард иргэдээ мөлжсөн. Энэ бол үнэн. Одоо эрчим хүчний салбар яг тийм байгаа. Дутагдалтай байгаа юу дутагдалтай байгаа. Бид нар хийж хэрэгжүүлж болох уу болно. Тэрийг бүр өрх бүрээ эрчим хүч үйлдвэрлэгч болгох боломж байгаа шүү. Та тэгэхээр энийг аягүй сайн бас судлаарай. Тэгж чадах юм бол 365 хоног дээрээ симуляц хийгээд үзэхэд нэг өрх сардаа 500 мянган төгрөгийн орлого олох, одоо байгаа орлого дээр нэмж олох ийм боломжууд байгаа тэрийг бас үзээрэй.

Аж үйлдвэрийн салбараа та өдөржингөө л уг нь аж үйлдвэрийн салбар ярьсан даа. Тэгээд аж үйлдвэрийн парк дээр өнөөдөр болохгүй байгаа хууль эрх зүйн шинэчлэлүүд хийгдэх ажлууд байгаа. Тэр лүү яг гүн ороорой. Хөрөнгө оруулалт бол орж ирье гээд хүлээгээд байж байгаа юм байна лээ шүү. Мөнгөгүй биш мөнгө олж болж байгаа. Дараа нь та төрийн алба...

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Очирбат гишүүнд нэг минут нэмж өгье.

Г.Очирбат: Эдийн засгийн хөгжлийн яамнаас яг энэ төрийн албан хаагч нар дээр ажил албан тушаалын тодорхойлолтын чиг үүргийн дагуу матриц шинжилгээ хийгээд 9 хувиар бол давхцаж байна аа гээд гаргаад ирчихсэн байгаа. 9 хувийг бид нар сонгогдох бололцоотой байна аа. Яагаад гэвэл хий дарга нар тэнд татвар төлөгч нарын мөнгөөр цалин аваад сууж байна гэдгийг гаргаад ирчихсэн. Энэ бол 20 хүрэх хүртэл бололцоотой гэж үзэж байгаа. Тэгэхээр энэ дээр бас та нягт нямбай яг ажиллах шаардлага тулж байгаа шүү. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууя.

Д.Ганмаа: Хэд хэдэн асуулт асууя аа. Нэгдүгээрт мэдээж салбарын буюу эрүүл мэндийн салбарт хамгийн эхэнд яг ямар бодлого хэрэгжүүлэх вэ гэдгийг асууя. Хоёрдугаарт, одоо байгаа эрүүл мэндийнхээ нөхцөл байдлыг яг яаж ямар байна аа гэж дүгнэж байгаа вэ гэдгийг бас асууя. Эрүүл мэндийн салбарын асуудлын гол шалтгаан нь одоо эрүүл мэндийн тогтолцоог уг сууриар нь яг харж чадаж байгаа юу? Яагаад гэхээр түрүүн бүтээмжид суурилсан одоо гүйцэтгэлээр цалин хөлсийг олгодог болгоно оо гэж ярьж байгаа нь яг суурь шалтгаанаа арилгаагүй цагт хэрэгжихгүй. Ийм учраас одоо эмч, эмнэлгийн ажилчид, мэргэжилтнүүдийн цалин, нийгмийн асуудал гэдгээр асуудлыг яаж шийднэ гэж харж байгаа бол оо гэдгийг сонирхож асууж байгаа болно.

Бас нэг нэр дэвшигчийн маань хэлж байгаа үгнээс нэг хамгийн одоо сэтгэлд буюу чихэнд чимэгтэй сонсогдсон нь хүний хөгжлийн мега төслийг хэрэгжүүлнэ ээ. Хүний хөгжил буюу эрүүл мэнд, боловсрол монгол хүн гэсэн үнэт зүйл дээр тулгуурлана гэж ярьсан нь их сайхан сонсогдлоо. Яг энэ дээр нь тэгвэл бид нар одоо энэ нийгмийн салбар буюу яг боловсрол, эрүүл мэнд, энэ орлогын тэгш бус байдалтай холбоотой хүнс, шим тэжээлийн асуудал, эцэг эхийн орлогоос хамаарсан боловсролын тэгш бус байдал, эрүүл мэндийн чанартай хүртээмжтэй энэ асуудлыг яг яаж шийдэх вэ? Бодитойгоор энийг арилгахын тулд ямар бодлого хэрэгжүүлэх вэ гэдгийг асууя.

За жоохон давхцаж байгаа ч гэсэн 2030 оны 17 дугаар одоо 1 дүгээр хэсэгт тогтвортой хөгжилд 15 хувьд ядуурлыг бууруулна гэсэн амлалт байгаа нь энэнтэй бас жоохон холбогдож байгаа. Энийг одоо хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. Эдгээр асуултаас гадна яг тодорхой хувиар яаж бууруулах боломжтой байгаа гэдгийг бас нэг хариулж өгвөл сайн байна.

Мэргэжлийн салбар салбарын төлөөллийг оруулж ирсэн энд бас нэр дэвшигч өөрөө өмнөх дарга нартай хамт бас нөгөө авторшип тиймээ хамтарч хийсэн энэ бодлогын хүрээндээ зарим нь бас одоо нөгөө мэргэжил мэргэжлийн төлөөлөл жагсаалын төлөөлөл одоо харьцангуй юу гэдэг юм тойргийн зовлонгүй Монгол Улсыг бүтнээр нь харах боломжтой ийм төлөөллүүд орж ирсэн зарим нь эндээс гаднаас одоо яг салбар салбартаа реформ хийе гэсэн сэтгэл санаа шулуудаж

зориглож ирсэн хүмүүс байгаа. Тэгэхээр эдгээр хүмүүсийг эдгээр төлөөллүүдийг гадаадад байгаа монголчууд яг бас орж ирэх одоо юу гэдэг юм энд ажиллах боломж бүрдэх нь үү, тэр суурь нь байна уу, эдгээр хүмүүсийн үр ашгийг нь яаж гаргаж байна, сонсож байна уу, мэдэрч байна уу гэдэг дээр харж байгаа гэдэгт би итгэлтэй байна.

Тэгэхлээр эдгээр хүмүүстэйгээ яаж хамтарч ажиллах вэ. Одоо жишээлбэл гэхэд намайг ирснээсээ хойш л шалгуур үзүүлэлт, үр дүнгийн хэмжүүр, үр ашиггүй байдал гэдгийг ярьсан боловч нэг бодитой өөрчлөлт шинэчлэлт гараад байгаа юм надад харагдахгүй байгаа учраас энийг заавал тодруулж асуух хэрэгтэй гэж би бодож байна.

Дараачийнх нь асуулт нь татвар, НӨАТ, хувь хүний аж ахуй, татвар, албан аж ахуй тэгээд нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулах тал дээр бас та яг...

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Нэр дэвшигч Занданшатар дарга.

Г.Занданшатар: Даваасамбуугийн Ганмаа гишүүний асуултад хариулъя аа. Эрүүл мэндийн салбартай холбоотой хамгийн түгээмэл асуудал бол эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн асуудал байдаг. Эрүүл мэндийн салбарын төсвийг ДНБ-ний 6 хувьд хүргэх шаардлагатай талаар ДЭМБ-ын зөвлөмж байгаа талаар би дээр өгүүлсэн. Энэ 6 хувьд хүргэхэд бол одоогийн байдлаар бол 3 орчим хувьтай байгаа. Энийг 2 дахин нэмэгдүүлэх шаардлагатай болно гэсэн үг. Тэгэхдээ өнөөдрийн манай төсвийн байдал бол энэ нь уул уурхайн циклээс шалтгаалаад хумигдаж байна.

Эрүүл мэндийн салбарын төсөв бол сүүлийн 5 жилийн хугацаанд нэрлэсэн дүнгээр 2.4 дахин өссөн юм байна лээ. Тэгэхдээ Эрүүл мэндийн даатгалын болон эрүүл мэндийн санхүүжилтийг оновчтой болгох, үр ашгийг нэмэгдүүлэх асуудал хамгийн чухлаар тавигдаж байна аа. Энэ дотроо эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ сум өрхийн эмнэлгийн санхүүжилтийн асуудлыг хөндөж ярих ёстой. Одоо энэ гүйцэтгэлийн санхүүжилт бол Улаанбаатар хотын эмнэлгүүд хүн өвчтөн үйлчилгээ ихтэй газар болбол үр дүнтэй. Хүн багатай газар бол үр дүн багатай. Ийм гүйцэтгэлийн санхүүжилт Монгол Улсын энэ газар нутаг хүн амын байршил суурьшлын онцлогоос шалтгаалаад ийм тэгш зөв хэрэгжих боломжгүй байгаа юм.

Ер нь манай энэ хот, хөдөөгийн ялгаа бол ер нь эрүүл мэнд, боловсролын салбар, хүний хөгжлийн салбарт тулгарч байгаа хамгийн том тэгш бус байдлын нэг өнцөг болж байна. Ийм ч учраас Улаанбаатар луугаа эргэж шаваад байдаг, төвлөрөөд байдаг энэ үйлчилгээний ерөнхий чиг хандлага, чанар, үйлчилгээнд цогцоороо энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтайгаа бүсчилсэн эмнэлгийн шаардлагатайгаа уялдах ёстой. Ийм учраас энэ дотор дижитал эмнэлэг буюу одоо и-эмнэлгийн тогтолцоо, зайны оношилгоо, бүсийн эмнэлгийн тогтолцоог энэ бүтцийнх нь хувьд нэг том шинэчлэл хийж харах хэрэгтэй юм шиг байгаа юм.

Хоёрдугаарт нь өнөөгийн эрүүл мэндийн нөхцөл байдал бол шинжилгээ, эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эмчийн тоо, чадавхыг нэмэгдүүлэх, хүртээмжгүй, өндөр өртөгтэй эмнэлгийн үйлчилгээ хөдөө орон нутгийн эмчийн дутагдал, нийгмийн хамгааллынх нь одоо тулгамдсан асуудал, телемедицинийг нэвтрүүлэх шаардлага, үр ашигтай санхүүжилт, чадварлаг хүний нөөцөөр бэхжүүлэх шаардлага гэх мэтчилэн олон асуудалтай уялдаж хэрэгжих ёстой.

Тийм ч учраас би энэ хүний хөгжилд чиглэсэн бодлого бол шинэ Засгийн газрын мега төсөл байх ёстой гэдэг нь мега хэлбэрээр харж байж эрүүл мэнд, боловсрол, хүний хөгжлийн асуудлаа, тэгээд ядуурлын асуудалтайгаа шийдэхэд л энэ хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг энэ үндэсний баялгийн сангийн бодлогын чиглэлийг гаргах ёстой. Ингэж байж бид одоо энэ гадаадад байгаа иргэд эрдэмттэйгээ хамтран ажиллах ерөнхий чиглэлээ гаргана. Энэ чиглэлээр харин одоо салбар салбарын төлөөлөл болсон нийгмийн бүлгүүдийн төлөөлөл болсон манай Их Хурлын гишүүд нэн ялангуяа эрүүл мэндийн салбарынхаа төлөөлөл болсон гишүүдийн эрүүл мэндийн салбарын реформ талаар судалж, ахалж манлайлж ажиллавал баяртай байх болно. Энэ зөвхөн Засгийн газрын ажил биш. Энэ ажилд тухайн салбаруудыг төлөөлж байгаа.

Одоо бизнесийн салбарынхан нь Худалдаа аж үйлдвэрийн танхимын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн энэ төлөөлж байгаа гишүүдэд маань яамтайгаа, бүтэцтэйгээ холбогдож ажилладаг ийм механизмыг бий болгох шаардлагатай юм билээ. Намын бүлгүүд дээр ийм 68-уулаа суулаа бүх юмыг яриад байх нь одоо зөв байх л даа. Тэгэхдээ энэ хэсэг бүлгүүдээрээ хуваагдаж, илүү үр ашигтай, оновчтой хэлэлцүүлгийн механизм, ажлын хэсэг, зөвлөлүүдийг бий болгох замаар энэ Хүний хөгжлийн зөвлөл, Бизнесийн зөвлөл гэдэг юм уу бүлгүүдийг ч гэсэн засагтайгаа уялдаж ажиллах шинэ механизмыг бий болгох шаардлагатай.

Яагаад гэвэл энэ бас олон мянган эмч нараа, олон мянган залуусаа, олон мянган бизнесийнхнийгээ...

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Тэгэхээр тойргийн төлөөллөөсөө гадна нийгмийн тодорхой бүлгийг төлөөлж тухайн салбарын асуудлыг хариуцаж байгаа чиглэл чиглэлээрээ ийм Засгийн газартай уялдаж ажилладаг механизмыг намын бүлгүүд, Улсын Их Хурлын бүтцийн байгууллагуудтай бий болгож ажиллах шаардлагатай гэж энэ чиглэлээр илүү тодорхой яривал энэ 5 минутад багтаагаад ярьчих асуудал биш учраас энэ чиглэлээр одоо бас судалгаа тооцоонд үндэслэж чиглэл чиглэлээрээ Улсын Их Хурлын бүтцийн байгууллагуудтай Засгийн газар төлөөлсөн гишүүдтэй нь хамтран ажиллах ийм бодол хандлагатай байна аа.

Д.Амарбаясгалан: Даваасамбуугийн Ганмаа гишүүн тодруулж асууя.

Д.Ганмаа: Та Стэнфордод 3 жил болсон. Визитинг сколараар ажиллаж байсан, АНУ-д ажиллаж байсан. Судалгаа шинжилгээ хийж байсан. Тэгэхлээр энэ мэдээ мэдээлэл, дата одоо шинжлэх ухаанчаар асуудалд хандана гэдэгт итгэлтэй байна. Дашрамд нь хэлэхэд энэ ДЭМБ дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ санхүүжилтийг 6 хувьд хүргэ гэсэн тийм рекоммендэйшн байдаггүй. Хаанаас тийм сайт эйшн референс яваад байгааг би сайн мэдэхгүй байна. Энэ бол санхүүжилтийн зарцуулалтын асуудлыг ярьж байгаа. Ялангуяа ингээд Out-of-pocket expense буюу одоо хувь хүнээс гарч байгаа зарцуулалт нэмэгдээд явчих юм бол харин ч энэ нь эсрэгээрээ нөгөө иргэддээ хүн төвтэй биш хүртээмж чанаргүй байдалд одоо сөрөг нөлөө үзүүлдэг гэсэн асуудал байгаа.

Тэгэхлээр бид нар энд шинжлэх ухаанчаар мэдээлэлдээ хандаж ярьцгаахгүй бол болохгүй гэдэг дээр та санал нэгдэх байх гэдэгт итгэлтэй байна. Энэтэй

холбоотой жишээлбэл АНУ өөрөө одоо дотоодын нийт бүтээгдэхүүн хамгийн өндөр эрүүл мэнддээ байдаг зарцуулдаг мөртөө хүртээмж чанар хамгийн...

Д.Амарбаясгалан: Ганмаа гишүүнд ганц минут нэмж өгье, нэг минут нэмж өгье.

Д.Ганмаа: Баярлалаа. Тэгээд энэ эрүүл мэндийн салбарын асуудлыг шийдэхийн тулд эрүүл мэндийн бид нар тусламж үйлчилгээ, хүртээмж, хариуцлагын тогтолцоог сайжруулах ийм хуулийн ажлын хэсэг гараад, яг ямар Монголд одоо ямар системээр явах юм бэ, тогтолцооны ямар загвар сайн ажиллах юм бэ энийгээ яаж үр ашигтай явах вэ гэдэг дээр моделийг нь боловсруулаад санал дүгнэлтээ хүргүүлчихсэн байгаа. Эрүүл мэндийн сайдад хүргүүлсэн. Улсын Их Хурлын гишүүдэд яг энэ салбарын хүмүүст хүргүүлсэн байгаа. Энэ ажил дээр дэмжиж ажиллаж хамтарна гэж хэлж байна гэж ойлголоо. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Чинбаатарын Анар гишүүн асуулт асууя.

Ч.Анар: Оройн мэнд ээ эрхэм нэр дэвшигч ээ. Та төр цомхон байх цомхотгол хийх тухай оройжингоо ярилаа. Гишүүд асуулаа. Өнөөдөр Монгол Улсад 16 яам, 22 сайд, 38 агентлаг, 21 үндэстний хороо, 4 зөвлөл, дахиад 4 комисс, Төрийн өмчит компани 119, 118, орон нутгийн өмчит компани 357 гэх мэтчилэн. Нөгөө төр данхаагаад байна гэдгийн тоо баримтууд нь энд байна.

Миний хувьд Их Хурал дээрээс төрийн процессыг хүнд сурталгүй дахин инженерчилж хийх ажлын хэсгийг хариуцаж байгаа. Гэхдээ яг энэ дээр чиг үүргээрээ Засгийн газар дээр хариуцаж байгаа чиг үүрэг давхардсан чиг үүрэгтэй. Төрийн цахим үйлчилгээний газар, Төрийн хэмнэлт, бүтээмжийн үндэсний зөвлөл, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Алсын хараа-2050, Эдийн засаг, хөгжлийн яам, Инновац, цахим харилцаа холбоо хөгжлийн яам. Дахиад дээрээс нь нэмээд бүтээмжийн менежерүүд, хяналтын менежерүүд нөгөө цомхон байна гээд дахиад хяналт бүтээмжийн менежерүүд нэмчихсэн.

Өнөөдөр АН-ын дарга Гантөмөр мэдэгдэл хийсэн байна. Төр цомхон байх ёстой бүгдээрээ л цомхон байх ёстой гэдэг. Тэгээд эргээгээд манай томилсон хүмүүсийг халбал арьсыг нь хуулна шүү, таны арьсыг хуулна гэж байна шүү дээ. Тэгэхээр энэ яагаад ийм төр том байгаа юм бэ гэдэг асуудал чинь өөрөө төрийг эв нэгдэлтэй цаашаа явуулахын тулд л том байлгаж байгаа. Улс төрийн намуудын оролцоог л хангахын тулд явж байна. Энэ улс төрийн шийдвэр.

Тэгэхээр энийг та цомхон байлгаж ийм реформыг хийж чадах уу? Энэнтэйгээ холбогдолтой асуулт ч байна. Та төрийг цомхон байлгана гээд ярьж байгаа мөртөө сая хэд хэдэн удаа дурдаж байна. Орон сууцжуулалтын банк байгуулна. Төрд банк байгаа шүү дээ. Төрийн банк гээд. Тэгээд төрийн байгууллагууд төрийн өмчит компани төрийн банк нь ТУЗ-ийн гишүүнийг нь Их Хурлын гишүүд мэддэггүй. Ноднин хуулиараа орж ирээд Төрийн өмчит компаниудын ТУЗ-ийн гишүүдийг нээлттэй болгохыг дэмжээгүй, бараг 100 гаруй ТУЗ-ийн гишүүнтэй юм шиг байна лээ. Эрдэнэс Монгол хэдэн ТУЗ-ийн гишүүнтэй юм мэдэхгүй. Тэгэхээр энэний цаана дандаа улс төрийн тохироонууд явж байгаа. Та энийг өөрчилж чадах уу? Тэгээд энэ олон том бүтэц нь хувийн хэвшилтэйгээ өрсөлддөг өө.

Дараагийн асуулт. Өнөөдөр хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын өдөр. 6 сарын 12-ны өдөр. Баасанжаргал гишүүн танаас аминчлан асуугаарай гэж захисны дагуу асууж байна. Засгийн газрын тогтоолоор хүүхдийн хөдөлмөрийг өвөл, хаврын уралдаанд хурдан морины уралдаанд орохыг хориглосон. Гэхдээ энэ хэрэгжихгүй байгаа. Та үүнийг цаашдаа яаж хэрэгжилтийг нь хангах вэ? Энэ дээр таны байр суурь, таны үзэл бодлыг бас сонсмоор байна аа. Манай ихэнх гишүүд бас морь уядаг болохоороо Монгол хүний сүлд хийморь гэж яриад дэмждэггүй юм билээ.

Д.Амарбаясгалан: За хариулт өгье. Нэр дэвшигч Занданшатар дарга.

Г.Занданшатар: Чинбаатарын Анар гишүүний асуултад хариулъя аа. Би чуулган дээр бол цомхон гэхээсээ илүү зохистой төр гэж ярьж байгаа. Зохистой, үр ашигтай, бүтээмжтэй төрийн тухай ярьж байгаа. Ер нь энэ эрүүл мэндийн салбар ч тэр, боловсролын салбар ч тэр бүтээмж, үр ашгийн тогтолцоо, гүйцэтгэлийн тогтолцоо гэдэг бол санхүүжилтийн ч үндсэн зарчим байх ёстой гэж байгаа юм. Зохистой гэдэг маань мэдээж одоо сургууль, эмнэлгийн тоо нэмэгдээд байна, шинээр бариад байна, тэрнийг дагаад багш, эмч нарын тоо дагана өснө.

Тэгэхээр тэрнийг цомхон болгоод байх нь юу вэ гэж. Цомхон гэдэг агуулгын нөгөө тал дахь ирж байгаа агуулга нь дижитал пост буюу одоо цахим шилжилтийн зарчмаар хиймэл оюун ухаан цахим үйлчилгээ нэвтрүүлэх замаар илүү үр ашигтай, цомхон бүтцийг бий болгоход бол яг тэр чиглэл чиглэлээр нь телемедицинээс авхуулаад и-боловсрол тэгээд бусад чиглэлүүдийн хүрээндээ ярих нь зүйтэй гэсэн ийм цомхон чадварлаг, үр ашигтай, зохистой, цомхон гэхээсээ илүү зохистой гэдэг зарчмыг алсын хараа хөтөлбөрт баримталсан байна аа гэж манай гишүүд ч хэлсэн учраас энэ зохистой гэдэг зарчмаа барих нь зүйтэй гэсэн. Зохистой гэдэг нь ингээд зөвхөн богино хугацаанд таалагдахын тулд алга ташуулахын тулд юм бүхнийг цомхотгоод л байхаасаа илүү үр дүнтэй байхыг, зорилгоо биелүүлсэн байхыг зарчмаа болгоно оо гэсэн энэ агуулгаар тодруулж хэлмээр байна.

Тийм учраас орон сууцжуулалтын банк бол энэ орон сууцны корпорац одоо энэ төрийн бүтцүүд байгаа. Тэр данхайчихсан бүтцүүдтэй харьцуулахад илүү хялбар. Төрийн банкийг ч гэсэн орон сууцны банк болгон төрөлжүүлэх, хөдөө аж ахуйн санхүүжилт, хоршоожилтын санхүүжилтийг ч гэсэн төрөлжүүлэх ийм шаардлагатай уялдуулж хэрэгжүүлнэ. Ийм шаардлагатай уялдана гэсэн зорилгоор энийг тодруулж хэлж байгаа юм.

50 гаруй орон бол ийм тусгай системтэй байдаг. Нэн ялангуяа манайх шиг энэ гэр хороолол, энэ барилга төлөвлөлт, газар ашиглалт, эрэлт нийлүүлэлт нь эмх замбараагүй, барилгын материалын үйлдвэрлэлээсээ авхуулаад барилгын нийлүүлэлт, худалдан авалтын зээлийн схем нь уялдаагүй ийм зохион байгуулалтгүй зах зээлийн бус ийм шахуу ийм зарчим болбол үр ашиг багатай байгаа нь олон улсын туршлагаар нотлогдож байгаа юмаа. Энэтхэг, Тайланд, Өмнөд Солонгос бол яг ийм зарчмаар илүү үр ашигтай эффективный үр ашигтай, үр дүнтэй, бүтээмжтэй хэрэгжүүлсэн жишиг судалгаанууд байгаа юмаа.

Д.Амарбаясгалан: Чинбаатарын Анар гишүүн тодруулж асууя.

Ч.Анар: Та зохистой төр буюу улс төрийн зорилгоор төр, төрийн албан хаагч, улс төрийн албан тушаалтан том байгаа дээр зохистой байлгана аа буюу яг эрс өөрчлөлт хийж чадахгүй юм байна аа. Тэгээд энэ хэцүү. Ойлгож байна.

Хоёрдугаарт та орон сууцны банк буюу нэмж төр банк байгуулахгүй. Төрийн банкныхаа тэр чиг үүргийг төрөлжүүлээд орон сууцжуулалтын зориулалттай болгоно гэж хэлж байна гэж ойлголоо. Би сая таны хариултаас. Хүүхдийн хөдөлмөрийн талаар таны үзэл бодол хэрэгжилтийг хянах талаар хариултаа авч чадсангүй. Өөр нэг тодруулах асуудал бол одоо өнөөдөр бид нар кибер болон мэдээллийн аюулгүй байдлын асуудал үндэсний аюулгүй байдлын хэмжээнд хүрэхээр хэмжээнд ноцтой болсон байгаа. Та энэ чиглэлээр бол нэлээн их ярьдаг хүний хувьд бас үүн дээрээ анхаарахаас зайлшгүй асуудал үүссэн байгаа шүү. Тэгээд хариултаа авъя аа дарга аа.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга нэмэлт хариулт өгье.

Г.Занданшатар: Хүүхдийн хөдөлмөр бол монгол үндэстний ондоошил, ижилсэл, соёлтой бас салшгүй холбоотой. Жишээлбэл морин уралдаанд хүүхэд унуулах юм бол Америкт бол энэ болохгүй хориотой. Гэтэл Швейцарт бол хүүхэд цанаар одоо хөлд орохдоо л адилхан гулгадаг. Тэнд бас л хүүхдийн эрхийн асуудал Альфийн нуруун дээр гулгаж явдаг. Тэгэхээр энэ үндэсний онцлог, ондоошил, ижилсэл бол энэ монгол наадам бол Монгол Улсын бас оюуны дархлаа, монголчуудын олон зуун мянган жилийн олон мянган жилийн энэ уламжлалтай уялдаатай ийм асуудал. Энийг одоо хуулиар зохицуулсан харьцаатай, хуульдаа, тэгээд заачихсан Пүрэвдорж гишүүн тодорхой хэлж байна.

Кибер аюулгүй байдлын тухай хууль бол энэ хүүхдийн хөдөлмөрийн конвенц, хүүхдийн эрхийн конвенцуудаар энэ тодорхой хязгаарлагдсан энийг хуулиар зохицуулчихсан. Энийг Засгийн газар бол хууль биелүүлэх үүрэгтэй учраас тэр хүндээ хэрэгжүүлдэг. Өвлийн уралдаантай энэ ч гэсэн...

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Кибер аюулгүй байдлын асуудлаар Анар гишүүнтэй санал нэг байна. Энэ зохистой төрийн асуудал гэдэг бол алсын хараа бодлогын баримт бичигт тусгагдсан нэр томъёо нь байгаа юмаа. Энэ улс төрөөс үл хамаараад зохистой үр ашигтай байх асуудлыг тэгж томъёолчихсон юм. Тэр кибер аюулгүй байдлаас гадна энэ сошиал мэдээллийн дайн, психологийн дайны хэлбэрт когнитив бор буюу одоо танин мэдэхүй нөлөөллийн үйл ажиллагаанд шилжчихсэн. Ийм учраас кибер аюулгүй байдал, сошиал зохицуулалт, хүний эрхийг хамгаалах асуудал, хиймэл оюун ухаанаар удирдсан сошиал медиагийн энэ асуудлууд бол кибер аюулгүй байдлын салшгүй нэг хэсэг болсон. Энийг зохицуулах шаардлагатай гэсэн тантай санал нэг байна аа.

Д.Амарбаясгалан: Ганбатын Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Манай хангайн бүс нутаг Баянхонгор, Өвөрхангай, Архангай аймгаас бас Архангай аймаг бол одоо бас Монгол төрийн голомт нутаг. Үе үеийн одоо төрийн зүтгэлтнүүд бас одоо Монгол төрийг авч явж байсан хүмүүс энэ бүс нутгаас төрсөн байдаг аа. Тэгээд энэ хүмүүсийн үргэлжлэл болж бас Монгол Улсын

Ерөнхий сайд одоо монгол хангайн бүс нутгаас төрөн гарах гэж байгаа учраас би энэ Занданшатар нэр дэвшигчийг бас дэмжиж байгаа.

Тэгээд хувийн хэвшлээ дэмжих тухай бас бид их олон жил ярьдаг. Тэгээд зарим зүйл маань бас байгаа онодоггүй. Тийм учраас одоо хууль эрх зүйн хувьд, татвар шимтгэлийн хувьд, бодлогын хувьд олон дэмжлэг хувийн хэвшилд байхаас гадна бас энэ хувийн хэвшлийнхээ итгэлийг төрдөө итгэх итгэлийг сэргээх мөн төртэйгөө хамтарч ажиллах, энэ улс орноо босгох ирээдүйн мөрөөдлийг нь бий болгох ийм шаардлага байна гэж үздэг. Тийм учраас энэ таныг Их Хурлын дарга байх үед батлагдсан төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль өнөөдрийг болтол одоо хэрэгжээд нэг олигтой хэрэгжсэн төсөл байхгүй байна л даа. Тийм учраас энэ одоо саяын энэ ажиллаж байсан Засгийн газар бас энэ хуулийг өөрчилж, шинэчлэн найруулахаар ажиллаж байгаа. Тэгээд одоо хугацаа нь дуусаж байна.

Тийм учраас таны Засгийн газар та энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг өөрчилж оруулж ирэх үү? хувийн хэвшилдээ ээлтэй байх талд нь өөрчлөлтийг хийх үү.

Хоёрдугаарт нь хөдөөгийн хөгжлийн асуудал маш чухал байгаа. Өнөөдөр хүн амын тал нь хөдөө орон нутагт амьдарч байгаа мөртөө ихэнх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт гол гол ажлууд хот руу хийгдээд байдаг. Тийм учраас ер нь энэ хүн амын тал нь амьдарч байгаа энэ хөдөө орон нутгийг хөгжүүлэх, хөдөөгийн хөгжилд онцгой анхаарах хэрэг байгаа. Тийм учраас энэ улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хөдөө орон нутагт бас оновчтой байлгах, хөдөө орон нутагт одоо хүн амьдрах таатай орчныг бий болгохын тулд наад захын инженерийн шугам сүлжээ, халуун, хүйтэн устай болгох, замтай болгох зэрэг энэ ажлуудыг бол одоо заавал эдийн засгийн үр ашиг, ашиг хонжоо хайхгүйгээр хиймээр байна аа. Тэгэхгүй бол зарим том бүтээн байгуулалт, зарим ажлыг ярихаар эдийн засгийн үр ашиг, ашиг хонжоо яриад байдаг. Үнэхээр энэ Монголын өргөн уудам нутагт тархан суурьшиж байгаа монголчуудыг нутагтаа аятай, тохитой амьдрах орчныг бүрдүүлэхэд бол ашиг гарахгүй нь ойлгомжтой.

Тийм учраас энэ нийгмийн ач холбогдлоо бодоод энэ том ажлуудыг хийх ёстой гэж бодож байна. Тэгээд мөн одоо энэ манай хангайн бүс нутаг дээр шинэ Хархорин хот байгуулагдана. Үүний хөрөнгө оруулалтыг ер нь яаж шийднэ гэж та харж байгаа вэ? Мөн одоо энэ 10 аймагт хэрэгжиж байгаа нэг 10 гаран жил яригдаж байгаа дулааны станцын асуудлууд байгаа. Эдгээрийг нэг та Ерөнхий сайд болсон дээрээ шийдээд дуусгаад ажил болгоод өгөөрэй гэж хүсье ээ. Тэгээд танд амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Нэр дэвшигч.

Г.Занданшатар: Ганбатын Хосбаяр гишүүндээ баярлалаа. Тодорхой бодит ажил хэрэгч санал санаачилгууд дэвшүүллээ. Тэр дотроо Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль бол арай чангадаад байгаа юмаа. Энийг бас шинэчлэх шаардлагатай. Хувийн хэвшлээ дэмжье гэдэг бодлого бол төр, хувийн хэвшлийн тэмцлийг илүү нээлттэй хялбаршуулахад ч байж энэ явах юм билээ. Одоо түүнчлэн хувийн хэвшлийн хийх боломжтой ажлыг төр хийхгүй байх зарчим баримтлах шаардлагатай. Төрийн зарим үйлчилгээний чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх шаардлагатай. Мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх шаардлагатай. Эдийн засагт хувийн хэвшлийн оролцоог тэгж нэмэгдүүлэх шаардлагатай. Үүний тулд жижиг, дунд

бизнес эрхлэгчдийг дэмжих, инновац, бүтээмжийг дэмжсэн эрх зүйн шинэчлэл хийх шаардлагатай.

Одоо Мэдээллийн технологийн эрх зүйн салбарыг дэмжих тухай хууль маань татварын бодлоготой уялдахгүй болохоор дэмжлэг нь хэрэгждэггүй. Тэгэхээр татварын бодлоготойгоо бүгдийг нь уялдуулж татварын реформоо бас хийх шаардлагатай. Бүсчилсэн хөгжлийг дэмжих татварын бодлого шаардлагатай. Мөнгөний бодлого бүсчилсэн хөгжлийн бодлогоо бас дэмжих шаардлагатай. Ингэж байж хангайн бүс одоо Архангай аймгийн аялал жуулчлал тэр хөгжлийн алтан гурвалжин гээд байгаа 3 аймаг дамнасан дэд бүтэц аялал жуулчлалын бодлого бол хэрэгжиж байж хангайн бүс бол бас шинэ суурьшлын бүс. Түүх соёл археологийн том төв утгаараа болж байж Улаанбаатарын төвлөрөл саарч, улс орны нөгөө Улаанбаатар улс болох гээд байгаа энэ нэг тэнхлэгийн таталцлалыг шинэ төв болгож хөгжүүлэхэд бүхий л утгаараа бас хангайн бүс чухал үүрэг гүйцэтгэх ёстой. Нэн ялангуяа Хархорин хотыг хөгжүүлэхэд шинэ хөрөнгө оруулалт, шинэ дэвшил, одоо боломж хэрэгжих ёстой. Энэ дээр одоо манай энэ хангайн бүсийн гишүүд бас Хархорин хотын бүтээн байгуулалтад дэмжиж оролцох, идэвхтэй оролцох талаар ажиллахыг хүсэж байна аа.

Д.Амарбаясгалан: Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Оройн мэнд ээ. Яах вэ сүүлийн үед бас намайг тэгээд байгаа юмаа. Та МАН-ыг их шүүмжилдэг хүн, энэ чинь бас өөрчлөгдөөд байна уу гээд яриад байгаа юм. Мэдээж хэрэг ажил хэрэгч шүүмжлэл байна аа, дэмжих ч асуудал байна аа. Энийг дандаа л одоо бас болохгүй, бүтэхгүй талаас нь яриад байж болохгүй ээ.

Занданшатар дарга бол бас улс орноо мэднэ ээ. Танд бол мэдэхгүй чадахгүй гэх зүйл байхгүй ээ. Баянхонгор аймгаас, Хонгор нутгаас та одоо 4 удаа ард түмний итгэлийг хүлээж сонгогдсон. Сая ч гэсэн бас сонгуульд оролцоод Архангай, Өвөрхангайгаас нэлээн их санал авсан. Урдуураа нэг хэдхэн хүний зөрүүтэй л ингэсэн байгаа байх. Одоо цөөхөн хугацаа үлдэж байна аа. Дараагийн сонгууль болтол. Тэгэхээр энэ хооронд одоо ямар ажлуудыг хийж амжуулах вэ гэдэг нэн тэргүүнд. Нөхцөл байдал бол одоо хүндэрчихсэн байгаа, амаргүй байгаа. Өмнөх Засгийн газрын хэр ажиллаж байсан, ямар байж байсан гэдгийг бол 2, 3 сарын дараа л ийм байжээ гээд эхлээд л илрээд эхлэх байх аа.

Одоо таны нэн тэргүүний Ерөнхий сайд болсны дараа бол таны бүрэн эрх хуулиар бол Засгийн газраа бүрдүүлэхээс эхэлнэ л дээ. Энэ одоо 126 гишүүнтэй олон намтай парламент л гэж байгаа юм л даа. Манай 2 нам бол одоо өсөж бойжиж байгаа, шинэ нам юу билээ Үндэсний эвсэл нам, Үндэсний эвсэл нам нөгөө Иргэний Зориг нам. Энэ 2 маань одоо мандатгүй ээ, бас жагсаалтаар орж ирсэн. Энэ бас зүйтэй, зөв. Нөгөө Хүн нам, би Хүн намынхныг, эх эцэг нь ч танихаа больчихсон байх аа л гээд байгаа найз нөхөд нь. Манай Золжаргалаас бусдыг нь. Тэгээд энэ хэд маань бас өсөж бойжиход хугацаа хэрэгтэй, цаг хугацаа хэрэгтэй, арай болоогүй байна л даа.

МАН-д бол би хүндэтгэлтэй ханддаг аа. 100 жил болсон, Ази тивдээ ууган. Манай АН ч уг нь алдаж оноод л бас эрийн цээнд хүрчихсэн ийм нам л даа 30-аад жил болчихсон. Өнөөгийн нөхцөл байдал их хүнд хэцүү байна аа. Эндээс бол та стандарт бус шийдвэр гаргах ёстой. Тэгж шаардаж байна. Нэг жилийн өмнөхтэй адилгүй байна шүү дээ. Тэгээд тулалдаанд шонхрууд ниснэ ээ л гээд байгаа юм.

Тулалдаанд одоо шонхруудаас шонхрууд ч биш л дээ, хашрууд нисдэг л дээ, тийм хашрууд нисдэг. Тэгэхээр одоо энд зохицуулаад та Засгийн газраа бүрдүүлэх хэрэгтэй.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Нэр дэвшигч Занданшатар дарга.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүний асуултад хариулъя аа. Санал нэг байна аа, сайхан санаачилга байна аа, бид эвлэвэл бүтнэ, ховолол гутна гэж бидний улс эв саналаа нэгтгэвэл одоо мэдэхгүй чадахгүй хэмээх зүйл үгүй болж олон ажлыг хамтдаа хийж хэрэгжүүлж энэ хүнд цаг үеийг давах боломжтой. Ийм учраас тантай санал нэг байна аа. Энэнд бол мэдлэг туршлага чухал аа. Одоо ажилтай ахиад л танилцаад л, ахиад л 6 сар, 7 сар биш шууд ажилдаа ороод л маргаашаас төсвийн тодотголоо маргаашаас энэ яриад байгаа хөгжил дэвшлийн хуулиудаа хэрэгжүүлээд үргэлжлүүлээд явах нь зайлшгүй чухал. Яагаад гэвэл энэ өнөөгийн гадаад нөхцөл байдал тэгж шаардаж байгаа. Гаднаа хүйтэрч байхад дотроо дулаан байх ёстой. Одоо түрүүн Анар гишүүний хэлсэнчлэн манай өрх болгон эрчим хүч үйлдвэрлэгч болох Карбон трэйдиг буюу одоо хөнгөлөлттэй зээл, хүлэмжийн хийг бууруулах энэ боломжуудыг хэр гаргах, эрчим хүчний шинэчлэл хийх олон боломжууд байна. Энэ боломжуудыг алдахгүйн тулд хурдтай ажиллах шаардлагатай.

Ийм учраас бид бол бужигнуулж богино хугацаанд алга ташуулж, ард иргэдэд таалагдах гэхээсээ илүү урт хугацаанд үр дүнд хүрэх шинэчлэлүүдийг хэрэгжүүлэхийн тулд өнөөдөр гашуун ч гэсэн маргааш үр дүнд хүрэх бодит чиглэлүүдийг хэрэгжүүлж өнөөдөр таалагдахгүй ч гэсэн маргааш үр дүнтэй байх бодлого чиглэлийг баримталж ажиллана гэж бодож байгаа. Шинэ Засгийн газрын нэн тэргүүнд хийх ажил бол энэ бараг гал унтраахад чиглэгдэж байна. Инфляцыг хязгаарлахад, иргэдийн амьжиргааг дэмжих бодит арга хэмжээ авахад төсвийн үр ашгийг сайжруулж алдагдлыг бууруулахад, төрийн бүтцийг одоо зохистой болгоход, эрчим хүчний энэ хямралтай байдлаа шуурхай шийдвэрлэхэд, 3 дугаар цахилгаан станцад болсон энэ асуудлууд эрчим хүчний хямрал одоо манайх 76 хувийг дотооддоо хангаж байна. Үндсэндээ 193 сая долларын импортоор авч байна. Тэгтэл эрчим хүч экспортлогч улс болох бүрэн боломж байна.

Үндэсний баялгийн сангаа бодитой хэрэгжүүлж, авлигын эсрэг шийдэмгий арга хэмжээ авахад ийм нийгмийн хүлээлт байгаад тохирч, нийцэж ажиллах ийм шаардлага байна аа. Ийм учраас нэг их сайхан сайхан яриад, өнөөдөр нийгэмд тааруулж алга ташаад л, сошиалд тааруулж нэг их мундаг цомхон болгох гээд аль эсвэл шинэ шинэ гоё нэр гаргах гээд байхдаа гол биш засгийн ажилд нэг 3 жилийн дараа бодит үр дүн гаргахад ядаж чиглэгдсэн тийм арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Тэгэхгүй бол өнөө маргаашаа аргалж явсаар байтал чинь ирээдүй урт хугацааны шийдлүүд хоолой дээр эрчим хүчнээс авхуулаад хутга тулгаад, хүндрэлтэй болчихоод байна. Дандаа өнөө маргаашаа аргалж сошиалд тааруулж ингэж явдаг хэлбэр маань урт хугацааны хүндрэлүүдийг бий болгочихсоны яруу тод жишээ нь 3 дугаар цахилгаан станц дээр болсон дэлбэрэлт гэж бодож байна, тэлж болно. Энэ 3 толгойтой болчихсон хариуцлага эзэнгүй болчихсон. Ийм учраас бид нийгмийн хүлээлтэд нийцэж, хурдтай, тогтвортой, үр дүнтэй засаглалыг эрхэм болгоно гэж бодож байгаа юм.

Д.Амарбаясгалан: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Эрчим хүчний асуудал хүнд байгаа. Тэгэхээр та эрчим хүчний асуудал дээр бол онц байдал зарласан нь дээр байх аа гэсэн ийм бодолтой байна. Энэ гадагшаа гаргаж байгаа уул уурхайн экспорт маань нүүрсний хувьд бол одоо 1.3 тэрбум долларын алдагдалтай байна аа, хүрэхээ байсан байна. 32 сая тонн нүүрс гаргасан гэж байгаа. Хэдийгээр алтны үнэ өндөр байгаа боловч нэг 500 сая доллароор нэмэгдсэн байна лээ. Өнгөрсөн оноо бодоход. Зэсийн хувьд, алтны хувьд бид нар 20 тонныг гаргадаг байсан бол энэ жил одоо нэг 7, 8 тонн ингэж гардаг болсон байна аа. Энэ дээр ямар ямар арга хэмжээ авч ажиллах вэ? Би байхдаа 2012-2014 онд тэр татварыг 2.5 болгосон юм. Бүгд л эсрэг байсан. Амьдрал дээр дараагийн жил бол 20 тонн алт авсан шүү. Хэрэв Оюу Толгойг одоо энд хамруулж чадах юм бол бид нар 40 тонн алт авч чадна аа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Ренчинбямбаагийн Сэддорж гишүүн асуулт асууя.

Р.Сэддорж: Өдөр бас бүлгийн хурал дээр асуусан. Энэ 14 мега төслийн нэлээн дээгүүр эрэмбэлэгдэж байх ёстой усны төсөл байгаа. Тэгээд Хэрлэн тоонот, Орхон онги гээд. Тэгээд Монголчуудад Монголын үйлдвэрүүд газрын гүний усыг хэмнэх цаг нь болсон. Тэгээд ийм учраас Засгийн газар энэ үйл ажиллагааны хөтөлбөртөө оруулсан 14 их төсөл гэж нэрлэсэн. Энэ төслийгөө одоо та үргэлжлүүлэх үү? Энийгээ одоо номер 2-т эхлүүлэх ямар боломж байна вэ? Говийн бүсийн ард түмэн бол одоо энийг л хүлээж байгаа.

Дээрээс нь Орхон Онги, Онги, Цагаан бургастай гээд шинэ төслийг эхлүүлсэн байгаа. Энэ дээр санамж бичиг бүх зүйлийг энэ 2 бүсийн гишүүд, Байгаль орчны яам санаачлаад Одонтуяа сайд хийсэн байгаа. Энэ дээр та анхаарлаа хандуулж Байгаль орчны Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам бол энэ төсөл л одоо арай хурдан эхэлж байж болохоор юм байна гэж судлаад ингэж шийдсэн байх. Тэгээд энэ 2 дээрээ та нэг хариулт өгөөч ээ.

Дараагийнх нь энэ Монгол Улсын орлого олж байгаа гол боомтууд, экспорт хийж байгаа хамгийн том боомтууд импортоор орж ирж байгаа импорт хийж байгаа одоо хамгийн том боомт, Замын-Үүдийн боомт, Замын-Үүд, Улаанбаатарын замыг та яаралтай шийдэхгүй бол үнэхээр өрөвдөлтэй. Хамгийн их ачаа явж байгаа монголчуудын гол бараа явж байгаа замыг та нэг очоод ажиглаарай. Та Улаанбаатар, Дундговь, Даланзадгад, Тавантолгой, Оюу Толгой, Нарийн сухайт явж байгаа тэр замыг нэг ажиглаарай. Ямар хүндрэлтэй байна? Нүүрс одоо эрчим юуны шахмал түлшний нүүрс зөөсөөр байгаад ийм болсон. Та Гашуунсухайтын боомтыг 10 гаруй мянган хүн амьдарч байгаа. Тэнд одоо нэг ч эмнэлэг байхгүй гэдгийг танд хэлье ээ. Тэнд эмнэлэг одоо үеийн төсөв дээр ерөөсөө суудаггүй. Тэгээд эдгээр асуудлууд дээр та анхаарлаа хандуулаач ээ. Энэ дээр бас нэг өөрийнхөө санаа бодлыг хэлээч ээ. Тэгээд иргэдтэй, аймгуудын иргэдтэй яаралтай уулзаач ээ, сайдуудаа энэ аймгуудаар явуулж, ард иргэдтэй уулзалт зохион байгуулах уу гэсэн ийм асуултууд байна.

Д.Амарбаясгалан: За хариулт өгье. Нэр дэвшигч.

Г.Занданшатар: Ренчинбямбаагийн Сэддорж гишүүний асуултад хариулъя аа. 14 мега төсөл дотор говийн бүс рүү гадаргын ус татах Хэрлэн тоонот, Орхон онгийн төсөл Засгийн газраас хэрэгжүүлэх ийм 14 төслийн одоо тэргүүн ээлжид багтсан. Орхон Онги төслийн дэд төсөл болох Онги цагаан бургастай усан

цогцолборын нээлт Төрийн ордонд болж байсан, болсон. Энэ 2 том төсөл нийлээд нэг 4.5 их наядын төсөвт өртөгтэй юм билээ. Энэ дотроо ТЭЗҮ-г нь нээх 7.6 тэрбум төгрөг байх аа. Хэрвээ алдаагүй бол төсөвт өртөгтэй тендер зарлагдаад тэгээд шалгаруулалт дээрээ бас асуудал үүсээд хойшлогдсон гэж бодсон. 2 компанийн нэр яваад. Энэ ТЭЗҮ-гээ эхний ээлжид хэрэгжүүлэх бололцоотой. За энийг сая яг саяны хэлээд байсан төр, хувийн хэвшлийн түншлэлээр босговол илүү үр дүнтэй, түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр хэрэгжүүлж болно.

Ер нь энэ 6 дугаар сардаа багтаагаад энэ төслийг яаралтай эхлүүлэх, шалгаруулалтыг нь зарлагдаж хэрэгжих бололцоотой. Хэрлэн тоонот төслийн хувьд бол арай хэрэгжих болоогүй, ТЭЗҮ нь ч хийгдээгүй, дотоодын ойлголцол санхүүжилтийг хэрхэн шийдэх асуудал нь тодорхойгүй байгаа юм байна лээ. Тийм учраас энэ мега төслүүд дотроос бас усны асуудал бол тэргүүлэх ач холбогдолтой. Ус дэд бүтцэд байж байж говийн бүс энэ уул уурхайн өмнийн говийн энэ том төслүүд бодитой үр дүнтэй хэрэгжих, нөгөө аж үйлдвэрийн парк цогцолборууд хэрэгжих бодит нөхцөлүүд бүрдэнэ ээ.

Ер нь алт төслийн хувьд бол харьцангуй алт гэх хөтөлбөр зарлаад байгаа боловч үр дүн 3.4 тонн алт Монгол банканд тушаагдсан бол харьцангуй чамлалттай үзүүлэлт. Манай валютын нөөцөд чухал үүрэг гүйцэтгэх ёстой алтны олборлолт бол харьцангуй сул байна. Оргил үедээ манайх нэг 21 тонн алт Монгол банканд тушааж байсан. Өдий хэв сарын байдлаар бол заримдаа 7, 8, 10-аад энэнээс 2 дахин их байсан хугацаатай. Боомтын асуудал бол Замын-Үүдийн манай хамгийн том зангилаа боомт оо. Манай эдийн засгийн хамгийн чухал боомт.

Тийм учраас Замын-Үүдийн нэвтрүүлэх чадварыг сайжруулах, эдийн засаг, нийгмийн үр өгөөжөөр эрэмбэлэхэд бол уул уурхай энэ боомт бол чухал ач холбогдолтой. Тэгэхдээ уул уурхай экспортын хувьд бол Гашуун сухайт, Шивээхүрэнгийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэн түрүүнд чиглүүлэх. Хүнс, барааны эргэлт ихтэй боомтуудад бол Замын-Үүдийн үйлчилгээ, хяналтыг сайжруулах, цахимжуулах, бараа эргэлт, ачаа эргэлт нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулах, дэд бүтцийг сайжруулах ажлыг үргэлжлүүлж, эрчимжүүлэх шаардлагатай гэж үздэг юм байна аа.

Д.Амарбаясгалан: Сэддорж гишүүн тодруулж асууя.

Р.Сэддорж: Зарим аймгуудын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд АН-аас сонгогдсон Иргэдийн хурлын төлөөлөгч нар тооны хувьд, одоо Хурлын хувьд Засаг даргаа сонгох томилолт хийх ийм боломжтой болчихсон байгаа. Нэг, хоёр аймаг байгаа. Тэгээд энэ дээр та ямар бодлого барьж ажиллах вэ? Тэгээд энэ одоо ард иргэдийн төлөөлөл болсон тэр аймгийн иргэдийн хурлуудыг одоо та хэр анхаарах вэ. Энэ дээр одоо ямар бодлого барих вэ гэдгийг асууя.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч хариулт өгье.

Г.Занданшатар: Уучлаарай энэ асуудлыг яг сайн сонссонгүй. Танд дараа жич уулзаад маргаашийн хуралдаан дээр дэлгэрэнгүй хариулт өгье өө.

Д.Амарбаясгалан: Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуулт асууя.

Р.Эрдэнэбүрэн: Оройн мэнд хүргэе. Олон асуултууд давхацсан учраас маш товчлоод хоёрхон асуулт асуух гэсэн юмаа. 1990 онд энэ 2 туйлт ертөнц өөрчлөгдөөд маш олон орон болбол олон намын системтэй сонгуультай ийм Үндсэн хуультай систем рүү олон орон шилжсэн байдаг. Тэгээд тэндээсээ их олон орон буцсан. Одоо болбол ямар нэр томьёо илүү их явж байна вэ гэхлээр сонгогдсон дарангуйлагч гэдэг ийм нэр томьёо хүртэл гарсан. Тэгээд ямар байдлаар арга замаар буцаж байна вэ гэхлээр нэг том намтай тойруулаад хэдэн жижиг намтай тэгээд олон намын системтэй юм шиг мөртөө нэг нам нь дандаа ингээд ялж байдаг ийм байдлаар энэ маш олон орон болбол нөгөө ардчиллаас, энэ парламентын системээс болбол буцаж байна аа гэж ингэж харагдаж байгаа.

Тэгээд манайд ч гэсэн ийм үзэгдэл болбол сүүлийн хэдэн жил их хүчтэй явж байгаад ялангуяа сая энэ Үндсэн хууль өөрчлөөд тэгээд одоо энэ сонгуулийн дараа бол Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын баримталсан бодлого болбол энэ чиглэлээс тийм зугтаах өөрчлөх ийм хандлага барьж ажиллалаа гэж ингэж боддог. Сөрөг хүчнээ одоо маш зоригтойгоор бас бэхжүүлэх ийм юм руу явсан гэж боддог. Тэгээд та энэ талаар бол ямар бодолтой байдаг вэ? Ер нь бид одоо ийм аюулд хүрсэн үү, цаашдаа яах ёстой вэ энэ талаар ямар бодолтой байна вэ гэдгийг бас нэгдүгээрт сонсох гэсэн юм.

Хоёрт болбол ер нь бид нар бас ингээд бүгдээрээ л улс орноо өөрчилье хөгжүүлье гээд ингээд явж байгаа. Бидэнд болбол хамгийн том саад болж байгаа зүйл болбол мэдээж одоо мөнгө төгрөгөөс гадна иргэдийн энэ хандлага сэтгэлгээг өөрчлөх чиглэлээр бол юу ч хийж чадахгүй яваад байна аа л гэж ингэж бодож байгаа. Зам гүүр том төслүүд яриад байгаа болохоос биш нөгөө л нэг хуучин төр бүгдийг нь хийх ёстой гээд ярьдаг. Хамтраад юмаа хийе ээ гэж боддог тэр сэтгэлгээ байхгүй. Энэ чиглэлээр ер нь олигтой ажил хийж чадахгүй байгаагаас болоод маш их олон ажлууд фэйлдэж байна аа гэж ингэж харж байгаа. Энэ талаар та ямар бодолтой байна вэ гэсэн ийм хоёрхон асуулт асууя аа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Нэр дэвшигч.

Г.Занданшатар: Равжихын Эрдэнэбүрэн гишүүний асуултад хариулъя аа. За ер нь ерээд он болбол ардчиллын 3 дахь давлагааны эрин үе. Өнөөдрийн Фрийдом хаус болон Видом мокс индексийн алийг нь ашиглах талаар бол 2 зөрүүтэй тайлбар өнөөдрийн парламентын мэтгэлцээн дунд өрнөж байна. Монголын ардчилал 2015 онд бид ухралтын шинж чанартай боллоо. Ардчиллын гол унагаах байгаа үзүүлэлт нь авлига, хариуцлагагүйн байдал, сонгуулийн системийн доголдол гэж шүүмжилж энэ талаар мэтгэлцээн бид өрнүүлж байсан.

Ийм ч учраас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бол парламентын ардчиллаа төгөлдөршүүлэх, төлөвшүүлэх энэ сонгуульд өрсөлдөөнт олон намын өрсөлдөөнт хэлбэрийг илүү төгөлдөршүүлэхийн тулд л өнөөдрийн энэ Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт хийгдэж, үр дүнд нь харьцангуй олон парламентын намтай харьцангуй репрезентити тернис буюу одоо төлөөллийн чадавх сайжирсан ийм парламенттай болж байгаа нь ардчиллын үзүүлэлтүүд сайжирч байгаа үзүүлэлт гэж бодож байна. Харин энийгээ бид өөрсдөө клантклизм буюу одоо энэ хуйвалдаан, эрх мэдэл, танил тал харсан системээр хэт буруу тийш нь хөтөлчихгүй байж энэ парламентын ардчилал Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй илүү үр дүнтэй хэрэгжүүлэхэд энэ эдийн засгийн үр өгөөж болгож ард иргэдээ хүртээмжтэй болгож байж энэ ардчилал маань бэхэжнэ, батажна, бусад системтэй харьцуулаад байна. Энэ утгаараа бас

ухралтууд бий болж байгааг бас үгүйсгэхгүй. Энэ чиглэлээр манай Эрдэнэбүрэн гишүүн бас олонтоо ярьж хэлдэг хүн. Энэ чиглэлээрээ анхаарч тэмцэж ажиллана байх аа гэж бодож байна аа.

Парламентын тогтолцоогоо бид дэмжиж, улам л төгөлдөршүүлж, 8 жилийн хугацаанд улам сайн болгож энэ парламентын системээ улам баталгаажуулах хэрэгтэй. Нэг, хоёр намын давамгайлал биш олон улсад сонгуулийн системээ гажуудлын нийтлэг үр дүнг засаад одоо улам л энэ чиглэл рүүгээ зөвлөлдөх ардчиллаар ард иргэдийг ухамсартай мэдээлэлтэй, тэнцвэртэй мэдээлэлтэй, нотолгоонд суурилсан, мэтгэлцээнд суурилсан ийм мэтгэлцээнтэй парламентын тогтолцоог дэмжиж ирснээр бол манай парламентын ардчиллын үзүүлэлтүүд улам сайжирна. Сүүлийн үед сайжирч байгаа. Үзэл бодлоо илэрхийлэх эрх, сонгуулийн өрсөлдөөн харьцангуй чөлөөтэй байна. Олон нийтийн хяналт, иргэний нийгмийн оролцоо нэмэгдэж байна. Залуучуудын оролцоо ил тод байдлын соёл бэхжиж эхэлсэн нь эерэг хандлага гэж бодож байна аа.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхбат: Бүгдэд нь оройн мэнд хүргэе ээ. Нэр дэвшигчээс зарим нэг ганц нэг асуултууд давхардаж байгаа ч гэсэн нэмж тодруулах зүйлүүдээс асууя аа гэж ингэж бодсон юм. Таны хувьд болбол туршлагын хувьд одоо эргэлзэж байгаа юм уу, итгэхгүй байгаа тийм хүн бол гарахгүй байгаа байх гэж бодогдож байгаа. Одоо олон салбарт олон институцэд удирдах ажил хийсэн ийм хүний хувьд өнөөдрийн энэ асуултад хариулж байгаа байдлыг харахад ч гэсэн бас үнэхээр ажлаа мэдэж байгаа, асуудлуудаа бол бүрэн дүүрэн ойлгож байгаа ийм байдлаар хариулт өгч байгаад бол бас талархалтай хандаж байна.

Нэгдүгээрт, миний асуух гээд байгаа нэг зүйл энэ бизнесийн орчныг сайжруулах тал дээр, дээрээс нь энэ татварын шинэчлэлийг хийх тал дээр одоо ямар арга хэмжээнүүд авах вэ гэдгийг л маш олон бизнес эрхлэгч нар энэ хувийн хэвшлийн олон аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл бол харж байгаа байх аа гэж ингэж бодогдож байгаа юм. Тэгэхлээр зэрэг ялангуяа энэ нэмэгдсэн өртгийн албан татварын хувь хэмжээг өөрчлөх тэгээд нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх өөрчлөх тал дээр та одоо ямар арга хэмжээ авах вэ гэдгийг нэгдүгээрт асуухыг хүсэж байна.

Хоёрдугаарт манай энэ говийн бүс нутаг одоо байгаль орчин энэ уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртөж байгаа ийм бүс нутаг. Тэгээд энэ байгаль орчинтой холбоотой саяын одоо энэ гишүүдийн яриад байгаа энэ усны төслийг хэрэгжүүлэх энэ тэр гээд ингэхлээр зэрэг эцсийн бүлэгтээ бол эдийн засаг дээр очоод гацчихдаг. Саяын таны ярьсан тэр 7.6 тэрбум төгрөгийн ТЭЗҮ болбол нөгөө Хэрлэн тоонот дээр Эрдэнэс Оюу Толгой компанийн зарласан Хэрлэн тоонот дээр хийгдэж байгаа төслийг л та Орхон онгитой андуураад хэлчхэв үү гэж надад бол сая бодогдчихлоо.

Тэгэхээр зэрэг би юу хэлэх гэсэн юм гэхлээр зэрэг ер нь энэ Өмнөговь аймгаас ч бай, ер нь говийн бүс нутгаас энэ улсын төсөвт татаж төвлөрүүлээд байгаа. Түрүүн Наранбаатар гишүүн хэлж байсан. 3.4 их наяд төгрөгийг АМНАТ-ын татварт аваад байдаг. Дээрээс нь 1.7 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлээд байдаг. Энэ мөнгөний тодорхой хувийг орон нутагт үлдээгээд, тэндээс нь одоо энэ

шаардлагатай байгаль орчны юм уу, бусад одоо чухал төслүүдээ хэрэгжүүлээд явах ийм боломжийг бол олгож өгөх тал дээр таны байр суурийг бас сонсмоор байна.

Хоёрдугаарт, энэ халамжаас хөдөлмөр лүү шилжих тал дээр бид нар одоо ямар бодлого барих вэ? Жишээ нь таны Засгийн газар. Ямар бодлого барих вэ? Одоо бид нар болбол яг үнэндээ халамжийн хэмжээ болбол хэтэрхий их байна, хөдөлмөрт одоо дургүй байна гэдэг ийм шүүмжлэл бол байнга явж байдаг болохлоор зэрэг энэ дээр одоо таны байр суурийг бас сонсьё гэж ингэж бодож байна. Нэг минутаа нэмээд авчихъя дарга аа.

Гуравдугаарт нь, энэ сэргээгдэх эрчим хүчийг бол одоо бид нар хөгжүүлнэ. Сэргээгдэх эрчим хүчийг энэ төслүүдийг гадна, дотнын хөрөнгө оруулалтуудыг бид нар одоо авна, авчирна гээд л одоо зөндөө олон жил, бас энэ үе үеийн сайд нар л яриад байдаг. Яг амьдрал дээр бол хэрэгжээд байгаа юм байдаггүй. 2019 онд энэ Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулаад, энэ эрчим хүч дамжуулах сүлжээнд холбогдон ажиллах, сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төслийг үнийн саналаар нь өрсөлдүүлэн сонгон шалгаруулна аа гээд нэг нэмэлт, өөрчлөлт орсон юм байна лээ. Гэсэн энэ нэмэлт, өөрчлөлт орсон цагаас хойш нэг ч төсөл сонгон шалгаруулаагүй өнөөдрийг хүртэл ингээд гацчихсан.

Олон компани, аж ахуйн нэгжүүд энэ дээр гаднын хөрөнгө оруулагчид авчраад ингээд ажил эхлүүлээд явах гэдэг. Ингээд өнөөдрийг хүртэл ингээд 5, 6 жил ингээд гацаатай хэвээрээ ингээд яваад байдаг. Тэгээд энэ тал дээр таны бас реформ шинэчлэл хийх одоо ийм байр суурийг бас...

Д.Амарбаясгалан: Хариулт өгье нэр дэвшигч.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүний асуултад хариулъя аа. Татварын реформын асуудлаар. Татварын реформыг татварын байр суурийг өргөжүүлж, татварыг тэгш, шударга болгоход л хамгийн гол нь чиглэгдэх ёстой гэж бодож байгаа. Учир шалтгаан юу вэ гэхээр одоо хүн болгон мэднэ. Ямар ч дэлгүүр үйлчилгээний газар очсон НӨАТ-тай авах уу, НӨАТ-гүй авах уу гэж асуудаг болчихсон. Тэгвэл НӨАТ-гүй болбол 5хувь, 10 хувь хямдардаг.

Ингэхээр нөгөө татвар төлдөггүй шударга бус хэсэг нь хожоод, татвар төлдөг шударга хэсэг нь хохироод байдаг өрсөлдөх чадвараа алддаг ийм тогтолцоо болчихоод байгаа юм. Энэ дотроо хамгийн их хэлмэгдэж байгаа нь үйлдвэрлэгч нар. Үйлдвэрлэгч нарын НӨАТ тооцоо, баримт бол тодорхой байдаг. Яагаад гэвэл одоо машин тоног төхөөрөмж бүх юмаар нь хэмжээд гарчихдаг. Импортлогч нар бол тодорхой биш манай гаалийн ил тод авлигал, гаалийн татвар, импортын татвар тэрнийгээ дагаад НӨАТ-аа төлөхгүй орж ирж байгаа байдал бол урд, хойд хилийн Алтанбулаг, Замын-Үүдийн боомт дээр гаальтай, гаальгүй машинаас авхуулаад бизнес эрхэлдэг бүх хүмүүс бараг ярьдаг.

Ингэхээр импортлогчид илүү давуу тал олгоод байгаа учраас импорт чинь эдийн засгийг давамгайлаад, валютын ханшийг хөөрөгдөөд, нөөцөд дарамт учруулаад, энэ их хүндрэлийг бий болгоод байгаа юм. Ийм учраас би НӨАТ-ын буцаан олголтыг нэмэгдүүлэх замаар НӨАТ-ыг тэгш шударга төлдөг зарчим болгочих юм бол үндэсний үйлдвэрлэгчдэдээ ч ашигтайтай, ажил олгогчдодоо ч ашигтай ийм тогтолцоог бүрдүүлэхийг зорьж татварын реформын гол чиглэл нэг жилийн хугацаанд ч байсан хамаагүй энэ өөрчлөлт хийх ёстой гэж үзэж байгаа.

Одоогийн хуулиар бол НӨАТ-ын иргэдийн буцаан олголтын хөнгөлөлтийг 100 хувь, 50 хувь, 20 хувь болгож хэрэглээнээс хамаарч чадалтай болгохоор тусгасан байна лээ. Энэ нэг 1.4 их наяд орчим төгрөгийн төсвийн ачаалал авах юм байна лээ. Одоо 168 мянган төгрөгийн НӨАТ төлж байгаа хүн 145 мянгаар одоо нөгөө 300 мянга хүртэл бол ингээд энэ хөнгөлөлт эдлээд арай бага ачаалалтай болно гэсэн ийм тооцооллууд хийгдэж байгаа. Тэгэхдээ энэ хэрэгжилтийн хувьд бас хүндрэлтэй байх магадлалтай.

Ийм учраас энийг нарийвчлан Ерөнхий сайдаар томилогдсон нөхцөлд Сангийн сайд, Сангийн яамныхантайгаа сууж, тооцооллыг нарийвчилж харна. Ер нь бүх бараа НӨАТ-тай И-баримттай шударга болчихвол татварын бааз суурь өргөжөөд тэлээд, үр дүнд нь татварын нийтлэг ачаалал дарамт буурах энийгээ дагасан олон төрлийн татварын чөлөөлөлт босохоос хамаарсан тэр НӨАТ-тай бараа, НӨАТ-гүй бараа гэдэг нөгөө бизнес эрхлэгчдийн транзакц зардал, бизнесийн зардал буурах гэх мэтчилэн олон эерэг талыг бий болгоно. Энийг 2015 онд энэ буцаан олголтыг хэрэгжүүлэх үед бас НӨАТ-ын орлого буурна гэж тооцож байсан боловч нэмэгдсэн далд эдийн засаг ил болсон олон баримт судалгаанууд нотолдог. За ингэснээрээ бас одоо би иргэддээ татварын дарамт үзүүлэхгүйгээр хэт энэ ялгааг багасгасан, хэт тансаг хэрэглээний буюу өндөр татвар Улаанбаатарын түгжрэлийг бууруулахад чиглэгдсэн төвийн байрлалын үл хөдлөх хөрөнгийн татварыг нэмэгдүүлэх гэх мэтчилэн ийм татварын бодлогуудыг бол хэрэгжүүлэх шаардлагатай.

Дөрөв 10-ын татварын бодлогыг хэрэгжүүлэхэд би бас татварын ажлын хэсэгт ажиллаж байсан юм. Энийг бол хувийн хэвшлээ дэмжих зорилгоор хийсэн. Энэ дотроо үлдсэн 2 татвар бол өв залгамжлалын татвар, үл хөдлөх хөрөнгийн татварын реформыг хийж чадаагүй юм. Энэ хоёрыг хийж байж бас энэ үр дүнтэй, эрүүл нийгэм бий болгоход анхаарч чадна. Энийг би танхим бизнес эрхлэгчид маань зөвөөр ойлгож, хүлээж авч, хэлэлцэж, зөвлөлдөж, чиглэл гаргаж чадна аа гэж бодож байна аа.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнхбат: Халамжаас хөдөлмөрт шилжих тал дээр одоо танай Засгийн газар ямар бодлого барих вэ гэдгийг би асуусан. Дээрээс нь энэ нөгөө түрүүн миний хэлсэн нөгөө энэ бүсчилсэн хөгжлийг бол таны хувьд бол үргэлжлүүлнэ ээ гээд ингэсэн. Дээрээс нь энэ байгаль орчны уур амьсгалын өөрчлөлттэй хамгийн их нэрвэгдэж байгаа энэ говийн бүс нутагт одоо бүх төсвийг нь ингээд аваад авчихдаг. Үндсэндээ 3.4 их наяд төгрөгийг АМНАТ-аар, төсөвт 1.7 тэрбум төгрөг ингээд төсөв бүрдүүлэх гээд ингээд авчихдаг. Ингэхлээрээ зэрэг бид нар нөгөө энэ гадаргын усны ч тэр, одоо бусад байгаль орчны төслүүдээ санхүүжүүлж чадахгүй болчихоод байгаа. Улсаасаа мөнгө гуйгаад байдаг. Нөгөөх нь тавигддаггүй. Тэгэхээр зэрэг өөрснөө энэ төсвөө тодорхой хэсгээ бүс дээрээ авч үлдээд, тэндээсээ зарцуулдаг байх тэр механизмыг хийж өгч одоо чадах уу гэдэг л энэ асуудлыг яачихъя.

Дөрөвдүгээрт нь тэр Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулаад өнөөдөр нь хүртэл нэг ч сонгон шалгаруулалт хийгдэхгүй байна аа.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт өгье.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүний асуултад хариулъя. Халамжаас хөдөлмөрт гэдэг маань бол тодорхой лоозон болж үлдмээргүй байгаа юм аа. Тэгээд халамжийн маш олон төрлүүдийн нэг байгааг нэгтгэж цэгцлэх ийм үүрэг чиглэлийг холбогдох сайд нарт өгөөд судалгаа хийлгэж байна. Энийг цээжний бангаар ярьж болохгүй байгаа учраас би судалгаан дээр үндэслэж дараачийн хурлуудаар бодит үр дүнгийн талаар мэдээлэл өгөх болно. Энэ бас нэлээн мэдрэмтгий асуудал. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлж, таныг говийн бүсийн хөгжлийн талаарх бодлогыг бид дэмжиж байгаа. Энэ бас төсвийн 3.4 их наядын АМНАТ-ын ашигт малтмалын нөөц ашигласны татварын хэдэн хувийг бүрдүүлэх бололцоотой вэ төсвийн нэгдсэн төсвийн бодлоготойгоо уялдуулж энэ талаар хариу өгье.

Сэргээгдэх эрчим хүчний асуудлаар мөн...

Д.Амарбаясгалан: Салдангийн Одонтуяа гишүүн алга байна. Жамбын Батсуурь гишүүн асуулт асууя.

Ж.Батсуурь: Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Тэгэхлээр Монгол Улс хэдийгээр нэгдсэн төсөвтэй Нэгдсэн Монгол Улс гэж хэлж, ярьдаг боловч Монгол Улсын нийт хүн амын 50 хувийг хамарсан одоо Улаанбаатар хот буюу агаарын бохирдол, хөрсний бохирдол, түгжрэл, утаа мөн одоо стресс, олон улсын одоо энэ нягтралтай хотуудын тоонд ордог. Гэтэл нөгөө талдаа хүн амын 50 хувь энэ одоо дэлгэсэн тэрлэг шиг Монгол гэж асар том газар нутагт 21 аймаг, түүний цаана сум суурингууд оршдог. Тийм учраас энэ нөхцөл байдлууд нэг хуулийн эрх зүйн асуудлаар хэрэгжүүлэхэд маш хэцүү байдаг. Энийг та ер нь юу гэж хардаг вэ гэсэн асуултыг нэгдүгээрт асуух гэсэн юм.

Хоёрт нь, АН-ын 2024 оны мөрийн хөтөлбөрийн зонхилох хэсэг болсон хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын чиглэлээр Оюун-Эрдэнийн Засгийн газар буюу одоо миний ажиллаж байсан Засгийн газарт маш том байр суурь эзэлж ордог оо, орсон. Үүнд юу гэж байна вэ гэхлээр одоо 150 мянган айлын орон сууц гэж АН-ын мөрийн хөтөлбөрт орсон. Энийг бид нар бүрэн хэрэгжүүлнэ гэхдээ бүрэн итгэлтэй ажиллаж явж байгаа. Та одоо 150 мянган айлын орон сууцыг бүрэн ашиглалтад оруулна гэдэгтээ итгэлтэй байна уу? Үүн дотор бол бид голлох зүйл бол ипотекийн зээлийг орон нутагт нийт эх үүсвэрийн 60, 70 хувийг олгоё. Мөн амины орон сууцад ипотекийн зээл олгоё, амины орон сууцыг дулаалах, байгалийн хүчин зүйлд тэсвэртэй болгосноор зээлийг өгөх боломжтой юмаа гэсэн ийм одоо зорилтыг дэвшүүлээд бол бас бүрэн үр дүнд хүрнэ гэсэн ийм явж байгаа. Энэ дээр та одоо ямар бодолтой байна вэ?

Дараагийн асуудал бол та түрүүн Хархорин хотыг тайлбарлачихлаа. Улаанбаатар хотын ачааллыг бууруулах Хүннү хот. Хүннү хотыг бол бид нар 2028 он гэхэд үндсэндээ эхний оршин суугчид оччихсон байна гэсэн ийм тооцооллыг хийж явж байгаа. Яг энэ тооцоолол одоо бас танд бодит байна уу, үгүй юү гэсэн ийм зүйлийг бас асууя.

Дараагийн нэг зүйл бол мөн АН-ын мөрийн хөтөлбөрөөс Засгийн газрын мөрийн хөтөлбөрт нэлээд том байр суурь эзэлдэг бол нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, Иргэдийн төлөөлөгчдийн хурал аймгийн, сумын ИТХ-ын эрх мэдлийг одоо Засгийн газар хэт төвлөрүүлэн татсан. Үндсэндээ иргэдийн хурал, сумын иргэдийн хурал, багийн иргэдийн нийтийн хурал, аймгийн Иргэдийн хурлыг бол

үндсэнд нь шүдгүй арслан болгочихсон. Энэ одоо хууль эрх зүйн нэг минутаа авчихъя дарга аа.

Энэ нөхцөл байдлыг та ер нь юу гэж харж байна вэ гэсэн энэ асуултад хариултууд авъя гэж бодож байгаа юм. Дээр нь барилгын салбар бол хамгийн их либералчлагдсан салбар. Тэгээд одоо нөхцөл байдлууд юу вэ гэхлээр бидний хийж чадсан зүйл бол эхний ээлжид одоо гав гинжнээс нь маш олон хууль дүрэм журам одоо өдий төдий албан газрын хаалга татдаг зүйлийг бол болиулж үндсэндээ 5-7 хоногт барилгын салбарын одоо тусгай зөвшөөрлийг бол шууд киоск машинаас авах боломжийг бүрдүүлсэн. Энэний цаана бол асар их авлигал, хээл хахууль буурсан, шат дамжлага буурсан гэж ингэж үзэж байгаа.

Цаашилбал барилгын салбарт энэ одоо эрх зүйн орчныг илүү тодорхой болгох, Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийг бол бид нар сая өргөн барих гээд бэлэн болоод ингээд үлдээсэн. Энэ үйл ажиллагааг та цааш нь үргэлжлүүлж, саяын одоо бид нарын тавьж байсан зорилтод 2028 он гэхэд хүрч чадах уу гэсэн асуултыг асууж байна аа.

Д.Амарбаясгалан: За хариулт өгье нэр дэвшигч.

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн сайдын асуултад хариулъя аа. Энэ асуултын хариулт нь бол их энгийн. Бид нар хамтарч ажиллаад энийг хэрэгжүүлж чадна аа. 105 мянган айлын орон сууцыг яаж хэрэгжүүлэхийг та надаас илүү сайн мэдэж байгаа Барилга, хот байгуулалтын сайд байсан хүн. Энэ талаар зөвлөж тусалж, хамтарч ажиллахыг хүсэж байна. Энэ чиглэлээр санхүүжилтийн механизм, эрэлт нийлүүлэлтийн зохицуулалтыг орон сууцжуулалтын банк байгуулах замаар шийдэх гарц гаргалгаа шийдлийг шийднэ. Энэ нь өөрөө үр ашигтай систем байгаа юм. Орон сууцны банк дандаа ашигтай ажилладаг. Одоо Солонгосын Кунимин банк байх аа хувийн банк болоод явчихсан. Тэгэхээр энэ нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх мэдлийг төвлөрүүлж орон нутгийн хөгжилд саад учруулах биш орон нутагт одоо ипотекийн зээлийн 18.9-хөн хувь нь олгогдож байхад, хүн амын тал хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна шүү дээ. Ингэж байж орон нутагт шийдлийг гардуулж хэрэгжүүлэх ийм бололцоотой.

Улаанбаатар хотын бөөгнөрөл, энэ гэр хорооллын барилгажуулалт, хөдөө орон нутагт төвлөрлийг сааруулж, орон сууцжуулалтуудыг нэмэх бодлогыг нарийн тооцоо судалгааны үндсэн дээр хэрэгжүүлэх бололцоотой. Энэ чиглэлээр Барилга, хот байгуулалтын сайдаар үр дүнтэй ажиллаж байсан Жамбын Батсуурь гишүүний саналыг одоо биечлэн судлаад, жич ярилцаад Таны хэлсэн санал санаачилгуудыг бодитой хэрэгжүүлэх талаар хамтарч ажиллая аа гэж одоо бас санал болгож байна.

Д.Амарбаясгалан: Дагуул хот, Хүннү хоттой холбоотой асуултад гүйцээж хариулъя. Нэг минут нэмж өгье.

Г.Занданшатар: Хархорин хот ч тэр, дагуул хот, Хүннү хот ч тэр энэ Төв аймгийн Хөшигтийн нисэх онгоцны буудал дагасан дэд бүтцийн энэ шийдэл бол ер нь бүгд л санхүүжилт эх үүсвэртэй л холбогдож байгаа шүү дээ. Ийм учраас орон сууцны банк байгуулах, ер нь барилгажуулалтын банк л гэсэн үг шүү дээ нэг талаасаа бол танай салбарын л банк гэсэн үг. Энэ бүхэн бол ер нь эцсийн дүндээ нөгөө мөнгө, санхүү эх үүсвэр л байвал тэгээд төлөвлөлт зөв байвал, эрэлт

нийлүүлэлтийг зохицуулж байвал шинэ хот байгуулах зайлшгүй шаардлагаа дагаад Улаанбаатарын төвлөрөл саарах энэ улам боломжууд хэрэгжих бололцоотой.

Тийм учраас би бас танаас илүү яаж мэдэх вэ. Та одоо харин надаас бас асуухаасаа илүү зөвлөж энэ талаар одоо мэдээллээ өгвөл сайн байна. Би энэ бүхнийг бас мэдээд судалчихсан танай салбарыг мэдэж байгаа юм яг одоогоор бас алга байна аа.

Д.Амарбаясгалан: Жамбын Батсуурь гишүүн тодруулж асууя.

Ж.Батсуурь: Энэ чинь одоо хамгийн гол нь Оюун-Эрдэнийн Засгийн газар буюу бидний ажиллаж байгаа Засгийн газарт бол 3 намын мөрийн хөтөлбөр, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны хөтөлбөр болж батлагдсан. Тэгээд энд одоо энэ орон сууц барилгын асуудлууд, мөн хот байгуулалтын асуудлууд бол нэлээн өргөн одоо бааз суурийг бол эзэлж байгаа юм.

Тийм учраас хамгийн гол нь таны Засгийн газрын үед энэ хүч маань саарахгүйгээр 2028 он гэхэд 150 мянган айлын орон сууц, түүн дотроо амины орон сууцыг ипотекийн зээлд хамруулах, мөн одоо суманд амьдарч байгаа хүмүүсийн амьдралын чанар, аймагт амьдарч байгаа хүмүүсийн амьдралын чанар, хотод амьдарч байгаа хүмүүсийн амьдралын чанар ижил болох юм бол их нүүдэл зогсож, Улаанбаатарын одоо төвлөрөл буурч, мөн одоо дагуул хот болон орон нутагтаа амьдрах ийм боломж бүрдэх юм бол өнөөдрийн одоо Монгол Улсын Улаанбаатар хотод байгаа бухимдал бол бүрэн арилах юмаа л гэсэн...

Д.Амарбаясгалан: Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууя. Сүүлийн гишүүн асуулт асууж байна.

Ж.Баярмаа: Оройн мэнд. Танд баярлалаа. Ямар ч байсан зөвхөн Фрийдом Хаусын индексийг бид нар тооцож болохгүй л дээ. Варетиз оф демок, варетиз оф демокризи гээд маш олон зуун жилийн дата дээр үндэслэж төлөв байдлыг тогтоодог. Монголынхыг чинь бараг 1911 оноос хойших датан дээр суурилдаг гэж байгаа шүү дээ. Тэгэхээр энийг болбол тооцож болохгүй. Энэ бол ерөөсөө буруу судалгаа гэж хэлж болохгүй л дээ Зулпхар гишүүн.

Тэгэхээр энэ дээр би ташрамд бас хэлэхэд нөгөө ингээд хүүхэд нүдээ таглачхаад би нуугдчихлаа гэдэг шиг жоохон тааруу гарсан дүнтэй индексээ энэ бидэнд хамаагүй гэхээд, гайгүй гарсныгаа баярлаад тэрэндээ дулдуйдаад инээд алдаад яваад байж болохгүй. Мэдээж тэр Видимийн индекс бол маш нарийн гардаг. Асар олон шалгуур маш нарийн экспертүүдийн үзлэгээр гэх юм уу тогтоогддог ийм байгаа юм. Тэгэхээр энийг болбол бүүр тооцохоор барах уу тооцох ёстой гэдгийг бол таныг бол би ойлгож байгаа юм байна гэж ойлголоо. Баярлалаа.

Тэгээд гадаадын хөрөнгө оруулалт Монгол Улсын Засгийн газрын өрийн өртэй холбоотой нэг зүйлийг асууя гэж бодлоо л доо. Одоо жишээлбэл Засгийн газрын өр гэхэд сүүлийн 10 жилд бол бараг 2.2 дахин өссөн байна. Хамгийн сүүлд Засгийн газрын гадаад өр 8.3 тэрбум доллар байна. Тэгсэн мөртөө экспорт, экспортын хэмжээ бөгөөд орж ирсэн орлого бас бүүр 3.4 дахин өссөн байна. Жишээлбэл сүүлийн 10 жилд сүүлийн 10 жилийн сүүлийн зөвхөн 3 жилийн экспортын орлогыг авч үзэхэд 44.3 тэрбум долларын орлого орсон байгаа юм. Тэгсэн мөртөө гадаад өрийн тоо хэмжээ ерөөсөө буураагүй. Тэгэхээр энийг та юутай

холбож үзэж байна вэ? Нөгөө төсөв нь томроод, төсвөө тэлээд тэгээд энийгээ одоо төсвийнхөө алдагдлыг нөхөх гэж дандаа ингээд гадаад зээл тусламж аваад байсан байж таарах нь уу?

Тэгэхээр та энэ гадаад өрийн бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх энэ өрийн хэмжээг ер нь бууруулъя гэж бодож байгаа юу? Юу гэж боддог вэ энэ дээр? Одоо болбол 2025 онд бол 55 хувь байхаар тогтсон юм байна. За хуулиар болбол тааз нь бол 60 байгаа. Тэгэхээр энийг еще бүүр 40-өөс доошоо оруулах ийм бодлогыг та баримтлах уу?

Хоёрдугаарт, гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой. Жилд бол манайх нэг 2-4 тэрбум орж ирдэг юм байна. Энэ бол бас дотоодын нийт бүтээгдэхүүний нэг 10- 20 хувь. Тэгэхээр эргээд эсрэгээрээ энэ гадаадын хөрөнгө оруулалтаа +40-өөс дээшээ оруулах. Нөгөө гадаад зээлээ 40-өөс доошоо оруулах буюу аль болох энэ одоо хөрөнгө оруулалтаа, санхүүжилтээ ийм эрүүл маягаар цаашаа хийж явах...

Д.Амарбаясгалан: Минут нэмж авах уу? За Баярмаа гишүүнд нэг минут нэмж өгье.

Ж.Баярмаа: Тэгэхээр гадаадын хөрөнгө оруулалтын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг нэмэх тийшээ та явах уу? Эсрэгээрээ нөгөө гадаад өрийн хэмжээг бууруулах чиглэл рүү явах уу? Гуравдугаарт, мартчихлаа. За яах вэ.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье нэр дэвшигч.

Г.Занданшатар: Ер нь ардчиллын индексийг бол шалгаруулдаг экономик интеллиженс юнит, Бертлс Менис сан, Фрийдом хаус, Вирайт оф демокрисис гээд ийм олон хэмжигдэхүүнүүд ийм индексүүд байгаа. Тэгэхдээ ямар индекс байх нь гол биш хамгийн гол нь байгаа зөв олж өвчнөө эмчлэхэд нь л энэ индексээ ашиглах нь зүйтэй гэж бодож байна. Хөрөнгө оруулалт өрийн харьцааны хувьд бол тантай мэдээж санал нэг байна. Энэ үр ашигтай гадаадын хөрөнгө оруулалт бол хүүгүй манай энэ хэмжих үзүүлэлт нь төсөвт эзэлж байгаа хүүгийн зардлаа тооцох ёстой юм байгаа юм л даа. Тийм учраас хүүгийн зардлыг бууруулах, энэ детест рестракчеринг хийхдээ өрийн зохицуулалт хийхдээ бага хүүтэй санхүүжүүлэлт зөөлөн ийм санхүүжилтүүдийг авах нь бол мэдээж ОУВС, Дэлхийн банк энэ тэрийн санхүүжилт нэмэгдэж байгаа ийм үзүүлэлтүүд байгаа. Энэ нь бол зөв хандлага.

Ер нь номинал дүнгээрээ нэмэгдэж байгаа боловч дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаа тогтмол буурч байгаа 41.8 хувь болсон санаж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүн Дэлхийн банкны стандартаар бол нөгөө дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулсан номинал хэмжээгээрээ үздэг. Тэгээд дотоодын нийт бүтээгдэхүүн өсөж байгаа учраас 2021 оноос хойш 62.6 хувь байснаасаа хойш энэ бол 60.5, 43.7 одоо 41.8 хувь болоод өрийн харьцаа буурч байгаа. Энэ дотроо бас нэг чухал зүйлийг онцлон хэлмээр байна. Их Хурлын даргаар ажиллаж байх үед Монгол банкны Хятадын свопын өрийн 1 тэрбум долларыг бол төлж барагдуулж, энэ өрийн хүнд нөхцөлтэй зээлүүдийг, өндөр хүүтэй зээлүүдийг бол эргүүлэн төлөх чиглэлийг бариад, мэдээж хямд бага эх үүсвэртэй, хөнгөлөлттэй зээлийг илүү болгох замаар шийдэж ирсэн.

Хөрөнгө оруулалт, өрийн зохистой харьцааг барихад дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрүүлэхгүйгээр өрийн удирдлагын хуулийгаа мөрдөх,

өндөр өгөөжтэй үйлдвэрлэл нэмэгдүүлэх салбарт хөрөнгө оруулалт оруулах, богино хугацаатай өндөр өртөгтэй зээл, өрийн санхүүжилт, бондын санхүүжилтээс зайлсхийх, өрийн ил тод тайланг одоо тогтмол нийтэлж байх ийм бодлого бол олон улсын жишиг ийм жишиг баримталж ажиллах ёстой.

Тийм учраас одоо тантай зарчмын хувьд санал нэг байна. Дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцааг 60 хувиас доогуур байлгах. Одоо 41.8 хувь байгаа. Гадаад, дотоодын өрийн баталгаатай зээл, төсөлд хяналт, эрсдэлийн үнэлгээг байнга хийж байх. Өрийн дарамтыг жигдлэх, бондын өрийн дарамтыг жигдлэх ийм зайлшгүй шаардлагууд бий. Энэ бүхэн маань эцсийн дүндээ валютын нөөцийн бодлоготой уялдах ёстой, экспортын бодлоготой уялдах ёстой. Ингэж байж бид өрийн хямралд орохгүй байх ийм чиг шугамыг гаргаж ирнэ. Түүнээс биш ер нь манай өрийн удирдлагын асуудлыг Улсын Их Хуралд хэлэлцэж, гадаад, дотоод өрийн харьцааг бол 60 хувиас доош барихаар бондын баримт, бондын дарамтыг жигдлэхээр энэ өрийн удирдлагын тухай стратегийг баталсан юм билээ. Энэ дээр одоо тоо баримтын хувьд эргэж нягтлах зүйл байвал Улсын Их Хурал бас номинал тоо баримтынх нь хувьд бас шалгах зүйлүүд байгаа.

Ер нь хөгжлийн албан ёсны тусламж, гадаадын шууд хөрөнгө оруулалт бол өрийн дарамтыг бууруулахад чиглэсэн ийм чухал чиг баримт болох ёстой гэж бодож байна. Манай статистикууд их зөрөөд байдаг юм. Монгол банкны тоо баримт нэг өөр. Гаднын донор байгууллагуудын Дэлхийн банк, Валютын сангийн тоо нэг өөр. Засгийн газрын тоо нэг өөр байгааг нягталж, Улсын Их Хурлаас нэг талд нь гаргах талаар бас нарийвчилж судалж үзэх болно.

Д.Амарбаясгалан: Баярмаа гишүүн тодруулж асууя.

Ж.Баярмаа. Одоо эдийн засагчид бол байнга ярьдаг тиймээ. Нөгөө мөчлөг сөрсөн, мөчлөг дагасан бодлого гээд. Тэгэхээр манайх ер нь түүхэндээ бараг мөчлөг сөрсөн буюу тэр зөв бодлогыг ер нь хэрэгжүүлээгүй юм шиг байгаа юм. Тэгээд нөгөө маш одоо ойлгомжтой болчихоод байна шүү дээ нөгөө экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнэ өндөр байх үед хуримтлал үүсгэж, хэцүү үед тэрийгээ ашиглах гээд тиймээ. Тэгэхээр энийг ерөөсөө нэг ч хэрэгжүүлдэггүй гэж эдийн засагчид ярьдаг. Тэгэхээр одоо хэрэвзээ бид нар энэ экспортын нүүрсний үнэ асар өндөр байгаад сүүлийн 3 жилд 43.3 тэрбум долларын орлого олсон үедээ зөв одоо зохион байгуулалттай байгаад хуримтлал хадгалалт үүсгэчихсэн байсан бол одоо ирэх энэ хүнд жилүүдэд ашиглах байжээ гэдэг.

Тэгэхээр та эдийн засагч хүний хувьд мөчлөг сөрсөн бодлогыг ер нь барих юм уу эсвэл яг өмнөх он жилүүдийнх шиг байнгын нөгөө өндөр үнэтэй үед нь яг тэр чигээр нь зарж хаяад л, тэгээд байхгүй болох үедээ хоосордог энэ бодлогыг баримталж явах юм уу гэдэг сүүлийн асуултыг асууя аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт өгье нэр дэвшигч.

Г.Занданшатар: Жудагийн Баярмаа гишүүн маш чухал асуулт асуулаа. Өнөөдөр чинь сүүлчийн тэмээний ачаа хүнд гэж сүүлийн асуулт учраас нэг зүйлийг бас магтаж байгаа юм биш онцлоод тэмдэглэхийе ээ гэж бодож байна. Хориг тавьсан явдал хориг тавих үедээ би яг таны наад хэлсэн мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай гэдгийг одоогоос 7 сарын өмнө хэлээд хориг тавихад энд би мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлж, төсвийг алдагдалгүй батлахдаа гол биш ийм

эрсдэл учрах гээд байна аа, мөчлөг эргэж ирэх гээд байна. Түүхий эдийн уналт бий болох гээд байна.

Ийм учраас төсвийг алдагдалгүй баталж байж энэ эрсдэлийг туулах юм байна аа гэж хэлж байсан. Ийм учраас бид энэ өнөөдрийн энэ үечлэл тэр нөхцөл байдлыг арай гайгүй тулж байна аа, 2.3 их наядаар дутах нь ээ. Хэрвээ тэр 2 их наядын алдагдалтай баталчихсан байсан бол өнөөдөр 4, 5 их наядын алдагдалтай бүүр хүнд байдалд бид тулчихсан, уначихсан сууж байх байсан байна аа гэдгээ бас хэлчихье гэж бодож байна аа.

Ер нь өрийн хувьд бол манайх 37.2 тэрбум долларын өртэй байгаа. Ер нь гадаадын шууд хөрөнгө оруулалт бол үндсэндээ Оюу Толгойн хөрөнгө оруулалт байгаа. Тийм учраас гадаад өрийн тогтвортой байдлын шинжилгээг бид байнга харж байх ёстой гэдгийг онцолж хэлье ээ.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье өө. 28 гишүүнээр тасаллаа. Ганзоригийн Лувсанжамц гишүүн үг хэлье. За энэ ирцийн дарааллаар Оюунсайханы Алтангэрэл гишүүн үг хэлнэ ээ.

О.Алтангэрэл: Нэр дэвшигчдээ нэг зүйлийг бас тодорхой хэлье ээ. Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар хураах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл дээр хууль эрх зүйн орчин байгаа гэж бас эндүүрч байна лээ шүү. 2012 онд одоо энд сууж байгаа Монгол Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн санаачлаад Монгол Улсын Эрүүгийн хуульд хууль бусаар хөрөнгөжих гэдэг зүйл заалт орсон юм. Харамсалтай нь өнөөдрийг хүртэл үндэслэлгүй хөрөнгөжих гэдэг энэ гэмт хэргээр ял шийтгэгдсэн 10 гаруйхан тохиолдол байгаа. Гэтэл энэ Монголын нийгэмд үндэслэлгүй хөрөнгөжсөн, хөрөнгөө хураалгах ёстой хэчнээн хүн байгааг Монголын ард түмэн хэлүүлэлтгүй мэдэж байгаа.

Дээрээс нь өнөөгийн Эрүүгийн хуулийг харах юм бол үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэрэг 100 сая төгрөгөөс дээш хөрөнгө дээр хамаарч байгаа юм. 100 сая төгрөгөөс дооших хөрөнгө дээр энэ зүйл анги үйлчлэхгүй. Нэмээд хэлэхэд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэж бий. Одоогоос 5 жилийн өмнөхөөс цааших энэ төрлийн гэмт хэргийг Эрүүгийн хуулиар шийдэх ямар ч бололцоогүй ээ. Энэ хуулийн үзэл санаа бол өнгөрсөн удаа 3 ч удаа Өршөөлийн хуулиар өршөөгдсөн. Тэгсэн мөртөө хөрөнгөө аваад үлдчихсэн энэ хүмүүст, Эдийн засгийн ил тод байдлын хууль гээд хэдэн их наядаар нь мэдүүлээд энэ хөрөнгөө аваад үлдчихсэн энэ хүмүүст буюу 2002 оноос хойш үйлчлэхээр Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар зарим харилцаанд буцаж үйлчлэхээр зохицуулсан ийм хуулийн төсөл байгаа шүү. Энэ мэдээллийг өгье.

Мөн дээрээс нь Монгол Улс түүхэндээ анх удаагаа Авлигын эсрэг конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулахаар санаачилга гаргаад явж байгаа. Энэ санаачилга дэмжигдэж гэмээнэ энэ бол Трансперенси интернэйшнлтэй хамтарсан үйл ажиллагаа. Энэ бол бидний ирэх 2 сард Авлигын төсөөллийн индекс ямар байх вэ гэдэгт туйлын чухлаар нөлөөлөх юм шүү. Ийм учраас энэ конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах энэ шийдвэрийг дэмжиж ажиллаарай гэж хүсэж байна.

Мөн нэр дэвшигчдээ хангайн тойргийнхныгоо төлөөлж бас хэлэх үг байна аа. Манай хангайн тойрог бол шашны 3 зул, Өндөр гэгээн, Ламын гэгээн, Заяын гэгээний ийм нутаг аа. Энэ жил монгол түмний сод их хөвгүүн Чингисийн алтан ургийн үргэлжлэл Өндөр гэгээн Занабазарын мэндэлсний 390 жилийн ой тохиож байгаа. Тэгэхээр бас энэ бүсийн төлөөллийн хувьд Өндөр гэгээнийхээ ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажилд онцгой ач холбогдол өгөөрэй гэж Хангайн бүсийнхээ нийт сонгогчдын өмнөөс хүсээд амжилт хүсье ээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Буланы Бейсен гишүүн үг хэлье.

Б.Бейсен: Энэ түрүүн бас би эрүүл мэндийн салбарын цалингийн асуудлыг асуусан. Та нэмж чадахгүй гэсэн. Тэгэхдээ энэ салбарыг та урьд нь Их Хурлын дарга байхдаа ч мэднэ. Ер нь байдал нэг хүнд байгаа шүү. 35 жил ажилласан, 30 жил ажилласан эмч одоо сая 700-аас сая 900 мянган төгрөг л авч байна. Бүгд цалингийн зээлтэй. Хүүхдээ сургах гээд зээл авч байна, орон сууцны зээл авч байна. Тэгээд өргөн хэрэглээний бараа нь бензин шатахууны үнийг нь салбар дийлэхгүй байна. Энэнтэй холбоотой энэ салбарын эмч, сувилагч асрагч нарын хомсдолд орсон. Энийг бас та анхаарч үзээрэй гэдгийг хэлмээр байна. Ядахдаа нэг дахин нэмж чадахгүй ч гэсэн 50 хувиар нэмэхгүй бол эдний байдал хүнд байгаа шүү гэдгийг хэлье.

Нөгөө талаар одоо улсын аюулгүй байдлын үүднээс энэ Монгол Улсын үндэсний эмийн үйлдвэрийг хөгжүүлэх талын асуудал дээр онц анхаараарай. Баталгаат лабораторийн асуудал байж байгаа. Дараагийн асуудал дээр хүнсний асуудал байгаа. Түрүүн бас ярьсан. Хавдрын ихсэлтийн 80 хувь нь одоо энэ хүнсний аюулгүй байдлаа алдсантай холбоотой. Нөгөө талаар хавдар их залуужиж байна. Энэ одоо хемикат ихтэй хавдар өсөх бодис ихтэй гээд түрүүн хэлсэн. Нөгөө талаар одоо янз бүрийн юмнууд байж байна. Энэнтэй холбоотой одоо хавдрын ихсэлт нь ингээд өндөр гарч байгаа нэг шалтгаан байгаа юм. Ерөнхийлөгчийн хүнсний хувьсгалын хувьд одоо энэ эх орондоо хүнсний ногоо тариалах асуудал дээр бас онцгой анхаарч ажиллана байх аа гэж бодож байна.

Энэ баруун бүсийн одоо 5 аймгийн байдал хүнд. Бензин шатахуун өндөр үнэтэй, өргөн хэрэглээний бараа тээврийн зардалтайгаа бас өндөр үнэтэй байгаа. Тийм учраас энэ баруун бүсдээ онцгой анхаарахгүй бол нэлээн хүнд байгаа шүү. Алслагдсан байдалтай, эмийн үнэ өндөр, хөнгөлөлттэй эмээ авч чаддаггүй. Тэгэхээр энэ баруун бүсдээ бас анхаарч ажиллаад түрүүн би бас ярьсан. Баруун бүс бас Цагааннуур боомтоор хуучин одоо малыг хөлөөр нь, амьдаар нь гаргаж байсан эрүүлжүүлэх бүс байгуулаад, бэлчээрийн даацаасаа бас хэтэрч байна. Энэнтэй холбоотой энэ төсөл хөтөлбөр нь бас ингээд бүтчихсэн юм байна. Тийм учраас энэ асуудал руу бас анхаарч ажиллаарай. Танд ажлын амжилт хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нанзадын Наранбаатар гишүүн үг хэлье.

Н.Наранбаатар: Би ер нь үг хэлэхээ болилоо. Бусад гишүүдээ уриалаад ингээд хэдүүлээ өнөөдөртөө багтаад Ерөнхий сайдаа томилъё оо. Үг хэлэх жагсаалтаас нэрээ хасуулъя аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлье.

Б.Пүрэвдорж: Апате апате, апате апате апате ха ха гээд нэг дуу байдаг юм. Танай ач зээ нар хүүхдүүд чинь та нарт дуулж өгч байгаа. Энэ дуу та нарыг шоглож байгаа. Апате гэдэг нь апартамент гэсэн үг, байр гэсэн үг. Солонгосын улс төрч нар ядуу хороололд очоод та нарын байрыг чинь, энэ хорооллыг чинь гоё сайхан хороолол болгож өгнө. Та нарыг бүгдийг нь апартамент байранд оруулж өгнө гэж саналыг нь аваад, тэгээд тэр чигээрээ зугтаад алга болдог улс төрчдийг залуучууд шоглосон дуу байхгүй юу даа. Тэгэх дээр өнөөдөр энэ яг өнөөдөр МАН бол яг 9 жилийн хугацаанд яг энэ дууны араас Монгол орныг орууллаа.

Иргэдээ ядуурлаас аварч, дундаж давхаргыг бий болгоно гэсэн улам ядууруулсан. Эдийн засгаа хямралаас гаргана гэсэн. Хулгай хийж улам хямралд оруулсан. Эх орноо өрнөөс гаргана гэсэн 15 сая төгрөгийн өртэй байсан нэг хүнд ноогдох өр 15 сая байсан бол одоо 38 сая болгосон. Татварын дарамтыг бууруулна гэсэн хаа сайгүй бүх шатанд татвар нэмж байгаа, хураамж нэмж байгаа. Зээлийн хүү буулгана гэсэн улам өссөн. Нийгмийн даатгалын шимтгэлийг буулгана гэсэн дахиад өссөн. 1 сая ажлын байрыг бий болгоно гэсэн залуучууд гадаадад дүрвэсэн. Төрийн өмчийн оролцоог бий болгоно гэсэн 30 хувийг төрийн өмчийн оролцоо бүр эдийн засагт 30 хувь байсныг бүр 70 хувь болгосон.

5 дугаар цахилгаан станц, Тавантолгойн цахилгаан станц. Багануурын цахилгаан станц, Тэвшийн говийн цахилгаан станц барина гэсэн. Нэг нь ч баригдаагүй. 100 мянган айлын орон сууц барина гэсэн тэрэндээ хүрээгүй. Төрийн урлагийн зардлыг багасгана гэсэн улсын төсөв 2016 онд 9.5 их наяд байсан бол 36 их наяд болгож, 4 дахин нэмсэн. Амьд бурхад болсон ахмадууддаа жил болгон тэтгэврийг чинь нэмж өгнө өө гэсэн 9 жилд гуравхан удаа нэмсэн. Авлигал хээл хахуулийг устгана гэсэн төрийн бүх шатанд албан тушаалтнууд хувийн хэвшлээс ард иргэдээс авлигал нэхдэг болсон. Тэгэх дээр үнэхээр жинхэнэ утгаараа та нар бол апате апате, апате апате болголоо доо.

Тэгээд одоо Занданшатар дарга аа, та бол ийм олон алдааг өнгөрсөн хугацаанд гаргасан алдааг бүгдийг нь засаж чадахгүй. Тийм учраас нэг 3, 4-хөн юм хийе. Татвараа багасгачих, нийгмийн даатгалын шимтгэлээ багасгачих, тэтгэврээ нэмчих, авлигал хээл хахуультай жоохон тэмцчих бүгдийг нь та чадахгүй. Энийг л хийгээрэй. Тэгэх юм болбол одоо тэр дууг танай үр ач нар чинь гишүүд та нарт дуулж өгөхгүй болох байх аа гэж найдаж байна.

Д.Амарбаясгалан: Банзрагчийн Түвшин гишүүн үг хэлье.

Б.Түвшин: Та бүхэндээ оройн мэндийг хүргэе. Тэгэхлээр энэ эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд одоо Ерөнхий сайд болно гэдэг болбол хэцүү. Гэхдээ нөгөө талдаа дахиад хэлэхэд энэ бол боломж шүү. Ер нь манай Монгол Улсын төсөв тэлж байгаа үед урсгал зардлаа хасахгүй дандаа тэлсээр байгаад одоо нүүрсний үнэ дундаж хэмжээнд хүрсэн ч бид нар тэрүүгээр төсвийн орлогоороо урсгал зардлаа дийлэхгүй ийм байдал руу оруулчихсан. Одоо 2.3 их наядаар дутаж байгаа. Дахиад нүүрсний үнийн хэмжээ буурахад энэнээс илүү ихээр дутагдана. Тийм учраас шинээр сонгогдож томилогдож байгаа энэ Ерөнхий сайдад ямар боломж байна вэ гэхлээрээ түүхэндээ анх удаа урсгал зардлыг 2020 оны үе рүү буюу 15 их наяд руу оруулах юм болбол энэ бол бас Монгол Улсын төсөв санхүүгийн түүхэнд гайхамшигтай сайхан амжилт болох ийм боломж байгаа шүү гэдгийг бас хэлэх гэсэн юм.

Энэ урсгал зардал буурснаараа үр ашиггүй зардал буурч, инфляц буурна. Нэг сумаар их олон туулай буудна л даа. Нөгөө талдаа энэ чинь болбол одоо валютын ханшид бас нөлөөлнө, гадагшлах үр ашиггүй зардал нэмэгдэнэ. Ийм олон олон хувилбаруудыг хийх учраас энэ бол анхаарах зүйл байж байгаа. За саяын Пүрэвдорж гишүүний хэлдэг шиг их олон олон зүйлд анхаарч чадахгүй. Боловсрол, эрүүл мэндээс гадна 3 дахь том анхаарах салбар болбол хөдөө аж ахуй буюу мал аж ахуйн салбар байж байгаа. 400 гаруй мянган иргэн хамаарагддаг энэ мал аж ахуйн ложистик тогтолцоогоо хөгжүүлж байж, Монгол орныхоо өв соёл, уламжлал монголчуудын үндэсний үйлдвэрлэж ирсэн одоо тэр мал аж ахуйн чиглэлдээ бүтээгдэхүүнүүдийг одоо эдийн засгийн эргэлтэд оруулах энэ түүхэн боломж бас таны өмнө хүлээгдэж байгаа шүү.

Долларын ханш өсөөд байгаа. Хэрэглээ хасахаасаа илүү монголчуудын үйлдвэрлэж байгаа зүйлийг үнэ цэнд оруулж борлуулдаг. Ямар ч тохиолдолд монголчуудын валютын орлого орж ирдэг тэр боломжийг хангах бас энэ түүхэн боломж байгаа. Тийм учраас эдийн засгийн одоо энэ хүндрэлтэй нөхцөл гэдэг нөгөө талаасаа маш том боломж юмаа.

Эцэст нь хэлэхэд шударга ёсыг хангаж, эв нэгдлийг эрхэмлэж ажиллахыг Танаас бас хүсье. Өнөөдөр бид нар одоо намчирхаж хуваагдаж байна, фракцалж хуваагдаж байна, бараг хүйсээрээ хуваагдаж байна, бүх зүйлээрээ хуваагдаж байна. Магадгүй энэ эв эеийг эрхэмлэж явж байгаа таны хэрвээ ажиллах юм болбол Монголчуудын хувьд энэ болбол бас нэгэн том амжилт аа гэж ингэж бодож байна. Тийм учраас таныг шударга ёсыг ард түмэн чинь хүлээж байгаа, бас эв эеийг хүлээж байгаа шүү гэдгийг хэлж энэ үгийг өндөрлөө өө.

Д.Амарбаясгалан: Ганзоригийн Лувсанжамц гишүүн үг хэлье.

Г.Лувсанжамц: Нэр дэвшигч Занданшатар танд оройн мэнд хүргэе. Юуны өмнө гишүүдийн асуултад тодорхой хариулсанд баярлалаа. Засгийн газраа бүрдүүлэхэд тань 4 зүйлийг захиж хэлмээр байна. Та тэмдэглээд авбал сайн байна.

Нэгдүгээрт, цомхон чадварлаг кабинет бүрдүүлж, үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг бодитоор хэрэгжүүлмээр байна. Төрийн бүтцээс гадна төсөл арга хэмжээний давхардлыг тодорхойлж, нэг зохион байгуулалтад оруулж, үр дүнтэй ажиллах. Нийгмийн тодорхой асуудалд зарцуулж байгаа хөрөнгө оруулалт, татаас, төсөл, арга хэмжээний зардлыг салбар салбараар нь нэгтгэж олон нийтэд ил болгомоор байна. Төр өөрөө хаана, юунд хэдийг зарцуулж байгаагаа мэдэхгүй байгаа ноцтой асуудал болчихоод байгаа юм. Утааны сонсголоор энэ маш тод харагдсан. Сүүлийн 15 жилийн хугацаанд 5.6 их наяд төгрөгийг үргүй зарцуулсан байгаад байгаа юм.

Энэнтэй уялдаад хоёрдугаарт, төлөвлөж чадахгүй бол хэрэгжүүлж чадахгүй. Төрөөс хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг зөв төлөвлөх нэгдсэн нэг төлөвлөгөөтэй болох. Кэй Пи Ай буюу шалгуур үзүүлэлтээ зөв тодорхойлох, нийгмийн асуудлыг бодитоор үр дүнтэйгээр шийдвэрлэх хэрэгтэй байна аа гэсэн хоёрдугаар асуудал.

Гуравдугаарх нь хоёртой уялдаад хот байгуулалтын салбарын хувьд ч бас нэгдсэн төлөвлөлтийн тогтолцоонд шилжих хэрэгтэй байгаад байгаа юм. Өнөөдрийг хүртэл газар төлөвлөлт, хот төлөвлөлт 2 тусдаа явж ирсэн. Төр нэг гараараа газрыг үнэгүй өгөөд, нөгөө гараараа иргэдийн төлсөн татварын мөнгөөр буцааж худалдаж

аваад, үргүй зардал үүсгээд байгаа юм. Тод жишээ хэлье. Толгойтын замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох 3.9 км-ийн авто замын ажил одоо дуусах гэж байгаа. Газраа түрүүлж олгосноос болоод ганцхан зам барих гэж 10 жилийг алдчихаж байгаа юм. Тэгэхээр энэ алдааг засахын тулд хот төлөвлөлт, газар зохион байгуулалтыг нэгтгэж нэг яаманд харьяалуулж өгөхийг хүсэж байна.

Эцэст нь утааг бууруулах бодлогын өөрчлөлтийг хийх хэрэгтэй байна аа. Төр өнөөдрийг хүртэл түлшинд буюу хэрэглээнд л татаас олгож ирсэн. Цаашдаа бид дулаалга буюу хэмнэлтийг дэмжих бодлогыг дорвитой хэрэгжүүлэх хэрэгтэй байгаад байгаа юм. Энийг тодотгож хэлье. Сая та орон сууцны банк байгуулна аа гэж олон удаа хэллээ. Тэгээд мэргэжлийн хүний хувьд бол үүн дээр зөвлөлдөх зүйл маш их байна аа. Уулзалт товлож жич уулзахыг хүсэж байна. Тэгээд энд сууж байгаа олон гишүүд, салбарын экспертүүдийн адилаар Засгийн газрын зөв ажлыг, зөв шийдлийг дэмжиж ажилламаар байна аа. Тэгээд танд амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Дүгэрийн Рэгдэл гишүүн үг хэлье.

Д.Рэгдэл: Оройн мэнд хүргэе ээ. Хоёр, гурван санаа байна аа. Тэгэхээр Монгол Улсын хувьд Занданшатар дарга бол ШУА-ийн тэргүүлэгч гишүүнээр ажиллаж байсан хүний тухайд бас энэ шинжлэх ухаан технологийн салбараа бол нэлээн сайн мэддэг байх гэж би ойлгож явдаг. Тэгэхээр өнөөдөр Монгол Улсын шинжлэх ухаан технологийн салбарын 1 сая хүнд ноогдох эрдэм шинжилгээний ажилтны тоогоороо Азийн дунджаас 3 дахин бага байна аа. Дотоодын нийт бүтээгдэхүүний хувиар манайх бол 01 хувь байдаг. Дэлхийн дунджаас 20 дахин бага байгаа юмаа. Нэг хүнд ноогдох судалгаа хөгжүүлэлтийн зардлаар БНХАУ-тай харьцуулахад 61 дахин бага.

Тэгэхээр бид нар энэ шинжлэх ухаан технологийн өрсөлдөөнд одоо ингээд үндсэндээ оршин тогтноход маш хэцүү болж байгаа. Тэгэхээр энэ Засгийн газрын 2024, 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт шинжлэх ухаан технологийн арга хэмжээний зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувьд хүргэнэ гээд заачихсан байгаа. Та энэнийг нэг хэлбэрэлтгүй барьж байгаад 2028 онд энэ хувьд нь хүргээдэх юм бол салбар бол эрс хурдан сэргэх юмаа. Тэгэхээр энд судалгаа хөгжүүлэлтийн ажилд шууд өгдөг зардал, өөрөөр хэлбэл эрдэм шинжилгээний ажлын жилийн зардал нь сүүлийн 15 жилийн дунджаар аваад үзэхэд Туулын хурдны замыг 100 метр зам барих зардалтай л тэнцэж байгаа. Туулын хурдны одоо төсөвлөж байгаа 100 метр зам барих мөнгөөр шинжлэх ухаан технологийн салбараа авч явж энэ бол бүр бүтэхгүй юм л даа.

Хоёр дахь асуудал бол энэ хөдөөгийн хөгжлийн асуудал байгаа юм. Тэгэхээр бид нар хөдөөг соёлжуулан хөгжүүлэх үү, эсвэл тэгсхийгээд байлгаад байх уу гэдэг ийм л замын ацан дээр л байгаад байгаа. Олон жил энэ хэмжээндээ байгаад байгаа юм. Тэгэхээр зэрэг миний бодлоор одоо энэ сумын төвийг аймгийн төвтэй авто замаар холбох, цаашдаа сумын төвүүдийг холбох энэ асуудлыг ер нь нэг анхаарч үзмээр байгаа юм. Жишээлбэл нэг дунджаар бодоход 4 сумын төвийг аймгийн төвтэй холбоход 600 орчим тэрбум төгрөг орж байгаа юм. 150 км зам барина гэж бодоход. Энүүгээрээ сумуудын төвд инженерийн дэд бүтэц, төвлөрсөн халаалтын систем хийвэл 110-120 сумын төвийг энэ 600 тэрбум төгрөгөөр хийх юм байгаа юмаа. Тэр машин өдөрт 10 машин явдаг замыг барих гэж улайран хөөцөлдөж байхын оронд энэ инженерийн дэд бүтцийг хийвэл илүү үр дүнтэй ажил болно. Соёлжино, одоо энэ сургуулийн цэцэрлэг, сургууль, цэцэрлэг, дотуур байрны

хүүхдүүдийн ариун цэврийн байгууламж жинхэнэ бодит утгаараа ажиллаж эхэлнэ. Хүүхэд бүр хар багаасаа ийм байгууламж ашиглаж сурна гээд ач холбогдол ихтэй.

Гурав дахь асуудал болбол бид нар ер нь сүүлийн 20 гаруй жил энэ хүртээмжтэй эдийн засгийн сууриа огт тавьсангүй. Хөгжлийн тулгууруудаа ерөөсөө бэхжүүлсэнгүй. Энэний гол зангилаа асуудал бол энэ ядууралд байгаад байдаг юм байна аа. Сүүлийн 20 гаруй жил ядуурлын түвшин үндсэндээ 30 хувьтай, за яах вэ нэг 27-30 хувийн хооронд хэлбэлздэг. Ядуу хүмүүсийн тоо хүн амын өсөлтөө дагаад улам өсөж нэмэгдээд байдаг. Энэ ядуурлаа бууруулахгүй бол бид нар одоо дундаж давхарга гэж түм яриад ямар ч нэмэр байхгүй нэг талаас. Нөгөө талаас дээд талд байдаг одоо баян чинээлэг давхарга хэзээ ч тэр дундаж давхарга руу орж бараг ирэхгүй, нөлөөлөхгүй. Бид нар ядуурлын түвшнээс энэ хүнээ хүмүүсээ гаргаж байж, дундаж давхаргаа бодитой бий болгож, улс орныг хөгжлийг тогтвортой авч явах суурийг тавина гэдэг нь бол ойлгомжтой байгаа юм.

БНХАУ 15 жилийн дотор 600 сая хүнээ ядуурлын шугамын доор байсан 600 сая хүнээ гаргасан. 15 жилд 600 сая. Тэгэхлээр зэрэг та Ерөнхий сайд болчихвол энэ Засгийн газрынхаа холбогдох улсуудаас нэг хэдэн хүн Хятад руу явуулаад, энэ арга барилыг нь нэг судлуулаад, энийг бодитой хийхгүй болбол бид нар дундаж давхаргагүй болоод ингээд явчих нь байна шүү. За баярлалаа.

Д.Амарбаясгалан: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн үг хэлье.

Д.Пүрэвдаваа: Оройн мэнд хүргэе ээ. 3 санал байна. Нэгдүгээрх нь асуулт асууж байхдаа би ярьсан. Төрийн аудитын асуудал байна аа. Ерөнхий сайд хүн бол энэ санхүүгийн сахилга бат гэдгийг бас мөрдүүлэх ёстой, үүрэгтэй хүн гэж бодож байна. 2024 онд төсвийн тодотгол хийгээд 30 их наядыг баталж өгсөн. Үндэсний аудитын газар миний санаж байгаагаар нэг 60 орчим төсвийн ерөнхийлөн захирагч нарт одоо хяналт тавьдаг. Тэр 60 орчим одоо ерөнхийлөн захирагч нараас миний ойлгосноор 2024 онд бараг дийлэнх яам хязгаарлагдмал аудитын дүгнэлт авсан. Тэгэхээр энэ хязгаарлагдмал дүгнэлт авсан сайд нарыг эргэж та одоо ирээдүйд алдаа гаргахгүй биз ээ гээд одоо багтаа оруулах вий. Тэрэн дээр бас тодорхой үнэлэлт дүгнэлт өгөөрэй гэж санал гаргамаар байна аа.

Хоёрдугаарт энэ төрийн нууцад авч байгаад будилаан тарьдаг энэ ялангуяа өгөөжгүй, эдийн засгийн хувьд, санхүүгийн хувьд өгөөжгүй худалдан авалтууд явагдаж ирсэн. Хамгийн тод жишээ нь ногоон автобус. Манай Үндэсний аюулгүй байдлын зөвлөл бол миний ойлгосноор та ч түрүүний хэлсэн одоо зэвсэгт хүчний чиглэлийн ч гэдэг юм уу, төрийн нууцад байх хэмжээний худалдан авалтыг авах ёстой болохоос биш ногоон автобус бол төрийн нууцад байх шаардлагагүй ээ.

Дээрээс нь шахмал түлшний үйлдвэр төрийн нууцад байх шаардлагагүй ээ. Олон улсын нээлттэй тендерээ зарлаад, сайн Япон, Германыг нь чаддаггүй юмаа гэхэд ядаж Солонгосыг нь авдаг хэмжээнд Монгол Улс баймаар байна аа. Та цаашдаа аль болохоор ийм нууцад авч худалдан авалт хийхгүй байх ийм саналыг гаргаж байна аа.

Гуравт нь, Засгийн газар ялангуяа яаралтай шуурхай горимоор Улсын Их Хуралд хуулийн төсөл оруулж ирдэг ээ. Хууль тогтоомжийн тухай хуулиа зөрчөөд, уул нь бол хууль зүйн хувьд яаралтай горимоор бол мөн адил үндэсний хэмжээнд үр өгөөж өгөх, богино хугацаанд зайлшгүй шийдвэрлэх үндэслэл бүхий хуулийг

оруулж ирэх ёстой төслийг. Гэтэл өнгөрсөн парламент таныг байх үед, одоо байх үед ч гэсэн Засгийн газар маш олон удаагийн давтамжтайгаар хууль тогтоомжийн хуульд нийцүүлж боловсруулах ёстой хуулийг яаралтай, мөн одоо тийм түргэвчилсэн горимоор шийдвэрлээд байгаа. Энэ нь амьдралд дандаа эерэг гэхээсээ сөрөг үр дүнгүүдийг тогтмол авчирч байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн үг хэлье.

С.Эрдэнэболд: Эзэн хичээвэл заяа хичээнэ гэж монгол үг байдаг. Өнөөдөр Монгол Улсын жирийн иргэн хичээгээд хичээгээд заяа нь улам доройтоод байгаа нөхцөл байдал тоо статистик байна аа. Тэгэхээр энэ дээр болбол энэ шинээр бүрэлдэх Засгийн газар, түүнийг тэргүүлэх Ерөнхий сайд онцгой анхаарч иргэд юунд, яагаад бухимдаад байна гэдгийг өглөө болгон санаж байх ёстой. Тангууд улс мөхөөгүй гэдгийг өглөө болгон сануул гэдэг шиг иргэд юунд бухимдаад байна, яагаад бухимдаад байгаа юм бэ гэдгийг өглөө болгон санах ёстой. Бодит байдлыг хүлээн зөвшөөрөх ёстой. Үнэнийг иргэдээсээ нууж болохгүй. Манай олон алдаа өмнөх алдаанууд амьдралыг хэтэрхий гоёчилж, хээнцэрлэж, халаас нь хоосон байхад чи сайхан амьдраад байгаа шүү гэдэг үлгэр зохиож түүнийгээ үзэл суртал болгосноор нэг өдөр иргэдийн бухимдал огцрох амархан гэж тэсэрч байгаа.

Зуны тэргүүн цагаагчийн могой сарын хар хулгана өдөр Монгол Улс 34 дэх Ерөнхий сайдтай болно. Энэ Ерөнхий сайд томилогдсоны дараанаас өгсүүлээд хариуцлагын том ачаа үүрнэ. Өнөөдөр олон гишүүд таныг дэмжиж, итгэж найдаж, танаас асар их хүлээлттэй үг хэлж байна. Бүгдийг нь биелүүлэх амаргүй хэцүү. Гэхдээ бодит байдлаа иргэдээсээ нууж болохгүй, үнэнийг хар цагаанаар нь хэлнэ гэдэг болбол төрийн зүтгэлтэн хүний, бас гүйцэтгэх засаглалын тэргүүн хүний үүрэг байх ёстой гэж бодож байгаа.

Мэдээж бид нар төсөл хөтөлбөр, мөнгө, аж ахуйн асуудал ярина аа. Энэ бол бодлогын асуудал шүү дээ. Гэхдээ хамгийн бага яригдаад байгаа зүйл бол монгол үндэстний оюун санааны дархлаа, оюун санааны тусгаар тогтнолын асуудал. Бид 2 хүчирхэг одоо хөрштэй. Олон улсын нөхцөл байдал асар эгзэгтэй ээдрээтэй. Монгол үндэстэн яаж илүү хүчирхэг хөгжин мандаж оршин тогтнох вэ гэдэг асуулт бол Ерөнхий сайдын өдрийн бодол, шөнийн зүүд байх ёстой. Кабинетын, байнгын тэмцэл зорилго байх ёстой. Энэ жил 130 жилийнх нь ой болж байгаа Жамсрангийн Самбуу гуайн тогтоолыг Улсын Их Хурал баталсан. Самбуу гуайн хойч үедээ хэлсэн, бас Самбуу гуайн үеийн нэр цэвэр түүхэнд үлдсэн зүтгэлтнүүдийн хэлсэн нэг үг бол төрийн хүн шуналгүй байх ёстой л гэсэн. Та, таны бүрэлдүүлэх кабинет шуналгүй байх ёстой. Шуналгүй хүмүүсийг зөв үйл хэргийг бий болгож чадах хүмүүсийг кабинетдаа оруулах ёстой. Ямар нэгэн шахаас, ямар нэгэн түлхээсээр биш, хожим нь насны эцэст эргээд харахад харамсахгүй, тэр үед тэгдэг байж дээ гэж бодохгүй хэмжээнд тултал нь ажиллах ёстой. Яагаад гэвэл энэ бол Монгол Улсын Засгийн газар. Аль нэг намын биш. Явцуу, ашиг сонирхол тээсэн хүмүүсийн биш Монгол Улсын Засгийн газар.

Тийм учраас мянга мянганаар өртөөлсөн Чингисийн төрийн Засгийн газар. Тийм учраас үүнийг та бас эрхэмлэн бодож яваарай. Харьцангуй уншдаг хүн учраас энэ зүйлийг хэлж байна. Огцрох амархан гэдэг талбай дээр 20 гаран хоног хэлэгдсэн үг дахиад л таныг ажлаа авсан эхний өдрөөс магадгүй хүмүүсийн сэтгэл дотор сэдэл болж эхэлнэ ээ. Тийм учраас итгэл гэдэг зүйлийг алдахгүйн тулд хичээгээрэй гэж

эрхэмлэн хүсье. Монгол төрийн алтан босгод бэлтгэгдсэн хүмүүс очиж ажиллах ёстой. Кабинетаа ард түмний итгэл даасан хүн.

Д.Амарбаясгалан: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн үг хэлье.

Л.Соронзонболд: Ерөнхий сайдад нэр дэвшигч Гомбожавын Занданшатарыг дэмжиж байгаа. Өнөөдөр энэ яриад байгаа энэ Орон сууцжуулалтын банкны санааг бол дэмжиж байна. Гэхдээ энийг бол төр дангаараа хийх биш хувийн сектортой хамтарч хэрэгжүүлээд, хэрэгжүүлсэн тохиолдолд яаж дэмжихээ л тодорхой болгох нь зөв болов уу гэж хэлмээр байгаа юмаа.

Яагаад гэхээр одоо Засгийн газрын хөтөлбөрт маш их идэвхтэй оролцсон Монгол банк өөрөө 7.5 их наяд төгрөгийн алдагдалтай байгаа. Онолоороо бол энэ алдагдлыг Засгийн газар нөхөх ёстой. Дүрмийн санг нь нөхөж өгөх ёстой. Хэрвээ дээрээс нь нийгмийн даатгалын нэрийн дансны 30 их наяд төгрөгийн өрийг гээд бодоод үзэх юм бол Монгол Улсын Засгийн газрын бодит өр бол маш их болно оо. Тийм учраас одоо аливаа ажлыг хийхдээ төр өөрөө хийх биш хувийн сектороор хийх, хамтарч хэрэгжүүлэх тал дээр сайн анхаарах ёстой гэж хэлмээр байгаа юм.

Нөгөө талдаа бид нар ингээд 14 мега төсөл гээд ирэх 4 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ ээ гээд 2024 онд баталсан. Тэгэхээр эдгээр одоо төслүүдийг Монгол Улсад үзүүлэх нийгэм эдийн засгийн ач холбогдол, өөрийгөө санхүүжүүлэх болон одоо орлого олох боломжоор нь эрэмбэлж хэрэгжүүлэх дээр бол анхаармаар байгаа юмаа. Яагаад гэхээр эдгээр төслийг хэрэгжүүлбэл гэхээр бол дахиад л Засгийн газрын өрийн таазны асуудал үүсээд байгаа юм. Тийм учраас төр өөрөө хэрэгжүүлэхээсээ илүүтэйгээр Монгол Улсын чадалтай томоохон компаниудаараа хариуцуулж хийлгэх талд дээр бас санаачилгатай ажиллаарай гэж бол захимаар байна аа.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн үг хэлье.

Ц.Идэрбат: Оройн мэнд хүргэе. Тэгээд улс оронд үүсээд байсан нөхцөл байдал, дараагийн Ерөнхий сайд хэн байх нь вэ. Манай нам одоо ямар шийдвэр гаргах нь вэ гээд олон асуулт ингээд өнөөдөр хариултаа авч байна. МАН-ын Бага хурал бол бас нэлээн дотоод ардчилалтай, нэлээн илэн далангүй, олон ч одоо 50 гаруй гишүүд улс орон, орон нутагтай холбоотой асуултуудад бас нэр дэвшигчдээс асуултаа, хариултаа бас нэлээн тодорхой авсан. Сая Улсын Их Хурлын 80 гаруй гишүүдийн энэ асуултыг бас нэг бүрчлэн сонслоо. Хариултыг ч нэг бүрчлэн бас сонслоо. Тэгэхээр ард түмэн бол одоо бид нараас энэ татварын шинэчлэл, энэ одоо баялгийн сан, тэгш хуваарилалт, энэ авлигал гээд энэ олон зүйлүүдээс одоо бас хариулт хүсэж байгаа.

Тэгээд Монгол Улсын Ерөнхий сайдаар хэрвээ та одоо ингээд сонгогдвол энэ асуудлууд дээр ямархуу байр суурь баримтлах вэ гэдгээ бас нэлээн тодорхой илэрхийллээ. Тэгээд энэ 2 хурал дээр хэлсэн хариулт болгоныг бас харьцуулж ингэж үзэхэд бас тэнд Бага хурал дээр ярьсан зүйл өнөөдөр ч гэсэн энэ Их Хурлын чуулганы танхимд яг л одоо бас хариулагдаж байна. Нөгөө талдаа бол та 20 гаран жил энэ Монголын улс төрд бас Монгол төрийн олон чухал албыг хашиж явсан ийм хүн.

Таныг одоо парламентын даргаар ажиллаж байх тэр цаг хугацаанд тэр Үндсэн хуулийн өөрчлөлт, энэ баялгийн сан гэдэг энэ зүйл өөрчлөлтөөр орж ирсэн. 2022 оны Эрүүгийн хуулийн тэр авлигатай холбоотой хатуу санкцууд бас орж ирсэн. 2024 оны энэ баялгийн сангийн хууль бас тийм ч амар биш байсан ч бас л парламентын босгыг давуулаад л ороод ирсэн. Тэгэхээр таны энэ 2 хурал дээр хэлсэн үг, өнгөрсөн энэ парламентын танхимд байхдаа хийж хэрэгжүүлж байсан эндээс бол ам ажлын зөрүү бол би бас нэг их тийм гарахгүй юм байна аа гэсэн ийм ойлголтыг энэ хоёр, гурав хоногийн хугацаанд бас авлаа гэдгээ нэн түрүүнд хэлье гэж ингэж бодож байна.

Тэгээд одоо сарын дараа наадам, наадмын маргааш намар, бидний өмнө олон тулгамдсан асуудал байгаа. Цаг алдахгүй ажилдаа орно гэсэн ийм зүйл байгаа юм байна. Тэгээд амжилт хүсье. Дэмжинэ гэдгээ илэрхийлье. Нөгөө талдаа бид бүхэн бол бас ардаа сонгогчидтой. Энэ 2028, 2024 оны сонгууль бол олон онцлогтой болсны нэг нь бол энэ бүсчилсэн хөгжил.

Манай зүүн бүсийн хувьд бол одоо түүхэн аялал жуулчлал, мал аж ахуй, дээрээс нь бол одоо бүсийн өөрийнх нь онцлог энэ 2 том хөрштэйгөө хиллэдэг, 7, 8 боомттой гээд ингээд олон энэ онцлогуудыг агуулсан одоо үйл ажиллагааны, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр томоохон зорилтууд туссан. Энэ 6 сарын 9-ний өдөр зүүн бүсийн зөвлөгөөн болох байлаа. Энэ зөвлөгөөнөөр бас энэ зүүн бүсийн олон асуудлууд шийдэгдэх байсан. Тийм учраас энэ зөвлөгөөнтэй холбоотой, хийгдээгүйтэй холбоотой энэ асуудлаас болоод энэ зүүн бүсэд хийгдэхээр төлөвлөгдсөн олон ажлууд бас битгий цалгардаасай гэж ингэж бас хүсэж байгаа.

Зүүн бүсийн ард иргэд бол биднээс маш их том хүлээлт байгаа гэдгийг бас та Ерөнхий сайдаар одоо сонгогдоод бас би анхаараасай гэж ингэж бас бодож байгаа гэдгээ бас зориуд хэлье ээ гэж ингэж бас цаг авсан юмаа. За амжилт хүсье. Баярлалаа Танд.

Д.Амарбаясгалан: Цэндийн Баатархүү гишүүн үг хэлье.

Ц.Баатархүү: Улс төрд бол улс төрийн соёл гэж ойлголт байдаг. Өнөөдөр Ерөнхий сайдад нэр дэвшигчид амжилт хүсье. Эхнийхээ 100 хоног хүртэл бол парламентын гишүүд дэмжээд явдаг. Би одоо Засгийн газрын гишүүнээр ажиллаж байсан хүний хувьд бол эхний 100 хоногт бол оруулж ирсэн асуудал болгоныг бол дэмжинэ ээ. 100 хоногийн дараанаас эхлээд Засгийн газраас оруулж ирсэн төсөл хөтөлбөрийн үр дүн хаа байна аа гэдэг хариултыг, хариуцлагыг иргэд олон түмэнтэйгээ хамт нэхэх болно гэдгийг хэлэх нь зөв байх аа.

Хоёрдугаарт төр бол төрийн одоо өндөр албан тушаалын хүн аливаа асуудалд дандаа ирээдүй цаг дээр биш яг өнөөдөр, өнгөрсөн цаг дээр хариулдаг ийм зарчимтай байх хэрэгтэй гэж боддог. Хоёрдугаарт, төр энэ төрийн өндөр албан тушаал хашиж байгаа хүн төр өөрөө ингээд горьдлого төрүүлдэг, иргэддээ дандаа итгэл төрүүлдэг, түүнийгээ биелүүлж чаддаггүй, ийм байдлаар ажилдаа бас хандаж болохгүй гэж боддог

Гуравдугаарт нь бол бүх зүйлийг хийх гэж оролдох нь өөрөө төрийн том алдаа болдог. Хамгийн чухал зүйл юу юм бэ гэдгээ эрэмбэлээд хийгээд явсан нь зөв байдаг. Хамгийн түрүүнд шинэ Засгийн газрын хувьд бол салбар болгоны нэгдсэн

мастер төлөвлөгөөг оруулж ирэх нь зөв байх аа гэж бодож байна. Бид нар маш энгийн жишээ хэлмээр байна. Улаанбаатар хот дээр хотын нэг дарга болоод түгжрэлийг шийдэхийн тулд метро санаачилсан. 2015 онд үүний дараа Виарти буюу тусгай замын автобус төслийг санаачилж, Улсын Их Хурлаар зээлийн гэрээ байгуулсан. Тусгай замын автобус яваагүй, метро яваагүй. Дараагийн дарга нь Эльарти санаачилсан. Түүний дараагийн хотын дарга нь бол дүүжин тээврээр шийдэх оролдлого хийсэн. Энэ юу хэлээд байна вэ гэхээр салбар болгонд салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө байхгүй байгаатай л холбоотой.

Ирсэн дарга болгон лоббиныхоо төслийг шахдаг, батлуулдаг, хийх гэж оролддог, үр дүн гардаггүй. Үүний 2 дахь жишээ агаар орчны бохирдлыг бууруулах асуудал. Зуухыг нь сольсон, янданг нь сольсон, янданд нь шүүлтүүр тавьсан сайжруулсан түлшний үйлдвэр байгуулсан. Хамгийн гол асуудал нь пассив барилгын стандарт, дулаалга, гэр хорооллын дахин төлөвлөлт байжээ гэдгийг тойроод яваад байсан. Энэ би хэн нэгнийг буруутгах гээд байгаа юм биш. Энэ салбаруудын нэгдсэн төлөвлөгөө төр, хувийн хэвшил, судалгаа шинжилгээний байгууллага гэсэн энэ гурвалжин дээр явахгүй байна аа. Хөгжлийн алтан гурвалжин гэдэг ойлголт бол төр, хувийн хэвшил, их сургуулиудын холбоосон дээр явна аа.

Тийм учраас одоо Монгол Улсын Ерөнхий сайдаар одоо сонгогдож байгаа Занданшатар дарга та бол энэ хөгжлийн гурвалжин гэдэг зарчмыг барьж ажилдаа хандахыг хүсэж байна. Ингээд таны Монгол төрийн хариуцлагатай ажилд томилогдох энэ үйл хэрэгт нь өндөр амжилтыг хүсэн ерөөе өө. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн үг хэлье.

Н.Батсүмбэрэл: Манай Баянхонгор нутгаас 34 дэх Ерөнхий сайд томилогдох гэж байна. Хөдөө орон нутгийн иргэдийн амьдралд дэм тус болох олон ажлыг хийж чадна гэдэгт бол итгэлтэй байна. Улаанбаатар хотын асуудлыг битгий орхигдуулаарай. Улаанбаатар хотод бол улсын хүн амын тал нь амьдарч байгаа. Эдийн засгийн дийлэнх эргэлдэж байгаа ийм газар шүү гэдгийг захиж хэлье ээ.

Бид ер нь эдийн засаг, тоо, мөнгө ярьсаараа байгаад нийгмийн дархлаагаа орхисон байна аа. Нийтийн эрүүл мэндээ орхисон байна аа. Боловсролын салбараа гээгдүүлсэн байна аа. Уг нь бол улс орны ирээдүй бол боловсролын хөгжил юмаа. Энэ боловсролын салбарт байгаа өндөр төлбөртэй хувийн сургууль өргөн олон түмний хүүхдүүдийн суралцдаг ардын сургууль хоёрт байгаа ялгааг та арилгаарай гэж би танд захъя аа. Та эрдэм номтой ойрхон хүн учраас энийг хийж чадна гэдэгт бол бүрэн дүүрэн итгэлтэй байна. Боловсролын өнөөдрийн доройтол ялзрал бидний бүрхэг харанхуй болгох биш боловсролын хөгжил, соён гэгээрэл биднийг урагш нь чирж, урагш нь хөгжүүлнэ гэдэгт би итгэж явдаг аа. Тийм учраас эрдэм номдоо ойрхон Ерөнхий сайд энэ ажлыг хийгээсэй гэж бодож байна.

Мөн нийгмийн олон шүүмжлэлийг та бас сонсож, хүлээж авч, эергээр дүгнэж үздэг Ерөнхий сайд байгаарай гэж хэлье ээ. Сая энэ дуулаад байгаа ахад зориулж хэлэхэд АН бас нэг тийм гэгээн цагаан нам биш шүү дээ. Монгол Улсыг 2012-2016 онд удирдсан, дампууралд нь аваачиж деполт хийнгээ алдсан. Засгийн газар удирдаж байсан Ерөнхий сайд нь эх орондоо ирж чадахаа больчихсон. Улсын Ерөнхийлөгч нь Тамгын газрын даргатайгаа оргон зайлчихсан тийм нэг сайхан гэгээн нам биш шүү. Энэ АН-ын нөхдүүд. Нөгөө нэг олон сайхан төсөл хөтөлбөрүүд

нь хаана байна. Нэг гэгээн сайхан одоо ажил хийж байсан юмыг яриад байж таарахгүй шүү гэдгийг бас энд эрхэм нөхдүүддээ хэлье ээ.

Улс орны нөхцөл байдал амаргүй байж байгаа. Геополитикийн ээдрээтэй үед бид хамтдаа урагшаа ажлуудаа явуулах ёстой гэж сая хамтарсан Засгийн газар байгуулаад ажилласан. Манай АН-ын журмын нөхдүүд нь өөрсдөө нэг нь гарч ирж огцруулна гэж гарын үсэг цуглуулаад л, нөгөөх нь гарч ирж шилбэдэж өшиглөөд л Засгийн газраа татаж унагах үндэслэлийг тавьсан шүү дээ. Бодит амьдрал нь энэ шүү дээ. Тийм учраас бас хаа хаанаа ухамсартай, ухаантай, бодолтой байцгаая аа. Тэгээд сонгогдож байгаа Ерөнхий сайдад ажлын өндөр амжилтыг хүсье ээ.

Д.Амарбаясгалан: Сонгобайн Замира гишүүн үг хэлье.

С.Замира: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ. Манай орон бол манай улс бол тийм ядуу улс биш ээ. Маш баян орон. Харин энийг бодитой ажил л болгох нь жоохон дутмаг байгаад байгаа байхгүй юу. Тийм учраас төрийн ч бай та бүхэнд маань нэг их бухимдаад, ард түмэн нь бас нэг их санаа зовоод хэрэггүй болов уу гэж би бодож байна. Ийм нэг амьдралын туршлагатай, файл ийм боловсролтой, эдийн засгийн мэдлэгтэй, өндөр мэдлэгтэй ийм хүн манай Засгийн газрыг удирдах гэж байгаад нь би их баяртай байна үнэнийг хэлэхэд.

Тэгэхдээ манай шинэ Ерөнхий сайд ажлаа юунаас эхлэх вэ? Хамгийн гол асуудал цахилгаандаа болоод байна. Цахилгаангүйгээр одоо үйлдвэр явахгүй, цахилгаангүйгээр халаалтын үнэ нэмэгдэнэ, цахилгаангүйгээр цахилгааны үнэ нэмэгдэнэ. Ард түмний нуруунд ачаа болоод бууж байна шүү дээ бүх юм чинь. Тийм учраас эхний ээлжид цахилгааны асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй. Тэгж байж том төслүүд, тэгж байж нөгөө бусад юмнуудыг ярих хэрэгтэй болж байна л даа.

Хоёрдугаар асуудал болохоор одоо жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх, дунд давхаргыг одоо дэмжин хөл дээр нь босгох, өрх бүрийн орлогыг сайжруулахын төлөө банк санхүүгийн асуудал. Банк санхүүгийн асуудал манай улсад замбараа алдсан. Одоо Монгол банк нь байна уу, бусад банк нь байна уу бүгдээрээ ББСБ-тай. Зарим нэг нь өдрийн нөгөө зээлдэгч билүү юу билээ нөгөө интернэтээр нь юу мөнгө зээлээд байдаг мөнгө хүүлэгчид ихэссэн. Ард түмэн бүүр зээлээс зээлийн хооронд амьдарч байна. Тийм учраас энэ замбараагүй банкны системийг нэг тийш нь болгох ёстой. Тэгээд бас авлигал хээл хахууль гээд газар авсан. Манай улсын нэг хөгжихгүй байгаа гол шалтгаан нь эндээ л байгаа. Энийг таслан зогсоох хэрэгтэй. Бүүр болохгүй бол баривчилж шоронд хорих хэрэгтэй зарим нэг хэсгийг нь. Тэгээд яваандаа өөр бусад нь нэг айгаад болих байлгүй дээ.

Тэгээд Монгол Улсын энэ үндэсний баялаг бол ашигт малтмал, ашигт малтмалын алт хөтөлбөрийг дэмжих хэрэгтэй. Тэгээд 5 хошуу мал, 5 хошуу малын мах, түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн гаргаж, экспортлох хэрэгтэй. Боловсрол, эрүүл мэндийн салбарт анхаарах хэрэгтэй. Тэгээд ямар ч үр дүнг нь гол нь хурал цуглаанаа зогсоох хэрэгтэй. Ийм их зардал гаргаад нэг цуглаан, хурал цуглаан хийгээд байдаг ямар ч үр дүн байхгүй. Тэгээд одоо улс төржөөд хар цагааныг дэнсэлсэн нэртэй хэн нэгэн албан тушаалтанд буруу өгч суух биш өндөр хэмжээтэй татвар, хураамж нийгмийн даатгал гэх мэт ард иргэдийн нуруунд үүрүүлсэн хүнд ачааг хөнгөрүүлэхийн тулд бодитой, оновчтой шийдлийг эрэлхийлж, шуурхай арга хэмжээ авч ажиллахыг шинээр байгуулагдах Засгийн газраас хүсье ээ. За танд амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн үг хэлье.

Б.Батбаатар: Өнөөдөр их олон гишүүд асуулт асууж, тэр болгонд хариултаа авч, дээрээс нь бас олон гишүүд санал хэлж, захиа даалгавар өгч байх шиг байна. Ер нь Ерөнхий сайд бол бас алтан загас биш. Тийм учраас бүх зүйлийг хийж чадах уу, чадахгүй юу гэдгийг бас тэр болгон хэлээд байхад их хэцүү. Үүнд бол парламентын буюу Улсын Их Хурлын энэ танхимд суугаа гишүүд, дээрээс нь парламентын 5 намын улс төрийн бодлогын дэмжлэг үзүүлэх шаардлагууд үүсэх байх аа.

Иргэний Зориг Ногоон Намын гишүүд бол саналаа нэгтгэсэн. Ерөнхий сайдад итгэл үзүүлэх эсэх асуудал дээр саналаа илээр хураалгая аа гэдэг саналыг тэр талд нь кнопоо дарж байсан. Бид энэ томилгоон дээр ч гэсэн саналаа нэгтгэсэн, нэгэн жигд санал өгнө өө. Бидний зарчим Иргэний Зориг Ногоон намын өв соёл бол нэгдүгээрт нь эрх ашгийн эрэмбэ Монгол Улс, 3 сая илүү ард түмэн. Энэ бол бидний 1 дүгээр зарчим. Монголчууд ядууралгүй улс орондоо эзэн болж, ажиллаж, амьдарч чадах нь бид нарын эн тэргүүний зорилт.

Энэ зарчим дээр нийлж байгаа тохиолдолд Иргэний Зориг Ногоон Намын гишүүд, Иргэний Зориг Ногоон Нам энэ зарчим дээрээ бол тууштай зогсоно оо. 126 гишүүнтэй анхны парламент анхныхаа Ерөнхий сайдын нүүрийг сольж дараагийн Ерөнхий сайдаа хүлээж авах гэж байх шиг байна. 3 Их Хурлын дарга, 3 Ерөнхий сайдын нүүр үзсэн парламентад гишүүн байсны хувьд юугаар туулж, яаж энэ асуудлууд өөрчлөгддөгийг мэднэ. Улс төрийн шийдвэрүүд нөлөөлдөг. Эрх ашгийн эрэмбийн алдаа, хаан сонголтоо хогийн сонголт болгож хувиргадаг тийм л зүйлүүд явж өнгөрсөн.

Нэр дэвшигч Занданшатар бол тэр парламентад сууж байсан тийм л гишүүн. Тэгэхээр энэ зовлонг, энэ замыг туулж гарна гэдэг бол хувь хүний улс төрийн гарц гаргалгаа, улс төрийн шийдвэр, түүнийгээ дэмжүүлж чадах эр зориг, ур чадвар энэ бүх зүйлээс хамаарна. Аливаа асуудал улс төр дээр очоод гацдаг. Гэхдээ Иргэний Зориг Ногоон нам энэ соёлыг бол зөвшөөрөхгүй байгаа. Ингэвэл тэгнэ шүү, тэгвэл ингэнэ шүү гэдэг үг Иргэний Зориг Ногоон Намын гишүүдийн амнаас нэг ч удаа гарч энэ танхимд унаагүй ээ. Ямар нэг байдлаар шантааж рэкетийн маягтай улс төр эрх мэдлийн албан тушаал дээр бид нар дөрөөлж асуудал ярьдаггүй ээ. Улс орны эрх ашгийн төлөө эн тэргүүнд тавьж асуудал ярьдаг. Тэгэхээр Засгийн газрын энэ төрийн загварчлал хэмнэлттэй, үр дүнтэй, бүтээмжтэй, хяналттай, дээрээс нь хурдтай ажиллах тэр зориг бол Ерөнхий сайдын манлайллаас ихээхэн шалтгаалдаг зүйл.

Бид нар Монгол Улсад шинжлэх ухаан ялж байх ёстой гэдэг зүйлд итгэл үнэмшлээ нэгтгэх хэрэгтэй. Хийх өөр бол дэгдсэн өчүүхэн салхинд хийсдэг хамхуул шиг байж болохгүй. Ингээд Засгийн газар 3 сая 500 мянган ард түмнээ сайхан амьдруулахын төлөө ажиллах ёстой гэж, ядууралгүй байх ёстой гэж хэлье ээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн үг хэлье.

Б.Жаргалан: МАН-ын Бага хурал гэдэг байгууллага сүүлийн 1 сарын хугацаанд 2 удаа хуралдлаа. Эхний удаагийн хурлаар Ерөнхий сайдын орлогоо

нотлох асуудлыг хамтарсан Засгийн газрын асуудал болгож ачааны хүндийг үүрч ирсэн АН-ыг гэрээг зөрчсөн гэж илт гүжирдсэн. Ингэхдээ хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд АН-аас оруулсан эдийн засгийн эрх чөлөөний реформ шинэчлэлийн бодлогыг үгүйсгэж, дангаараа буюу хяналтгүй засаглах шийдвэр гаргасан. Хоёр дахь удаа хуралдахдаа иргэд олон нийт хэвлэл мэдээллээс нуугдаж байгаад битүү хатуу байдлаар Ерөнхий сайдад нэр дэвшигчийг тодрууллаа. Энд сууж байгаа олонхын бүлгийн 68 гишүүн намынхаа Бага хуралд харьяалагддаг л байлгүй. Та нарт л гэж хэлэхэд парламентын ардчиллын гол онцлог бол Ерөнхий сайд парламентын гишүүн байдаг бөгөөд эргээд энэ танхимынхаа өмнө хариуцлага хүлээдэг. Гэтэл МАН-ын Бага хурал гэдэг байгууллага намаасаа сонгогдсон бүхэл бүтэн 68 гишүүний хэнийг нь ч Ерөнхий сайдаар ажиллах чадамж, чадваргүй гэж үзсэн нь хачирхалтай санагдаж байна. Энэ ч яах вэ танай намын дотоод асуудал.

Бид бүхэнд хамаатай асуудал гэвэл бид парламентын ардчиллаа бэхжүүлэх, хамгаалах ёстой гэж яриад байдаг. Занданшатар гуай ч гэсэндээ олон жил энэ танхимд суусан, Улсын Их Хурлыг даргалж байсан хүний хувьд парламентын тогтолцооны мөн чанарыг ойлгож байгаа гэдэгт итгэж байна. Сая намаасаа түдгэлзээд 4 жил болж байгаа Ерөнхийлөгч энэ танхимд орж ирээд парламентын дархлаа гэж ярьсан атлаа энэ томилгоонд ч мөн бас мөн ил далд хэлбэрээр оролцсон гэгдэж байна. Тиймээс нэр дэвшигч маань засаглал хоорондын хяналт тэнцлийг маш сайн хангаж, хөндлөнгийн нөлөөнд автахгүй байхыг хичээх хэрэгтэй болов уу. Улсын Их Хурлын гишүүд бид ч гэсэндээ бас энэ үйл хэрэгт шамдаж, энэ институт хоорондын зөрчлөөс бас урьдчилан сэргийлэх шаардлагатай санагдаж байна.

Ер нь хараад байхад эрх баригч намын шийдвэр гаргаж байгаа процесс бүх процесс маш хаалттай, иргэд олон нийтээс тусгаарлагдмал хэлбэртэй байна аа. МАН-ын Бага хурал бол төр гэсэн хандлагатай. Уучлаарай та нар олонх байж болно гэхдээ өөрсдийгөө төр гэж бүү андуур. Монгол төрийн шийдвэр засаглал хоорондын олонх цөөнхийн хяналт тэнцэл дунд иргэдийн хараа хяналт дор гарах учиртай. Тиймээс цаашид Улс төрийн намын тухай хуулийг өөрчилж намын удирдах албан тушаалтан сонгуульт гишүүнийг төрийн сонгууль, улс төрийн өндөр дээд албан тушаалд нэр дэвшүүлэх журам шалгууруудыг хуульчилж өгөх шаардлагатай гэж бодож байна.

Улс төрийн нам ил тод нээлттэй, дотоод ардчилалтай болж байж засаглал сайжирна аа. Энэ шинэчлэлийг бид хийж чадвал парламентын бүрэн эрхээ хамгаалах, ардчиллаа хамгаалахад чиглэсэн том алхам болно гэж харж байна. Энэ танхимд яригдсан бүх бодлогын шийдлүүд ч гэсэндээ эх үндэс нь энд байна аа. Цаашид энэ Улсын Их Хурал Монгол Улсад тулгамдсан улс төр, нийгэм, эдийн засгийн асуудлуудаа шийдвэрлэх, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, бизнесийн орчныг сайжруулах, үндэсний аж ахуйн нэгжүүдээ дэмжих, ардчилал сайн засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн эрх зүйн шинэчлэлийг хамтдаа хийгээд явах итгэлцэл, орон зай, хүсэл зориг байгаа гэж итгэж байгаа учраас энэ зарим нэг тодорхой саналуудыг хэллээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн үг хэлье.

Х.Тэмүүжин: Ерөнхий сайд томилогдох гэж байгаа энэ үйл явдалтай холбоотойгоор хэд хэдэн үг бас хэлмээр санагдаж байна. Нэгдүгээрт бид Үндсэн хуулийн энэ Ерөнхий сайдын томилгоотой холбоотой асуудлыг зөв голдиролд нь

оруулж хэрэглэхгүй бол бүүр буруу тийшээ явчихлаа. Ерөнхий сайдыг нэр дэвшүүлэх эрх мэдэл бол парламентын олонход байгаа. Тэр олонхыг авсан нам шийдвэрээ бүлгээрээ гаргах ёстой. Тэгснээс биш парламентаас гадна хуралдаад, гаднаас шийдвэр гаргаж ирээд яг цөөнхийн бүлэгт танилцуулж байгаа юм шиг танилцуулдаг жишиг ерөөсөө байж болохгүй ээ.

Хоёрт нь, парламентын олонхын бүлэг олонх болсон тэр хэсэг нь Ерөнхийлөгчид Ерөнхий сайдынхаа нэрийг өгөх ёстой болохоос биш нам хөндлөнгөөс нь өгч ерөөсөө болохгүй ээ. Ингэх юм бол утга учир. Энэ нөгөө парламентын засаглал гэдэг утга учир өөр алга болж байгаа. Энийг биднүүс нэг бодох ёстой. Хоёрт нь шинэ Ерөнхий сайдад нэр дэвшиж байгаа хүн маань яасан ч цочроотой бас тийрэлттэй байх юм бэ дээ. Ковид болон 2 удаагийн парламентын бүрэн эрхийн хугацаанд хэт олонх байсандаа эрдээд шүүмжлэл өөрөөсөө өөр дуу хоолойг сонсох тэвчээргүй болсон бол энэ бол Монгол Улсын Ерөнхий сайдыг хийх чадваргүй гэсэн үг шүү. Асуудалд субъектив хандахаасаа илүүтэйгээр бодлогоо ярих хэрэгтэй шүү.

Дахиад би нэг үг хэлмээр санагдаад байгаа юм. Монгол Улсын Ерөнхий сайд Монгол Улсын Засгийн газар нэг зүйл дээр бат зогсох ёстой. Монгол Улсын гүйцэтгэх эрх мэдлийн бие даасан байдлыг хамгаалах ёстой. Хэн нэгний гарын үзүүрт зарагддаг хүүхэлдэй байж болохгүй шүү. Би мэдэж сайн санаж байна. Тухайн үед Жаргалтулгын Эрдэнэбат билүү Ерөнхий сайд байсан. Энэ Ерөнхий сайд өөрөө Ерөнхий сайд байж чадаагүй. Дараагийн Ерөнхийлөгч энэ хүн болно гэж горьдоод, итгээд эрх мэдлийг яг хулгана хөөөгөө зөөж байгаа юм шиг Ерөнхийлөгч рүү зөөж гүйсэн. Харамсалтай нь бодсон хүн нь Ерөнхийлөгч болоогүй өөр хүн болчихсон. Хамгийн түрүүнд зөөж гүйсэн эрх мэдлийнхээ золиосонд өөрөө огцорсон. Монгол Улсад энэ түүх дахиад давтагдах вий. Эрх мэдлийг хулганы хөөө шиг зөөж болохгүй шүү. Гүйцэтгэх эрх мэдэл. 2027 онд болсноор чинь болохгүй дахиад өөр юм болох вий. Нутгийн дүү, нутгийн ах, манай намын ах гэдэг энэ ойлголтуудаас Ерөнхий сайд хол байх ёстой шүү.

Улсын Их Хурлын дарга байхдаа нутгийн ахдаа үйлчлээд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр Улсын Их Хурлын эрх мэдлийг аваачиж өгч байсан. Давхар дээлтэй холбоотой төмөр замын нарийн царигтай холбоотой олон шийдвэрүүдийг Улсын Их Хурал дээр ахынхаа төлөө гаргаж байсан энэ алдааг давтаж болохгүй шүү. Ерөнхий сайдад ах гэж байхгүй шүү. Ерөнхий сайдад Монгол Улсын эрх ашиг байгаа. Ерөнхий сайдад өөрийг чинь томилсон хүний тухай яриа биш өөрийг чинь Улсын Их Хурал томилж байгаа шүү энийгээ сайн бодоорой.

Төгсгөлд нь хэлэхэд Монгол Улс жижиг улс биш, хүн ам жижигтэй л улс. Монгол Улс өөрийнхөө тусгаар тогтнолыг дипломат бодлогоор хамгаална дээр нь сөрөн тэсвэрлэх чадвараараа хамгаална. Монгол Улсын иргэн болгон зэвсэг эзэмших чадвартай байх ёстой. Монгол Улсын иргэн болгон хэрсүү бөгөөд тархиараа бусдыг давж гарах чадалтай байх ёстой. Дээр нь шинжлэх ухаан технологийн ололтоор энэ улс эдийн засгаа ч босгож, тусгаар тогтнолоо ч хамгаалах ёстой. Тэгснээс биш цээжээ дэлдсэн...

Д.Амарбаясгалан: Энхбатын Болормаа гишүүн үг хэлье.

Э.Болормаа: Ингээд эрхэм гишүүддээ энэ оройн мэндийг хүргэе. Үндсэн хуульд заасны дагуу Улсын Их Хуралд олонх суудал авсан намын буюу МАН-ын нэр

дэвшигч болж хамт олныхоо дэмжлэгийг авч чадсан Занданшатар нэр дэвшигчдээ баяр хүргэе. Та Улсын Их Хурлын даргаар ажиллаж байх үедээ өнөөдрийн энэ холимог тогтолцоотой 126 гишүүнтэй парламентыг бий болгоход хүйсийн мөн тэгш оролцоог хангахад онцгой хувь нэмэр оруулсан. Үүнээс гадна бас зөвлөлдөх ардчилал, ди.парламент гэх мэтчилэн одоо нээлттэй засаглалын одоо чухал чухал зүйлүүдийг урагшлуулсан гэж үзэж байгаа.

Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхий сайд бүрэн эрхийнхээ хүрээнд бүтэц бүрэлдэхүүнээ одоо бүрдүүлнэ ээ. Та өнөөдөр хариултдаа цаг алдалгүй энэ 7 хоногт энэ зүйлийг хийнэ ээ гэж байна. Үүнийг дэмжиж байна. Яагаад гэвэл бид ажлаа хурдан үргэлжлүүлэх ёстой, бидэнд шийдэх ёстой олон асуудлууд байна. Улсын Их Хуралд олонх авсан МАН-ын нэр дэвшигч учраас МАН-ын бүлгийн 30 гишүүн гарын үсэг зурж, бүтэц бүрэлдэхүүнээ бүрдүүлэхэд Удирдах зөвлөлд одоо анхаарах 3 зарчмын шаардлагыг хүргүүлсэн байгаа. Эдгээр 3 зарчмын шаардлага маань яг таны одоо манлайлж ирсэн, баримталж ирсэн тэгш оролцооны зарчмаар эв нэгдлийг хангах, жендерийн эрх тэгш байдлыг хангах, мөн улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хангах гэсэн ийм одоо 3 зарчмын зүйлс байгаа.

Өнөөдөр энд байгаа гишүүд бүгд хамгийн чухал зүйлс буюу Монгол Улсын хөгжлийн бодлогын асуудлуудыг хөндөж ирсэн. Тэгэхээр Засгийн газар, таны тэргүүлэх Засгийн газар эдгээр асуудлууд дээр үр дүнд хүрэхийн тулд Монгол Улсын хөгжлийг нэг түвшинд ахиулахын тулд хамгийн гол нь чадварлаг бүтэцтэй, мөн тогтвортой засаглах учиртай. Тэгэхээр энэ гарын үсэг зурж эдгээр зарчмын асуудлыг хөндсөн гишүүдийнхээ нэрийн өмнөөс би бас танд энэ бичгийг албан ёсоор гардуулъя. Тэгээд эдгээр асуудлууд дээр шийдэл гаргахын тулд бас тогтвортой, чадварлаг бүрэлдэхүүнтэй засгийг удирдаасай гэж би чин сэтгэлээсээ ерөөе. Энэ бол Монгол Улсын эрх ашгийн асуудал юм байгаа юм аа. Тэгээд танд ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөгөөд энэхүү бичгийг албан ёсоор гардуулъя аа.

Д.Амарбаясгалан: Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн үг хэлье.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээрээ өнөөдөр энэ бид бас энэ шөнө дөл болтол хуралдаж нэг чухал асуудлаа шийдэж байна. Тэгэхээр би зарим нэгэн тоо баримтыг хэлье. Энэ 2020 он гэхэд манай дотоодын нийт бүтээгдэхүүн жилдээ нэг 4128 ам.доллар 1 хүнд оногдох нь ингэж байсан. 2024 оны эцэс гэхэд энэ тоо бол 6898 ам.доллартой ингээд тэнцэх болсон. Жил болгон нэг мянга орчим доллароор нэмэгдсэн гэсэн үг. Тэгсэн хэдий ч бол 2025 онд уул уурхайн одоо үнийн өсөлт, түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалаад экспортын орлого унаад өнөөдөр энэ эдийн засгийн түр зуурын ийм хямрал, одоо түр зуурын ийм хүндрэлтэй байдал үүсэж байна гэж харж байгаа. Тэгээд эдийн засаг төсвөө бас хийхдээ энийгээ бас зөв тооцож, энэ түр зуурын энэ хүндрэл бэрхшээлийг давах тал дээр анхаарна биз ээ гэж бодож байна.

Трампын тарифын бодлого бол үндсэндээ өнөөдөр олон улсын эдийн засагт сөргөөр нөлөөлөөд манай энэ түүхий эдийн үнэ унахад бол шууд нөлөөлсөн гэдэг нь бол нүдэнд ил байна. Тэгэхээр одоо бол улс төрийн нөхцөл байдал бол хүндхэн байна аа, амаргүй байна. Ийм цаг үед бол та гадаад бодлогыг өмнөх засгийн газруудынхаа гадаад бодлогыг, олон улсын одоо олон тулгуурт энэ гадаад бодлогыг үргэлжлүүлж, Засгийн газрын ялангуяа боомтын бодлогыг бол залгамж чанарыг нь хангах шаардлагатай гэж бодож байна.

Таны чуулганы нэгдсэн хуралдааны үеэр хэлсэн үгүүдээс мөн одоо асуултад хариулсан байдлаас хараад энэ Засгийн газрын бодлогыг үргэлжлүүлэх юм байна аа өмнөх. За 2026 оны боловсролыг дэмжих жил болгохыг бол дэмжиж байгаа юм байна аа гэдгийг бол ойлгож байна. Энд бол би их баяртай байна. Энэ хүрээнд бол нийтдээ нэг цоо шинээр 108 сургууль, 95 цэцэрлэгийг улс орныхоо хэмжээнд байгуулчих юм байна. Боловсролын салбарын ажилтан багш нарынхаа амьжиргааг дээшлүүлчих юм байна. Мөн одоо тэгш хамран сургах цогц бодлогыг хэрэгжүүлчих юм байна, ажиллах орчныг нь сайжруулах юм байна гэж ойлгож байгаа. Өнөөдөр бас багш нарын үндсэн цалинг ярьж байгаа шүү дээ. Нэмэгдлийг нь оруулаагүй үндсэн цалин нь бол 1 сая 485 мянган төгрөгийн л ийм цалинтай байгаа. Энийг бол энэ боловсролыг дэмжих жилийнхээ хүрээнд нэлээн зоригтой нэмчих ийм шаардлагатай гэж харж байгаа.

Энэ та бас өөрөө хэлж байна. Хүний хөгжлийг дэмжихийг нэг мега төслийн хэмжээнд авч үзнэ гэлээ. Энэ бол тун олзуурхуштай хэрэг. Багш хүний гар дээрээс бол маргаашийн наран мандана гэдэг гэсэн гоё үг байдаг. Энэ боловсролын салбарт ажиллаж байгаа багш ажилтныхаа энэ үндсэн цалинг бол энэ хүрээндээ нэмээд авах нь бол Монгол Улсын ирээдүйг гэрэлтүүлэх нэг том алхам болно гэдгийг одоо нуршиж хэлэх хэрэггүй гэж бодож байна. Боловсролыг дэмжих жил гэдэг бол багшийг дэмжинэ ээ гэсэн үг. Боловсролыг дэмжих жил гэдэг бол сургууль, цэцэрлэгтэй болно л гэсэн ийм үг ээ.

Нөгөө талдаа энэ төрийн албан хаагчдын тоо нь өссөн боловч үнэхээрийн нэр хүнд нь сайнгүй байна. Үйлчилгээний чанар шуурхай байдал нь сайжрахгүй байна. Та болохоороо ер нь үр ашиггүй зардлыг танаад, тэр цомхотгоно гэхээсээ илүүтэй зохист хэмжээнд нь хүргэнэ гэсэн ийм бодлого барих юм байна энийг ойлгож байна. Гэхдээ бид бол юу гэж үзэж байна вэ гэхээр яамдынхаа бодлогыг нь одоо энэ чадавхыг нь дээшлүүлээд, агентлагуудыг бас зоригтой цөөлөх, шаардлагагүй ийм газарт нь бол цомхотгох бодлогыг зоригтой хэрэгжүүлэх ёстой гэж ингэж бодож байна аа.

Тэгээд эцэст нь бол тусгаар тогтнол, эрх чөлөө, шударга ёс, эв нэгдэл энэ бол энэ чиглэл рүү хийж байгаа үйлдэл болгоныг бол бид дэмжинэ. Харин хяналт шүүмжлэл гэдэг чинь зэрэгцэж явах ёстой. Үүнийг бол одоо ардчиллын амин сүнс гэдгийг цохон тэмдэглэе. Ингээд танд амжилт хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн үг хэлье.

Х.Баасанжаргал: Би Занданшатар даргаас асуулт асуух байсан боловч өөрийнхөө хариуцлагагүй байдлаас болоод хугацаанаасаа хоцроод ороод ирсэн учраас одоо зайлшгүй энэ үгийг хэлье гэж бодож байна. Тэгээд таныг бас анхаарлаа хандуулаасай гэж бодож байна. Гантөмөр гишүүн түр хүлээж байх уу. Гантөмөр гишүүн ээ. Би нэг 2 зүйлийг л хэлэх гэсэн юм. Хүүхэд хамгааллын асуудал буюу Ерөнхий сайд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийг тэргүүлдэг. Хоёрдугаарт, Ерөнхий сайд бас Жендерийн үндэсний хороог тэргүүлдэг. Тэгэхээр зайлшгүй хүүхдийн эрхийн асуудал, жендерийн асуудал хоёрыг одоо танаас асууна. Тантай одоо энэ асуудлын талаар зайлшгүй одоо таны үүрэг, хариуцлага гэдгийг бол энэ танхимд сануулах ёстой гэж одоо хуулиараа тийм учраас танд бол сануулах ёстой гэдэг утгаараа энэ 2 үгийг хэлж байгаа юм.

Тэгээд ялангуяа өнөөдөр түрүүн Анар гишүүн асуусан. Хурдан морь унаач хүүхдийн асуудал ялангуяа өвөл, хаврын хурдан морины уралдааны асуудал хэдийгээр үндэсний одоо ондоошлын өв уламжлалын асуудал байдаг боловч ялангуяа өвөл, хаврын уралдаан гэж бас онцолж байгаагийн учрыг бол та бас надаар тайлбарлуулалтгүй маш сайн мэдэж байгаа байх аа гэж найдаж байна.

Хоёрдугаарт, яг энэ Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн дээр жендерийн квотыг ахиулах уу гэдэг асуултыг олон гишүүд асуусан боловч та бол ямар нэгэн тоо энэ дээр бол яг шууд бол хариулсангүй яг үнэнийг хэлэхэд болбол ганц бөөрөнхий хариулсан асуулт нь бараг энэ л байсан байх гэж бодож байна. Тэгэхээр энэ дээр бас маргааш, нөгөөдрөөс гээд энэ Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнийг оруулж ирэхдээ үе үеийн Засгийн газар хамгийн ихдээ 3 эмэгтэй сайдтай байсан. Энэ босгыг ямар ч байсан өсгөх байх гэж танд бас итгэж найдаж байна аа гээд.

Тэгээд энэ 2 асуудал дээр таныг бас Засгийн газрын түвшиндээ онцгой анхаараасай гэж хүсэж байгаа. Тэгээд ялангуяа хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай байгаа эмзэг бүлгийн хүүхдүүдийн асуудал дандаа бодлогын гадна үлддэг. Ялангуяа анхан шатны үйлчилгээ үзүүлж байгаа төрийн албан хаагчид нийгмийн ажилтнуудын асуудал гэж байнга ингэж бодлогын гадна үлддэг ээ. Одоо бүүр орон нутгийн төсөвт энэ асуудлыг шилжүүлчихсэн чинь энэ жил нийслэл гэр бүлийн хүчирхийллийн төвийн төсвийг нийслэлээс санхүүжүүлэх боломжгүй ээ гээд ингээд орхичихсон байгаа. Тэгэхээр яг нөгөө хамгийн анхан шатанд хамгийн эмзэг бүлэгт үйлчилгээ үзүүлдэг яг энэ төсвийн асуудал дээр бас таныг онцгой анхаараад таны эрэмбийн одоо эрэмбэлж байгаа асуудлуудын эхний 5 дотор эдгээр асуудлуудыг оруулаасай гэж чин сэтгэлээсээ хүсэж байна. Тэгээд танд амжилт хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн үг хэлье.

Л.Мөнхбаясгалан: Хэдхэн зүйл захъя. Нэгдүгээрт, хүний эрхээр жаргахаар өөрийн эрхээр зов гэж эрх чөлөөний мэдрэмжтэй ард түмний маань үг бий. Хэн нэгний дохио зангаагаар хатгаа сүлбээсэнд битгий ороорой. Өөрийнхөө мэдлэг боловсролд итгэж найдаад ажиллах юм бол та өнөөдөр энэ танхимд ярьсан бүх зүйлээ хэрэгжүүлж чадна аа. Монголчууд зовж ханасан, монголчууд ядуу байж ханасан, 600 гаруйхан мянган төгрөгийн тэтгэвэртэй, тэтгэврийн насныхан өнөөдөр уул уурхайн нөлөөллийн бүсэд амьдраад малаа маллаж байгаа хэрнээ ашиг шимийг нь хүртэж чадахгүй, идээшиж дассан нутгаасаа хөөгдөн түрэгдэж нүүж яваа ард түмэн чинь таныг яг өнөөдөр хараад сууж байгаа. Тэгэхээр хааны алба дүүжлүүрийн гогцоо хоёр нэг дор байдаг гэдэг Оросын нэг үг байдаг. Тэрийг бодож явна биз.

Хоёрдугаарт, хэн баялгийг эзэмшиж байна тэр хүн өнөөдөр төрийг эзэмшиж байна аа. Энийг болиулмаар байна аа Занданшатар дарга аа. Эх орных нь баялгийг эзэмшихээд ард түмнийг нь ядуу амьдруулаад, нутаг орноос нь хөөж байгаа энэнд чинь иргэд чинь бухимдаад байгаа юм. 21 аймаг би сая тойроод ирсэн. 300 гаруй мянган хүний гарын үсэг цуглуулсан. Та өөрөө Улсын Их Хурлын дарга байхдаа Салхитын мөнгөний орд гэж жижигхэн орд газраар 600 гаруй мянган ахмадынхаа 6 сая хүртэлх тэтгэврийн зээлийг тэглэх хуулийг баталж байсан хүн. Та баялгийг яаж ард түмэнд түгээх вэ гэдгийг мэддэг хүн. Тэгэхээр энийгээ хэрэгжүүлээрэй. Та өөрөө Баялгийн сангийн хуулийг баталсан хүн. Одоо энийгээ гардан хэрэгжүүлэх, тэрийг санхүүжүүлэх боломж танд олдож байна. Энэ бол алтан боломж. Яг үнэхээр

зорьсон бүтээсэн юмаа хийе гэсэн хүнд бол энэ хүнд бас ховорхон олдох боломж юмаа.

Дараагийн захиас та танхимаа бүрдүүлэхдээ Бүгд Найрамдах Сингапур Улсад бүртгэлтэй Люксембургийн Гүнт улсад бүртгэлтэй Энержи Ресурс гэдэг компаниас хандив авч Улсын Их Хуралд сонгогдсон гишүүдээс танхимдаа оруулмааргүй байна. Та өнөөдөр Цагаан суваргыг стратегийн ордуудаас хасуулж байгаад эзэмшсэн тэр компанийн төлөөллийг Засгийн газартаа оруулмааргүй байна аа. Хэрвээ та энийг оруулах юм бол та шударга ёс гэж яриад ч хэрэггүй. Таны Засгийн газрыг огцруулах ажил эхлэх болно шүү эндээс.

Дараагийн захиас та говийн усны төсөл буюу Орхон онги, Хэрлэн тооно төслийг Засгийн газрынхаа мега төслүүдээ нэгдүгээрт эрэмбэлж өгөөч ээ. Та удахгүй хэдхэн минутын дараа Ерөнхий сайд болно. Яагаад гэвэл энэ бол зөвхөн говийн усны төсөл биш энэ Монгол Улсын усны төсөл юмаа. Онгио сэргээх, Орхоноо хамгаалах, Хэрлэнгээ хамгаалах энэ гол юм байгаа юм. Монгол Улс өнөөдөр газар нутгийнхаа 87 хувьд нь геологийн хайгуул хийсэн байдаг. Тэгсэн хэрнээ усны хайгуул дээр дөнгөж 17.8-хан хувьтай. Миний сонгогдсон говийн бүсэд стратегийн 7 орд байгаа. Одоо нэмэгдээд удахгүй 11 болно усгүй. Бид өнөөдөр Монгол Улсын сангийн авдрыг дүүргэдэг. Өмнөговь аймаг хамгийн их мөнгийг өгдөг. Тэгсэн хэрнээ бид өөрсдийнхөө олсон орлогоор усны төслөө хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Та удахгүй төсвийн тодотгол өргөн барих гэж байна. Тандалт хийх гэж байна. Говийн усны төслийг битгий танаарай гэж танаас говиос сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний хувьд, говийн ард түмнийхээ өмнөөс хүсье ээ.

Энэ усны хайгуулыг хийхэд жилд 10-хан тэрбум. Аравхан тэрбум. Энийг хэдүүлээ хийчихвэл одоо таныг хэрвээ говийн усны төслийг амжилттай хэрэгжүүлж чадах юм бол цэнхэр дээлээ өмсөөд одоо сурталчилгаанд чинь явахад бэлэн байна даа.

Эцэст нь ордны тэмцэлд ялагдсан ч гэсэн олон түмнийхээ дэмжлэг...

Д.Амарбаясгалан: Отгоны Саранчулуун гишүүн үг хэлье.

О.Саранчулуун: Нэг зүйлийг хэлэх гээд байгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөх ажил Монголд бодлогоор биш сэтгэл хөдлөлөөр хэмжигддэг болчихоод байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөө хийсэн ажил гэхээр тогтолцоо биш дандаа түр зуурын арга хэмжээ байдаг. Төсөв нь үл үзэгдэгч байгаа ч юм шиг, байхгүй ч юм шиг. Тэгээд том урт төслүүдэд нь ерөнхийдөө орчихсон гээд байгаа мөртөө нарийвчлаад яг хэдэн хүнтэй байгаа вэ гэхээр бас байхгүй байгаад байгаа юмаа. Энийг харагддаг болгоод өгөөч ээ энэ төсвийг. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд чиглэсэн үйл ажиллагаа гэхлээр баяр ёслол дагаад тайзны чимэглэл шиг ийм дүр төрхтэй олон жил явж иржээ. Ер нь олон юмнуудыг харахаар.

Өнөөдөр хариуцлагаас илүү сэтгэл ханамж ямар байна, хүмүүс яаж баярлаж байна, баярлахихсан уу, болчихсон уу гэдэг шиг ийм хөөцөлдсөн ийм ажил их байдаг юм байна гэдгийг бас харлаа. Уул нь нэг удаагийн урамшуулал нэг нэр төдий зураг нэг тийм юмаар ингээд аргацаадаг биш баймаар байгаа юм. Уул нь энэ хөгжлийн бэрхшээлтэй хүнд чиглэсэн бодлого чинь шоу биш шүү дээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд юм хийсэн гэхээрээ шоудаж байгаа юм шиг харагддаг ийм юмыг одоо больцгоомоор байна. Энийг бас би шинэ засгаас хүсэж байна. Өдөр бүр

шийдвэр нь хүртээмжтэй, сар бүр, жил бүр үнэлгээ нь дандаа төсөвт нь ингээд харагддаг ийм болмоор байгаа юм. Тэгвэл эд нарыг хийе гэвэл би төсөв дээр нэмэхгүйгээр тодорхой яг хийчихвэл болохоор нэг дөрөвхөн зүйлийг хэлчихмээр байгаа юм. Бүх бодлогод хүртээмж яримаар байгаа. Тэгээд олон улсын тайландаа олон улсын нөгөө нэгдэж орсон бид нар энийг нь хийчихье гэж дэлхийн одоо том том тэр чуулганд очиж амласан юмнууд дээрээ тайлангаа зөв илгээдэг болмоор байгаа юм.

Хоёрдугаарх нь энэ зун Улаанбаатар хотод ер нь бүх газар болох бүх баяр ёслол олон нийтийн арга хэмжээг хүртээмжтэй болгомоор байгаа юм. Заавал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцдог орц гарц, хаалга, тасалбар мэдээлэл нь тийм байлгая аа. Энэ зун хийх бүх дулаалгын төслүүдээ хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй болгомоор байгаа юм. Орон сууцны бодлогоо хүртээмжтэй болгомоор байна аа.

Дараагийнх нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүний одоо холбоотой дэмжсэн төсвөө нэг ганцхан ширхэг баганад тусгай харагдуулаад өгөөч ээ гэж одоо би бүтэн жил ер нь ярилаа даа. Эхлээд ингээд тайлбарлаж үзлээ, албан бичиг явуулж үзлээ, энэ чуулганд ирэхээр нь гуйж үзлээ, бүх л одоо сайд нартаа хэлж үзлээ, одоо бодвол энэ намар орж ирэх байх гэж найдаж байна. Тэгэхээр төсвийн зардлын баганатай би тийм зардлыг бас хармаар байна. Тийм мэдээллийг хармаар байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дэмждэг мэргэжилтнүүдийгээ дэмжмээр байна. Нийгмийн ажилтнуудынхаа төсөв дээр анхаармаар байгаа. Бид нар 800 гаруй нийгмийн ажилтантай болсон. Эхнээсээ ажлаасаа гарч эхэлж байгаа халшраад, дээрээс нь цалингүй учраас. Ийм одоо хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс дээр нэг ийм зүйл байгаа.

Хоёрдугаарх нь гадаад орнуудад очихоор сэтгэл санаа хэчнээн хэцүү байсан ч гэсэндээ гудамжинд гарахаар тайвширчихдаг, цэвэрхэн, хүртээмжтэй, стресс багатай байдаг учраас. Монгол Улсад болохоор аягүй эсрэгээрээ байдаг. Өглөө хэчнээн сэтгэл санаагаа өргөөд гудамжинд гарч ирээд сэтгэл санааг нь буцаагаад орчин нь нураачихдаг. Тэгээд энэ иргэдийн сэтгэл санааг нураагаад байгаа зүйл нь ерөөсөө манай хотын энэ хэзээ таслах нь мэдэгдэхгүй халуун ус, халуун хүйтэн ус, хэзээ хаах нь мэдэгдэхгүй зам, хэзээ барих нь мэдэгдэхгүй хашаанууд, хэзээ буцааж бөглөх нь мэдэгдэхгүй нүхнүүдээр ингээд хүмүүсийн орчин ингээд аягүй муухай болгочихдог. Тэгэхээр энэ жил одоо нэгэнт л шинээр засгаа байгуулж байгаа бол энэ дээрээ нэг анхаараад өгөөч ээ. 22 цагаас хойш хүмүүсийн тэр хашхичихдаг тэр мотортой яндантай бүх зүйлийг цэгцлээд амар тайван хот болгоод өгөөч ээ энэ зундаа. Ядаж ийм ийм зүйлүүдийг харагдсан байвал бас их сайхан намрыг угтмаар байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн үг хэлье.

О.Цогтгэрэл: АН 35 жилийн тэртээ Монгол Улсад нийгэм, эдийн засгийн эрс өөрчлөлт шинэчлэлийг бас манлайлж, хүн төрөлхтний нийтлэг жам ёсны хөгжлийн зам руу нь бас оройлон манлайлж байсан бас энэ хугацаанд ялж ялагдаж, нэгдэж задарч бутарч, олон л бэрхшээлийг даван туулсан ийм улс төрийн хүч байна. Өнөөдөр энэ удаагийн сонгуулийн циклд 42 гишүүнтэй бас нэлээн томоохон бүлэг албан ёсны сөрөг хүчний байршил дээр бас ирж байна. Тэгэхлээр одоо үлдэж байгаа цаг хугацаанд АН-ын хувьд Засгийн газраас явуулж байгаа бодлогыг зөвийг нь зөв гээд, бурууг нь буруу гээд буруушааж чадах бас 35 жилийн түүхэндээ хатуужсан бойжсон бас ийм улс төрийн хүчин. Бүх зүйлийг хааж боох, бүх зүйлийг

унагаах, гацаах чиглэлд АН-ын хувьд байж таарахгүй. Бас аялдан дагалдаад болж байна, бүтэж байна гээд чимээгүй дагаад явах ийм улс төрийн хүчин бас АН биш.

Тэгэхлээр зөв зүйлийг зөв гэж, хамгийн гол нь энэ иргэддээ энэ эдийн засгийн эрх чөлөө, улс төрийн эрх чөлөө олон олон зүйлүүдийг бизнесийн эрх чөлөө өмчийн эрх эдгээр зүйлүүдийг суурь үзэл баримтлал болгож АН асуудалд бас ханддаг аа. Ийм учраас эдгээр бодлогуудаас эрс зөрсөн бодлогууд гарах юм болбол АН-ын хувьд АН-ын бүлгийн хувьд энэ Засгийн газар огцрох ёстой гэдэг байр суурийг тод томруунаар илэрхийлээд явж чадах бас ийм улс төрийн хүчин гэдгийг бас анхааруулаад энд хэлье ээ төгсгөлд нь.

Өнгөрсөн хугацааны эдийн засаг, улс төрийн бодлогын алдаа оноо маань бас хаанаа байна аа. Бид нар бас суурь дүгнэлт хийх ёстой тал талдаа бас мэдээллээ солилцох ёстой, ойлголцох ёстой гэж бодож байна. Миний хувьд ер нь одоо бид нар энэ яагаад өнгөрсөн хугацааны эдийн засгийн тодорхой өсөлтүүд байсан уу байсан. Тэгэхдээ яагаад иргэнд хүртээмжгүй, иргэнд наалдацгүй, иргэн нь оролцдоггүй, хувийн бизнесүүд нь оролцдоггүй эдийн засгийн тогтолцоо, эдийн засгийн ийм бүтэц рүү явчхав аа гэдэг дээр шинэ Ерөнхий сайд дүгнэлт хийх ёстой л гэж боддог. Төр томорсон, төсөв томорсон, ТӨК-ийн орон зай хэт тэлснээс болоод бизнесүүдийн орон зай өнгөрсөн хугацаанд бодитойгоор бас хумигдаж ирсэн. Энийг дагаад авлигалын асуудлууд, олон олон зүйлүүд.

Энэний төгсгөлд энэний үр дүнд бид нарын тунхагладаг чөлөөт зах зээлийн эдийн засаг гэдгийн механизмууд нь өөрөө ажиллаж чадахгүй болж, тэр ядуурлыг бууруулж чадахгүй тэр механизм нь ажиллахгүй, ажлын байрыг бий болгож чадахгүй шинэ техник технологи нэвтрүүлэх чадал чансаа нь яагаад гэвэл тэдгээрийн орон зай нь хумигдчихсан. Ийм учраас оролцоогүй, хүртээмжгүй эдийн засгийн ийм тогтолцоо өнгөрсөн хугацаанд бий болчихсон гэж боддог оо. Тэгээд шинэ Ерөнхий сайд бодлого чиглэл дээрээ эдгээр зүйлсүүдийг бас авахыг нь аваад, хаяхыг нь хаяад анхаарч ажиллана үзээд тэгээд АН-ын бүлгийн хувьд төр засгийн бодлогыг, Засгийн газрын бодлогыг зөвийг нь зөв гэж, бурууг нь буруу гэж бас асуудлаа байр сууриа илэрхийлж чадах ийм төлөвлөсөн улс төрийн хүчинтэй бас хамтран ажиллах ажиллана аа гэдгийг бас давтан хэлье ээ.

Д.Амарбаясгалан: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн үг хэлье.

М.Нарантуяа-Нара: Шөнийн мэнд хүргэе ээ. Тэгэхээр өнөөдөр ялангуяа энэ чуулганыг үзэж байгаа иргэдийн хувьд бол бас их таатай, нааштай олон зүйлүүдийг мэдээллийг сонсож байгаа байх аа. Тэгээд яах вэ мэдээж Ерөнхий сайд бол алтан загас биш ч гэсэн салбар яамдынхаа одоо сайд нарын туслалцаатайгаар олон олон салбарын асуудлыг нааштай сайхан шийдэх боломжтой. Тэгээд ялангуяа өнөөдөр бол залуу гэр бүлийг дэмжих асуудал дээр тэр банкны орон сууцны банк гэдэг асуудал ярилаа. Орон сууцны банкныг нээхээс наана ипотекийн зээлийн асуудлыг үнэхээр одоо бас нэг танил тал, авлигын шинж чанараас нь салгах үнэхээрийн одоо яг энэ залуучуудыг орон сууцжуулах хөтөлбөрт маш сайн хамрагдуулах тал дээр үнэхээр анхаарч ажиллаасай гэж хүсэж байна аа.

Тэгээд Гэр бүлийн тухай хууль уг нь Хууль зүй, дотоод хэргийн яамнаас мөн Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас Гэр бүлийг дэмжих тухай хууль орж ирэх гэж байсан. Тэгээд энэ хуулиудыг маш яаралтай шинэ засгийн хүрээнд энэ салбар яамдууддаа яаралтай өргөн бариулах ажлыг бас сайн хийгээсэй гэж бодож

байна аа. Мөн түүнчлэн Засгийн газрын хөгжлийн хөтөлбөрт орсон байсан яслийг хөгжүүлэх хөтөлбөрөө маш яаралтай хэрэгжүүлээсэй гэж бодож байна. Яагаад гэвэл ээжүүдэд сарын 50 мянга байна уу, 500 мянга байна уу тэр төрийн одоо цалинтай ээж гэсэн нэртэй ийм мөнгийг хүлээдэг байснаас хүүхдүүдээ чанар, баталгаа, стандарт хангасан яслийн үйлчилгээнд хүүхдүүдээ даатгаж харуулчхаад өөрсдийнхөө мэргэжил ур чадвараараа ажлаа хийх нь ээжүүдэд илүү их орлого одоо орлоготой байх эх үүсвэр болно.

Тэгээд дөнгөж саяхан ажлын хэсгийн хүрээнд 3 дугаар цахилгаан станц дээр ажиллаад ирэхэд цахилгаан станцын нийт ажилчид бол ерөөсөө л энэ эрчим хүчний салбарыг улс төржилтөөс ангид байлгаач ээ гэдэг хамгийн 1 дүгээр том хүсэлтийг тавьж байсан. Тэгээд 3 дугаар цахилгаан станцын хувьд бол үүссэн гэмтэл нь бол ерөөсөө тэр нөгөө нэг тендерийн тухай хууль гэдгийг баримтлаад явахаар зарим үед тендерийн тухай хууль гэхээр мэдээж хамгийн хямдхан одоо худалдан авалтыг хийхээр зорьдог. Гэтэл тэр чинь улс эх орны хамгийн чухал зайлшгүй хамгийн сайн чанартай бүтээгдэхүүнийг хамгийн сайн ч одоо үнээр авах ийм зүйл дээр ингэж тендерийн тухай хуулийг баримталснаас болоод бас ийм чанар баталгаа хангахгүй ийм зорилтот хугацаандаа хүрэхгүй ийм гэмтэл осол бас гарах эрсдэлтэй байдаг юм байна лээ. Тэгэхээр зэрэг ялангуяа ийм нарийн мэргэжлийн салбар яамдуудынхаа худалдан авалтыг заавал тендерийн тухай хуулиар гээд байхгүй байх ийм шаардлагууд байдаг юм байна аа гэж харсан.

Тэгэхээр өнөөдөр бол маш олон ийм зүйлүүдийг та бас ч үгүй өөртөө итгэлтэй ярьж байгаа байдал чинь бас олон хүнд бас гэгээ татуулж байгаа болов уу гэж бодож байна. Тэгэхээр эд нарыгаа хамгийн гол нь ажил хэрэг болгох төлөө л тууштай зориорой гэж хүсэх байна. Тэгээд танд амжилт хүсье ээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Равжихын Эрдэнэбүрэн гишүүн үг хэлье.

Р.Эрдэнэбүрэн: Нэр дэвшигчид амжилт хүсэж байна. Тэгээд нэрээ татлаа.

Д.Амарбаясгалан: Жудагийн Баярмаа гишүүн үг хэлнэ алга байна.

За ингээд Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа. Одоо Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох асуудлаар ил санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд хурууныхаа хээг уншуулаад санал хураалтад бэлтгэе. Гишүүд хурууныхаа хээг уншуулж санал хураалтад бэлтгэлээ хангая. Хэдэн гишүүн бүртгэгдэж байна надад мэдээлэл.

Ирц бүртгэлийн нэг санал хураалт явуулаадахъя. Ирц бүртгэлийн санал хураалт. 87 гишүүн бүртгэгдсэн байна. Ирц бүртгэлийн санал хураалтад орж чадаагүй гишүүд байна уу? Олон гишүүн байна. Гишүүд хурууныхаа хээг уншуулаад санал хураалтдаа бэлдье. Ирц бүртгэлийн санал хураалт дахиж явуулъя. Санал хураалт 107 гишүүн бүртгэгдсэн байна. Санал хураалт эхлүүлье.

Монгол Улсын Ерөнхий сайдаар Гомбожавын Занданшатарыг томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа. Санал хураалт.

За 108 гишүүн дэмжиж 92.3 хувиар санал дэмжигдлээ. Улсын Их Хурлын гишүүн Булгантуяаг дэмжсэнээр протоколд тэмдэглээ.

Монгол Улсын ерөнхий сайдаар Гомбожавын Занданшатарыг томилох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо. Чинбатын Ундрам гишүүнийг протоколд тэмдэглэе.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар хот. Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай.

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 6 дахь заалт, 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэг, 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсэг санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас Тогтоох нь:

1.Монгол Улсын Ерөнхий сайдаар Гомбожавын Занданшатарыг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Эрхэм хүндэт Гомбожавын Занданшатар танд Монгол Улсын 34 дэх Ерөнхий сайдаар томилогдсонд Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, улс орны хувь заяаг тодорхойлох хариуцлагатай албанд өндөр амжилт хүсье ээ.

Ерөнхий сайд Оюун-Эрдэнийн тэргүүлсэн Засгийн газар эдийн засгийг сэргээх бодлогыг амжилттай хэрэгжүүлж чадсаныг 2020 онд -4.6 хувийн уналттай байсан эдийн засаг 2024 онд 4.9 хувьд хүрч өссөн. Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 6898 ам.долларт хүрч Монгол Улс Дэлхийн банкны орлогын ангиллаар дунджаас дээгүүр орлоготой улсын ангилалд шилжсэнээс харж болно.

Оновчтой бодлогын үр дүнд түүхий эдийн экспортын өсөлт 2023 онд төсөв төлбөрийн тэнцлийг ашигтай гарч, гадаад валютын албан нөөцийг 5.5 тэрбум ам.долларт хүргэж чадсан. Засгийн газрын өрийг сүүлийн 5 жилийн хугацаанд 75.5 хувиас 41.8 хувь руу бууруулж, улсын зээлжих зэрэглэлийг 10 жилийн дараа анх удаа нэг шатаар дээшлүүлж, В нэмэх тогтвортой түвшинд хүргэж сайжруулсан. Харин өнөөдөр гадаад улс төрийн орчин нөхцөл, эдийн засгийн тодорхойгүй байдлаар нөхцөлдүүлсэн шинэ нөхцөл байдал, шинэ сорилт, шийдэл хүлээсэн бодлогын түвшний асуудлууд таны өмнө тулгарч байна.

Иймд шинэ Засгийн газрын тэргүүнээр ажиллахдаа та дараах асуудлуудад онцгойлон анхаарч, бодит үр дүнтэй шийдлүүд хэрэгжүүлнэ гэдэгт итгэлтэй байна аа.

Макро эдийн засгийн нөхцөл байдлын хүрээнд гадаад орчны тодорхой бус байдал намдахгүй харин ч улам ээдрээтэй болж байгаа өнөө үед эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангах асуудал өнөөдөр тэргүүн зэргийн ач холбогдолтой байна аа. 2025 оны эхний 4 сарын байдлаар түүхий эдийн үнийн

уналтаас нүүрсний экспортын орлого өмнөх оны мөн үеэс 1.2 тэрбум ам.доллараар буурсан нь төсөвт дарамт учруулаад зогсохгүй урсгал дансны алдагдлыг тэлэхээр дүр зураг харагдаж байна.

Төлбөрийн тэнцэл 5 сарын урьдчилсан тооцоогоор 400 гаруй сая ам.долларын алдагдалтай, урсгал тэнцэл 1.2 тэрбум долларын алдагдалтай гарсан нь өмнөх оны мөн үеэс 36 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юмаа. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх онтой харьцуулахад эхний 4 сард 14.4 хувь буюу 1.4 их наяд төгрөгөөр буурсан. Төсвийн тэнцэл 58 орчим тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан. Өнгөрсөн оны мөн үед төсвийн тэнцэл 2.1 их наяд төгрөгийн ашигтай гарч байсан.

Иймд Засгийн газрын зүгээс улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбэ дэс дарааллыг эргэж харах, мега төслүүдийг эдийн засагт дарамт болохгүйгээр хэрэгжүүлэх гарц гаргалгааг гаргаж гадаад, дотоод эдийн засгийн орчин нөхцөл байдлыг байдалд нийцсэн төсвийн бодлогыг тодорхойлж, Улсын Их Хуралд хэлэлцүүлэх шаардлагатай.

Үнийн өсөлт, зээлийн хүүг эрүүл зохистой түвшинд хүргэх хүрээнд иргэд аж ахуйн нэгжүүдээ ажлын байраар хангаж, орлоготой байлгах бодлогыг Засгийн газар тууштай баримтлах ёстой. Иргэд аж ахуйн нэгжүүдийнхээ бодит орлогыг бууруулахгүй байхын тулд амьдралынх нь чанарт хамгийн ихээр нөлөөлж байгаа үнийн өсөлтийг хязгаарлаж, нам доор түвшин тогтворжуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна аа. Инфляц энэ оны эхний 4 сарын байдлаар 8.6 хувьтай гарсан. Ажлын байр бий болгож нэмэгдүүлж байгаа жижиг, дунд үйлдвэрлэлүүдийг бодлогоор дэмжих ажлыг тогтвортой хэрэгжүүлэх нь үр дүнд хүрнэ гэж үзэж байна. Хүнд хэцүү цагт хямд эх үүсвэрээр жижиг, дунд үйлдвэрлэлүүдээ дэмжиж байж ажлын байраа хадгалж, иргэд аж ахуйн нэгжүүд нь хохирол багатай гарсан түүх олон байдаг аа.

Монгол Улсын хувьд Ерөнхийлөгчийн санаачилсан цагаан алт, хүнсний хувьсгал Засгийн газраас хэрэгжүүлж байгаа шинэ хоршоо зэрэг ажлын байрыг хадгалахын сацуу шинээр ажлын байр бий болгож, нэмэгдүүлж байгаа хөтөлбөрүүд юмаа. Ард иргэд аж ахуйн нэгжүүдийн хувьд зээлийн хүүгийн дарамт бодит ачаа болсоор байгаа. Зээлийн хүүг бууруулах чиглэлд дорвитой бодлого хэрэгжүүлж, иргэд аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн дарамтыг бууруулж, зээлийн хүүг эрүүл зохистой түвшинд авчрах нь эдийн засгийн идэвхжилийг сэргээхэд тус дэм болоход чухал нөлөө үзүүлнэ ээ. Үүний зэрэгцээ шударга өрсөлдөөнийг дэмжсэн монопол зах зээлийн бүтэцтэй салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, иргэд аж ахуйн нэгжүүд дэх аж ахуйн нэгжүүдэд ирэх аливаа үнийн хүүгийн дарамтыг бууруулах орчин бүрдэх юмаа.

Гадаад худалдаа ба ханшийн асуудлын хүрээнд. Гадаад эдийн засгийн тодорхой бус байдлаас үүдэлтэй түүхий эдийн үнийн бууралт, урсгал дансны алдагдлыг тэлэхээр дүр зураг харагдаж байна. Урсгал данс төлбөрийн тэнцлийн алдагдлыг шат дараатай бууруулж, төгрөгийн ханшийг тогтворжуулах нь тулгамдсан асуудал болж байна аа. 2025 оны эхний 4 сарын байдлаар экспортын орлого 695 сая ам.доллараар буурч, импорт 132.9 сая ам.доллараар нэмэгдсэн нь валютын гадагшлах урсгалыг нэмэгдүүлж байна аа.

Иймд гадаад худалдааны бодлогыг Засгийн газрын түвшинд онцгой анхаарч, экспортын бүтцийг төрөлжүүлэх, валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд бодлого арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Төрийн албаны реформын хүрээнд Монгол Улсын төрийн албыг цомхон бүтээмж өндөртэй болгох шаардлага улам бүүр тодорхой болж байна. Төсвийн урсгал зардлыг бууруулах, төрийн бүтцийг цомхон чадварлаг болгож байж үр дүнд хүрнэ гэж үзэж байна. Монгол Улсад өнөөдрийн байдлаар 120 гаруй төрийн өмчит, 270 орчим орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой компаниуд, 58 мянга гаруй ажилтнаар үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр байгууллагын бүтээмж, үр ашиг хангалтгүй байгаа тул хувьчлах, менежментийн шинэчлэл хийх, хувийн хэвшил хамтран ажиллах замаар эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх нэн шаардлагатай байна аа.

Татварын реформын хүрээнд Монгол Улсад 108 мянга гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдний зүгээс татварын дарамттай холбоотой санал хүсэлтүүд ихээр ирж байна. Эрүүл өрсөлдөөнтэй эдийн засгийн орчныг бий болгохын тулд иргэд аж ахуйн нэгжүүдэд ээлтэй татварын цогц реформ ус агаар мэт хэрэгтэй болоод байна.

Иймд Засгийн газрын зүгээс татварын реформыг оновчтой хэрэгжүүлэх, прогрессив татварын тогтолцоог бий болгох, дотоодын аж ахуйн нэгжүүдийг дарамтгүй, таатай нөхцөлд ажиллах боломжийг нэмэгдүүлэх нь эдийн засгийн идэвхжилийг дэмжих чухал алхам болно. Дотоодын аж ахуйн нэгжүүдийн хийж гүйцэтгэх боломжтой ажлуудыг гадаадын компаниудад шилжүүлдэг алдаатай жишгийг зогсоох цаг нь болсон. Үндэсний үйлдвэрлэгчдээ бодитоор дэмжих, тэдэнд өрсөлдөх, хөгжих орон зайг бий болгох нь эдийн засгийн тогтвортой өсөлтийн үндэс суурь юмаа.

Өнгөрсөн хугацаанд гарсан алдаа завхралыг давтахгүй байхын тулд дотоодын бизнесийн орчныг илүү таатай, шударга болгоход онцгой анхаарах шаардлагатай. Үүний тулд хуулиас давсан журмуудыг цэгцэлж, хууль журмын харьцааг зохистой түвшинд хүргэхэд Улсын Их Хурлын зүгээс бүрэн дэмжиж ажиллах болно. Эрчим хүчний найдвартай байдлыг хангах хүрээнд Монгол Улсын эрчим хүчний салбар нь үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой хөгжлийн тулгуур салбар юмаа.

Сүүлийн жилүүдэд эрчим хүчний чадлын дутагдал байнга үүсэж, хэрэглэгчдийн найдвартай хэрэглээнд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал 1965 онд байгуулагдсан Дулааны 3 дугаар цахилгаан станцын хүчин чадал хуучирч, саяхан болсон осол нь шинэчлэл засварын ажлыг яаралтай эхлүүлэх шаардлагатайг харуулж байна.

Ирэх намар дулааны улирлаас өмнө тус станцын шинэчлэлийг шуурхай хийж, хэрэглэгчдийн найдвартай хэрэглээг хангах нэн тэргүүний зорилт байх болно. Сүүлийн 3-4 жил дараалсан зудын байдалтай өвөлжилт, хаваржилт хүнд, олон малчин өрхийн амьжиргаанд хүнд ачаа үүрүүлж байна. Сүүлийн жилүүдэд олон сая толгой мал хорогдсон нь мал аж ахуйн салбарт томоохон хохирол учруулсан.

Иймд Засгийн газрын зүгээс өвөлжилтийн бэлтгэлийг эртнээс хангах малчидтай хамтран зудын эрсдэлээс сэргийлэх цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх нэн шаардлагатай. Өнөөдөр Улсын Их Хурлын гишүүдээс олон чухал

асуудлыг хөндөж ажил хэрэгч саналууд гарсан. Та эдгээрийг өөрийн ажилдаа авах гээхийн ухаанаар хандаж, ажилдаа тусгаж ажиллахыг танаас хүсэж байна.

Эрхэм Ерөнхий сайд аа, Таны манлайлал доор монгол төрийн бодлого ард түмний амьдралд эерэг өөрчлөлт авчирна гэдэгт итгэлтэй байна. Эдийн засгийн тогтвортой байдал, нийгмийн шударга ёс, төрийн хэмнэлттэй, үр ашигтай бүтэц, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх бодлогууд шинэ Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл байх ёстойг төгсгөлийн үгэндээ хэлье ээ.

Төр түвшин, түмэн олон амгалан байх болтугай. Танд ажлын өндөр амжилтыг хүсье ээ.

За ингээд Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар таныг суудалдаа суухыг урьж байна аа.

Одоо Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар үг хэлнэ ээ. Индэрт урьж байна.

Г.Занданшатар: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ард иргэд ээ,

Та бүхэндээ зуны тэргүүн сарын шинийн 16-ны улаан тэргэл сартай шөнийн мэндийг өргөн дэвшүүлье ээ.

Юуны өмнө надад өндөр үүрэг хариуцлага, итгэл найдвар хүлээлгэсэн Монгол Улсын Ерөнхий сайдаар тохоон томилсон Улсын Их Хурлын гишүүд та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Засгийн газрын тэргүүний өндөр хариуцлагатай албан тушаалд нэрийг минь дэвшүүлсэн МАН, журмын нөхдөдөө намын шийдвэрийг дэмжиж намайг Ерөнхий сайдаар томилуулах саналаа Үндсэн хуулийн дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх танд талархлыг хамтатган дэвшүүлье.

Шударга ёс, баялгийн тэгш хуваарилалт мега төслүүд, бүсчилсэн хөгжил шинэ сэргэлт зэрэг томоохон бодлого, зорилт дэвшүүлж, зохих үр дүнд хүргэсэн Монгол Улсын 32, 33 дахь Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ болон түүний тэргүүлсэн Засгийн газрын гишүүдэд хүндэтгэл илэрхийлж буйг минь хүлээн авна уу.

Шинээр байгуулагдах Засгийн газар МАН, АН, ХҮН-ын 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн зорилтуудыг тусгасан хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, амжилт ололтыг улам бататгаж ажиллах болно. Мөн өнөөдөр Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн асуусан, хэлсэн санал, дүгнэлтүүдэд үндэслэж, үйл ажиллагааны хөтөлбөрөө баяжуулж, засаж залруулж, цаашдын зорилтоо шинэчлэн тодорхойлох болно.

Эрхэм гишүүд ээ.

Өнөөдөр дэлхий дахинд геополитик, гео стратегийн хурцадмал нөхцөл байдал үргэлжилж, худалдаа тарифын дайн нүүрлэсэн энэ нэн эгзэгтэй цаг үед улс

орнууд түүний дотор Монгол Улсад эдийн засгийн болон улс төрийн гадаад улс төрийн шинж чанартай хүндрэл сорилт бэрхшээлүүд тулгарч байна аа. Түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалсан уул уурхайн цөөн тооны бараа бүтээгдэхүүнээс хэт хамааралтай Монгол Улсын эдийн засагт хүндхэн сорилт тулгарах эрсдэл бий болсон. Тухайлбал манай улсын эдийн засаг сүүлийн 4 жилд дунджаар 5 хувиар өсөж байсан бол 2025 оны эхний улиралд эдийн засгийн өсөлт 2 дахин буурлаа. Нүүрсний экспорт зогсонги байдалд орж, төсвийн орлого тасалдаж, гадаад валютын нөөцөд Монгол төгрөгийн ханшид сөрөг дарамт учирч, инфляц нэмэгдэх ийм эрсдэлтэй байна аа. Манай эрчим хүчний системийн найдвартай тасралтгүй үйл ажиллагаанд ч гэсэн гэнэтийн эрсдэлүүд бий болж, эрсдэл үүсэж байна.

Иймээс эдийн засгаа тогтворжуулж, иргэдийнхээ орлого, амьжиргааг тамиржуулах, эрчим хүчний гэнэтийн доголдол зэрэг тулгамдсан асуудлуудыг нэн яаралтай шийдвэрлэх шаардлага бас үүсэж байна аа. Эрсдэл сорилтыг даван туулах, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүх түвшинд төлөвшүүлэх нь шинэ Засгийн газрын нэн тэргүүний зорилт байх болно оо. Монголчууд бид гадаад, дотоод таагүй нөхцөлөөс хохирогч ч биш хожиж гарах ёстой. Үүний тулд Засгийн газар үндэсний аюулгүй байдал, монгол хүний эрх ашигт заналхийлж, итгэлийг нь үгүй хийж, мөрөөдлийг нь сүүдэртүүлж байгаа асуудлуудыг эрэмбэ, шат дараатай шийдвэрлэхийг эрхэм зорилгоо болгоно оо.

Улсын эдийн засаг хүнд байгааг одоо бас шулуухан хэлье. Зардлаа багасгаж, орлогоо хэмнэхээс өөр сонголт бидэнд байхгүй. Гэхдээ эрсдэлийг даван туулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ард түмэн аж ахуйн нэгжийнхээ нуруунд үүрүүлж, халаас хэтэвчийг нь тэмтрэх замаар бус харин төрийн үрэлгэн зардлыг багасгаж, төр өөрөө бүсээ чангалах зарчмыг баримтлах шаардлагатай гэж үзэж байна аа.

Тиймээс Монгол Улсын 2025 оны төсөвт нэн яаралтай хэмнэлтийн тодотгол хийж, төсвийн сахилга бат, ил тод, нээлттэй, нэгдмэл байдлыг чанд сахиж, хариуцлагын тогтолцоог эрс чангатгана аа. Төсвийн зардал ачааллыг нэмэгдүүлж байгаа төрийн бүтцийг эмхлэн цэгцэлж, тооноос чанарт шилжиж, цомхон чадварлаг, бүтээмжтэй төрийн албыг бий болгох чиглэлд бодитой алхмуудыг хийх шаардлагатай байна аа. Төрийн өмчит аж ахуйн нэгж чиг үүрэг нь давхардсан үндэсний хороод болон үр ашиг муутай төрийн сангуудыг цэгцэлнэ ээ. Төрийн өмчит компаниудын тоог цөөлнө өө. Хувьчлалыг эрчимжүүлж, засаглалыг сайжруулж, олон нийтийн хяналттай, цомхон, чадварлаг, үр өгөөжтэй байхуйц бүтцийн өөрчлөлтийг хийж мэргэшсэн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх нь зайлшгүй шаардлага мөн гэж үзэж байна аа.

Манай Засгийн газар хөдөлмөрлөж байгаа хүн бүрийг ажил олгогч, баялаг бүтээгч нараа бүх талаар дэмжиж ажиллах болно. Тиймээс татвар, нийгмийн даатгалын сангийн цогц реформ хийж, иргэд аж ахуйн нэгжийн татварын дарамтыг бууруулж, шаталсан шударга татварын тогтолцоог бэхжүүлж, татварын бааз суурийг өргөтгөх арга хэмжээг авна аа. Түүнчлэн хувийн хэвшлийн хийх боломжтой ажлыг төр хийхгүй байх зарчмыг баримтална. Төр зарим үйлчилгээний чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлж, эдийн засагт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх чиг баримтална. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, инновац, бүтээмжийг дэмжсэн эрх зүйн шинэчлэл хийж, бизнесийн орчны хүндрэл чирэгдлийг арилгаж, хувийн хэвшлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ ээ.

Хүний хөгжил бол манай Засгийн газрын хамгийн том мега төсөл байх болно. Шинэ Засгийн газар Монгол хүний хөгжлийг бодлогынхоо цөмд нь, иргэдийнхээ эрхийг шийдлийнхээ голд нь тавьж асуудалд ханддаг, ард түмний төлөө Засгийн газар байхыг эрхэм зорилтоо болгож ажиллана аа. Чадварлаг, бүтээмжтэй, эрүүл саруул, дэлхийд өрсөлдөх чадвартай Монгол хүний хөгжилд чиглэж, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын цогц реформыг эрчимжүүлэх болно. Бүтээмж, гүйцэтгэл, үр дүнд суурилсан цалин хөлсний бодлогыг салбар бүрд нэвтрүүлнэ. Халамжийн тогтолцоонд шинэчлэл хийж, хамгийн сайн халамж бол хөдөлмөр эрхлэлт байх зарчмыг удирдлага болгоно. Тэтгэврийн шинэчлэлийг эрчимжүүлж, нийгмийн даатгалын сангийн алдагдлыг бууруулж, удирдлага менежментийг шударга, ил тод, мэргэжлийн хөрөнгийн удирдлагын тогтолцоонд шилжүүлнэ.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг тууштай хэрэгжүүлж баялагтаа Эзэн Монгол хөтөлбөрөө тууштай хэрэгжүүлнэ. Монгол хүн баялагтаа эзэн байх ёстой. Эзэн байхын учир нь өмчийнхөө зарцуулалтад хяналт тавих, үр өгөөжийг нь тэгш хүртэх хэрэгтэй байхад чиглэгдэнэ ээ. Энэ зарчмын үүднээс стратегийн ач холбогдол бүхий орд эзэмшигч аж ахуйн нэгжүүдтэй хийж буй хэлэлцээрүүдийг үргэлжлүүлэн бодитой үр дүнд хүргэнэ.

Эрхэм гишүүд ээ,

Монголчууд бид ардчилсан Үндсэн хуулиа батлаад 30 гаруй жилийг туулжээ. Миний бие өнгөрсөн хугацаанд ард түмэн төр засгийн дэмжлэгээр парламент, гүйцэтгэх засаглал, гадаад харилцаа, төрийн бодлогын түвшинд ажиллахдаа олон сорилт бэрхшээлийг туулж, ардчиллын засаглалыг бэхжүүлэх, төлөөллийн ардчиллыг зөвлөлдөх ардчилалтай хослуулан, төрийн тогтвортой байдлыг хангахыг тууштай зорьж, ард түмнээ сонсож ажиллаж ирсэн.

Улсын Их Хурлын даргаар ажиллаж байхдаа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлуулж, газрын хэвлийн баялагтаа ард түмэн эзэн байх суурь зарчмыг Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар батлуулж өнгөрсөн парламент чадсан. Мөн хүний эрхийн хамгаалагчийн тухай хууль, төрийн хүнд суртлыг бууруулах зөвшөөрлийн хууль, авлигагүй, нээлттэй засаглалыг бэхжүүлэх цахим хөгжлийн багц хууль, Хүний хөгжлийг дэмжих боловсролын багц хууль, Зөвшөөрлийн хууль, авлигатай тэмцэх багц хуулиудыг баталж, эрх зүйн шинэчлэлийг бид хэрэгжүүлсэн. Хууль батлагдах бол нэг хэрэг ээ. Тиймээс шинэ Засгийн газар хууль хэрэгжүүлэх, хуулийг биелүүлэх, хуулийн үйлчлэлийг тэгш байлгах, шударга, ёс, тэгш эрхийг хангахад бүхий л анхаарлаа хандуулна аа.

Мөн төрд ёс зүйг сахиулах нь Засгийн газрын нэн тэргүүний зорилт байх болно оо. Хууль дээдлэх, ёс зүйн хариуцлагыг эрхэмлэх зарчим дээрээсээ эхэлж, ард иргэд, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хамтарсан хяналт, оролцоо, ил тод байдал дээр тулгуурлах учиртай. Ард түмэнтэйгээ хамгийн ойр, тэдний үгийг сонсдог, шаардлагыг анхаардаг, үйл ажиллагаа, шийдвэр нь ил тод байдаг төр засаг л иргэдийнхээ итгэлийг, төрд итгэх итгэлийг сэргээж чадна аа. Иймээс авлигаас ангид, ард түмнээсээ зугтаадаггүй, эрх мэдлийн ард нуугддаггүй үнэнээ хэлдэг засаг байх болно.

Манай Засгийн газар хариуцлага нь эзэнтэй Засгийн газар байх учиртай гэж үзнэ ээ. Алга ташуулахад эзэн олон, алдаа дутагдалд хариуцагч байхгүй байх нь наад захын шударга ёсны зарчимд нийцэхгүй гэж үзнэ ээ. Тиймээс алдаа бурууг цаг

тухайд нь хариуцлага тооцох тооцдог байх зарчмыг мөрдлөг болгоно. Алдсанаа үл байдаг, буруудсанаа засдаг, буруутанд хариуцлага оноодог байх нь ардчилсан засаглалын зарчим мөн чанарт нийцэх учиртай.

Бид асуудлыг ерөнхийлж бөөрөнхийлдөггүй, ацаглаж хойш тавьдаггүй, улс төржилт талцалгүй Засгийн газар байхыг эрхэмлэнэ. Түүнчлэн богинын зайны дуулиан шуугианд хөтлөгдөхгүйгээр улирлын чанартай бэрхшээлүүдийг оновчтой шийдвэрлэж, урт хугацааны ултай суурьтай шийдэлд төвлөрнө өө. Шинэ Засгийн газарт төрийн бодлогын залгамж чанарыг хэлбэрэлтгүй сахина. Өмнөх Засгийн газрынхаа сайхан бодлогыг сайн бодлогыг тууштай үргэлжлүүлж, улс орны язгуур эрх ашиг сонирхолд нийцсэн мега төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлж, цаг алдалгүй хэрэгжүүлэхийг зорино оо.

Түүнчлэн нийслэл Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдол зэрэг олон жил бугшмал асуудлыг шийдвэрлэх, нийслэлийн бодлого, үйл ажиллагааг бүхий л талаар дэмжиж ажиллах болно оо. Дэлхийн хамтын нийгэмлэг бүс нутгийн түвшинд гадаад харилцааны ололтоо ахиулж, амжилтаа бататгана аа. Гадаадын хөрөнгө оруулалтыг тууштай дэмжиж, Монгол Улсын язгуур эрх ашиг сонирхлын цорын ганц Монгол Улсын язгуур эрх ашиг сонирхлыг цорын ганц хэмжүүр шалгуур нь болгоно. Монгол Улс сайн хөрш, найдвартай түнш, итгэлтэй хамтрагч гэдэг дүр төрхийг баталгаажуулахыг эрмэлзэнэ ээ. Товчилж хэлбэл олон улсад Монгол Улсынхаа өсөн нэмэгдэж буй нэр хүндийг бататган бэхжүүлэгч гадааддаа ч нэр хүндтэй Засгийн газар байхыг эрмэлзэнэ ээ.

Түүнчлэн дижитал пост гэсэн уриан дор цахим шилжилтийг эрхэмлэгч Засгийн газар байхыг зорино. Их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт бидний зорилт байх болно. Төрийн ажил үйлчилгээг цахимд шилжүүлэх эрмэлзэл бүрийг хөдөлмөр хөнгөвчлөх, бүтээмж нэмэгдүүлэх, инновац, шинэ технологи нэвтрүүлэх шийдэл болгоныг манай Засгийн газар ямагт урамшуулан дэмжих болно оо. Дэлхий дахинд үүсээд байгаа хурцадмал нөхцөл байдал, Монголыг чиглэсэн гаднын ашиг сонирхол цөөхөн монголчууд биднийг эвтэй байхыг шаардаж байна аа. Энэ шаардлага хэзээ хэзээнээс илүү үнэ цэнтэй болсныг монгол хүн бүр мэдэрч санаж явах учиртай. Үзэл бодол ондоо, байр суурь тусдаа, намын харьяалал өөр байж болно оо. Гэхдээ бид Монголоо гэсэн нэг л сэтгэлтэй байх ёстой. Бид нэг Монголын нэгдмэл үнэт зүйлтэй ард түмэн.

Тиймээс бид шударга ёсыг дээдэлж эвийг эрхэмлэдэг Засгийн газар байхыг зорино оо. Ойрын нөхөд хэрэлдэхэд холын дайсан баярладаг гэсэн үг бий. Үүн дээр нь нэмээд гадаа хүйтэрч байхад гэр дотор дулаан байх ёстой гэдгийг би нэмж хэлмээр байна. Эвийг хичээж, эеийг эрхэмлэж, зөвшилцөл ойлголцлын эн тэргүүнд эрэмбэлж, Монголынхоо төлөө, ард түмнийхээ төлөө нэгэн үзүүрт сэтгэлээр зүтгэхийг Монгол Улсын Их Хурлын гишүүдээсээ эрхэмлэн хүсье ээ.

Монгол Улсын Засгийн газрын тэргүүний хувьд би хүнийг төвд нь тавьсан хөгжил, шударга ёсыг эрхэмлэсэн төр, нэг бодлого, нэг зүтгэл уриаг үйл хэрэгтээ хэрэгжүүлж, эв нэгдэл, итгэл дээр суурин ажиллах болно гэдгээ илэрхийлье ээ. Нэг Монгол, нэг гэр бүл, нэг ард түмэн гэдгээ гүнзгий ухамсарлаж, хүсэл зорилго, үнэт зүйлээрээ нэгдэн нийлж сэргэн мандсан хүчирхэг Монголын төлөө хамтдаа зүтгэцгээе. Мөнх хөх тэнгэрийн дор Монгол Улс мандан бадрах болтугай.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: За баярлалаа. Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөлөө.

Өглөө 10 цагаас чуулганы хуралдаан үргэлжилнэ эхэлнэ.

00.45 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ
ХЯНАСАН: ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ